



Улаанбаатар хот 16102, Баянгол дүүрэг, 20-р хороо,  
Сонсголон, “Жаст Агро” ХХК

## “МАХ БОНД”

Нийт гаргах бондын тоо:	3,000,000
Хэсэгчилж гарах давтамж:	3 удаа
Нэг удаад санал болгох хэмжээ:	1,000,000 ширхэг
Бондын нэрлэсэн үнэ:	10,000 төгрөг
Нийт үнийн дүн:	30,000,000,000 MNT
Бондын хугацаа:	12 сар
Бондын жилийн хүү:	16.2%
Бондын сарын хүү:	1.35%
Хүү төлөх хугацаа:	Улирал тутамд
Бондын баталгаа:	Үл хөдлөх хөрөнгө болон борлуулалтын гэрээгээр баталгаажна.



### Андеррайтер



#### БиДиСек ХК

Андеррайтер, Брокер, Дилер,  
Хөрөнгө оруулалтын зөвлөх

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө 27/1  
Утас: 976-11-313108, Факс: 976-11-323411  
И-мэйл: info@bdsec.mn, Вэб: www.bdsec.mn



**ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД**

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ НЬ МОНГОЛ УЛСЫН “КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛЬ”, “ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ” БОЛОН МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ХОЛБОГДОХ ЖУРМУУДЫН ДАГУУ БОНД ГАРГАН ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨӨ САНХҮҮЖҮҮЛЖ БАЙГАА БОЛНО.

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 7.1-Д ЗААСНЫ ДАГУУ ОЛОН НИЙТЭД ГАРГАЖ БҮЙ ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО БҮРТГЭСЭН НЬ УГ ҮНЭТ ЦААСНЫ ЭРСДЛИЙН ТАЛААР АЛИВАА БАТАЛГАА ГАРГААГҮЙ БОЛОХЫГ АНХААРАХ НЬ ЗҮЙТЭЙ. ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД **ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ** ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.

Энэхүү үнэт цаасны танилцуулгад хөрөнгө оруулагч танд бонд худалдан авах шийдвэр гаргахад туслах, шаардлагатай бүхий л мэдээллийг агуулахыг зорьсон болно. Танилцуулгад хөрөнгө оруулагч танд шаардлагатай мэдээллийг бүрэн оруулаагүй байж болох ба лавлах тодруулах зүйлийг Үнэт цаас гаргагч компани болон Андеррайтерын “БиДиСЕК” ХК-д хандаж авна уу.

Андеррайтерын компани нь энэхүү үнэт цаасны танилцуулгыг бэлдэхдээ “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийн 28 дугаар зүйлд заасан мэргэжлийн компанийн хариуцлага, ёс зүйн журмыг баримтлан аудитын компанид шалгуулсан санхүүгийн тайлангийн мэдээллийг алдаа, зөрүүгүйгээр авч ашигласан болно.



## ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД УЧИРЧ БОЛОХ ЭРСДЭЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛС

Монгол улсын мал аж ахуй, байгаль цаг уурын онцлог, компанийн үйл ажиллагаа, удирдлага, улс орны эдийн засаг, төр засгийн бодлого шийдвэрүүдийн улмаас тус компанид учирч болох эрсдлүүдийн хүчин зүйлс.

### Байгаль , цаг уураас хамааралтай эрсдэл:

Монгол улсын мал аж ахуйн салбар нь нүүдлийн мал аж ахуй бөгөөд байгал, цаг, уурын өөрчлөлтөөс шууд хамааралтай. Энэ утгаараа байгалийн аливаа аюулт үзэгдэл, ган, зуд, халдварт өвчин зэрэг нь махны салбарт шууд нөлөөлдөг.

Махны салбарт байгаль орчны өөрчлөлтийн нөлөөллөөс хамааран дараах эрсдэлүүд үүсэх магадлалтай. Үүнд:

- Ган, зудын нөлөөллөөр малын зүй бус хорогдол гарах. Энэ нь махны нийлүүлэлтийг бууруулж, махны үнийг өсгөх. Тухайлбал 2009-2010 оны өвөл зуд болж, нийт 7.5 сая мал хорогдсон нь махны нийлүүлэлтийг эрс бууруулсан.
- Махны үнэнд нөлөөлж буй хамгийн том шокын нөлөө нь ган, зудны асуудал байдаг. Судалгаанаас харахад манай улсад зуд 115 жилийн давтамжтайгаар тохиолдолддог бөгөөд тухайн жилд махны нийлүүлэлт буурч, хомсдол ихсэж махны үнэ маш ихээр нэмэгддэг.
- Зун хэт халснаас мал өвс тэжээлийн дутагдалд орж, тарга хүчээ бүрэн авч чадахгүй байх. Энэ нь махын гарц болон чанарт нөлөөлөх,
- Монгол улс малын шүлхий, боом зэрэг халдварт өвчний идэвхтэй бүсэд байдаг ба эдгээр өвчин гарсан тохиолдолд махны чанар болон нийлүүлэлтийг бууруулах



### Компанийн үйл ажиллагааны эрсдэл

#### Мах бэлтгэлийн үйл ажиллагааны эрсдэл:

Тус компанийн салбар үйлдвэрүүд нь үйл ажиллагааны цар хүрээгээ ойр орчмын 200 километрийн радиус бүхий тойрог дахь хөдөө, орон нутагт ажиллаж амьдарч буй малчдыг хамруулан мал бэлтгэх үйл ажиллагаагаа явуулдаг ба үүнд дараах эрсдэл учрах магадлалтай. Үүнд:

- Махны салбар нь мах бэлтгэх, боловсруулах, худалдах нэгдсэн системд ороогүйгээс дурын худалдаачин /ченж/ малчдаас малыг өндөр үнээр худалдан авч зах зээлд нийлүүлж байгаа нь компанийн мах бэлтгэлийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх. Тухайлбал, мал бэлтгэлийн зах зээлийг багасгах болон малын үнийг нэмэгдүүлэх,
- Малыг тууварлалтын явцад малын жингийн алдагдал үүсэх болон мал алдагдах, өөрчлөгдөх, хорогдох зэрэг шалтгаанаас малчид малаа үйлдвэр дээр туурварлаж авч ирэхээс газар дээр нь ченжүүдэд худалдахыг илүүд үзэх.

- Бондын борлуулалтаас орох нийт 30 тэрбум төгрөгийн мах бэлтгэх учир хөдөө орон нутагт махны үнийн өсөлтийг бий болгох.

### **Бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хадгалалтын үйл ажиллагааны эрсдэл**

Компани нь үйлдвэрлэлийн технологи, бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйг дээшлүүлэхэд ихээхэн анхаарч хөрөнгө оруулалт болон ажлын хүчин чармайлт гаргаж байгаа боловч гэнэтийн болон гадаад, дотоодын хүчин зүйлээс хамаарч үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд дараах эрсдэл гарах магадлалтай. Үүнд:

- Түүхий эдийн хомсдолоос шалтгаалан хүчин чадлаа бүрэн ашиглаж чадахгүй байх,
- Мал бэлтгэл хийгдэж буй бүс нутагт малын гоц халдварт өвчин гарснаас хөл, хорио цээр тавигдах,

### **Борлуулалтын үйл ажиллагааны эрсдэл:**

Мах нь хүн амын хүнсний хэрэглээний нэг үндсэн хэсэг тул маханд эрүүл ахуйн өндөр шалгуурыг тавьдаг. Компанийн мах бэлтгэл, боловсруулалт болон худалдан авагчдын үйл ажиллагаатай холбоотойгоор дараах эрсдэл учрах магадлалтай. Тухайлбал,

- Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа болон бүс нутагт гарсан аливаа байгалийн гамшиг, халдварт өвчний улмаас махны тээвэрлэлтэнд хориг тавих, энэ нь борлуулалт цагтаа хийгдэхгүй байх,
- Дотоодод гарсан малын халдварт өвчний улмаас импортлогч орны мэргэжлийн байгууллагаас худалдан авалтандаа хориг тавих, шаардлагаа өндөрсгөх.
- Ялангуяа үнэт цаас гаргагч нь үхэр, адууны махны борлуулалтын дийлэнх хэсгийг ОХУ-руу экспортлодог ба ОХУ-н зүгээс махны хорио цээрийн асуудлыг цуцлахгүй байх эрсдэлтэй. Ингэснээр үхрийн махны борлуулалтын хамгийн том суваг хаагдаж борлуулалтын орлого төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй байх эрсдлийг дагуулна.

/Монгол малыг эрүүлжүүлэх, мал аж ахуйн бүтээгдэхүүн экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр малын гоц халдварт шүлхий өвчнөөс сэргийлэх, өвчлөмтгий мал сүргийг вакцинжуулах эрүүлжүүлэх зорилгоор ОХУ 375,0 сая рублийн буцалтгүй тусламжийг 2011 оны зунаас үзүүлж эхлээд байна. 2011 оны 09 сарын 14-ээс үхрийн махны хорио цээр тавигдах магадлал 80%-тай байгаа ба хорио цээр тавигдснаар ОХУ-руу экспортлох боломжтой болно. Адууны махны экспортонд ямар нэгэн хорио цээр байхгүй байна./

- Импортын татвараа нэмэгдүүлэх. Ингэснээр борлуулалтын зардал нэмэгдэх,
- Дотоодын зах зээл дээр ченжүүд болон малчдаас шууд нийлүүлж буй махны борлуулалтаас шалтгаалж, компанийн борлуулалт буурах,
- Бурятмяспром-той байгуулсан гэрээний дагуу бүтээгдэхүүнийг хэсэгчлэн ачих бөгөөд хэсэгчлэн ачсан бараа болгондоо тооцоог тухай бүр хийнэ. Эхний төлбөр орж ирээгүй тохиолдолд дараагийн мах нийлүүлэлт хийгдэхгүй байх улмаар борлуулалт хэвийн явагдахгүй, ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлж магадгүй,



## **Хүний нөөц, удирдлагын үйл ажиллагааны эрсдэл**

Улс орны эдийн засаг өсч, салбаруудын өсөлт эрчимтэй явагдаж байна. Ялангуяа уул уурхай салбарын эдийн засагт эзлэх байр суурь хурдацтай нэмэгдэж байгаа нь иргэдийн энэ салбарт ажиллах сонирхолыг нэмэгдүүлж байна. Энэ дараах эрсдэлийг учруулах магадлалтай. Тухайлбал,

- Чадварлаг удирдлага, ажилтнуудаа алдаж, боловсон хүчний дутагдалд орох,
- Мах бэлтгэлийн үед хөдөө орон нутагт байгаа салбаруудад үндсэн ажиллах хүчний дутагдал үүсэх,

## **Санхүүгийн үйл ажиллагааны эрсдэл**

Компанийн үйл ажиллагаа, худалдан авагч болон үйлдвэрлэлийн гол түүхий эдийн үнийн өөрчлөлтөөс шалтгаалж компанид дараах эрсдэл учрах магадлалтай. Тухайлбал,

- Түүхий эд болон бусад шаардлагатай материалуудын үнийн өсөлтөөс шалтгаалж төсөвлөсөн зардал хэтрэх,
- Зардлын өсөлтийн улмаас үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай эргэлтийн хөрөнгийн дутгадалд орох,
- Худалдан авагч нь цаг хугацаандаа төлбөрөө төлөхгүй байх,
- Улс орны эдийн засийн байдлаас шалтгаалж нөөцийн махны урамшууллын мөнгө цаг хугацаандаа төлөгдөхгүй байх,
- Махны бизнесийн мөнгөний урсгалын цикл нь хугацааны хувьд 12-15 сарын хугацааг хамарч үргэлжилдэг. Өөрөөр хэлбэл, тухайн оны 6 дугаар сард мал бэлтгэлд гаргасан мөнгө нь мөн оныхоо 9-12 сард мах болж, дараа оны шинэ мах өргөнөөр худалдаалагдаж эхлэх хүртэл арилжаалагддаг. Энэ хугацаа нь ерөнхийдээ 9 сар байдаг. Иймээс тухайн онд мал бэлтгэл, маханд гарсан мөнгө дараагийн ээлжит мал бэлтгэл, махны үйлдвэрлэлийг санхүүжүүлэх хангалттай эх үүсвэр болж чадахгүй байх,

## **Эдийн засгийн хүчин зүйлсийн эрсдэл**

Улс орны эдийн засаг, нийгэмд бий болж болзошгүй сөрөг үзүүлэлтүүд нь компанийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүний борлуулалт, бүтээгдэхүүний өртөгт нөлөөлөх магадлалтай. Тухайлбал,

- Инфляцийн түвшний өсөлтөөс шалтгаалан дотоодын худалдан авагчдын чадвар буурах,
- Цахилгаан эрчим хүчний үнийн өсөлт нь бүтээгдэхүүний өртгийг нэмэгдүүлэх,
- Валютын ханшийн тогтворгүй байдлаас шалтгаалж, ханшийн зөрүүнээс алдагдал хүлээх,
- Хятадын бизнес эрхлэгчид ченжүүдтэй хамтран махны зах зээлд орж, малыг ихээр худалдан авч байгаа нь малын үнийг өсгөх,
- ОУ-ын зах зээл дээрх газрын тосны үнийн болон ОХУ-н экспортын татварын өсөлтөөс шалтгаалсан түлш, шатахууны үнийн өсөлт нь компанийн мах тээвэрлэлтийн зардлыг нэмэгдүүлэх,
- Гадаад худалдааны өсөлтөөс шалтгаалан төмөр замын тээвэр нэмэгдэж байгаа нь бүтээгдэхүүний тээвэрлэлт саатах, цаг хугацаандаа худалдан авагчид очихгүй байх,
- Малыг хөлөөр нь хөрш зэргэлдээ улс орнуудад экспортлох,



## **Улс төрийн бодлого, шийдвэрийн эрсдэл**

Төр засгийн эдийн засаг, нийгмийн салбарт хэрэгжүүлж буй бодлого, шийдвэрүүд компанийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтад нөлөөлөх магадлалтай. Тухайлбал,

- Төр засгийн тогтворгүй байдлаас шалтгаалж, салбарын хууль, эрх зүйн орчинд өөрчлөлт оруулах,
- Махны үнийг тогтвортой байлгах нэрийдлээр махны үнийг зах зээлийн бодит үнээс доогуур байлгах,
- Иргэдийн нийгмийн халамжийн чиглэлээр авч хэрэгжүүлж буй бодлого нь улсын төсвийг тэлж, үүнтэй холбоотойгоор татварын хэмжээнд өөрчлөлт орох,
- Нөөцийн махыг бэлтгэх, борлуулалтанд олгож буй урамшууллын хэмжээ бууруулах,

## **Төлбөрийн чадварын эрсдэл**

Бонд гаргагч нь бондын хүүгийн ба үндсэн төлбөрийг цаг хугацаанд нь төлж чадахгүй байдалд түр болон бүрмөсөн орж болзошгүй байх эрсдэл бага ч энэхүү эрсдэлийг бий болгох тодорхой хүчин зүйлс байх магадлалтай юм.

- Дээр дурдсан эдийн засаг, улс төрийн нөхцөл байдал, байгалийн давагдашгүй хүчин зүйл болон малын гоц халдварт өвчин зэргээс шалтгаалах эрсдэл гэх мэт хүчин зүйлс төлбөрийн чадварт өөрчлөлт оруулах шалтгаан болохыг үгүйсгэх аргагүй.

## **Бусад эрсдэл**

Мөнгөний үнэгүйдлээс шалтгаалж хөрөнгө оруулагчийн эзэмшиж буй бондын бодит үнэ цэнэ, хүүгийн бодит орлого буурах эрсдэл байдаг. Энэхүү эрсдлээс амжилттай зайлсхийх шийдэл гэж байдаггүй.

Дээр дурдсан эрсдлүүд нь гадаад болон дотоод хүчин зүйлсийн нөлөөнөөс хамааран учирч болох эрсдлүүд юм.



**ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГЫН ХУРААНГУЙ**


Үнэт цаас гаргагч нь мал бэлтгэлийн үйл ажиллагаа явуулж, бэлтгэн нийлүүлэгдсэн малыг үйлдвэрийн аргаар төхөөрч, мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэн дотоодын болон гадаадын зах зээлд борлуулах үйл ажиллагааг эрхэлдэг. Тус компани нь 2005 оноос урт хугацааны хөрөнгө оруулалтын нэгдмэл бодлогын хүрээнд техник, технологийн шинэчлэлтийг ээлж дараатайгаар хийсний үр дүнд Монгол улсын хэмжээнд мал бэлтгэлийн 32.3 хувь (41634 толгой мал бэлтгэсэн), үйлдвэрийн аргаар мал төхөөрөх хүчин чадлын 26 хувь (нэг удаадаа бод-1810, бог-8900 толгой), мах махан бүтээгдэхүүн хадгалах хүчин чадлын 30 (19200 тн), махны экспортын 22.8 (2010 оны байдлаар 4518.9 тн-ыг экспортлосон) хувийг дангаараа хангах болсон. Мөн үйлдвэрийн аргаар бэлтгэж буй нийт махны 40 (2010 онд нийт 2111 тн үйлдвэрлэсэн) орчим хувийг үйлдвэрлэн, нийслэлийн хэмжээнд худалдаалагддаг улсын нөөцийн мах болон экспортын мах, махан бүтээгдэхүүний 1/3-ийг (2010 оны байдлаар 6918.9 тн мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэж борлуулсан) дангаараа хангаж байна.

Малыг алс холоос, дундын зуучлагчаар дамжуулдаг байсан мал бэлтгэлийн өртөг өндөртэй хуучин арга барилыг тус компани нь 2006 оноос халж, бүсчилэн мал бэлтгэх шинэ аргийг нэвтрүүлсэн. Ингэхдээ малыг хамгийн алсдаа 50-200 км-т тууварлан үйлдвэрт нийлүүлэх боломжтойгоор 11 аймаг, орон нутгийг хамарсан томоохон сүлжээ үйлдвэрүүдийг бий болгоод байна.

Манай улсад нийтдээ том, жижиг нийлсэн 35 орчим махны үйлдвэр ажиллан, жилд 90 орчим мянган тонн мах, махан бүтээгдэхүүнийг үйлдвэрийн аргаар боловсруулах хүчин чадалтай хэдий ч эргэлтийн хөрөнгийн дутагдлаас хамаарч 20-30 хувийг л ашиглаж, хотуудын махны хэрэглээний 30 орчим хувийг хангаж байна. Мах, махан бүтээгдэхүүний ханган нийлүүлэлт үндсэндээ ченжүүдээр дамжин хийгдэж байгаа нь хүнсний аюулгүй байдалд хурцаар яригдах асуудал болж байна.

**Үнэт цаас гаргагчийн бий болгосон давуу тал:**

- ✓ Ямарваа байгалийн болон гэнэтийн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс ангид байхуйцаар орон нутагт мал хүлээн авч үйлдвэрийн аргаар төхөөрч боловсруулах, хадгалах үйлдвэрүүдийн сүлжээг бий болгосон. Энэ нь байршлын давуу тал бөгөөд байгалийн давагдашгүй хүчин зүйл, малын халдварт өвчний дэгдэлтийн үр дагаварыг бага байлгах нөхцөл бололцоог бий болгосон.
- ✓ Бэлтгэлийн малыг 50-200 километрийн зайд тууварлах болсноор нэг малын махны гарцыг нэмэгдүүлж, улмаар мал бэлтгэлийн үнийн 50-200 төгрөг хүртэлх өсөлтийг даах боломжийг бүрдүүлсэн.
- ✓ Эгзэгтэй цэгийн аюултай байдлыг шинжлэн хянах HACCP /Hazard analysis and Critical Control Point/ системийг бий болгож байна..
- ✓ Сэлэнгэ, Багануур, Дорнод, Улаанбаатар зэрэг салбар үйлдвэрүүд нь төмөр замд холбогдсон.
- ✓ 2011 онд бэлтгэгдэх махны экспортын борлуулалтын гэрээнүүд урьдчилан хийгдсэн. Тухайлбал,
  - Лалын Бүгд Найрамдах Иран Улс руу 4600 /дөрвөн мянга зургаан зуун/ тонн хонины махыг 2012 оны 02 дугаар сарын 28-наас өмнө 2 удаагийн тээвэрлэлтээр нийлүүлэх гэрээг 2011 оны 3 дугаар сарын 10-ны өдөр "Юни трейд" компанитай байгуулсан.
  - ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улсын "Бурятмяспром" компанитай 30 720 000 /гучин сая долоон зуун хорин мянга/-н ам.долларын үнийн дүн бүхий адуу, үхрийн 12000 /арван хоёр мянга/-н тонн махыг 2011 оны 8 дугаар сарын 01-нээс 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдөр



хүртэлх хугацаанд нийлүүлэхээр худалдах, худалдан авах гэрээг 2011 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр байгуулсан.


- ✓ Үнэт цаас гаргачийн эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр бондын үндсэн болон хүүгийн төлбөрийг бүрэн хангахуйц үнийн дүнтэй үл хөдлөх хөрөнгөөр бондын баталгаа гаргаж буй зэрэг нь үнэт цаас гарган татан төвлөрүүлэх хөрөнгийг үр ашигтай зарцуулж, бондыг цаг хугацаандаа эргэн төлөх боломжуудыг бүрдүүлж байна.

Үнэт цаас гаргагч нь үнэт цаас гаргахын өмнөх улирлын санхүүгийн тайлангийн үзүүлэлтээр нийт 3.85 тэрбум төгрөгийн өр төлбөртэй байгаа ба үүнээс 2.81 тэрбум төгрөг нь эргэлтийн хөрөнгө санхүүжүүлэх зорилгоор Хадгаламж банкаас авсан богино хугацаат зээл байна.

Тус зээлийн гэрээг анх 2010 оны 10 дугаар сарын 29-ны өдөр 1060/136 тоот Зээлийн гэрээгээр эргэлтийн хөрөнгө нэмэгдүүлэх зориулалтаар 1,900,000,000 /нэг тэрбум есөн зуун сая/ төгрөгийг сарын 1.8 хувь, жилийн 21.6 хувийн хүүтэйгээр 12 сарын хугацаатай зээлэхээр харилцан тохиролцож байгуулсныг 2011 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулан 1060/136-01 тоот гэрээг дараах нөхцөлтэйгээр байгуулсан.

Зээлийн хүүг 2011 оны 01 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн сарын 1.3 хувь, жилийн 15.6 хувь, зээлийн хэмжээг 915,000,000 /есөн зуун арван таван сая/ төгрөгөөр нэмэгдүүлж 2,815,000,000 /хоёр тэрбум долоон зуун сая/ төгрөг болгон, зээл төлөгдөж дуусах хугацааг 12 сараар нэмж сунгаж, зээлийн хүүний төлбөр төлөгдөж дуусах эцсийн хугацааг 2012 оны 10 дугаар сарын 20-н хүртэл сунгасан.

“Голомт банк” ХХК, “Жаст Агро” ХХК болон “БиДиСЕК” ХК-ийн хооронд 2011 оны 5 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан хамтран ажиллах санамж бичигт тусгагдсанаар Голомт банк нь Үнэт цаас гаргачийн олон нийтэд санал болгож буй бондоос 10 тэрбум төгрөгийн үнийн дүнд худалдан авах сонирхлоо илэрхийлсэн.





**ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ОЛОН НИЙТЭД САНАЛ БОЛГОЖ БУЙ БОНДЫН  
МЭДЭЭЛЭЛ**

*Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын Компанийн тухай (1999) хуулийн 42, 43 дугаар зүйл,  
Үнэт цаасны зах зээлийн тухай (2002) хуулийн 4, 5 дугаар зүйлийг үндэслэн олон нийтэд  
нээлттэй бонд гаргаж байна.*

<b>Бондын төрөл:</b>	Нэрлэсэн үнэтэй, биет бус
<b>Нэрлэсэн үнэ:</b>	10,000 төгрөг
<b>Нийт ширхэг</b>	3,000,000 ширхэг
<b>Нийт үнийн дүн:</b>	30,000,000,000 төгрөг
<b>Бондын хугацаа:</b>	12 сар
<b>Хүүгийн хэмжээ жилийн, /сарын/:</b>	16.2% , /1.35%/
<b>Хүү төлөх хугацаа:</b>	Улиралд нэг удаа
<b>Анхдагч зах зээлд байршуулах:</b>	Хэсэгчлэн
<b>Хэсэгчилэн гаргах давтамж:</b>	3 удаа
<b>Хэсэгчилэн гаргах хэмжээ:</b>	10,000,000,000 төгрөг
<b>Эргүүлэн авах нөхцөл:</b>	Хэсэгчлэн гаргасан хугацаа бүрийн эцэст нэрлэсэн үнээр
<b>Бонд гаргах зорилго:</b>	Мал бэлтгэлийн ажлыг санхүүжүүлэх
<b>Бондын баталгаа:</b>	Үл хөдлөх хөрөнгө болон мах борлуулалтын гэрээгээр баталгаажна.
<b>Бондын үндсэн болон хүүгийн төлбөрийн хугацаа хэтрэлт:</b>	Хүү төлөх өдрөөс хугацаа хэтэрсэн хоног тутамд хүүгийн төлбөрөөс 0.02%-иар алданги нэмж тооцон хүүг алдангийн хамт Үнэт цаас эзэмшигчид шилжүүлнэ.
<b>Бондын андеррайтер:</b>	“БиДиСек” ХК
<b>Бонд эзэмшигчдийн бүртгэл, төлбөр тооцоо, хадгаламж:</b>	“Үнэт Цаасны Төлбөр Тооцоо Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ТӨХХК
<b>Бонд арилжаалагдах зах зээл:</b>	Монголын Хөрөнгийн Биржийн арилжаагаар дамжуулан олон нийтэд нээлттэй арилжаална.




**ҮНЭТ ЦААСЫГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ**

Нийтэд санал болгон гаргаж буй 3,000,000 ширхэг бондыг анхдагч зах зээлд байршуулах хүчин төгөлдөр хугацаа нь 12 сар байна. Бондыг анхдагч зах зээлд байршуулахдаа нэг сая ширхэгээр гурван хуваан хэсэгчлэн гаргана.

**Бонд гаргах, төлбөр төлөх хугацааны график**

Хугацаа	2011 он						2012 он								
	Сар	8	9	10	11	12	1	2	3	4	5	6	7	8	9
Бонд 1		10 тэрбум төгрөг													
Бонд 2			10 тэрбум төгрөг												
Бонд 3				10 тэрбум төгрөг											
Хүүгийн төлбөр 1				+				+			+			+	
Хүүгийн төлбөр 2					+				+			+		+	
Хүүгийн төлбөр 3							+			+			+	+	
Үндсэн төлбөр 1													+		
Үндсэн төлбөр 2														+	
Үндсэн төлбөр 3														+	

- I. Эхний хэсгийн нэг сая ширхэг буюу 10 тэрбум төгрөгийн бондыг СЗХ-ны зөвшөөрөл гарч, МХБ-д бүртгэгдсэнээс хойш 2011 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн дотор анхдагч зах зээлд нэрлэсэн үнээр худалдан байршуулна. Эхний нэг сая ширхэг бондыг анхдагч зах зээлд амжилттай байршуулснаас хойш ажлын 15 хоногийн дотор анхдагч зах зээлд байршуулсан тайланг холбогдох эрх бүхий байгууллагууд болон олон нийтэд хүргэнэ.
- II. Санал болгох дараагийн нэг сая ширхэг бондыг эхний хэсгийн бонд анхдагч зах зээлд амжилттай арилжаалагдсаны дараа Үнэт цаас гаргагчийн эргэлтийн хөрөнгийн хэрэгцээтэй уялдуулан 2011 оны 8-9 дүгээр сард анхдагч зах зээлд байршуулна. Нийтэд санал болгосон хоёрдах хэсгийн нэг сая ширхэг бондыг анхдагч зах зээлд амжилттай байршуулснаас хойш ажлын 15 хоногийн дотор анхдагч зах зээлд байршуулсан тайланг холбогдох эрх бүхий байгууллагууд болон олон нийтэд хүргэнэ.
- III. Санал болгох гуравдах хэсгийн нэг сая ширхэг бондыг хоёрдох хэсэгт санал болгосон бонд анхдагч зах зээлд амжилттай арилжаалагдсанаас хойш Үнэт цаас гаргагчийн эргэлтийн хөрөнгийн хэрэгцээтэй уялдуулан 2011 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор анхдагч зах зээлд байршуулна. Нийтэд санал болгосон гуравдах хэсгийн бондыг анхдагч зах зээлд амжилттай байршуулснаас хойш ажлын 15 хоногийн дотор анхдагч зах зээлд байршуулсан тайланг холбогдох эрх бүхий байгууллагууд болон олон нийтэд хүргэнэ.



**Агуулга**

<b>НЭГ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ</b> .....	<b>14</b>
1.1 Үнэт цаас гаргагчийн танилцуулга .....	14
1.2 Компанийн хаяг, хариуцсан захирал, холбоо барих утас .....	14
1.3 Үнэт цаас гаргагчийн түүх .....	15
1.4 Зах зээлийн мэдээлэл .....	17
1.5 Монголын эдийн засаг ба Засгийн газрын бодлого .....	23
1.6 Үнэт цаас гаргагчийн бүтэц зохион байгуулалт .....	25
1.7 Үнэт цаас гаргагчийн толгой болон охин компанийн тухай мэдээлэл .....	25
1.8 Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнуудын мэдээлэл .....	28
1.9 Ажилтан албан хаагчдын мэдээлэл .....	30
1.10 Салбаруудын байршил, хүчин чадал .....	31
1.11 Үйлдвэрлэл, Чанарын хяналт .....	33
1.12 Дэд бүтэц, тээвэрлэлт .....	38
1.13 Борлуулалт .....	39
1.14 Сүүлийн 3 жилийн санхүүгийн үзүүлэлт .....	43
1.15 Үнэт цаас гаргагчийн өр төлбөрийн талаар .....	46
1.16 Хараат бус аудиторын тайлан .....	47
1.17 Тайлангийн шинжилгээ .....	51
1.18 Үнэлгээний байгууллагаар гүйцэтгүүлсэн хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний тайлангийн дүгнэлт .....	54
1.19 Үнэт цаас гаргахтай холбогдуулан гаргасан хуульчийн дүгнэлт .....	56
1.20 Хууль эрх зүйн орчин .....	60

**ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА**

2.1 Олон нийтэд санал болгох бондын танилцуулга .....	64
2.2 Үнэт цаас гаргах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр .....	65
2.3 Бондын баталгаа .....	67
2.4 Үнэт цаас эзэмшигчийн эрх .....	69
2.5 Үнэт цаас гаргагчийн үүрэг .....	69
2.6 Үнэт цаас гаргагчийн санал болгож буй бондын хүүгийн түвшин .....	70
2.7 Анхдагч зах зээлд байршуулах арилжаа .....	70
2.8 Үнэт цаас гаргах замаар хуримтлуулах хөрөнгийн зарцуулалт, Эдийн засаг үр ашгийн тооцоо .....	74
2.9 Тухайн үнэт цаасыг худалдан авснаар хөрөнгө оруулагчдад учирч болох эрсдэлийн хүчин зүйлс .....	79

**ХҮСНЭГТҮҮД**

Хүснэгт 1 Малын тоо /Төрөл тус бүрээр/ .....	17
Хүснэгт 2 Нөөцийн мах .....	21
Хүснэгт 3 Махны экспорт .....	22
Хүснэгт 5 Албан тушаалтнуудын мэдээлэл .....	28
Хүснэгт 6 Захирлуудын зөвлөл .....	28
Хүснэгт 7 Бусад эрх бүхий албан тушаалтнуудын мэдээлэл .....	30
Хүснэгт 8 Үйлдвэрүүдийн хүчин чадал .....	32
Хүснэгт 9 Компанийн хөрөнгө оруулалтын хэмжээ .....	32
Хүснэгт 10 Үйлдвэрийн үйл ажиллагааны технологийн горим .....	34
Хүснэгт 11 Мах бэлтгэлийн тоо, махны гарц .....	35
Хүснэгт 12 Экспортын хэмжээ /тн/ .....	40
Хүснэгт 13 ОХУ дахь махны борлуулалт .....	41
Хүснэгт 14 Жаст Агро нөөцийн махны бэлтгэлийн хэмжээ /тн/ .....	41
Хүснэгт 15 Баланс .....	44

СЗХ  
2011 он 7 сар 26 өдөр  
**БҮРТГЭВ**  
№ 01

МХБ-ийн гишүүн  
Э.М.Төр-Очирагч  
Брокер, ил төрийн  
"БИ.А.А.К"  
УТААНЫ Д. 2052-032



Хүснэгт 16 Орлогын тайлан.....	45
Хүснэгт 17 Хураангай орлогын тайланд хийсэн бүтцийн шинжилгээ.....	51
Хүснэгт 18 Балансын хандлагын шинжилгээ.....	52
Хүснэгт 19 Мах бэлтгэх төлөвлөгөө.....	76
Хүснэгт 20 Тураг мах үйлдвэрлэл.....	76
Хүснэгт 21 Махны нэгжийн өртөг.....	76

**ЗУРАГНУУД**

Зураг 1 Бүтэц зохион байгуулалт.....	25
Зураг 2 Сүлжээ үйлдвэрүүдийн байршил.....	31
Зураг 3 Үйлдвэрүүдийн байршлын радиус.....	35
Зураг 4 Үнэт цаас гаргагч болон Хадгаламж банкны салбаруудын байршил.....	36
Зураг 5 Транс Монголын төмөр замын сүлжээ.....	39

**ГРАФИКУУД**

График 1 Дэлхийн улс орнуудын хэрэглээ.....	18
График 2 Мах, махан бүтээгдэхүүний хэрэглээний бүтэц.....	18
График 4 Махны үнийн индекс ба ХҮИ.....	19
График 5 Махны үнэ /Жилийн дундаж/.....	20
График 6 Махны үнийн чиг хандлага.....	20
График 7 Махны үнийн сарын нөлөө.....	20
График 8 ХААҮ-ийн динамик, сая төгрөг.....	24
График 9 Жаст группын борлуулалтын орлого /тэрбум ₮/.....	26
График 10 Нийт борлуулалтын бүтэц /%/.....	40
График 11 Борлуулалтанд эзлэх экспортын хэмжээ /%/.....	40
График 12 Нөөцийн махны бэлтгэлийн хэмжээ.....	41
График 13 Жижиглэнгийн махны борлуулалтын бүтэц.....	42
График 14 Банк болон ААН-ийн бондын хүүгийн судалгаа.....	70
График 15 Компанийн бондын хүүгийн мэдээлэл.....	70

**СХЕМҮҮД**

Схем 3 Үйлдвэрийн процесс.....	33
Схем 1 Ердийн махны үйлдвэрийн үйл ажиллагааны схем.....	34
Схем 2 Үнэт цаас гаргагчийн махны үйлдвэрийн үйл ажиллагааны схем.....	35



*Handwritten signature*



**ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР**

*Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан үгийн товчлолууд нь дараах утгыг агуулна.*

ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
ББӨ	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг
БДК	Брокер, дилерийн компани
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗГ	Засгийн газар
БНСВУ	Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс
МУ	Монгол Улс
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МХБ	Монгол Хөрөнгийн Бирж
МАА	Мал аж ахуй
НББ	Нягтлан бодох бүртгэл
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОХУ	Оросын Холбооны Улс
УМХ	Улсын мэргэжлийн хяналт
ТУЗ	Төлөөлөн Удирдах Зөвлөл
ТӨХ	Төрийн өмчийн хороо
УБ	Улаанбаатар
ХАА	Хөдөө аж ахуй
ХААУ	Хөдөө аж, ахуйн үйлдвэрлэл
ХББ	Хагас боловсруулсан бүтээгдэхүүн
ХК	Хувьцаат компани
ХНХ	Хувь нийлүүлэгчдийн хурал
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХҮИ	Хэрэглээний үнийн индекс
ХШЗ	Хянан шалгах зөвлөл
НАССР	Эгзэгтэй цэгийн аюултай байдлыг шинжлэн хянах /Hazard analysis and Critical Control Point/
УМХГ	Улсын Мэргэжлийн Хяналтын Газар
УИХ	Улсын Их Хурал
ҮТЕГ	Үндэсний Татварын Ерөнхий Газар
ҮЦТТТХТ	Үнэт Цаасны Төлбөр Тооцоо Төвлөрсөн Хадгаламжийн Төв
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс



**НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР**

*Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан нэр томъёонууд нь дараах утгыг агуулна.*

Ажлын байр	Ажилчин хүн тодорхой ажилбарыг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай технологийн тоног төхөөрөмж, багаж, нэмэлт хэрэгслээр тоноглогдсон ажиллах орчин
Ам.доллар	Америкийн Нэгдсэн Улсын мөнгөн тэмдэгт
Андеррайтер	Уг үнэт цаасыг олон нийтэд санал болгох ажлыг гүйцэтгэж буй "БиДиСЕК" ХК
AAA	Олон улсын зах зээлд мах, махан бүтээгдэхүүн нийлүүлэх эрх
AA	Дотоодын зах зээл, импортлогч орны эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр тухайн оронд мах, махан бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагаа явуулах эрх
Валютын ханш	Монгол Банкны тухайн өдрийн төгрөгийн бусад валюттай харьцах мөнгөн нэгж
Зуучлагч	Үнэт цаасны зуучлагч андеррайтерийн компани
Технологи ажиллагаа	Аливаа ажил, үйлчилгээний ажилбарыг техникийн шаардлагын дагуу гүйцэтгэх тогтоосон дараалал
Төгрөг	Монгол Улсын мөнгөн тэмдэгт
Үнэт цаас гаргагч	Үнэт цаасаа олон нийтэд санал болгон санхүүжилт татан төвлөрүүлж буй "Жаст Агро" ХХКомпани
ҮЦТТТХТ	Монгол Улсын 100 хувийн төрийн өмчит "Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК
ISO 2000	Энэхүү олон улсын стандарт нь зөвхөн бараа бүтээгдэхүүн бус мөн уг аж ахуйн нэгжийн ажилчдын ур чадварыг сайжруулах, техник технологийн шинэчлэл хийхэд гол баримталдаг стандарт



**ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГА, МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН  
ТАНИЛЦУУЛГА**

**АУДИТЫН КОМПАНИ : “ДАЛАЙВАН АУДИТ” ХХК**



“Далайван аудит” ХХК нь 1993 онд байгуулагдсан бөгөөд аудит, зөвлөх, хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ хийх үйлчилгээг үзүүлдэг компани юм. Тус компани нь 2007 онд нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйлчилгээний дэлхийн томоохон сүлжээ болох Бэйкер Тилли Интернэйшнл-ийн гишүүнээр элссэн байна..

“Жаст Агро” ХХК-д аудит хийсэн аудиторууд:

№	Овог нэр	Мэргэжил, эрдмийн зэрэг цол	Албан тушаал	Ажлын туршлага	Холбоо барих
1.	Цэрэнгаваагийн Жигдэн	Мэргэшсэн Нягтлан Бодогч, Аудитор, Үнэлгээчин	Ерөнхий захирал	Нягтлан бодох бүртгэл, аудитын чиглэлээр 36 жил ажиллаж байгаа	Утас: 976 11-305401 Э-шуудан: info@dalaivanaudit.mn Хаяг: Монгол Улс, Улаанбаатар-210524,
2.	Д. Мэндбаяр	Мэргэшсэн Нягтлан Бодогч, Аудитор	Аудитор	Нягтлан бодох бүртгэл, аудитын чиглэлээр 5 жил ажиллаж байгаа	Баянгол дүүрэг, Амарсанаагийн гудамж-5
3.	А. Сарангэрэл	Мэргэшсэн Нягтлан Бодогч, Татварын Итгэмжлэгдсэн Нягтлан Бодогч	Аудиторын туслах	Нягтлан бодох бүртгэл, аудитын чиглэлээр 6 жил ажиллаж байгаа	Далайван Аудит компанийн байр

**ҮНЭЛГЭЭНИЙ КОМПАНИ: “БҮРТГЭЛ ЭРДЭМ НИЙГЭМЛЭГ” ТББ**

“Жаст Агро” ХХК-д үнэлгээ хийсэн үнэлгээчид:

№	Овог нэр	Мэргэжил, эрдмийн зэрэг цол	Ажлын туршлага	Холбоо барих
1.	Банздайн Сайнжаргал	Эдийн засагч, нягтлан бодогч мэргэжилтэй /Эдийн засгийн ухааны доктор (ph), профессор/	“Говь”, “Петровис”, “Буян”, “Таванбогд”, “Эрэл”, “Жаст” зэрэг компанид хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ хийж байсан	Утас: 976-99169793
2.	Лувсан-Ишийн Мөнх-Очир	Эдийн засагч, нягтлан бодогч мэргэжилтэй /Эдийн засгийн ухааны доктор (ph), профессор/		



*(Handwritten signature)*



**ХУУЛИЙН КОМПАНИ: “АНАНД ЭНД БАТЗАЯА” ХХК**




“Ананд энд Батзаяа” ХХК нь 2003 оноос хойш хууль зүйн зөвлөгөө, өмгөөллийн үйлчилгээг үзүүлж буй компани юм.

Тус хуулийн фирм нь 2010 онд дэлхий даяар 1000 гаруй хуульчидтай, тэргүүлэгч олон улсын хуулийн фирм болох Гибсон, Данн эйнд Кратчэр ХХК /Gibson, Dunn & Crutcher LLP/ -тэй хамтран ажиллахаар харилцан тохиролцож, үйл ажиллагаагаа хамтран явуулж байна.

“Жаст Агро” ХХК-д хуулийн дүгнэлт өгсөн хуульчид:

№	Овог нэр	Мэргэжил, эрдмийн зэрэг цол	Албан тушаал	Ажлын туршлага	Холбоо барих
1.	Бодьхүүгийн Батзаяа	Хуульч, докторант	Гүйцэтгэх Захирал	Хуулийн чиглэлээр 7 жил ажиллаж байгаа	Гар утас (МУ): 976-99110907, 99990564 Гар утас (Олон улс): 852 93332727 И-мэйл: batzaya@anand-advocates.mn, batzaya@yahoo.com
2.	Чулууны Отгонбаатар	Хуульч, Монголын Өмгөөлөгчдийн Холбооны гишүүн	Өмгөөлөгч	Өмгөөлөгч болон хуулийн зөвлөхийн чиглэлээр ажилласан туршлагатай	Гар утас: + 976-99035886. И-мэйл: otgonbaatar@anand-advocates.mn,





**АНДЕРРАЙТЕРЫН КОМПАНИ: “БИДИСЕК” ХК**


“БиДиСЕК” ХК нь Брокер, Андеррайтер, Хөрөнгө оруулалтын зөвлөхийн цогц үйлчилгээг үзүүлэгч, Монголын хөрөнгийн зах зээлээс татан төвлөрүүлсэн нийт хөрөнгийн 60 гаруй хувьд өөрийн үйлчилгээг үзүүлсэн тэргүүлэгч компани.

“Жаст Агро” ХХК-ийн төсөлд ажиллаж буй мэргэжилтнүүд:

№	Овог нэр	Мэргэжил, эрдмийн зэрэг цол	Албан тушаал	Ажлын туршлага	Холбоо барих
1.	Бүрэнмэндийн Лхагвадорж	Бизнесийн удирдлага, Магистр	Тэргүүн дэд захирал	ХЗЗ-д 1997 оноос хойш ажиллаж байгаа	Утас: 976 -323411 Гар утас: 976-99082446 И-мэйл: lkh@bdsec.mn
2.	Буяндэлгэрийн Лхамдолгор	Санхүүгийн менежмент, Бакалавр	Хөрөнгө оруулалтын албаны ахлах мэргэжилтэн	ХЗЗ-д 2006 оноос хойш ажиллаж байгаа	Утас: 976 -11-321763 Гар утас: 976-99010589 И-мэйл: lhamdolgor@bdsec.mn
3.	Ганболдын Мөнхтулга	ОУ-ын менежмент, Бакалавр	Институционал харилцагчийн албаны менежер	ХЗЗ-д 2007 оноос хойш ажиллаж байгаа	Утас: 976 -11-323411 Гар утас: 976-99010539 И-мэйл: mganbold@bdsec.mn
4.	Баттөмөрийн Ганболд	Бизнесийн удирдлага	Хөрөнгө оруулалтын албаны мэргэжилтэн	2008 оноос хойш ажиллаж байгаа	Утас: 976 -11-323411 Гар утас: 976-99012845 И-мэйл: ganbold@bdsec.mn
5.	Баярсайханы Бямбацогт	Нягтлан бодогч, Бакалавр	Санхүүгийн албаны мэргэжилтэн	2010 оноос хойш ажиллаж байгаа	Утас: 976 -11-323411 Гар утас: 976-99057062 И-мэйл: byambatsogt@bdsec.mn
6.	Тогтохсүрэнгийн Отгонцэрэн	ОУ-ын эдийн засаг, Бакалавр	Харилцагчийн албаны мэргэжилтэн	2010 оноос хойш ажиллаж байгаа	Утас: 976 -11-313108 Гар утас: 976-99043165 И-мэйл: otgoo@bdsec.mn



**ШИЙДВЭР ГАРГАЛТАНД ОРОЛЦСОН ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ**

Үнэт цаас гаргагч нь нэг гишүүнтэй бөгөөд эрх барих дээд байгууллага нь өмчлөгч "Жаст групп" ХХК байна.


Овог нэр	Албан тушаал	Хаяг
Шаравламдангийн Батхүү	Ерөнхий захирал	"Жаст групп" ХХК-ийн ерөнхий захирал

**Захирлуудын зөвлөлийн гишүүдийн мэдээлэл**

"Жаст групп" ХХК-ийн Ерөнхий захирлын 2007 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А-161/07 тоот тушаалаар Төртогтохын Содномдаржааг "Жаст Агро" ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар томилсны дагуу Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагаар ажиллаж байна.

Үнэт цаас гаргагч нь 2011 оны 3-р сарын 31-ний өдөр дүрмээ шинэчлэн найруулж, Улсын бүртгэлийн албанд бүртгүүлсэн. Тус дүрмийн 2.3-т компани нь Захирлуудын зөвлөлтэй байна гэж заасан ба захирлуудын зөвлөлийн гишүүдийн товч танилцуулга:

№	Овог нэр	Албан тушаал	Ажлын туршлага	Холбоо барих утас
1.	Т.Содномдаржаа	Гүйцэтгэх захирал	Барилгын салбарт 16 жил, Махны салбарт 30 жил ажилласан.	8811-8370, 9911-8370
2.	Л.Болор	Маркетинг хариуцсан дэд захирал	Жаст групп-д 7 жил ажилласан. Англи, солонгос, орос хэлтэй.	8800-0088
3.	Ч.Баасанжаргал	Санхүү хариуцсан дэд захирал	НББ-ийн багшаар 4 жил, Махны салбарт санхүүгийн чиглэлээр 6 жил ажилласан. Мэргэшсэн нягтлан бодогч	8801-8880, 9906-8880
4.	С.Зориг	Үйлдвэрлэл хариуцсан дэд захирал	Махны салбарт 30 жил ажилласан	8804-0682



**НЭГ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

**1.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТАНИЛЦУУЛГА**

<b>Компанийн оноосон нэр:</b>	“Жаст Агро” ХХК
<b>Байгуулагдсан огноо:</b>	2007 он
<b>Улсын бүртгэлийн дугаар:</b>	9011098074
<b>Регистрийн дугаар:</b>	5138424
<b>Хувьцаа эзэмшигч:</b>	“Жаст групп” ХХК 100 хувийн хувьцаа эзэмшдэг
<b>Үйл ажиллагааны үндсэн чиглэл:</b>	Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хадгалах, худалдах
<b>Үйл ажиллагаа явуулах хугацаа:</b>	Хугацаагүй
<b>Салбар нэгжийн тоо:</b>	Нийт 11 аймаг, орон нутгийг хамарсан мах боловсруулах салбар үйлдвэрүүдтэй

**1.2 КОМПАНИЙН ХАЯГ, ХАРИУЦСАН ЗАХИРАЛ, ХОЛБОО БАРИХ УТАС:**

**Компанийн төв байр:**

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Сонсголон, Мах маркет төв  
 Удирдлага: Т. Содномдаржаа  
 Утас: 976-77329074  
 Факс: 976-11-636277

Вэб сайт: [www.iustgroup.mn](http://www.iustgroup.mn)

Э-мэйл: [info@iustagro.mn](mailto:info@iustagro.mn)

**Орон нутаг дахь салбарууд:**

Баян-Өлгий мах маркет, Баян-Өлгий аймаг, Өлгий сум, 4-р баг  
 Удирдлага: Н.Бейбитхан  
 Утас: 8807-2812

Булган мах маркет, Булган аймаг, Хутаг өндөр сум, 1-р баг, 4-р хороо  
 Удирдлага: Э.Пүрэвлам  
 Утас: 8807-8227

Завхан мах маркет, Завхан аймаг, Тосонцэнгэл сум, Хайрхан баг 9-9  
 Удирдлага: Ч. Алтанцэцэг  
 Утас: 8807-3554

Сүхбаатар мах маркет, Сүхбаатар аймаг, Баруун урт сум, 5-р баг  
 Удирдлага: Л.Ганхуяг  
 Утас: 8800-9801

Увс мах маркет, Увс аймаг, Улаангом сум, 3-р баг  
 Удирдлага: Д.Төмөр-Очир  
 Утас: 8804-0692

Дорнод мах маркет, Дорнод аймаг, Хэрлэн сум, 1-р баг  
 Удирдлага: М.Энхбат  
 Утас: 8804-2150

Хөвсгөл мах маркет, Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг  
 Удирдлага: У.Эрдэнэбаатар  
 Утас: 8804-0877

Багануур мах маркет, Улаанбаатар, Багануур дүүрэг, 3-р хороо  
 Удирдлага: Д.Лувсанцэнд  
 Утас: 8807-0604

Сэлэнгэ мах маркет, Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум, 4-р баг  
 Удирдлага: О.Баатарцогт

Өвөрхангай мах маркет, Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 5-р баг



Утас: 8804-0670

Удирдлага: Ж.Шоовдор  
Утас: 8807-9301

### **1.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТҮҮХ**

Үнэт цаас гаргагч нь мал бэлтгэлийн үйл ажиллагаа явуулж, бэлтгэн нийлүүлэгдсэн малыг үйлдвэрийн аргаар төхөөрөн эцсийн бүтээгдэхүүн болох мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэн дотоодын болон гадаадын зах зээлд борлуулах үйл ажиллагааг эрхэлж байна.

Тус компани нь малыг алс холоос, дундын зуучлагчаар дамжуулан бэлтгэдэг байсан өртөг өндөртэй аргыг халж, 2007 оноос бүсчилэн мал бэлтгэх шинэ аргийг нэвтрүүлсэн.

Өнөөдрийн байдлаар Үнэт цаас гаргагч нь 11 аймаг, орон нутгийг хамарсан хоногт 10710 толгой мал нядлах, 19200 тн мах хадгалах хүчин чадал бүхий бизнесийг бий болгоод байна.

### **Бизнесийн түүх**

2000 онд “Жаст групп” ХХК нь ХАА-н үйлдвэрлэлийн салбарт оролцох талаарх стратегийн шийдвэрийг гарган хөдөө орон нутгаас мал бэлтгэн төхөөрүүлж, мах экспортлож эхэлсэн. Энэхүү үйл ажиллагааг групп доторх бизнесийн салбар хариуцан ажиллаж байв. Өнгөрсөн 10 гаран жилийн хугацаанд энэ салбар нь хөдөө, орон нутагт хэвийн ажиллах боломжгүй, үйл ажиллагаагаа зогсоосон махны үйлдвэрүүдийг худалдан авч, хөрөнгө оруулж, барилга байгууламжуудыг сэргээн засварлан үйлдвэрлэлийн технологи, шугмуудыг шинэчлэн сайжруулан бизнесийн нэг систем болгон нэгтгэсэн. Тухайлбал,


2002 оны 11 дүгээр сард ТӨХ-ны зохион байгуулсан Баянгол дүүргийн 20 дугаар хороонд байрлалтай 10,000 тонны хөргөлттэй агуулахын цогцолборын дуусаагүй барилгыг худалдах дуудлага худалдаанд мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл худалдаа эрхэлдэг 3 аж ахуйн нэгж, нэг иргэн хамтран оролцож /иргэн Ч.Бүрдэмбат, “Эс Жи” ХХК, “Шинэ агро” ХХК болон “Жаст групп” ХХК/, худалдан авсан.

Улмаар 2003 оны 11 дүгээр сард “Мах маркет” ХХК-ийг үүсгэн байгуулж, барилга угсралтын ажлыг гүйцээж, Япон, Бүгд Найрамдах Солонгос Улсаас тоног төхөөрөмж худалдан авч, угсарч суурилуулсанаар үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

“Жаст групп” ХХК нь 2006 оны 02 дугаар сард “Эс Жи” ХХК-ийн эзэмшиж байсан “Мах маркет” ХХК-ийн 30 хувийн хувьцааг худалдан авснаар “Мах маркет” ХХК-ийн нийт хувьцааны 60 хувийг эзэмших болсон.

“Жаст групп” ХХК нь 2007 онд “Шинэ агро” ХХК болон иргэн Ч.Бүрдэмбат нарын эзэмшиж байсан “Мах маркет” ХХК-ийн 40 хувийн хувьцааг худалдан авснаар үнэт цаас гаргагчийг 100 хувь өөрийн өмчлөлд шилжүүлсэн.

2007 оноос эхлэн мал бэлтгэлийн шинэ системийг нэвтрүүлэн малыг малчдаас дундын зуучлагчгүйгээр, хөдөө орон нутгийн салбар үйлдвэрүүд дээр шууд худалдан авах болсон.



2010 онд Олон улсын Эгзэгтэй цэгийн аюулгүй байдлыг шинжлэн хянах НАССР (Hazard Analysis and Critical Control Point) системийг төв үйлдвэрт нэвтрүүлж эхэлснээр бэлтгэж буй махны ариун цэвэр, чанарын баталгааг олон улсад хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд хүргэх болсон.

2011 оны 01 дүгээр сард Төв үйлдвэрийн төмөр замыг ашиглалтанд оруулснаар экспортын ачилт, тээвэрлэлтийг хөнгөн шуурхай болгож чадсан.

**Бизнес дэх хөрөнгө оруулалт**

Үнэт цаас гаргагч нь 2006 оноос үйл ажиллагаагаа өргөжүүлэх, үйлдвэрлэлийн хүчин чадлыг өсгөх, экспортоо нэмэгдүүлэх, мал бэлтгэлийн шинэ тогтолцоог бий болгож, малыг малчдаас дундын зуучлалгүй худалдан авах зорилгоор хөдөө орон нутагт салбар үйлдвэрүүдийг худалдан авч, хөрөнгө оруулалт хийж эхэлсэн.

2006 онд Сүхбаатар мах маркет, 2007 онд Завхан мах маркет, Булган мах маркет, Баян-Өлгий мах маркет, Увс мах маркет, 2008 онд Хөвсгөл мах маркет, Дорнод мах маркет, 2009 онд Багануур мах маркет, Сэлэнгэ мах маркет зэрэг үйлдвэрүүдийг шинэчлэн сайжруулж, өргөтгөсөн.

2010 онд Булган, Завхан, Сүхбаатар мах маркет үйлдвэрүүдийн хөргөлтийн системийг шинэчлэхэд зориулж 962 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн. Үүний үр дүнд хүйтэн үйлдвэрлэлийн хэмжээ хоёр дахин нэмэгдэж, нэг удаагийн бүрэн хүчин чадал 19200 тн-д хүрсэн ба олон улсын хэмжээнд хориглосон пероны хөргөлтийг зогсоосон.

НАССР системийг нэвтрүүлэхтэй холбогдуулан шаардагдах иж бүрэн тоног төхөөрөмжийг худалдан авч суурилуулж, сургалтуудыг хийсэн.

2010 онд Улаанбаатар мах маркет үйлдвэрийн хөргөлттэй агуулахын гуравдугаар давхрын хөргөлтийн системийг шинээр шинэчилсэн. Үүний үр дүнд төв үйлдвэрийн хадгалалтын хүчин чадал 2500 тн-оор нэмэгдэж 7000 тн-д хүрсэн.

2011 оны 10 дугаар сард Өвөрхангай мах маркет үйлдвэрийг ашиглалтанд оруулахаар төлөвлөж ажиллаж байна.



**1.4 ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ**

Манай улсын эдийн засгийн буюу ДНБ-ний 30 орчим хувийг ХАА салбарын үйлдвэрлэл эзэлж байгаагийн дийлэнхийг мал аж ахуйн салбарын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн байна. ДНБ-д ХАА-н үйлдвэрлэлийн эзлэх хувь хэмжээ нь:

- Шилжилт<sup>1</sup>ийн үеийн өмнөх 1981-1992 онуудад дунджаар 17 хувь,
- Шилжилтийн дараах 1992-2000 онуудад 35 хувь,
- 2009-2010 онуудад дунджаар 23.5 хувийг тус тус эзэлж байна.

Сүүлийн 3 жилийн статистикаар хүн амын ажил эрхлэлтийн 40 орчим хувь, гадаад худалдааны 10 гаруй хувийг хөдөө аж ахуйн салбар бүрдүүлж байна. Ажил эрхлэлтийн түвшингээр нь авч үзвэл ХАА-н үйлдвэрлэл манай орны эдийн засгийн суурь хүчин зүйл хэвээр байгаа ба цаашид ч энэ байдал хэвээр хадгалагдана гэж үзэж байна.


ХАА-н үйлдвэрлэлийн дийлэнхийг МАА-н салбар бүрдүүлж байгаа бөгөөд энэ нь мах, ноос, ноолуурын бэлтгэл болно. Мал аж ахуйн салбарын онцлог нь жилийн дөрвөн улирлын туршид бэлчээр, усаа даган нүүдэллэх уламжлалт нүүдлийн аж ахуйд түшиглэдэг. Нүүдлийн уламжлалт арга, зан үйл хэвээр боловч МАА-н үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд малчдаас гадна Засгийн газар, ченж, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд буюу ихэвчлэн банкууд, мал эмнэлгийн байгууллагууд, тээврийн үйлчилгээ үзүүлэгчид, бөөний болон жижиглэнгийн сүлжээ дэлгүүрүүд гэсэн өртөг бүтээгч бус оролцогчидтой. Эдгээр нь малчид ба үйлдвэрлэгч нарт санхүүгийн дарамтыг тодорхой хэмжээнд бий болгодог.

2010 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын хэмжээгээр 32.7 сая толгой мал тоологдож, өмнөх оныхоос 25.7 хувиар буурсан дүнтэй гарчээ. Энэ нь 2010 онд тохиолдсон зуд болон зарим аймгуудад малын гоц халдварт өвчин гарч мал ихээр хорогдсонтой холбоотой юм.

№	Малын төрөл	2007 он	2008 он	2009 он	2010 он
1.	Адуу	2,239.5	2,186.9	2,221.3	1,920.3
2.	Үхэр	2,425.8	2,503.4	2,599.3	2,176.0
3.	Тэмээ	260.6	266.4	277.1	269.6
4.	Хонь	16,990.1	18,362.3	19,274.7	14,480.4
5.	Ямаа	18,347.8	19,969.4	19,651.5	13,883.2
	<b>Нийт</b>	<b>40,263.8</b>	<b>43,288.5</b>	<b>44,023.9</b>	<b>32,729.5</b>

Хүснэгт 1 Малын тоо /Төрөл тус бүрээр/

Эх сурвалж: МУ-н Үндэсний статистикийн хорооны 2007-2010 оны эмхэтгэл



**Монгол улсын мах, махан бүтээгдэхүүний зах зээл**



2010 оны үзүүлэлтээр Монгол улс нэг хүнд ноогдох махны хэрэглээгээрээ дэлхийд 10 дугаарт буюу нэг хүн жилд 108.8 кг мах хэрэглэж байгаа нь дэлхийн дундаж хэрэглээнээс 2.7 дахин их байна.



<sup>1</sup> Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн харилцаанаас чөлөөт зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж байсан хугацаа болно.



*График 1. Дэлхийн улс орнуудын хэрэглээ*  
Эх сурвалж: МУ-н Үндэсний статистикийн хороо, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

**Хэрэглээ:**

Статистикийн Газар болон хоол хүнсний судалгаа хийдэг байгууллагуудаас гаргасан мэдээллээс үзвэл манай улсын мах, махан бүтээгдэхүүний хэрэглээнд малын мах 69.3 хувь, гахайн мах 2.3 хувь, шувууны мах 0.4 хувь, хиам, лаазалсан мах 15 хувь, загас болон далайн гаралтай хүнс 13 хувийг тус тус эзэлдэг байна.




*График 2. Мах, махан бүтээгдэхүүний хэрэглээний бүтэц*  
Эх сурвалж: Нийслэлийн өрхийн амьжиргаа" илтгэл 2010 он

Дээрх мэдээллээс манай улсын хүнсний гол хэрэглээ нь малын гаралтай мах, махан бүтээгдэхүүн болох нь харагдаж байна.

**Нийлүүлэлт:**

Манай улс жилд дундажаар хонин толгойд шилжүүлснээр нийт малын 13-15 хувийг буюу 8 сая орчим толгой мал хүнсэнд хэрэглэж, 230 орчим мянган тонн мах үйлдвэрлэж, дотоодын хэрэгцээнд нийлүүлж байна. ХАА-д үйлдвэрлэсэн нийт махны 10 хүрэхгүй хувь нь мал төхөөрөх үйлдвэрүүдэд бэлтгэгдэж, 23 мянга орчим тонн махыг үйлдвэрийн аргаар боловсруулж байна. Статистик мэдээллээс үзэхэд мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрийн хүчин чадлын 14 хувь болж байна.<sup>2</sup> Мах, махан бүтээгдэхүүний гол нийлүүлэлт нь таван хошуу мал юм. Тухайлбал, нийт ХАА-д бэлтгэн төхөөрч боловсруулсан нийт махны 25-30 хувийг үхрийн, 35-40 хувийг хонины, 10-15 хувийг ямааны, 15-20 орчим хувийг адууны мах эзэлж байна. 2009 онд хийсэн судалгаагаар сүргийн эргэлтээр тооцоход 200-аас дээш мянган тонн мах ХАА-аас бэлтгэх нөөц, бололцоотой гэгдсэн байна.



Эх сурвалж: Нийслэлийн өрхийн амьжиргаа" илтгэл 2010 он

Сүүлийн 5 жилд малын тоо ихээхэн өссөнөөр хүнсэнд хэрэглэх малын нөөц нэмэгдэж мах үйлдвэрлэлийн хэмжээ өсч байна.

Хүнсэнд хэрэглэсэн малын тоог бүтцээр авч үзвэл ямааны арьс, ноолуурын үнийн өсөлттэй холбоотойгоор хүнсэнд хэрэглэж буй ямааны тоо толгой 2003 оноос эхлэн өссөн байна.

<sup>2</sup> Нийслэлийн ХАА-н газрын 2009 оны тайлангаас

ХАА-д бэлтгэн төхөөрч боловсруулсан нийт махны 25-30 хувийг үхрийн, 35-40 хувийг хонины, 10-15 хувийг ямааны, 15-20 орчим хувийг адууны мах эзэлж байна. 2009 онд хийсэн судалгаагаар сүргийн эргэлтээр тооцоход 200-аас дээш мянган тонн мах ХАА-аас бэлтгэх нөөц, бололцоотой гэгдсэн байна.

БҮРТГЭВ  
№ 01

УЛААНБААТАР ХОТ  
МХБ-ийн гишүүн  
Андеррантер  
Брокер, и-н-гийн  
"БИЗНЕС" ХК  
УТД 467-4 2092482



2010 оны байдлаар Мах, махан бүтээгдэхүүний сарын дундаж хэрэглээний улсын дундаж 8.4 кг, Улаанбаатар хотод 6.4 кг, Монгол хүний нэг сарын махны хэрэглээг




График 3. Хүнсэнд бэлтгэсэн малын бүтэц  
Эх сурвалж: МУ-н Үндэсний статистикийн хороо

төдийлэн бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй байгаа юм. Үүний тод илрэл нь жил бүрийн хавар махны нийлүүлэлт буурч, үүнээс улбаатай махны үнийн өсөлт идэвхжиж инфляцийг хөөрөгдөх гол хүчин зүйл болдог явдал юм. Иймд махыг үйлдвэрлэлийн аргаар боловсруулан зориулалтын хөргүүрт, стандартын дагуу хадгалах хүчин чадал, хадгалалтын хугацааг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага зүй ёсоор бий болж байгаа.

**Махны үнэ ба инфляци** /Эх сурвалж: МУ-н Үндэсний статистикийн хороо, Монгол банк/



График 5. Инфляцийн түвшин

Улаанбаатар хотын 2011 оны инфляцийн түвшинг 2010 оны түвшинтэй харьцуулахад 11,7 пунктээр буурсан байна. Инфляцийн бууралтыг бүхэлд нь махны үнэтэй холбон тайлбарлаж болох юм. Инфляцийн бууралтын 90 орчим хувийг зөвхөн мах махан бүтээгдэхүүний барааны бүлэг эзлэж байна.



График 3. Махны үнийн индекс ба ХҮИ

2010 оны 4-р сарын байдлаар инфляцийн түвшин 8 хувиас давахад нөлөөлсөн хамгийн гол үзүүлэлт нь махны үнийн өсөлт байсан. Цас зуд, ган зэрэг байгалийн гамшигт үзэгдэлтэй холбоотойгоор улсын хэмжээгээр 7.5 сая мал хорогдсон нь махны нийлүүлэлтэнд зохих нөлөөгөө үзүүлсэн. Улаанбаатарт нийлүүлэгдэж байгаа махны хэмжээ өмнөх жилүүдээс ойролцоогоор гурав дахин багассан нь махны үнэд сөргөөр нөлөөлсөн.

2006-2010 оны сараар

Stamp: МУ-н Үндэсний статистикийн хороо, БҮРТГЭВ, ТТ49467, 2010.02.22

Signature: [Handwritten signature]

<sup>3</sup> "Нийслэлийн өрхийн амьжиргаа" илтгэл 2010 он



өгөгдсөн махны үнийн индекс болон инфляцийн түвшний хоорондын хамаарал, хандлагыг график 7-д харуулав. Уг графикаар махны үнэ өндөр саруудад инфляцийн түвшин өндөр, бага үед доогуур түвшинд байсан байна. 2008 оны санхүү, эдийн засгийн хямралтай холбоотойгоор инфляци өндөр түвшинд хүрсэн бөгөөд үүнд махны үнээс гадна олон хүчин зүйлс нөлөөлж байсан.

**Махны үнэ**

Махны үнэ 2002 онд дунджаар 1173 төгрөг байсан бол 2010 онд дундаж үнэ 4789 төгрөг хүрч өсчээ.




График 4. Махны үнэ /Жилийн дундаж/

Эх сурвалж: МУ-н Махны холбоо, Үнэт цаас гаргагчийн борлуулалтын мэдээлэл 2003-2010

Махны үнэнд хийсэн хугацааны цувааны /динамик/ бүрэлдэхүүн хэсгийн шинжилгээнээс харахад махны үнэ 12-р сараас 6-р сар хүртэл өсч, 6-р сараас эхлэн 12-р сар хүртэл буурдаг, энэ нь манай улсын байгаль, цаг уурын онцлог болон мал бэлтгэл, махны үйлдвэрлэлийн улирлын шинж чанартай үйл ажиллагааны улмаас хаврын улиралд махны нийлүүлэлт буурдагтай холбоотой.




График 6. Махны үнийн сарын нөлөө





График 5. Махны үнийн чиг хандлага

Махны үнийн чиг хандлага буюу тренд нь жил ирэх тусам өсөх хандлагатай байна.

Эх сурвалж: МУ-н Үндэсний статистикийн хороо, Андеррайтерын компанийн судалгаа

**Нөөцийн мах**

Жил бүрийн хаврын улиралд бий болох махны хомсдолоос гарч, хүн амын мах, махан бүтээгдэхүүний хэрэгцээг жигд тогтвортой хангах арга зам нь махны нөөцийг бүрдүүлэх. Манай улс 2006 оны Засгийн газрын "Махны тогтвортой хангамжийг бүрдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 178-р тогтоолын



дагуу хот, суурин газрын хүн амын хавар, зуны хэрэгцээнд зориулж мах нөөцөлж, махны хангамж, үнийг тогтворжуулах зорилгоор нөөцийг махыг бэлтгэн, бэлтгэсэн аж ахуй нэгжүүдэд "Мах бэлтгэн хадгалж, борлуулсан аж ахуйн нэгжид урамшуулал олгох журам"-ын дагуу урамшуулал олгож байна.

**Нөөцийн мах бэлтгэлийн талаарх зарим статистик**

**2008 онд:** "Мах импекс" ХХК, "Тайж трейд" ХХК, "Монгол мах экспо" ХХК, "Мах экспо" ХХК, "Жаст-Агро" ХХК, "Дорнын говь" ХХК зэрэг компани нийлээд 7000 тонн мах нөөцөлсөн.

**2009 онд:** "Жаст агро" ХХК, "Мах импекс" ХХК, "Дорнын говь" ХХК, "Монгол мах экспо" ХХК, "Тайж трейд" ХХК, "Мах экспорт" ХХК зэрэг компани нийлээд 7000 тонн мах нөөцөлсөн.

**2010 онд:** "Жаст агро" ХХК, "Мах импекс" ХХК, Багахангайн мах боловсруулах үйлдвэр, "Давшилт трейд" ХХК, "Мах экспорт" ХХК, "Монгол мах экспо" ХХК, "Тэнгэр трейд" ХХК, "Баруун монгол интернэйшнл" ХХК, "Соотон" ХХК, "Тайж трейд" ХХК гэсэн том, жижиг 10 компани өөрсдийн хөрөнгөөр 2800 тонн махыг нөөцөлсөн.

Он	Нөөцөлсөн махны хэмжээ /тн/			Нийт	Худалдаалсан байдал /тн/			Нөөцийн махны үнэ /төг/		
	Хонины мах	Ямааны мах	Үхрийн мах		4-р сард	5-р сард	6-р сард	Хонины мах	Ямааны мах	Үхрийн мах
2010	2000 гаруй	700 гаруй		2800	1325	1475		2900	1900	
2009	5000	1400	600	7000	1000	3600	2400	2800	2100	2800
2008				7000	1300 (III)	2500	1500	2900		
2007				3900				2100		
2006	1500	5000	500	7000				2100		


*Хүснэгт 2. Нөөцийн мах*

Эх сурвалж: МУ-н Үндэсний статистикийн хорооны эмхэтгэл 2006-2010, Андеррайтерын компанийн судалгаа

Нийслэлийн хүн амын мах, махан бүтээгдэхүүний нэг өдрийн хэрэглээг тооцвол 186 тонн байна. Хүн амын худалдан авах чадварт суурилан нөөцийн махны хэрэгцээг тоймловол<sup>4</sup> хаврын улиралд нийслэлчүүд нэг өдөрт 7.4 тн мах болно. Судалгаагаар жил бүрийн хавар махны үнийн өсөлтийг сааруулахын тулд нийслэлийн хэмжээнд 11-16 мянган тн мах нөөцлөх шаардлагатай бөгөөд энэ нь нийслэлчүүдийн хувьд 50-80 хоногийн хэрэглээ юм.

2008-2010 онд жилд дунджаар 6-11 аж ахуй нэгж нөөцийн мах бэлтгэлийн ажилд оролцож, нийт дүнгээрээ 6.3 тэрбум төгрөгийн урамшуулал авчээ. 2008 онд нийт 7000 тн бэлтгэсэн байгууллагуудад кг тутам 414 төгрөгийн урамшуулал олгожээ. 2009 онд кг тутамд 340 төгрөгний урамшуулал олгосон бол 2010 онд кг тутамд 500 төгрөгний урамшуулал буюу 2.4 тэрбум төгрөг олгохоор төлөвлөснөөс аж ахуй нэгжүүдэд нөөцийн маханд бэлдсэн махны гүйцэтгэлээс хамаарч 58 хувийг нь олгосон байна.

<sup>4</sup> 2010 оны "Нийслэлийн өрхийн амьжиргаа" илтгэлд өгүүлснээр нийслэлийн нийт хүн амын 29.8 хувь ядуурлын шугмаас доогуур хэрэглээтэй байна гэжээ.



**Гадаад зах зээл ба экспорт**

Монгол Улс нь ОХУ, БНХАУ, БНСВУ-д мах нийлүүлэх гэрээг Засгийн газар хооронд байгуулсан байдаг. 2009 онд 8.8 мянган тн үхрийн мах, 8.6 мянган тн адууны мах гадаадын зах зээлд гаргаж байсан бол 2010 онд 3.9 мянган тн үхрийн мах, 10.9 мянган тн адууны мах экспортолжээ. Экспортлосон үхрийн махны хэмжээ өмнөх оныхоос 55.9 хувиар буурсан. Энэ нь Монголын зүүн бүсийн аймгуудад малын гоц халдварт шүлхий өвчин гарч, ОХУ-аас үхрийн махны импортод хориг тавьсантай холбоотой юм. Харин адууны махны экспорт өмнөх оныхоос 26.5 хувиар өссөн байна.

Малын төрөл	2007 он	2008 он	2009 он	2010 он
Адууны мах	7,072.8	6,097.1	8,635.3	10,925.0
Үхрийн мах	3,846.8	4,210.4	8,818.5	3,888.2
<b>Нийт</b>	<b>10,919.6</b>	<b>10,307.5</b>	<b>17,453.8</b>	<b>14,813.2</b>

Хүснэгт 3 Махны экспорт

**Экспортын хэмжээ /тэрбум төгрөг/**



График 12. Экспортын хэмжээ

Эх сурвалж: МУ-н махны холбоо, Үнэт цаас гаргачийн

“Жаст агро” ХХК, “Соотон” ХХК, “Тэнгэр трейд” ХХК, “Мах импекс” ХК, “Дорнын говь” ХХК, “Мо тува” ХХК, “Бумномин” ХХК, “ЭДГС” ХХК, “Ерранзит” ХХК, “Монгема” ХХК гэсэн 10 компани сүүлийн гурван жил экспортолсон махны 97 хувийг хийж гүйцэтгэсэн байна. Мах импортолдог улс орнуудын эрүүл ахуйн стандарт болон бусад шаардлага, хадгалалт, тээвэрлэлтийн нөхцөл нь



махны экспортыг нэмэгдүүлэхэд гол бэрхшээл болж байна.

ОХУ-ын 142 сая хүн ам бүхий дэлхийд махны импортын хэмжээгээрээ АНУ-ын дараа хоёрдугаарт ордог эдийн засаг өндөр өсөлттэй орон юм. Манай улсын махны экспорт ОХУ-ын импортын 1 орчим хувийг л эзлэж байна.

ОХУ-ын мал эмнэлэгийн газрын статистикаар нэг хүн жилд дунджаар 81 кг мах хэрэглэх шаардлагатай бөгөөд одоогийн байдлаар 62 кг хэрэглэдэг. Эндээс үзэхэд дээрх зах зээл нь 1.2 сая тн тураг махны зах зээл байгаа нь мах үйлдвэрлэгч компаниудын хувьд экспортоо нэмэгдүүлэх боломж буйг харуулж байна.

**Өрсөлдөгчид**

Манай улсад нийтдээ том, жижиг нийлсэн 35 орчим махны үйлдвэр ажиллан, жилд 90 орчим мянган тонн мах, махан бүтээгдэхүүнийг үйлдвэрийн аргаар боловсруулах хүчин чадалтай хэдий ч 20-30 хувийг л ашиглаж, хотуудын махны хэрэглээний 30 орчим хувийг (23 мянган тн) хангаж байна. Энэ байдал нь мах, махан бүтээгдэхүүний ханган нийлүүлэлт үндсэндээ чөлөөтэй дамжин хийгдэж байна гэсэн үг юм. Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн дийлэнх нь мал



бэлтгэх нэгдсэн сүлжээгүй, хот суурин газарт төвлөрсөн, хөргөлтийн тоноглогдсон агуулах байрны багтаамж, хүчин чадал харьцангуй дутмаг байдаг тул бэлэн бүтээгдэхүүн хийж зах зээлд нийлүүлэх илүү сонирхолтой байдаг. Үнэт цаас гаргагч нь одоогоор тураг мах, шулж ангилсан махны борлуулалтаар илүү дагнаж байгаа тул дотоодын мах үйлдвэрлэгчдийн зүгээс үзүүлэх дарамт бага гэж үзэж байна.

2010 оны байдлаар мах, махан бүтээгдэхүүн боловсруулах 70 орчим үйлдвэр үйл ажиллагаа явуулж байгаагаас 50 орчим нь Улаанбаатар хотод байрладаг байна. Эдгээр үйлдвэрүүдийн бүтээгдэхүүнийг дараах байдлаар бүлэглэж болохоор байна. Үүнд:

- Тураг мах /гулууз, мөчилсөн, цул, ястай/
- Дайвар бүтээгдэхүүн
- Ангилсан мах /булчингийн бүтцээр жижиглэж савласан/
- Хиам, зайдас
- Лаазалсан бүтээгдэхүүн/консерв, үхэр, адууны жигнэсэн мах/
- Хагас боловсруулсан ба бэлэн бүтээгдэхүүн гэсэн ерөнхий ангилалд багтааж байна.

Эдгээрээс тураг махны борлуулалт хамгийн их хувийг эзэлдэг нь хэрэглэгчид ихээр худалдан авдагтай холбоотой.

Тиймээс үйлдвэрүүд тураг мах экспортод гаргахаас гадна нийт бэлтгэсэн махны 10 хүрэхгүй хувийг эзэлдэг ангилсан мах, хиам, консерв, хагас боловсруулсан бэлэн бүтээгдэхүүний зах зээл дээр өрсөлдөж байна.

Үнэт цаас гаргагч нь бусад мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг өрсөлдөгчид гэж шууд үзэж болохгүй. Учир нь компанийн үйлдвэрлэлийн гол зорилго тураг мах үйлдвэрлэх, түүний дийлэнхийг экспортод гаргах юм.

### 1.5 МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСАГ БА ЗАСГИЙН ГАЗРЫН БОДЛОГО

2010 оны урьдчилсан байдлаар ДНБ-ий өсөлт өмнөх онд төлөвлөснөөс давсан бөгөөд эдийн засгийн өсөлт болон бүтцэд уул уурхайн салбарын үйлдвэрлэл давамгайл байна. ДНБ ба ХАА-ийн 1990 оноос хойшхи динамик өөрчлөлтийг графикаар харуулъя.



График 13. ДНБ ба ХАА

Эх сурвалж: МУ-н Үндэсний статистикийн хороо



Графикуудаас харахад ХААҮ-ийн хэмжээ 2001 оноос хойш өсөлттэй байгаа ч ДНБ-ий өсөлт болон түүнд эзлэх хувийн жин байнга буурсан байна.




График 7. ХААҮ-ийн динамик, сая төгрөг

Эх сурвалж: МУ-ын Үндэсний статистикийн хороо

Эдгээр график дүрслэл нь Засгийн газар ХААҮ-ийг хөгжүүлэхэд ихээхэн анхаарч дэмжих шаардлага буй болсныг харуулна. Иргэдийн мөнгөн хадгаламжийн хүү буурсан ч зээлийн хүүгийн хувь хэмжээ дорвитой буурахгүй байгаа нь банк, санхүүгийн байгууллагууд өртөг өндөртэй эх үүсвэрээс аль болохоор зайлсхийж байгаа, үүний цаана хөрөнгө, мөнгөний

хуваарилалтын тэнцвэртэй байдал алдагдаж буй харуулж байна.

Эдийн засгийн бүтэц өөрчлөгдөж, уул, уурхайн үйлдвэрлэлийн хүчин зүйлийн нөлөө өсөн нэмэгдэж байна.

Хот хөдөөгийн ялгаа улам бүр ихэсч байгаа нь иргэдийн хот суурин газар луу шилжих хөдөлгөөнийг нэмэгдүүлж, ажилгүйдэл, ядуурал нэмэгдэх үндэс суурийг өргөжүүлж байна.

Хүн амын хүнсний бүтээгдэхүүний чанар, стандарт гэхээсээ илүүтэйгээр хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдал, хүрэлцээнд нэн тэргүүнд анхаарах шаардлагатай болж байна.

**Засгийн газрын үйл ажиллагаа**

- Ажлын байрыг нэмэгдүүлэх, мэргэшилтэй ажиллагсдыг бэлтгэх талаар анхаарч зарим нэг алхмыг хийж байна.
- Хүнсний хангамжинд Засгийн газрын нэгдсэн бодлого хэрэгжүүлэн нөөцийн мах бэлтгэх, махны үйлдвэрлэлийг НӨАТ-аас чөлөөлсөн зэрэг арга хэмжээг авч байна.
- Уул уурхайн салбарын хөгжил эрчимжиж байгаа өнөө үед эдийн засгийн бүтцийн тэнцвэрт харьцааг хэрхэн хадгалах талаар анхаарч эхэлсэн зэрэг нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлж байна.




**1.6 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

“Жаст Агро” ХХК нь Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу байгуулагдаж, үйл ажиллагаагаа явуулж буй хуулийн этгээд юм. Тус компани нь “Жаст групп” ХХК-ийн 100 хувийн хөрөнгө оруулалттай охин компани бөгөөд компанийн эрх барих дээд удирдлага нь “Жаст групп” ХХК-ийн Ерөнхий захирал байна.

“Жаст групп” ХХК нь нэг хүний өмчлөлтэй компани бөгөөд компанийн хувь нийлүүлэгч нь Монгол Улсын иргэн Ш.Батхүү юм.

**Компанийн бүтэц зохион байгуулалт**




Зураг 1.Бүтэц зохион байгуулалт

**1.7 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТОЛГОЙ БОЛОН ОХИН КОМПАНИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ**

Үнэт цаас гаргагчийн 100 хувийн хувьцааг эзэмшигч толгой компани нь Монгол Улсын хуулийн этгээд болох “Жаст групп” ХХК болно. “Жаст групп” ХХК-ийн өөрийн хөрөнгө нь 2 014 000 000 /хоёр тэрбум арван дөрвөн сая/ төгрөг.

“Жаст групп” ХХК нь 1999 онд Газрын тосны бүтээгдэхүүний худалдааны чиглэлээр үйл ажиллагаагаа эхэлсэн бөгөөд 2000 оноос хөдөө аж ахуйн салбарт, 2006 оноос барилга болон олон улсын худалдааны салбаруудад ажиллаж байна.

2009 онд уул уурхай болон банк, санхүүгийн салбарт томоохон хөрөнгө оруулалтыг хийснээр эдгээр чиглэлд идэвхитэй үйл ажиллагааг эрхлэн явуулж байна. 2010 онд ОХУ-ын Москва хот, БНХАУ-ын Бээжин хотноо өөрийн төлөөлөгчийн газрыг нээсэн байна.



**“Жаст групп” ХХК-ийн бизнесийн салбаруудад ажиллаж байгаа компаниуд:**

- |                                    |                          |
|------------------------------------|--------------------------|
| Хөдөө аж ахуйн салбар              | - “Жаст Агро” ХХК        |
| Газрын тосны бүтээгдэхүүний салбар | - “Жаст Ойл” ХХК         |
| Банк, санхүүгийн салбар            | - Хадгаламж банк         |
| Барилгын салбар                    | - “Эрд тана” ХХК         |
| Уул уурхайн салбар                 | - “Олон овоот гоулд” ХХК |
| Олон улсын худалдааны салбар       | - “Маркентайл хаус” ХХК  |





График 8. Жаст группын борлуулалтын орлого /тэрбум ₮/

График 16. Борлуулалтын орлогын бүтэц /Охин компаниар/

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн толгой компанийн борлуулалтын мэдээ 2010

**“Жаст Ойл” ХХК**

“Жаст групп”-ийн анхдагч бизнес болох газрын тосны бүтээгдэхүүний үйл ажиллагааг эрхлэгч “Жаст Ойл” ХХК нь 1999 онд байгуулагдсан. Тус компани газрын тосны бүтээгдэхүүний 4 агуулах, Улаанбаатар хот болон 16 аймагт байрлах 41 шатахуун түгээх станцын өргөн цар хүрээтэй сүлжээ бүхий Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүний томоохон импортлогч компанийн нэг юм.

**Холбоо барих:**


Улаанбаатар 14191, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 42, Монголын Залуучуудын Холбооны байр, Утас/Факс: 314014, 318261, И-мэйл: oil@justgroup.mn, Вэб: www.justgroup.mn

**“Хадгаламж банк”**

Тус банк нь орон сууц, нийтийн аж ахуй, тэтгэвэр тэтгэмж, хадгаламжийн үйлчилгээг 1940-өөд оноос үзүүлж ирсэн “Хадгаламжийн касс”-ын суурин дээр байгуулагдсан бөгөөд 1996 онд төрийн өмчит компани болсон.

2009 оны 4 дүгээр сараас банкны удирдлагад “Жаст групп”-ын бодлогыг хэрэгжүүлж эхэлснээр хэтийн зорилго, үзэл баримтлалаа цор цориндоо тодорхойлон, үйл ажиллагааныхаа цар хүрээг эрс өргөжүүлэн ажиллаж байна.

Хадгаламж банк нь 2010 онд Монгол шуудан банкныг өөртөө нэгтгэснээр банкны активын хэмжээ 2 дахин нэмэгдсэн ба 2010 оны жилийн эцсийн байдлаар нийт актив 442.7 тэрбум төгрөг байна. Банкууд нэгдсэнээр банкны орон нутаг дахь салбар нэгжүүдийн тоо 320-д хүрч, Монгол орны аймаг, сум бүрт хүрч үйлчилж чадах банкны сүлжээг бий болгосон.



**Холбоо барих:**

Улаанбаатар 15160, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Холбоочдын гудамж-4, Хадгаламж банкны төв байр, Утас/Факс: 70115566, 327467, И-мэйл: bank@savingsbank.mn, Вэб: www.savingsbank.mn

**“Эрд тана” ХХК**

“Эрд тана” ХХК нь 2004 онд байгуулагдсан бөгөөд барилгын салбарт үйл ажиллагаагаа явуулж байна. Тус компани Нийслэлийн Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт 10 давхар 2 барилга, 15 давхар 3 барилга бүхий орон сууцны томоохон цогцолборын барьж эхлүүлэн 2010 оны 12 дугаар сард дуусган бүрэн ашиглалтанд оруулсан.

**Холбоо барих:**

Улаанбаатар 13335, Баянзүрх дүүрэг, 14-р хороо, Зүүн дөрвөн зам худалдааны төвийн байр, Утас/Факс: 456562, И-мэйл: erdtana@justgroup.mn, Вэб: www.justgroup.mn

**“Олон овоот гоулд” ХХК**

“Олон Овоот гоулд” ХХК нь 2009 оны 6-р сараас эхлэн Олон Овоотын алтны үндсэн ордын ашиглалтын үйл ажиллагааг явуулж байна. Олон Овоотын алтны үндсэн орд нь Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын нутаг дэвсгэрт газар зүйн хувьд Ханын Хэцийн өргөгдөлд Улаанбаатар хотоос 500 км, Өмнөговь аймгийн төв Даланзадгад хотоос 100 км, Мандал-Овоо сумын төвөөс 45 км, Баянхошуу багийн төвд байрладаг.

**Холбоо барих:**

Улаанбаатар 14191, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 42, Монголын Залуучуудын Холбооны байр, Утас/Факс: 329074, 55252490, И-мэйл: info@olonovootgold.mn, Вэб: www.justgroup.mn

**“Меркентайл хаус” ХХК**

Тус компани “Жаст групп” ХХК-ийн үйлдвэрлэж буй одоогийн бүтээгдэхүүн болон ирээдүйд үйлдвэрлэх бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээл дээр гаргах үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд эрхлэх хүрээнд 2008 онд байгуулагдсан.

Ингэснээр “Меркентайл хаус” ХХК нь Монголд үйлдвэрлэгдэж буй уул, уурхайн бүтээгдэхүүнүүдийг дэлхийн зах зээл дээр худалдаалах үйл ажиллагааг эрхэлсэн Монголын анхны компани болсон юм.

**Холбоо барих:**

Улаанбаатар 14191, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 42, Монголын Залуучуудын Холбооны байр, Утас/Факс: 318261, 315612, И-мэйл: finance@justgroup.mn, Вэб: www.justgroup.mn

**“Хатан суман” ХХК**

Тус компани нь 2010 онд байгуулагдсан бөгөөд гадаад худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. “Хатан суман” ХХК-ийг “Жаст Агро” ХХК нь 100 хувь эзэмшдэг.

**Холбоо барих:**

Улаанбаатар, Баянгол дүүрэг, 20-р хороо, Сансголон, “Жаст Агро” ХХК-ийн байр Утас: 636277,





**1.8 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУДЫН МЭДЭЭЛЭЛ**

Үнэт цаас гаргагч компанийн дүрмийн 2.1-т зааснаар эрх барих дээд удирдлага нь "Жаст групп" ХХК байна.

№	Овог нэр	Албан тушаал	Ажлын туршлага
1.	Шаравламдангийн Батхүү	Ерөнхий захирал	1990-1992 онд Статистикийн төв газар статистикч, эдийн засагч, 1992-1994 онд УБ хотын гүйцэтгэх захиргаанд мэргэжилтэн, 1994-1996 онд "MCS" ХХК-д Дэд захирал, 1996-1999 онд "Жамп" ХХК-д Дэд захирал, 1999 оноос өнөөг хүртэл "Жаст групп" ХХК-ийн Ерөнхий захирлаар ажиллаж байна.

Хүснэгт 4 Албан тушаалтнуудын мэдээлэл

**Захирлуудын зөвлөл**

"Жаст групп" ХХК-ийн Ерөнхий захирлын 2007 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А-161/07 тоот тушаалаар Төртогтохын Содномдаржааг "Жаст Агро" ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар томилсноор Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагаар ажиллаж байна.

Үнэт цаас гаргагч нь 2011 оны 3-р сарын 31-ний өдөр дүрмээ шинэчлэн найруулж, Улсын бүртгэлийн албанд бүртгүүлсэн. Тус дүрмийн 2.3-т компани нь Захирлуудын зөвлөлтэй байна гэж заасан ба захирлуудын зөвлөлийн гишүүдийн товч танилцуулга:

№	Овог нэр	Албан тушаал	Ажлын туршлага	Холбоо барих утас
1.	Т.Содномдаржаа	Гүйцэтгэх захирал	Барилгын салбарт 16 жил, Махны салбарт 30 жил ажилласан.	8811-8370, 9911-8370
2.	Л.Болор	Маркетинг хариуцсан дэд захирал	Жаст групп-д 7 жил ажилласан. Англи, солонгос, орос хэлтэй.	8800-0088
3.	Ч.Баасанжаргал	Санхүү хариуцсан дэд захирал	НББ-ийн багшаар 4 жил, Махны салбарт санхүүгийн чиглэлээр 6 жил ажилласан. Мэргэшсэн нягтлан бодогч	8801-8880, 9906-8880
4.	С.Зориг	Үйлдвэрлэл хариуцсан дэд захирал	Махны салбарт 30 жил ажилласан.	8804-0682


Хүснэгт 5: Захирлуудын зөвлөл



Компанийн тухай хуулийн 81-р зүйл, компанийн дүрмийн 3.1-д заасны дагуу гүйцэтгэх захирал, тэргүүн дэд захирал, дэд захирал, албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий эдийн засагч зэрэг албан тушаал эрхэлдэг этгээдийг эрх бүхий албан тушаалтанд тооцно.

**Бусад эрх бүхий албан тушаалтны мэдээлэл**

№	Овог нэр	Албан тушаал	Ажлын туршлага
1	С.Бүүвэйбаатар	Ерөнхий ня-бо	Эрдэнэт прогресс ХХК-ийн махны үйлдвэрт 5 жил, Жаст Агро ХХК-д 3 жил ажилласан
2	О.Нэмэхбаяр	Эдийн засагч	МУИС төгсөөд ажиллаж эхэлсэн.
3	Г.Баярсайхан	Техникийн албаны дарга	Хөргөлтийн чиглэлээр 17 жил ажилласан.
4	Д.Эрдэнэчимэг	Чанар, ариун цэврийн албаны дарга	Ажлын туршлага 31 жил, Махны салбарт 5 жил ажилласан.
5	Б.Дорждулам	Хүний нөөц, захиргааны албаны дарга	Жаст групп-д 6 жил ажилласан.
6	Д.Лувсанцэнд	Багануур Мах Маркет үйлдвэрийн дарга	Махны салбарт 25 жил ажилласан
7	Н.Бейбитхан	Баян-Өлгий Мах Маркет үйлдвэрийн дарга	Ажлын туршлага 30 жил, Махны салбарт 5 жил ажилласан.
8	Э.Пүрэвлхам	Булган Мах Маркет үйлдвэрийн дарга	Махны салбарт 9 жил ажилласан
9	М.Энхбат	Дорнод Мах Маркет үйлдвэрийн дарга	Ажлын туршлага 14 жил, Махны салбарт 1 жил ажилласан.
10	Д.Төмөр-Очир	Увс Мах Маркет үйлдвэрийн дарга	Махны салбарт 3 жил ажилласан
11	Ж.Шоовдор	Өвөрхангай Мах Маркет үйлдвэрийн дарга	Ажлын туршлага 38 жил, Махны салбарт 2 жил ажилласан.
12	Ч.Алтанцэцэг	Завхан Мах Маркет үйлдвэрийн дарга	Махны салбарт 3 жил ажилласан
13	Л.Ганхуяг	Сүхбаатар Мах Маркет үйлдвэрийн дарга	Ажлын туршлага 23 жил, Махны салбарт 7 жил ажилласан.
14	О.Баатарцогт	Сэлэнгэ Мах Маркет үйлдвэрийн дарга	Махны салбарт 6 жил ажилласан
15	У.Эрдэнэбаатар	Хөвсгөл Мах Маркет	Махны салбарт 2 жил



үйлдвэрийн дарга

ажилласан

*Хүснэгт 6 Бусад эрх бүхий албан тушаалтнуудын мэдээлэл***1.9 АЖИЛТАН АЛБАН ХААГЧДЫН МЭДЭЭЛЭЛ**


“Жаст Агро” ХХК 2010 онд 253 үндсэн ажилтан, 573 гэрээт ажилчидтайгаар үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс төв үйлдвэрт үндсэн 125, гэрээт буюу нядалгааны үеэр түр ажилтан 16, бусад нь орон нутгийн үйлдвэрүүдэд ажилладаг. Орон нутгийн үйлдвэрүүдэд үндсэн ажилтан “Баян-Өлгий Мах Маркет” салбарт 13, “Сүхбаатар Мах Маркет” салбарт 13, “Булган Мах Маркет” салбарт 14, “Завхан Мах Маркет” салбарт 15, “Увс Мах Маркет” салбарт 10, “Дорнод Мах Маркет” 10, “Хөвсгөл Мах Маркет” салбарт 16, “Багануур Мах Маркет” 15, “Сэлэнгэ Мах маркет” салбарт 11, “Өвөрхангай Мах маркет” салбарт 9 мэргэжилтэн тус тус ажиллаж байна.

Нийт ажиллагсдын 65 хувь нь эрэгтэй, 35 хувь нь эмэгтэй, үүнээс орон нутгийн үйлдвэрийн ажилчдын 84 хувь нь эрэгтэй, 16 хувь нь эмэгтэй байна. Насны бүлгээр нь авч үзвэл 45 хувь нь 36 хүртэлх насны залуучууд, 28 хувь 35-45 насны, үлдсэн 27 хувь нь 45-аас дээш насны ахмад туршлагатай ажилчид ажиллаж байна. Өөрөөр хэлбэл үйлдвэрийн үйл ажиллагааг гурван үеийн ажилчид авч яваа гэж хэлж болно.

Эдгээр ажилчдын 32 хувь нь бакалавр болон түүнээс дээш боловсролтой удирдах ажилтнууд, 40 хувь нь техник, технологийн тусгай мэргэжлийн ажилчид, үлдсэн 28 хувь нь дунд боловсролтой ажилчид ажиллаж байна. Үүнээс техникийн мэргэжлийн ажилчид 22 хувь, МАА, махны мэргэжилтнүүд 15 хувийг бүрдүүлж байна.

Ажилчдынхаа сургалтын бодит хэрэгцээг тодорхойлж, шинэ ажилчдаа сургалтанд хамруулахын зэрэгцээ жил бүр сургалтын төлөвлөгөө боловсруулан, сургалт хөгжлийн журмын дагуу сургалт зохион байгуулдаг.

Компани үндсэн ажилчдаа сургах, дадлагажуулж, мэргэшүүлэхээс гадна гэрээт ажилчдынхаа нийгмийн байдал, дадлага, чадварт анхаарал хандуулан ажиллаж байна. Орон нутгийн үйлдвэрүүдийн үйл ажиллагааг явуулдаг хүний нөөц нь гэрээт ажилчид тул тэднийг чадваржуулснаар түүхий эдийн технологи, чанар сайжрах юм. Иймд тэдгээр ажилчдыг ажлын үеэр урамшуулах, сайшаах, дадлагажуулах ажлыг орон нутгийн үйлдвэрүүд дээр анхаарч ажиллаж байна.



**1.10 САЛБАРУУДЫН БАЙРШИЛ, ХҮЧИН ЧАДАЛ**

Үнэт цаас гаргагч нь ХАА-н салбарт үйл ажиллагаагаа явуулж байгаа тэргүүлэгч компанийн нэг бөгөөд нэг удаад 10 мянга гаруй толгой мал бэлтгэн төхөөрч, 19.2 мянган тонн мах хөргөн хөлдөөх аммиакан хөргөлт бүхий хөдөө орон нутгийг хамарсан 11 салбар үйлдвэр, борлуулалтын цэгүүдтэй мал бэлтгэл, мах үйлдвэрлэл, борлуулалтын нэгдсэн цогц тогтолцоо бүхий сүлжээг бий болгон ажиллаж байна.




*Зураг 2 Сүлжээ үйлдвэрүүдийн байршил*

“Жаст групп” ХХК нь 2002 оноос ХАА-н салбарт урт хугацааны хөрөнгө оруулалтын нэгдмэл бодлогын хүрээнд мах бэлтгэх, боловсруулах үйлдвэрүүдийн техник, технологийн шинэчлэлтийг ээлж дараатайгаар хийсний үр дүнд Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын хэмжээнд мал бэлтгэлийн 32.3 хувь (41634 толгой мал бэлтгэсэн), үйлдвэрийн аргаар мал төхөөрөх хүчин чадлын 26 хувь (нэг удаадаа бод-1810, бог-8900 толгой), мах махан бүтээгдэхүүн хадгалах хүчин чадлын 30 (19200 тн), махны экспортын 22.8 (2010 оны байдлаар 4518.9 тн-ыг экспортлосон) хувийг дангаараа хангах болсон. Нийслэлийн хэмжээнд худалдаалагддаг улсын нөөцийн мах болон экспортын мах, махан бүтээгдэхүүний 1/3-ийг (2010 оны байдлаар 6918.9 тн мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэж борлуулсан) дангаараа хангаж байна.

Малыг малчдаас дундын зуучлалгүйгээр орон нутгийн үйлдвэрүүд дээр шууд худалдан авч, мал хүлээж авах хугацааг тухайн оны 12 сар хүртэл уртасгаж, орон нутгийн онцлог болон зах зээлийн байдлыг харгалзан үнийн уян хатан бодлого баримтлан ажилласнаар мал бэлтгэлийн тоо, махны гарцийг нэмэгдүүлсэн. Махны гарц нэмэгдэх нь мал бэлтгэлийн үнийн өсөлтийг тодорхой хэмжээнд нөхөх, нэг кг махыг боловсруулахад гарах зардлыг багасгасан нь компанийн ашигт ажиллагаанд эерэгээр нөлөөлж байна.

2011 он 7 сар 26 өдөр  
БҮРТГЭВ  
№01

УЛААНБААТАР ХОТ  
МХБ-ийн гишүүн  
Ан.террантер  
Брокер, ил.терийн  
“БИДИСЭХ”  
ХК  
ТТ44467-205246



*Handwritten signature in blue ink.*

**Үйлдвэрүүдийн хүчин чадал**

Үйлдвэрийн нэр	Хоногт нядлах хүчин чадал (тоо, толгой)		Хөргөлтийн хүчин чадал (тн)	Гүн хөлдөөлтийн хүчин чадал (хоног/тн)
	Бод	Бог		
1 Улаанбаатар Мах маркет	-	1,000	7,000	20
2 Баян-Өлгий Мах маркет	120	800	1,000	20
3 Булган Мах маркет	120	700	500	20
4 Завхан Мах маркет	120	-	500	15
5 Сүхбаатар Мах маркет	120	800	750	20
6 Увс Мах маркет	80	400	250	15
7 Дорнод Мах маркет	200	1,600	3,000	60
8 Хөвсгөл Мах маркет	200	500	1,000	40
9 Багануур Мах маркет	300	1,000	1,200	40
10 Сэлэнгэ Мах маркет	350	1,600	3,000	40
11 Өвөрхангай Мах маркет	200	500	1,000	/дуусаагүй/
<b>Нийт</b>	<b>1,810</b>	<b>8,900</b>	<b>19,200</b>	<b>290</b>

Хүснэгт 7. Үйлдвэрүүдийн хүчин чадал

**Технологийн шинэчлэл**

Үнэт цаас гаргагч нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, техник, технологийн шинэчлэлтийг "Жаст групп" ХХК-ийн бүрэн дэмжлэг, санхүүжилтаар 2006-2010 оны хооронд нийт дүнгээрээ 28.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт ба шинэчлэлтийг хийсэн.

Үзүүлэлт	2006	2007	2008	2009	2010	Нийт
Үйлдвэр	89.8	1,940.0	1,264.9	6,659.9	285.2	10,239.9
Үйлдвэрийг шинэчлэн засварлах	109.4	195.8	703.7	96.9	520.4	1,626.2
Үйлдвэрлийн өргөтгөл	48.8	189.0	485.5	19.9	-	743.2
Тоног төхөөрөмж худалдан авалт, угсралт	36.8	418.9	524.0	1,138.4	2,105.7	4,223.8
Үндсэн хөрөнгө худалдан авалт	-	474.3	160.3	12.0	4.1	650.7
Төв үйлдвэр	-	6,786.1	3,554.3	-	-	10,340.3
Зам, байгууламж	2.6	-	-	71.0	340.1	413.7
<b>Нийт дүн</b>	<b>287.4</b>	<b>10,004.2</b>	<b>6,692.7</b>	<b>7,998.1</b>	<b>3,255.5</b>	<b>28,237.8</b>

Хүснэгт 8. Компанийн хөрөнгө оруулалтын хэмжээ




СЭХ  
2011 он 7 сар 06  
БҮРТГЭВ  
№ 01

УЛААНБААТАР ХОТ  
ИХБ-ийн гишүүн  
Андерраагтер  
Брокер, интерни  
"ИХБ-СЕК"  
ХХК  
ТТХ 1467-4-2052452



1.11 ҮЙЛДВЭРЛЭЛ, ЧАНАРЫН ХЯНАЛТ

Үйлдвэрлэлийн процесс




Схем 1. Үйлдвэрийн процесс

Үнэт цаас гаргагчийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үе шат, дамжлага тус бүрд үйл ажиллагааны болон боловсруулалтын технологийн зааварчилгааг нь Олон улсын чанар, стандартын шаардлагад нийцүүлэн ажилладаг. Учир нь махны салбар хүнсний хэрэглээний гол бүтээгдэхүүн бөгөөд эрүүл ахуй, чанарын нарийн хяналт, технологийн чанд хатуу горимыг шаарддаг.

**Үйлдвэрийн үйл ажиллагааны технологийн горимууд:**

1. Мал бэлтгэлийн технологи	Туувраар ирсэн малыг тусгаарлан бактерилогийн болон серологийн шинжилгээнд оруулан, өвчтэй мал ямар ч тохиолдолд бэлтгэхгүй байх шаардлагыг мөрдөн ажилладаг.
2. Нядалгааны технологи	Малыг нядлахын өмнө 36 цаг амрааж, малын мах нядалгааны явцад хатуурч, чанар муудахгүй байх технологийг мөрдөж ажиллана. Нядалгааг стандартын зориулалтын шугам, ариун цэврийн шаардлага хангасан орчинд технологийн дагуу гүйцэтгэн нядалгааг гүйцэтгэж буй ажиллагсдын ариун цэвэр, эрүүл мэндийн шаардлагыг хангасан стандарт гарган мөрдүүлснээр нядалгааны явцын тураг махны чанарыг хангуулж байна..
3. Сэврээлтийн технологи	Нядалгаанаас гарсан тураг махыг хасах 4 хэмийн хүйтэнд сэврээж халуун махны гадаргууд тогтсон хүчлийг зайлуулна. Махыг 24 цаг сэврээж, зөөлрүүлэх арга техникийг стандартын дагуу гүйцэтгэнэ.
4. Шуулалгааны технологи	Шуулалгааны технологийн ариун цэврийн байдалд өндөр стандартыг тогтоох бөгөөд шал, хана, тааз нь аливаа химийн бодис агуулагдаагүй, дулаан, хүйтэн



	нэвтрүүлдэггүй материалаар хийгдсэн байх ба шалан дээр унасан хаягдал нь бохирын шугамаар гадагш автоматаар зайлуулагддаг, хэрэглээнд ордоггүй байна. Шулалгааг гүйцэтгэж буй ажиллагсадын эрүүл мэнд, ариун цэврийн стандартыг мөрдүүлж ажиллана.
5. <i>Хөлдөөлтийн технологи</i>	Тураг болон шулсан махыг хасах 40 хэмээс доошгүй температурт гүн хөлдөөж, түүний шинэлэг байдлыг борлуулах үе шат хүртэл хадгалах боломжийг хангуулна. Ингэснээр мах харлах, чанараа алдах байдал "Мах маркет" брэндийн мах, махан бүтээгдэхүүнд огт гарахгүй байх ёстой.
6. <i>Хадгалалтын технологи</i>	Мах, махан бүтээгдэхүүнийг хасах 14 хэмээс доошгүй температурт хадгалах стандартыг мөрдүүлнэ.
7. <i>Тээвэрлэлтийн технологи</i>	Мах, махан бүтээгдэхүүний тээвэрлэлтийг зориулалтын сав, хэрэгслээр гүйцэтгэж, тээвэрлэлтийн явцад бүтээгдэхүүн гэмтэх, бохирдох, хорогдох байдал гаргуулахгүй байх стандартыг мөрдүүлнэ.
8. <i>Савлалт, түгээлтийн технологи</i>	Мах, махан бүтээгдэхүүнийг хэрэглэгчийн худалдан авах хүсэл, сонирхолд нийцсэн хэмжээгээр савлаж бэлтгэнэ. Сав, баглаа боодлын тусгай стандартын горимыг мөрдөж ажиллана. Савласан бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд түгээх борлуулалтын сүлжээг оновчтой зохион байгуулна.
9. <i>Байгаль орчинд хор нөлөөгүй байх</i>	Үйлдвэрээс гарч буй хог хаягдлыг зайлуулах, бохирын төвлөрсөн байгууламжид хийж байх техник, технологийн горимыг мөрдүүлж ажиллана. Аммиакан хөргөлтөт хөргүүрийн системийг хэрэглэх бөгөөд тэдгээрийн аюулгүй ажиллагааны зохион байгуулалтыг дээд зэргээр хангуулсан байна.

*Хүснэгт 9. Үйлдвэрийн үйл ажиллагааны технологийн горим*

Мал бэлтгэл, махны үйлдвэрлэлийн үйл ажиллагааг бүдүүвчээр дүрслэн харуулвал,




А. *Бусад махны үйлдвэрлэгчдийн үйл ажиллагааны схем :*



*Схем 2. Ердийн махны үйлдвэрийн үйл ажиллагааны схем*

Б. *Мах маркет үйлдвэрийн үйл ажиллагааны схем :*

Үнэт цаас гаргагчийн салбар үйлдвэрүүдийн үйл ажиллагааны цар хүрээ нь ойр орчмын 200 км-ийн радиус бүхий тойрог дахь орон нутгийн малчдыг хамарсан байдлаар зохион байгуулагдсан.






Схем 3. Үнэт цаас гаргагчийн махны үйлдвэрийн үйл ажиллагааны схем

Үнэт цаас гаргагч нь мал бэлтгэлийн шинэ системийг 2007 оноос эхлэн нэвтрүүлж эхэлсэн ба ингэснээр малчдад илүү ойртон малын алсын тууврын зайг багасгасны дүнд жингийн алдагдал багасгах, малчин үйлдвэр хоёрын хооронд махны ченжийн дамжлагыг арилгаснаар мал бэлтгэлийн үнийн хөөрөгдлийг бууруулах хэрэглэгчдэд эрүүл ахуйн шаардлага хангасан чанартай махыг бэлтгэн нийлүүлэх, малчдад 7-р сараас 12-р сар хүртэлх хугацааны турш боломжтой цагтаа малаа зах зээлийн үнээр үйлдвэрт нийлүүлэх бололцоог бий болгон ажиллаж байна.

Энэхүү систем нь малыг шууд үйлдвэр дээрээ худалдан авч технологийн дагуу боловсруулж байгаа нь бэлтгэсэн махны чанарыг сайжруулж, өртгийг хямдруулаад зогсохгүй малчин өрхийн амьжиргааг тэтгэх, малын хулгайтай тэмцэх зэрэг нийгмийн чухал ач холбогдолтой ажил болж байна.

Нэр төрөл	2007 он		2008 он		2009 он		2010 он	
	Бэлтгэсэн малын тоо	Нэг малын махны гарц%/	Бэлтгэсэн малын тоо	Нэг малын махны гарц%/	Бэлтгэсэн малын тоо	Нэг малын махны гарц%/	Бэлтгэсэн малын тоо	Нэг малын махны гарц%/
Үхэр	16,703	42.3	19,765	45.2	25,468	46.3	6,238	47.7
Адуу	3,335	44.5	4,615	47.4	9,521	49.9	4,152	51.5
Хонь	33,902	40.1	55,911	42.1	860	41.9	23,374	42.3
Ямаа	4,235	39.1	8,273	36.5	1,116	-	7,870	41.9
<b>Бүгд дүн</b>	<b>58,175</b>	<b>-</b>	<b>88,564</b>	<b>-</b>	<b>36,965</b>	<b>-</b>	<b>41,634</b>	<b>-</b>

Хүснэгт 10 Мах бэлтгэлийн тоо, махны гарц



Зураг 3. Үйлдвэрүүдийн байршлын радиус



Мал бэлтгэлийн үед дараах чиглэлээр банктай хамтран ажилладаг.


**1. Малын төлбөр тооцоо гүйцэтгэх:**

Мал бэлтгэлийн үйл ажиллагаанд зориулсан мөнгөн хөрөнгийг Хадгаламж банкинд байршуулан тус банкны орон нутгийн салбаруудаар дамжуулан төлбөр тооцоог гүйцэтгэдэг. Мал тушаасан малчинд төлөх мөнгөн дүнгээр чекийг мал хүлээн авагчид бичиж олгодог ба чек бичигдсэнээс хойш ажлын 3 хоногийн дотор дээрхи банкны аль ч салбараас бэлэн мөнгө авах эрхтэй. Энэ нь үйлдвэр дээр их хэмжээгээр бэлэн мөнгө байлгах, бэлэн мөнгөний аливаа эрсдэлээс хамгаалах, малчдад өөрсдийн бэлэн мөнгөний зарцуулалтыг хүссэн үедээ хийх боломж бүрдэнэ.

**2. Малчдын зээлийг мал бэлтгэлтэй холбох:**

Малчид цагаан сараар эсвэл баяр, наадам, хичээл орох үеэр гэх мэт бэлэн мөнгөний хэрэгцээ гарсан үед банкинд хандан зээл авдаг. Малчид зээлээ, малаа борлуулсан орлогоосоо төлөх хүсэлт гаргасан тохиолдолд тус компанитай холбоо тогтоон намар нэгдсэн зохион байгуулалтанд оруулж, үйлдвэрт малаа нийлүүлдэг.

Малчдыг урамшуулах, идэвхижүүлэх зорилгоор үйлдвэрт малаа нийлүүлсэн малчдын зээлийн хүүний 1/3 хэсгийг компани хариуцан банкинд төлдөг. Хадгаламж банк аймаг, сум бүрт байрладаг учраас дээрх 2 чиглэлээр хамтарч ажиллахад ямар нэгэн хүндрэл бэрхшээл гардаггүй бөгөөд харилцан бизнесээ дэмжиж ажиллаж байна.



Зураг 4 Үнэт цаас гаргагч болон Хадгаламж банкны салбаруудын байршил

2011 оны 7 сар 26 өдөр  
**БҮРТГЭВ**  
№ 01


**Мал бэлтгэн нийлүүлэх процесс**

Малчид, мал нийлүүлэгчдээс малын эмч, мал тоологч, пүүлэгч, мал бэлтгэлийн мэргэжилтэн болон бусад холбогдох албан тушаалтны бүрэлдэхүүнтэйгээр малыг хүлээж авдаг бөгөөд махны хяналтын улсын байцаагч хяналт тавин ажилладаг. Малыг хүлээж авах үед амьдын жин, махны гарцаар нь жинлэн авдаг.

Малыг хүлээн авахдаа дараахи бичиг баримтуудыг бүрдүүлдэг:

- Гарал үүслийн гэрчилгээ /орон нутгийн Мал Эмнэлэг Ариун Цэврийн Алба/
- Цагдаагийн байгууллагын тодорхойлолт
- Малыг тушаагчийн иргэний үнэмлэх, орон нутгийн засаг даргын тодорхойлолт
- Зүсмийн бүртгэлийн жагсаалт

МХБ-ийн гишүүн  
Бронд, тусгай зориулалтын  
"БЭН СЕК"  
Г. А. К.  
ТАА4467 - 2052-112



Хүлээж авсан нийт малын 20-30 хувьд санамсаргүй түүврийн аргаар сонголт хийн малын эмчийн үзлэг хийж, шаардлагатай гэж үзсэн тохиолдолд /сэжигтэй мал ирсэн, экспортын мал бэлтгэлийн үед харилцагчийн хүсэлтээр болон хяналтын байцаагч, малын эмч нарын хамтарсан шийдвэрээр/ 100 хувь цусны шинжилгээнд хамруулдаг. Өвчтэй буюу өвчний сэжиг илэрсэн малыг тусгаарлаж, нядалгааны малын стандарт шаардлага хангаагүй тохиолдолд "Махны хяналтын дүрэм"-д заасны дагуу ангилан шийдвэрлэдэг.

**Үйлдвэрлэл**

Тус компани өөрийн салбар үйлдвэрүүдэд орчин үеийн махны үйлдвэрлэлийн техник, технологийг нэвтрүүлэх, олон улсын жишигт нийцсэн нэгдсэн нэг стандарт технологиор үйлдвэрлэлийг явуулж, дотоод, гадаадын зах зээлд хүнсний эрүүл ахуйн шаардлага хангасан мах, махан бүтээгдэхүүнийг тогтмол, найдвартай нийлүүлэх боломж бүхий махны үйлдвэрлэлийг бий болгосон байна.

Ингэснээр малчдаас хүлээн авсан малыг бэлтгэж, нядласны дагуу үйлдвэрүүдэд махыг сэврээсэн байдлаас шууд шулж бэлтгэдэг. Энэ нь махны чанарыг алдагдуулахгүйгээр хэрэглэгчдэд хүрч байх нөхцлийг бүрдүүлсэн.

**Чанарын хяналт**

Мал бэлтгэлээс эхлүүлэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, тээвэрлэх, борлуулах хүртэл онцгой анхаарч, шат шатанд чанарын хяналтыг хатуу тавьж ажиллах нь хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн өндөр чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндсэн нөхцөл, шаардлага юм.


Иймд Үнэт цаас гаргагч нь үйлдвэрлэлийнхээ процессын бүхий л түвшинд малыг хүлээн авахаас эцсийн хэрэглэгчдэд хүргэх хүртэлх үйл ажиллагаандаа эрүүл ахуй, чанарын хяналтыг хийж байна.

Тухайбал тус компани 2010 оны 9-р сарын 01-нээс эхлэн ОУ-д хүлээн зөвшөөрөгдсөн Эгзэгтэй цэгийн аюултай байдлыг шинжлэн хянах /НАССР<sup>5</sup>/ системийг Мах маркет Төв үйлдвэрт нэвтрүүлснээс гадна ISO 22000 болон үндэсний стандартад бүрэн нийцсэн орчин үеийн технологийг үйлдвэрлэлдээ нэвтрүүлээд байна.

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд чанарын хяналтыг дараахи байдлаар явуулдаг.

1) *Амьд малаас авах шинжилгээ:*

Уг шинжилгээг мал нядалгаанд орохоос нэг хоногийн өмнө авах ба нядалгаанд орох үед хариу нь гарсан байх ёстой. Шаардлагатай үед бүх малаас шинжилгээ авдаг бөгөөд онц шаардлагагүй үед нийт малын 20-30 хувийг шинжилгээнд хамруулдаг.



2) *Махнаас авах шинжилгээ:*

Энэхүү шинжилгээг түүвэрлэн авдаг бөгөөд орон нутгаас ирж буй маханд дараахи байдлаар шинжилгээ хийгддэг. Үүнд:

- a. Орон нутагт үйлдвэрийн малын эмчийн үзлэгээр орно.
- b. Мах маркет төв үйлдвэрт ирсэн үед хяналтын шинжилгээнд орно.
- c. Улсын мал эмнэлгийн төв лаборатори болон нийслэлийн мал эмнэлгийн төв лабораторид улирал бүр шинжилгээнд орно.



3) *Мах, болон махан бүтээгдэхүүнд дараах шинжилгээг хийж байна.*

<sup>5</sup> Hazard analysis and Critical Control Point



Мах махан бүтээгдэхүүнд чийглэг, PH, нитрит, давс, амино –азот, уураг, тослог, хэт ислийн тоо, формалины сорил, зэсийн цэнхэр, бенздины сорил, неслерийн урвалж, нянгийн тоо, сальмонелл, мөөгөнцөр болон E coli тодорхойлох шинжилгээг стандартын дагуу хийдэг юм.

**Хяналтын лаборатори**

Тус компани нь өөрийн төв болон салбар үйлдвэрүүддээ чанарын хяналтын лабораторийг ажлуулж, эрүүл ахуй, ариун цэврийн хяналтыг хийж байна. Төв лаборатори нь УМХ<sup>6</sup>-аар итгэмжлэгдсэн лаборатори юм.

Салбар лабораториудад төвөөс аргазүйн зөвлөгөө өгч шууд удирдлагаар ханган, шаардлагатай эм урвалж, багаж төхөөрөмж нийлүүлэн ажилладаг.

Одоогоор орон нутгийн дөрвөн лабораторид /Булган Мах маркет, Сүхбаатар Мах маркет, Хөвсгөл Мах маркет, Увс Мах маркет / тоног төхөөрөмж бүрэн тавигдсан. Цаашид дэс дараатай бусад үйлдвэрийн лабораторийн хүчин чадлыг сайжруулж шаардлагатай багаж тоног төхөөрөмжөөр тоноглохоор ажиллаж байна.

**1.12 ДЭД БҮТЭЦ, ТЭЭВЭРЛЭЛТ**

Компанийн орон нутаг дахь бүх үйлдвэрүүдэд техникийн шинэчлэлийг үе шаттай хийж байгаа ба төв үйлдвэрийн бэлэн бүтээгдэхүүний цех нь хоногт 1500-2000 кг мах хөлдөөх хүчин чадалтай, БНСУ-ын Hankook Fudee Industries Co.,Ltd, БНХАУ-ын Guangzhou Xuzhong Food Machinery Co.,Ltd зэрэг үйлдвэрийн тоног төхөөрөмжийг ашигладаг. Бэлэн бүтээгдэхүүний цех нь хоногт 1000 кг хиам үйлдвэрлэх хүчин чадалтай бөгөөд ОХУ, ХБНГУ-ын Seydelmann үйлдвэрийн төхөөрөмжүүдийг ашигладаг. Хөргөлтийн тоног төхөөрөмж нь Япон Улсын Hasagewa, БНСУ-ын DONG YONG үйлдвэрийн тоног төхөөрөмж, Нядалгааны болон эхлэн боловсруулах цех нь ОХУ, БНСУ, ХБНГУ-ын тоног төхөөрөмж, лаборатори нь ОХУ, БНХАУ-ын тоног төхөөрөмжийг тус тус үйл ажиллагаандаа ашигладаг.

Орон нутгийн үйлдвэрээс 20 тоннын багтаамжтай хөргүүр бүхий 3 машин, 20 тоннын багтаамжтай задгай 2 машинаар /задгай машиныг өвлийн улиралд мах тээвэрлэхэд ашигладаг/ төв үйлдвэр лүү мах болон дайвар бүтээгдэхүүнээ тээвэрлэдэг. Үнэт цаас гаргагчийн Улаанбаатар хот дахь төв үйлдвэр нь 5 давхар объект бүхий нядалгааны цех, мах боловсруулах цех, бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цех, болон хөргөгч, хөлдөөх агуулахуудаас бүрдэнэ. Энэхүү 5 давхар объектийн бүх давхарт мах хадгалах, хөлдөөх агуулахууд байдаг бөгөөд нийт хүчин чадал нь 7,000 орчим тонн мах хадгалах, хөлдөөх багтаамжтай. Үүнээс өнөөдрийн байдлаар 1, 2-р давхрын хасах 18<sup>0</sup>С-ээс хасах 20<sup>0</sup>С температуртай 14 хадгалах агуулах болон хасах 40<sup>0</sup>С температуртай гүн хөлдөөх агуулахуудыг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Давхар болгонд хяналтын камер ажиллуулдаг бөгөөд агуулахын харуул хамгаалалтын ажлыг тусдаа өөр компани гүйцэтгэдэг. Ээлж хүлээлцэх болгонд санхүүтэй бүртгэл тооцоо нийлнэ. Төв үйлдвэрээс сүлжээ дэлгүүрүүдэд мах, махан бүтээгдэхүүнийг түгээхдээ 600 кг-аас 1 тоннын багтаамжтай хөргүүртэй машинаар тээвэрлэдэг.

"Жаст Агро" ХХК нь бүтээгдэхүүний тээвэрлэлтийн түргэн шуурхай байдлыг хангах зорилгоор Улаанбаатар төв үйлдвэрийг 2011 оны 01-р сард Транс-Монголын төмөр замтай холбосон. Ингэснээр төв болон орон нутгийн салбар үйлдвэрүүдэд боловсруулсан махаа Төв үйлдвэрээсээ экспортын ачилт хийн, худалдан авагчдад шууд хүргэх боломжтой болсон.

<sup>6</sup> Улсын мэргэжлийн хяналт гэсэн үгний товчлол



Транс Монголын төмөр зам нь ОХУ-ын Транс Сибирийн төмөр замтай Науш хотод холбогдохоос гадна Хятад улстай Замын-Үүдийн боомтоор холбогддог.




Зураг 5 Транс Монголын төмөр замын сүлжээ

**1.13 БОРЛУУЛАЛТ**

Улсын хэмжээгээр махны борлуулалт ченжээр дамжуулан худалдах, боловсруулах үйлдвэрүүдээр дамжуулан үйлдвэрийн аргаар боловсруулан худалдах, гадаад зах зээлд экспортлох гэсэн 3 чиглэлээр хийгддэг.

Үнэт цаас гаргагчийн техник, технологийн шинэчлэл, үйл ажиллагааны цар хүрээг өргөтгөхөд чиглэсэн хөрөнгө оруулалт болон удирдлагын явуулж буй бодлого, зах зээлд баримтлах стратегийн хэрэгжилтийн үр дүнд компанийн үйлдвэрлэл болон борлуулалтын хэмжээ жил бүр нэмэгдсээр байна.



Тус компани нийслэл болон хөдөө орон нутгийн нийт 11 салбар үйлдвэрт мал бэлтгэл, махны үйлдвэрлэлийг явуулж, бод, богийн тураг мах, ангилсан мах, дайвар бүтээгдэхүүн, хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн гадаад, дотоодын зах зээлд борлуулж байна.

СЗХ  
2011 он 7 сар 26 өдөр  
БҮРТГЭВ  
№ 01

УЛААНБААТАР ХОТ  
МХБ-ийн гишүүн  
Ан.террантер  
Брокер, дилерийн  
"БИЛСЕК"  
АЖ  
ТА4467 д. 2011.7.23



*Handwritten signature in blue ink.*



График 9. Нийт борлуулалтын бүтэц /%/

Үнэт цаас гаргагч нь сүүлийн жилүүдэд экспортод чиглэсэн үйл ажиллагаанд түлхүү анхаарч, үйлдвэрлэлийн технологийн шинэчлэлийг түүнд чиглүүлэн өөрчлөн сайжруулах бодлого баримталж байгаа ба энэ чиглэлийн мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн ажиллаж байна. 2010 оны жилийн эцсийн байдлаар Үнэт цаас гаргагчийн махны нийт борлуулалтанд эзлэх экспортын хэмжээ 2006 оноос хоёр дахин нэмэгдэж, борлуулалтын 70 гаруй хувийг эзлэж байна.



График 10. Борлуулалтанд эзлэх экспортын хэмжээ /%/

Компани сүүлийн 2 жил үхэр, адууны мах түлхүү бэлтгэн экспортод гаргасан бөгөөд энэ нь худалдан авагчийн үйл ажиллагааны онцлогтой холбоотой юм.

Тухайлбал, 2009 онд үхэр, адууны мах түлхүү бэлтгэж, нийт үйлдвэрлэсэн махны 82 хувийг экспортод гаргаж, дотоодын зах зээл дээр дайвар бүтээгдэхүүн болон хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг борлуулжээ.


Харин 2010 онд мөн адил экспортын гэрээтэйгээ уялдуулан үхэр, адууны мах бэлтгэн, үхрийн махны 92 хувийг, адууны махны 97 хувийг экспортод гаргасан бөгөөд үлдсэн хувийг дотоодын зах зээл дээр борлуулсан байна.

Экспортын бүтээгдэхүүн	2007 он	2008 он	2009 он	2010 он	Нийт
Үхрийн мах	474.6	1,186.8	2,205.1	2,559.7	4,426.2
Адууны мах	651	239.7	475.3	1,911.4	3,277.4
Хонины мах	-	-	-	47.7	47.4
Үхрийн хатаасан мах	-	-	0.8	-	0.8
Бэлэн бүтээгдэхүүн	-	-	-	0.1	0.1
<b>Нийт хэмжээ</b>	<b>1,125.6</b>	<b>1,426.5</b>	<b>2,681.2</b>	<b>4,518.9</b>	

Хүснэгт 11. Экспортын хэмжээ /тн/

2007 – 2010 онуудад экспортод гаргасан мах, махан бүтээгдэхүүний 65.9 хувийг үхрийн мах, 33.6 хувийг адууны мах, үлдэх хувийг хонь болон бусад бүтээгдэхүүн эзэлж байна.

Үнэт цаас гаргагч нь экспортод гаргаж байгаа мах, махан бүтээгдэхүүнээ ОХУ, Лалын Бүгд Найрамдах Иран Улсын компаниудад гэрээгээр борлуулдаг бөгөөд



сүүлийн 4 жилд гаргасан мах, махан бүтээгдэхүүний 99.2 хувийг ОХУ-ын компанид нийлүүлсэн ба ОХУ-ын Сибирь Алс Дорнодын бүс нутагт байрлах үйлдвэрүүдэд гаргаж буй махны ихэнх хувийг нийлүүлдэг.

	2007 он	2008 он	2009 он	2010 он	Нийт дүн	Эзлэх хувь
Улаан Үд хот, Бурятмяспром	544.7	2,846.8	8,272.5	11,238.0	22,902.0	86.4%
Тува	1,410.9	723.9	-	-	2,134.9	8.1%
Эрхүү хот, "Сивмаркер" ХХК	-	-	16.78	-	16.8	0.1%
Эрхүү хот, "Иркутский" ХХК	-	-	-	986.4	986.4	3.7%
Хакас, Абакан хот	-	-	-	457.9	457.9	1.7%

*Хүснэгт 12 ОХУ дахь махны борлуулалт*

Хүснэгтээс харахад "Жаст Агро"ХХК-ийн гол худалдан авагч нь Улаан Үд хотын "Бурятмяспром" үйлдвэр байгаа бөгөөд сүүлийн 4 жилийн борлуулалтын 86.4 хувийг "Бурятмяспром" эзлэж байна.

"Бурятмяспром" үйлдвэр нь сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд Үнэт цаас гаргагчтай хамтран ажиллаж байгаа ба ихэвчлэн үхрийн мах авч, боловсруулан дотоодынхоо зах зээл дээр консервлэн борлуулдаг. Нийт 4 үйлдвэр, 8 үйлдвэрийн бус газраас бүрддэг бөгөөд өдөрт 130 мянган лааз мах, 20 тонн хиам, 10 тонн хагас боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай юм.

**Нөөцийн махны борлуулалт**


Үнэт цаас гаргагч нь анх 2006 оноос эхлэн Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Махны холбоотой гэрээ байгуулан, нөөцийн махыг бэлтгэж, боловсруулан, хүн амын махны хаврын хэрэгцээг хангах чиглэлээр ажиллаж ирсэн байна.



*График 11. Нөөцийн махны бэлтгэлийн хэмжээ*

№	Махны төрөл	2007 он	2008 он	2009 он	2010 он	2011 он
1.	Үхрийн мах	350	350	150	550	150
2.	Хонины мах	1,150	1,150	1,770	150	1,770
3.	Ямааны мах	-	-	480	700	480
	<b>Нийт</b>	<b>1,500</b>	<b>1,500</b>	<b>2,400</b>	<b>1,400</b>	<b>2,400</b>


*Хүснэгт 13. Жаст Агро нөөцийн махны бэлтгэлийн хэмжээ /тн/*



**Жижиглэнгийн махны борлуулалт**


Тус компани нь хагас боловсруулсан бууз, банш, таташ, бүтэн утсан гуя, чанамал, утлагат хиам зэрэг 30 орчим нэр төрлийн бэлэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн өөрийн нэрийн дэлгүүрүүд болон томоохон сүлжээ дэлгүүрүүдээр борлуулж байна.

Үнэт цаас гаргагч нь дээрх төрлийн бүтээгдэхүүнийг, цаашид энэ чиглэлийн үйлдвэрлэлийг өргөжүүлэх төлөвлөгөөгүй байгаа. Учир нь компанийн үйлдвэрлэл, борлуулалтанд энэ чиглэлийн бүтээгдэхүүний эзлэх хувь бага, мөн зах зээл дээр өрсөлдөгч ихтэй байдаг.



Сүүлийн 3 жилийн борлуулалтаас харахад 60 орчим хувийг (3,199.3 тн) тураг болон ангилсан мах, 35 орчим хувийг (1,895.3тн) дайвар бүтээгдэхүүн, үлдсэн 5 орчим хувийг (287 тн) бэлэн бүтээгдэхүүн эзэлдэг байна.

График 12. Жижиглэнгийн махны борлуулалтын бүтэц



**1.14 СҮҮЛИЙН 3 ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ**

<b>БАЛАНС</b>		/төгрөгөөр/		
<b>А. ХӨРӨНГӨ</b>	<b>2008</b>	<b>2009</b>	<b>2010</b>	<b>2011 Q2</b>
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	128,733,317	18,060,895	16,940,500	52,106,257
Дансны авлага	222,813,606	2,095,073,758	345,598,844	184,638,902
Найдваргүй авлагын хасагдуулга	-	-		
Бусад татварын авлага		3,204,489		
Бусад авлага			217,800	
Бараа материал	5,068,403,113	8,196,365,925	3,313,597,149	2,876,561,466
Урьдчилж төлсөн зардал /тооцоо	-	-		96,490,343
Салбаруудын тооцоо			1,900,000,000	1,066,883,993
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>5,419,950,037</b>	<b>10,312,705,067</b>	<b>5,576,354,293</b>	<b>4,276,680,963</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>				
Үндсэн хөрөнгө	17,151,258,000	20,322,578,160	20,883,624,889	32,044,297,532
Хуримтлагдсан элэгдэл		-408,392,026	-917,962,901	-200,326,993
Бусад үндсэн хөрөнгө	6,836,670,101	10,018,327,778	11,654,545,739	13,490,059,641
Хуримтлагдсан элэгдэл	-42,770,053	-735,497,819	-1,556,698,211	-535,138,103
Дуусаагүй барилга		101,735,623	2,524,374,686	2,2569,520,200
Биет бус хөрөнгө	3,953,871	3,953,871	3,953,871	3,953,871
Хуримтлагдсан элэгдэл		-395,387	-790,774	-988,467
Хөрөнгө оруулалт ба бусад				2000,000
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>23,949,111,919</b>	<b>29,302,310,200</b>	<b>32,591,047,298</b>	<b>47,373,377,679</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>29,369,061,956</b>	<b>39,615,015,267</b>	<b>38,167,401,591</b>	<b>51,650,058,643</b>
<b>Б. Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч</b>				
Дансны өглөг	602,041,664	2,819,494,978	1,025,513,169	420,466,973
Цалингийн өглөг				
ОАТатварын өглөг	3,449,132		20,504,560	8,563,936
ХАОАТ-ын өглөг	5,786,140	6,342,867	987,460	127,696
НӨАТ-ын өглөг				
Бусад татварын өглөг				
ЭМНДШ-ийн өглөг	5,657,547			169,405
Ногдол ашгийн өглөг				
Банкны богино хугацаат зээл			1,900,000,000	2,815,000,000
Бусад өглөг				
Урьдчилж орсон орлого			116,170,108	127,830,009
Богино хугацаат өглөг/салбарын	4,988,955,225	7,109,912,733	2,469,871,858	
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>5,605,889,706</b>	<b>9,935,750,577</b>	<b>5,533,047,154</b>	<b>3,372,158,019</b>
Урт хугацаат өр төлбөр	16,984,335,300	24,982,391,094	28,237,845,242	468,187,241
Урт хугацаат зээл				
Бусад урт хугацаат өглөг				
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>16,984,335,300</b>	<b>24,982,391,094</b>	<b>28,237,845,242</b>	<b>468,187,241</b>
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>22,590,225,006</b>	<b>34,918,141,671</b>	<b>33,770,892,396</b>	<b>3,840,345,261</b>
<b>Эзэмшигчдийн өмч</b>				



*Handwritten signature in blue ink.*

УЛААНБААТАР ХОТ  
 2011 оны 7 сар 26 өдөр  
 БҮРТГЭВ  
 № 01

*Handwritten signature and stamp.*





## ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Өмч: хувийн	10,000,000	10,000,000	10,000,000	28,247,845,242
Хувьцаат капиталын дүн	10,000,000	10,000,000	10,000,000	28,247,845,242
Дахин үнэлгээний нөөц	11,554,795,132	11,554,795,132	11,129,775,386	26,567,984,661
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг				
Хуримтлагдсан ашиг /алдагдал			-6,743,266,192	-7,006,116,520
Тайлангийн үеийн	5,529,488	-2,081,963,354	123,340,997	64,042,787
Өмнөх үеийн	-4,791,487,671	-4,785,958,183	-6,866,607,189	-7,070,159,308
<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>6,778,836,949</b>	<b>4,696,873,595</b>	<b>4,396,509,195</b>	<b>47,809,713,382</b>
<b>Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>29,369,061,956</b>	<b>39,615,015,267</b>	<b>38,167,401,591</b>	<b>51,650,058,643</b>

Хүснэгт 14 Баланс



<b>ОРЛОГЫН ТАЙЛАН</b>				<i>/төгрөгөөр/</i>
<i>ҮЗҮҮЛЭЛТ</i>	<i>2008</i>	<i>2009</i>	<i>2010</i>	<i>2011 Q2</i>
Борлуулалтын орлого	7,669,353,855	10,309,506,115	17,799,654,295	3,675,716,415
Борлуулалтын хорогдол ба буцаалт	-27,210,995	1,678,903	1,871,418	
Борлуулалтын хөнгөлөлт		400,217		
<b>Борлуулалтын орлогын дүн</b>	<b><u>7,642,142,860</u></b>	<b><u>10,307,426,996</u></b>	<b><u>17,797,782,877</u></b>	<b><u>3,675,716,415</u></b>
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	4,992,702,491	6,000,055,274	8,874,999,731	1,712,994.699
<b>Нийт ашиг /алдагдал/</b>	<b><u>2,649,440,369</u></b>	<b><u>4,307,371,722</u></b>	<b><u>8,922,783,146</u></b>	<b><u>1,962,721,716</u></b>
Үндсэн болон нэмэгдэл цалин	693,125,611	1,063,419,166	1,130,814,909	393,447,463
Нийгмийн даатгалын шимтгэл	78,123,971	131,998,154	138,141,175	55,128,365
Засвар үйлчилгээний зардал	90,221,773	96,783,654	210,313,205	33,724,712
Ашиглалтын зардал	199,007,038	291,336,294	309,184,324	49,615,540
Түрээсийн зардал	36,223,655	39,265,624	34,611,250	13,566,831
Албан томилолтын зардал	62,859,803	72,208,795	46,082,427	16,077,346
Тээврийн зардал	174,443,284	227,043,963	151,170,616	7,729,200
Түүхий эд материалын зардал	11,767,660	24,543,825	28,766,066	
Элэгдлийн зардал	759,720,590	1,102,551,568	1,434,607,603	860,460,048
Зар сурталчилгааны зардал	14,985,689	21,464,051	10,694,214	3,723,970
Шуудан, холбооны зардал	21,422,687	23,860,239	15,280,029	7,250,475
Шатахууны зардал	170,901,138	378,164,246	240,541,891	37,979,031
Найдваргүй авлагын зардал			9,040,522	
Зээлийн хүүгийн зардал	550,735,409	3,174,908,815	4,910,534,681	207,150,904
Бусад зардал	420,185,807	508,465,733	484,368,011	188,845,191
<b>Үйл ажиллагааны зардлын дүн</b>	<b><u>3,283,724,114</u></b>	<b><u>7,156,014,125</u></b>	<b><u>9,154,150,925</u></b>	<b><u>1,874,915,537</u></b>
<b>Үндсэн үйл ажиллагааны ашиг /алдагдал/</b>	<b><u>-634,283,746</u></b>	<b><u>-2,848,642,404</u></b>	<b><u>-231,367,779</u></b>	<b><u>87,806,178</u></b>
Үйл ажиллагааны бус орлого	668,775,061	826,185,982		
Үйл ажиллагааны бус зардал	25,512,696	59,506,933		-13,852,973
<b>Үндсэн бус үйл ажиллагааны ашиг /алдагдал/-ын дүн</b>	<b><u>643,262,365</u></b>	<b><u>766,679,050</u></b>	<b><u>375,218,337</u></b>	<b><u>-13,852,973</u></b>
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/</b>	<b><u>8,978,619</u></b>	<b><u>-2,081,963,354</u></b>	<b><u>143,850,557</u></b>	<b><u>73,953,206</u></b>
Орлогын татварын зардал	3,449,131,50		20,509,560	9,910,418
<b>Татварын дараах ашиг /алдагдал/</b>	<b><u>5,529,488</u></b>	<b><u>-2,081,963,354</u></b>	<b><u>123,340,997</u></b>	<b><u>64,042,787</u></b>

Хүснэгт 15 Орлогын тайлан



**1.15 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ӨР ТӨЛБӨРИЙН ТАЛААР**

Үнэт цаас гаргагч нь үнэт цаас гаргахын өмнөх улирлын санхүүгийн тайлангийн үзүүлэлтээр нийт 3.85 тэрбум төгрөгийн өр төлбөртэй байгаа ба үүнээс 2.81 тэрбум төгрөг нь эргэлтийн хөрөнгө санхүүжүүлэх зорилгоор Хадгаламж банкаас авсан богино хугацаат зээл байна.

Тус зээлийн гэрээг анх 2010 оны 10 дугаар сарын 29-ны өдөр 1060/136 тоот Зээлийн гэрээгээр эргэлтийн хөрөнгө нэмэгдүүлэх зориулалтаар 1,900,000,000 /нэг тэрбум есөн зуун сая/ төгрөгийг сарын 1.8 хувь, жилийн 21.6 хувийн хүүтэйгээр 12 сарын хугацаатай зээлэхээр харилцан тохиролцож байгуулсныг 2011 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулан 1060/136-01 тоот гэрээг дараах нөхцөлтэйгээр байгуулсан.

Зээлийн хүүг 2011 оны 01 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн сарын 1.3 хувь, жилийн 15.6 хувь, зээлийн хэмжээг 915,000,000 /есөн зуун арван таван сая/ төгрөгөөр нэмэгдүүлж 2,815,000,000 /хоёр тэрбум долоон зуун сая/ төгрөг болгон, зээл төлөгдөж дуусах хугацааг 12 сараар нэмж сунгаж, зээлийн хүүний төлбөр төлөгдөж дуусах эцсийн хугацааг 2012 оны 10 дугаар сарын 20-н хүртэл сунгасан.

Үнэт цаас гаргагчийн 100 хувийн охин компани болох “Хатан суман” ХХК –ийн нэр дээр Голомт банкнаас 7,5 тэрбум төгрөгийн зээлийг авч, тус зээлийг зээл шилжүүлэн ашиглах гэрээний дагуу “Жаст групп” ХХК авч ашиглаж, зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг бүхлээр нь хариуцан ажиллаж байна.

“Хатан суман” ХХК-ийн нэр дээр бүртгэлтэй 10,2 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий Сэлэнгэ мах маркет, Багануур мах маркет үйлдвэрүүдийг “Жаст Агро” ХХК нь өөрийн үйл ажиллагаанд бүрэн ашиглаж байгаа ба тус үйлдвэрүүдийн балансын бүртгэл толгой компани болох “Жаст Агро” ХХК-ийн баланст бүртгэлтэй байна.



**1.16 ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН**

Үнэт цаас гаргагч нь "Далайван Аудит" ХХК-тай гэрээ байгуулан 2010 оны жилийн эцсийн, 2011 оны 1 болон 2 дугаар улирлын санхүүгийн тайланд хараат бус аудиторроор ажиллуулсан.

**2011 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайлангийн дүгнэлт**



**ДАЛАЙВАН АУДИТ**

Аудит, нягтлан бодох бүртгэлийн зөвлөгөө,  
хөрөнгийн үнэлгээний итгэмжлэгдсэн байгууллага

Монгол Улс, Улаанбаатар хот  
Баянгол дүүрэг, Амарсанаагийн гудамж-5  
Утас: 305401, 99006277, 99008659  
Факс: +976-11305403  
Элчлүүр: info@dalaivanaudit.mn  
Вэб хуудас: www.dalaivanaudit.mn

**АУДИТОРЫН ТАЙЛАН**

**"Жаст Агро" ХХК-н Гүйцэтгэх  
захирал Т.Содномдаржаа танаа**

Бид "Жаст Агро" ХХК-н (цаашид "Компани" гэх) 2011 оны 06 дугаар сарын 30-ний өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн санхүүгийн тайлан, орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон мэдэгдэхүйц нягтлан бодох бүртгэлийн бодлого, тодруулгуудад гэрээний дагуу аудит хийлээ.

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь компанийн гүйцэтгэх удирдлагын үүрэг хариуцлага байна. Энэхүү үүрэг хариуцлагад алдааны улмаас гарч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайланг бэлтгэх ба үнэн зөв толилуулахад холбогдох дотоод хяналтын системийг бий болгох, хэрэгжүүлэх, түүнчлэн нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, тухайн нөхцөл байдалд тохирох нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх үүргүүд орно.

Бид хийж гүйцэтгэсэн аудит дээрээ үндэслэн эдгээр санхүүгийн тайлангийн талаар хараат бус зөвлөмж гаргах нь аудитын үүрэг байна. Аудитыг Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Эдгээр стандартууд нь санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохистой баталгаажуулалтыг олж авахын тулд аудитаа төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг. Аудитын ажилд санхүүгийн тайлангууд дахь дүн, тодруулгуудын дагалдах нотолгоог олж авах горимуудыг гүйцэтгэх ажил орсон болно.

Аудитын явцад бид өмнөх он болон 2011 оны 1-р улиралд илэрсэн алдаа, зөрчил дутагдал, тэдгээрийг арилгахтай холбогдуулан компанийн ерөнхий удирдлага, санхүү, бүртгэлийн ажилтнуудад өгсөн зөвлөмжийн хэрэгжилтыг гаргуулан авч, тухайн тайлангийн хугацаанд компанийн гүйцэтгэх удирдлагын хийсэн томоохон дүнтэй тооцооллууд ба баримталсан нягтлан бодох бүртгэлийн зарчмуудыг үнэлэх, түүнчлэн санхүүгийн тайлангуудын ерөнхий толилуулгад үнэлэлт өгөх ажлууд орсон. 2011 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулахад эдгээр ажлын хүрээнд хийгдсэн үр дүн чухал нөлөө үзүүлэх болно.



an independent member of  
**BAKER TILLY  
INTERNATIONAL**

УЛААНБААТАР ХӨТ  
**ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ, МНБ  
Ц.ЖИГДЭН**  
МХБ-ийн гишүүн  
Ан.серрантер  
Брокер, лицензийн  
"БИДИСЕН"  
2011 оны 07-р сарын 22-ны өдөр  
ТТА-167-А, 2052-132

СЭХ  
2011 оны 7 сар 28 өдөр  
**БҮРТГЭВ**  
№ 01

**Ажлын тэмдэглэл:**

1. 2011 оны 2-р улиралд хийгдсэн томоохон дүнтэй гүйлгээний талаар:

1.1. “Мах Маркет интернейшнл”, “Хатан суман” гэсэн 2 компанийг “Жаст Агро” ХХК нь өөрийн охин компани болгон бүртгүүлснээр хөрөнгө оруулалтын дансны үлдэгдэл 2,000.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн.

1.2. “Хатан суман” ХХК-тай 2010 оны 12-р сарын 20-ны өдөр “Зээл шилжүүлэн ашиглах гэрээ”-р 7.5 тэрбум төгрөгний зээлийг “Жаст групп” ХХК-тай байгуулсан бөгөөд үүний 915,000.0 мянган төгрөгийг “Жаст Агро” ХХК нь ашиглаж байна. Энэ зээлийн дүнгээр банкны богино хугацаат зээлийн үлдэгдэл нэмэгдсэн байна.

1.3. “Хатан суман” ХХК-н Сэлэнгэ, Багануур Мах Боловсруулах үйлдвэрүүдийг “Өмч ашиглуулах гэрээ”-р “Жаст Агро” ХХК нь ашиглаж байна. Энэ тухай “Өмч ашиглуулах гэрээ”-ний үндсэн дээр бид дээрх үйлдвэрүүдийн ашиглалт, засвар үйлчилгээ, хадгалалт хамгаалалтыг бүрэн хариуцаж байгаа тул өөрсдийн санхүүгийн тайланд тусган бүртгэсэн гэж тус компанийн ажилтан тайлбарласан.

1.4. “Жаст Агро” ХХК-н зүгээс бидэнд гаргасан тайлбараар компанийн дээрх үйл ажиллагаа нь тайлант оны турш үргэлжлэн явагдана гэсэн тул 2011 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд үр дүн нь тусгагдах учир бид 2011 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт гаргахдаа илүү тодорхой тусгана.

2. Аудитын явцад 2010 оны жилийн эцэс болон 2011 оны 1-р улиралд санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийн хэрэгжилтийг тус компанийн санхүү бүртгэлийн ажилтнуудаар гаргуулж авсан. Ингэхэд санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, эх үүсвэр, өртөг зардал, татварын тооцооллын талаар нийт 7 зөвлөмж өгөгдсөнөөс 5 зөвлөмжийг биелүүлэн ажилласан байна.

“KANTON-AUDIT” CO., LTD.  
CPA ACCOUNTING, AUDITING  
AND TAX SERVICES

Аудиторын туслах:

Ш.Нарантунгалаг



Удирдлагад хүргүүлэх энэхүү захидлаар өмнөх тайланд тусгагдсан хязгаарлалт

**Зөвлөмжийн хэрэгжилт**

**Санхүүгийн тайлагналын талаар**

1. Тус компанийн өнөөгийн болон ойрын төлбөрийн чадварын шинжилгээг хийхэд доорхи үзүүлэлттэй байна.
  - Эргэлтийн хөрөнгийн харьцаа 1:1
  - Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа 0.1

УЛААНБААТАР ХОТ  
МНБ-ийн Гүйцэтгэл  
Брэнд, Инвентарийн  
“БИЛЭГ”  
ТТА4463 2052432

СЭХ  
2011 он 7 сар 06 өдөр  
БҮРТГЭВ  
№ 01




- Үнэмлэхүй хөрвөх хөрөнгийн харьцаа 0.003

Дээрхи үзүүлэлтээс дүгнэхэд компани нь харилцагчийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагыг цаг хугацаанд төлж барагдуулах чадвар муу байна.

2. Валютаар илэрхийлсэн хөрөнгө, өр төлбөрийн үлдэгдлийг Монгол банкны албан ханшаар тэгшитгэл тооцож, валютын ханшийн зөрүүний хэрэгжээгүй олз, гарз бүртгээгүй байна.

Аудитаар өгөгдсөн зөвлөмж

1. Компанийн өнөөгийн болон ойрын төлбөрийн чадвар муу байгаа шалтгааныг тодруулан удирдлагад танилцуулж шийдвэр гаргуулан компанийн төлбөрийн чадварыг нэмэгдүүлэх,
2. “Нягтлан бодох” бүртгэлийн тухай хуулийн 9-р зүйл, “Нягтлан бодох бүртгэлийн бодлого”-ын баримт бичигт зааснаар валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө, өр төлбөрийн үлдэгдлийг Монгол банкны албан ханшаар илэрхийлж, валютын ханшийн зөрүүний олз гарз тооцож байх.

Зөвлөмжийн хэрэгжилт

1. Төлбөрийн чадварын харьцаа 2010 оны жилийн эцсийн үзүүлэлттэй харьцуулахад сайжирсан дүнтэй байна.
2. Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.
3. Зөвлөмжийн дагуу ханшийн тэгшитгэлийг Монгол банкны ханшаар илэрхийлсэн болно. Энэ хүрээнд гадаад валютаар үлдэгдэлтэй 2 харилцах дансны үлдэгдэл, 4 харилцагч байгууллагын үлдэгдэлд ханшийн тэгшитгэл хийсэн.

Компанийн нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн талаар



1. Бэлтгэн нийлүүлэгчид урьдчилж төлсөн 12,099.6 мянган төгрөгийн урьдчилгааг дансны авлагаар тайлагнасан.
2. Санхүүгийн тайланд тусгагдсан 29,389,237.3 мянган төгрөгийн биет хөрөнгийг “Жаст групп” ХХК-тай 2010 оны 3 сарын 31-ний өдөр байгуулсан “Өмч шилжүүлэн ашиглуулах гэрээ”-ний дагуу ашиглаж байна.
3. Гэрээгээр ашиглаж буй хөрөнгийг компани нь зарж борлуулах, бусдад шилжүүлэх, барьцаалах эрхгүй бөгөөд энэ талаар зөвхөн санал гаргах эрхтэй ба гэрээг жил бүр дүгнэж, акт үйлдэн тайлант хугацааны хөрөнгийн хөдөлгөөнийг гэрээний хавсралтанд тусгадаг.

Аудитаар өгөгдсөн зөвлөмж

1. Бэлтгэн нийлүүлэгчдэд урьдчилж төлсөн урьдчилгааг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 4.4-ийн дагуу бүртгэж тайлагнах.
2. Санхүүгийн тайланд тусгагдсан үндсэн хөрөнгийн өмчлөлийн асуудлыг компанийн ерөнхий удирдлагад танилцуулан шийдвэр гаргуулан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 4.5-дахь тодорхойлолтод заасны дагуу үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгаж байх.

Зөвлөмжийн хэрэгжилт

1. Зөвлөмжийн дагуу 2011 оны 1-р улирлын тайланд урьдчилж төлсөн төлбөрийг “Урьдчилж гарсан зардал”-ын ангилалаар бүртгэв. Энэхүү тооцоонд 2 харилцагчийн 10,0 сая төгрөгийн тооцоог хамруулан бүртгэсэн.



2. Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн /шилжилт хөдөлгөөн, худалдан борлуулах, худалдан авах гэх мэт/ гаргах тухай бүр өмчлөгчөөс зөвшөөрөл хүсэж шийдвэрлэсний үндсэн дээр үндсэн хөрөнгийн бүртгэлийг хөтөлж байна.

Эх үүсвэрийн талаар

1. Урт хугацаат өр төлбөрийн дансанд “Зээл шилжүүлэн ашиглах гэрээний дагуу 10 аж ахуйн нэгж, 2 хувь хүнээс авсан нийт 33,030.3 мянган ам.доллар, 2,000,000.0 мянган төгрөгийн зээлээр санхүүжигдэн 2006-2010 онуудад хийгдсэн тус компанийн харъяа мал, мах боловсруулах үйлдвэрүүдийн өргөтгөл, шинэчлэлтэй холбоотой 28,237,845.2 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг бүртгэсэн.
2. Данснаас хассан үндсэн хөрөнгөнд ногдох 115,856.9 мянган төгрөгийн дахин үнэлгээний хэрэгжилтийг хүлээн зөвшөөрч бүртгэлд тусгаагүй байна.

Аудитаар өгөгдсөн зөвлөмж

1. Урт хугацаат өр төлбөрийг “Нягтлан бодох бүртгэлийн бодлого”-ын баримт бичгийн 4.8.2-д заасны дагуу бүртгэлд тусгах мөн хувь нийлүүлэгчээс эргэн төлөгдөхгүй нөхцлөөр хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг дээрхи баримт бичгийн 4.9-ийн 2-д зааснаар бүртгэх.
2. Үндсэн хөрөнгийн данснаас хасах үеийн олз, гарзыг “Нягтлан бодох бүртгэлийн бодлого”-ын баримт бичгийн 4.5.7-д зааснаар бүртгэж, тайлант хугацааны орлогын тайланд тайлагнах.
3. Данснаас хассан үндсэн хөрөнгөд ногдох дахин үнэлгээний зөрүүг хэрэгжсэнд тооцож “Нягтлан бодох бүртгэлийн бодлого”-ын баримт бичгийн 4.9.3-д заасны дагуу бүртгэлд тусгаж байх

Зөвлөмжийн хэрэгжилт

1. Өмчлөгч болох “Жаст групп” ХХК-ийн Ерөнхий захирлын 2011 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн А-01/18 тоот тушаал гарч, урт хугацаат өрийг хааж өмчлөгчийн өмчийг нэмэгдүүлэхээр шийдвэрлэсний дагуу бүртгэлд тусгав.
2. Зөвлөмжийн дагуу бүртгэж байна.
3. Зөвлөмжийн дагуу 2010 оны санхүүгийн тайланд тусгагдсан данснаас хассан үндсэн хөрөнгийн дүнг Дахин үнэлгээний нэмэгдэл дансанд тусгасаныг 2011 оны 1 дүгээр улирлын тайлан балансад залруулан бүртгэв.

Өртөг, зардлын талаар

1. Үйлдвэрлэлтэй холбоотой тайлант хугацаанд гарсан 3,503,020.5 мянган төгрөгийн шууд болон шууд бус зардлыг тайлант хугацааны удирдлага борлуулалтын зардлаар тайлагнасан.
2. Гадаад валютын ханшийн зөрүүнээс үүссэн 15,587.0 мянган төгрөгийн гарзыг үйл ажиллагааны зардлаар ангилж тайлагнасан.

Аудитаар өгөгдсөн зөвлөмж

1. Үйлдвэрлэлтэй холбогдон тайлант хугацаанд гарч байгаа шууд болон шууд бус зардлыг “Нягтлан бодох бүртгэлийн бодлого”-ын баримт бичгийн 4.3-д зааснаар өртгийн объект бүрээр хуримтлуулан бүртгэж, бараа бэлэн бүтээгдэхүүний өртөгт шингээж байх.



2. Гадаад валютын ханшийн зөрүүний олз, гарзыг “Нягтлан бодох бүртгэлийн бодлого”-ын баримт бичгийн 4.11-д зааснаар ангилж тайлагнаж байх.

*Зөвлөмжийн хэрэгжилт*

1. 2011 оны 1 дүгээр улиралд Орон нутгийн салбар үйлдвэрүүд мал төхөөрч, өртөг тооцоолох үйл ажиллагаа явуулаагүй. Зөвхөн удирдлагын шатны зардал гаргасныг хуримтлуулан үйл ажиллагааны зардлаар тайлагнасан.
2. Зөвлөмжийн дагуу санхүүгийн программын жижиг алдааг залруулан 2011 оны 1 дүгээр улирлын тайланг гаргав.

Татварын тооцооллын талаар

1. Тайлант хугацаанд бүртгэсэн найдваргүй авлагын 9,040.5 мянган төгрөгийн зардлыг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайланд татвараас хасагдах зардалд оруулан татварын тооцооллыг хийсэн.

Аудитаар өгөгдсөн зөвлөмж

1. Орлогын албан татварын тооцооллыг 2006 оны “ААНОТ-ын тухай хууль” ҮТЕГ-ын даргын 2006 оны 235 тоот тушаалаар батлагдсан “Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх аргачлал”-ын дагуу хийж байх.

*Зөвлөмжийн хэрэгжилт*

1. Зөвлөмжийн дагуу үйл ажиллагаандаа мөрдлөг болгож байна.

**1.17 ТАЙЛАНГИЙН ШИНЖИЛГЭЭ**

2008-2010 оны хураангуй орлогын тайланд хийсэн бүтцийн шинжилгээ (%)

Үзүүлэлт	2008	2009	2010
Борлуулалтын орлого	100.0	100.0	100.0
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	65.3	58.2	49.9
Нийт ашиг	34.7	41.8	50.1
Үйл ажиллагааны зардал	43.0	69.4	51.4
Үйл ажиллагааны ашиг	(8.3)	(27.6)	(1.3)
Татварын өмнөх ашиг	0.12	(20.2)	0.80
Татварын дараах цэвэр ашиг	0.10	(20.2)	0.70

*Хүснэгт 16. Хураангай орлогын тайланд хийсэн бүтцийн шинжилгээ*

Үнэт цаас гаргагчийн орлогын тайланд хийсэн бүтцийн шинжилгээгээр борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, хүүгийн болон татварын зардлууд нь ашгийн зохих шатлалд хэрхэн нөлөөлж буйг дүгнэвэл:

2008-2010 онуудад борлуулалтын орлого жил дараалан хурдацтай 10 гаран тэрбум төгрөгөөр өссөн байна. Борлуулалтын өсөлтийг дагаад борлуулалтын өртөг, зардал өсөх нь зүйн хэрэг, гэхдээ борлуулалтын өртгийн хувийн жин 2008 онд 65.3 хувь байсан нь 2009 онд 58.2 хувь, 2010 онд 49.9 хувь болж буурсан сайн үзүүлэлттэй байгаа ба нийт ашгийн хувь 34.7–50.1 хувь хүртэл өсчээ. Энэ нь мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өртөг зардлын бууралт гэхээсээ илүүтэй борлуулалтын өртгийг зөвхөн мал мах худалдан авалтын шууд зардлаар тооцсон болон махны худалдах үнийн өсөлттэй холбоотой байх магадлалтай. Нийт ашиг нэмэгдсэн боловч үйл ажиллагааны зардал 2008-2009 онд 2.2 дахин, 2009-2010 онд 27.9 хувиар тус бүр нэмэгдсэн нь үндсэн ажиллагааны үр дүн алдагдалтай гарах шалтгаан болжээ. Үйл ажиллагааны зардал дахь зээлийн хүүний зардлын эзлэх хувь жил ирэх тусам өсч байгаа нь тус компанид зээлийн



БДЦ он 7 сар 26 өдөр  
**БҮРТГЭВ**  
№ 01



хүүний зардал дарамт болоод байгааг харуулж байна. Иймд санхүүжилтээ зардал багатай өөр эх үүсвэрээс татах шаардлагатай байгаа нь илэрхийлэгдэнэ. Зээлийн зардал 2009 онд 5.76 дахин, 2010 онд 2009 онтой харьцуулахад 1.55, 2008 болон 2010 онуудыг харьцуулахад бараг 9 дахин өссөн нь харагдаж байна.

**2008-2010 оны хураангуй балансад хийсэн хандлагын шинжилгээний үр дүн**

Үзүүлэлт	2008	2009	2010
1 Мөнгө	100%	14%	13%
2 Авлага	100%	940.3%	155.1%
3 Бараа материал	100%	161.7%	65.4%
4 Эргэлтийн хөрөнгийн дүн	100%	190.3%	102.9%
5 Үндсэн хөрөнгө	100%	126.5%	135.6%
6 Эргэлтийн бус хөрөнгийн дүн	100%	122.4%	136%
7 Нийт хөрөнгийн дүн	100%	134.9%	130%
8 Дансны өглөг	100%	468.3%	170.4%
9 Салбарын өглөг	100%	142.5%	49.5%
10 Богино хугацаат өр төлбөрийн дүн	100%	177.2%	98.7%
11 Өр төлбөрийн дүн	100%	154.6%	149.5%
12 Эзэмшигчдийн өмчийн дүн	100%	69.3%	64.9%
13 Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	100%	134.9%	130%

*Хүснэгт 17. Балансын хандлагын шинжилгээ*

Тус компанийн үндсэн хөрөнгө 2008-2009 онуудад жил дарааллан өсч, 2010 онд буурч 2009 оны түвшингээс буурсан ч 2008 оны түвшинтэй харьцуулахад 30 хувиар өссөн байна. Үүнд авлага, бараа материалын өөрчлөлтүүд голлох нөлөөллийг үзүүлсэн байна. Харин урт хугацаат зээлийн хувьд санхүүжилт жил ирэх тусам өсч байгаа нь харагдаж байна. Нийт эх үүсвэрийн өсөлт нь 2009 онд 1.35 дахин өссөн харагдаж байгаа ч энэ өсөлт зөвхөн зээлийн өсөлт гэж харагдаж байна.

**Санхүүгийн тайланд хийсэн харьцааны шинжилгээний үр дүн**

Санхүүгийн харьцааны нэр	Тооцсон үзүүлэлт	2008	2009	2010
<b>Төлбөрийн чадвар болон санхүүгийн тогтвортой байдалд хийсэн шинжилгээний үр дүн</b>				
Өөрийн капиталын оролцоо, хувь	ӨК:НХ	23.1%	11.9%	11.5%
Эргэлтийн харьцаа	ЭХ:БХӨ	0.97	1.04	1.01
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар	(ЭХ-БМ):БХӨ	0.06	0.21	0.41
Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн харьцаа	НӨ:ЭӨ	3.33	7.43	7.68
Өрийн харьцаа	ӨК:НХ	0.77	0.88	0.88
Өр төлбөр ба авлагын харьцаа	БХӨ:Авлага	25.2	4.74	16.0
<b>Хөрөнгийн ашиглалт болон компанийн ашигт ажиллагааны байдалд хийсэн шинжилгээний үр дүн</b>				
Нийт хөрөнгийн эргэц	НО:НХ	0.26	0.26	0.47
Өөрийн хөрөнгийн ачаалал	БО:ӨК	1.13	2.19	4.05
Үндсэн хөрөнгийн эргэц	БО:ЭБХ	0.32	0.35	0.55
Авлага цуглуулах дундаж хугацаа	Ав:БО*360		40	25
Бараа материалын эргэц /удаа/	ББӨ:БМ	0.99	0.73	2.68
Ашгийн норм /нийт ашгаар тооцсон/	НА:БО	0.35	0.42	0.5
Ашгийн норм /У.А-ны ашгаар тооцсон/	УАА:БО	(0.08)	(0.28)	(0.01)
Ашгийн норм /цэвэр ашгаар тооцсон/	ЦА:БО	0.001		0.01



*Handwritten signature in blue ink.*




Нийт хөрөнгийн өгөөж	ХТӨЦА:НХ	0.0003	0.0526	0.0038
Өөрийн хөрөнгийн өгөөж	ТӨЦА:ӨК	0.001	(0.443)	0.028

- Компани санхүүгийн тогтвортой байдлын хувьд өөрийн хөрөнгийн оролцоо багассаар 2010 онд 11.5 хувь болсон, тэр хэмжээгээр өрийн харьцаа нэмэгдэж 2008 онд өр төлбөрийн дүн өөрийн хөрөнгөөс 3.3 дахин их байсан нь 2010 онд 7.68 дахин их болж 2 дахин өссөн, эргэлтийн хөрөнгийн харьцаа хангалттай биш (дөнгөж 1.01-1.04) байгаа хүндрэлүүд байна. Эргэлтийн харьцаа нь богино хугацаат өр төлбөрөө эргэлтийн хөрөнгөө ашиглан төлөх чадвар ямар байгааг илэрхийлдэг ба хоёртой ойрхон байх нь хамгийн тохиромжтой гэж үздэг боловч энэ нь салбар болон компанийн онцлогоос шалтгаална. Компанийн ирээдүйн мөнгөн урсгалыг урьдчилан таамаглах боломж их байх тусам эргэлтийн харьцаа бага байх боломжтой байдаг.
- Эргэлтийн хөрөнгийн тогтвортой санхүүжилт дутагдалтай, богино хугацаат төлбөрүүд нь авлагын дүнгээс дунджаар 15 дахин их байгаа нь эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн тусгайлсан бодлого, зохицуулалт шаардлагатайг харуулж байна.
- Хөрөнгийн ашиглалтын хувьд нийт болон өөрийн хөрөнгийн ачаалал жилээс жилд хурдацтай нэмэгдсэн нь борлуулалтын орлогын өсөлттэй холбоотой бөгөөд авлагын цугларуулалт 40-25 хоног болж түргэссэн нь сайн үзүүлэлттэй байна.
- Ашигт ажиллагааны хувьд өнгөрсөн 3 жилийн хугацаанд тус салбар жил дараалан алдагдалтай ажилласан учраас ихэнх үзүүлэлтүүд сөрөг утгатай гарчээ.

Өмчлөгч болох "Жаст групп" ХХК-ийн Ерөнхий Захирлын 2011 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн А-01/18 тоот тушаал гарч, 2010 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн өглөг хэсэгт тусгагдсан урт хугацаат өрийн эргэн төлөгдөх нөхцөлгүйгээр "Жаст Агро" ХХК-д оруулсан хөрөнгө оруулалт болох 28,237,845,241.90 төгрөгийн хөрөнгө оруулалтын хэмжээгээр компани хоорондын тооцооны дүнг бууруулж, "Жаст Агро" ХХК-ийн эзэмшигчдийн өмчийн дүнг нэмэгдүүлэхээр шийдвэрлэсний дагуу 2011 оны 1-р улирлын санхүүгийн тайланд тусган бүртгэсэн. Энэхүү шийдвэртэй холбоотойгоор Үл хөдлөх хөрөнгүүдийн өмчлөх эрхийг "Жаст Агро" ХХК-ийн нэр дээр шилжүүлэх ажил хийгдэж, Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт 2011 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр бүртгүүлж, баталгаажуулсан байна.

Ийнхүү өрийн хэмжээ буурснаар нийт эх үүсвэрт зээлийн эх үүсвэрийн эзлэх хувь буюу нийт хөрөнгийн дотор зээлийн эх үүсвэрээр санхүүжигдэж байгаа хэсгийн хувь хэмжээ буурч байгаа таатай үзүүлэлт харагдаж байна.



**1.18 ҮНЭЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГААР ГҮЙЦЭТГҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН БОЛОН БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН ДҮГНЭЛТ**

Үнэт цаас гаргагч нь “Бүртгэл-Эрдэм Нийгэмлэг” ТББ-тай № 2011/03 тоот гэрээ байгуулан хөрөнгийн болон бизнес үнэлгээг хөрөнгийн зах зээлд бонд гаргах зорилгоор хийж гүйцэтгүүлсэн.

Тус компанийн үндсэн хөрөнгийн үнэлгээг үйлдвэр тус бүрээр, хөрөнгийн нэр төрлөөр тайлангийн 2 дугаар бүлэгт тооцоолсноор бүгд 45,206.9 сая төгрөг гэж гаргасан.

Нийт активын үнэлгээний цэвэр дүн нь үндсэн ба эргэлтийн хөрөнгийн үнэлэгдсэн дүнгээс хүлээгдэж байгаа өр төлбөрийг хассан дүнгээр тооцоологддог. Энэ зорилгоор 2010 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар тодорхойлсон нийт хөрөнгө, тэдгээрт хийгдсэн хараат бус аудитын байгууллагын (“Далайван Аудит” ХХК) дүгнэлт тодруулга зэргээс үзвэл:

1. Эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл 5576.3 сая төгрөг гэж тайлагнасан боловч бусад авлагаас 12.3 сая төгрөгийг урьдчилж төлөгдсөн төлбөр тооцоонд шилжүүлжээ. Эргэлтийн хөрөнгийн өнөөгийн үнэлгээг тодорхойлохын тулд бид бэлэн бүтээгдэхүүний үлдэгдэл 15 хувиар борлуулалтын цэвэр ашгийг тооцоолж үнэлгээг 467.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, харин “Жаст групп” ХХК-ийн компани хоорондын тооцоогоор үүссэн 1900.0 сая төгрөгийг авлага болон богино хугацаат өрийн дүнгээс хасаж, эргэлтийн хөрөнгийн цэвэр дүнг 4 144.0 сая төгрөгөөр, богино хугацаат өрийн үлдэгдлийг 3 633.1 сая төгрөгөөр тус тус тооцлоо.
2. Урт хугацаат өрийн дансанд бүртгэгдсэн 28 237.8 сая төгрөгийн өр төлбөр нь бүхэлдээ “Жаст Агро” ХХК-нийн төв ба орон нутгийн сүлжээ үйлдвэрүүдийг байгуулахад Жаст групп (толгой компани)-ээс сүүлийн 5 жилд оруулсан хөрөнгө оруулалтын санхүүжилт тул “Далайван-Аудит” компанийн дүгнэлт, менежментийн зөвлөмжийн дагуу үлдэгдлийн дүнгээр урт хугацаат өрийн дүнг бууруулж, “Жаст Агро” ХХК-нийн эзэмшигчдийн өмчлөлд бүртгэх тухай “Жаст групп” ХХК-нийн Ерөнхий захирлын 2011 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн А-01/18 тоот тушаалыг үндэслэн урт хугацаат өр төлбөрөөс хасаж цэвэр активын үнэлгээг хүснэгт 3-аар тодорхойллоо.



**Цэвэр активын үнэлгээний нэгдсэн товчоо (сая төгрөгөөр)**

Хөрөнгийн нэр	2010 оны санхүүгийн тайлангийн		Үнэлгээний тохируулга	Шинэчилэн тогтоосон үнэлгээ
	Үлдэгдэл	Аудитын тохируулга		
<b>1. Эргэлтийн хөрөнгө</b>				
- Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	16.9			16.9
- Дансны болон бусад авлага	345.8	-12.3		333.5
- Холбоотой талуудын тооцоо	1 900.0		-1 900.0	
- Бараа материал	3 313.6		467.7	3781.3
- Урьдчилж төлсөн төлбөр, тооцоо		12.3		12.3
Эргэлтийн хөрөнгийн дүн	5 576.3		-1 432.3	4 144.0
<b>2. Эргэлтийн хөрөнгө</b>				
- Үндсэн хөрөнгө (цэвэр) ба дуусаагүй барилга	32 587.9	-431.8	13 050.8	45 206.9
- Биет бус хөрөнгө	3.2			3.2
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	32 591.1	-431.8	13 050.8	45 210.1
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>	<b>38 167.4</b>	<b>-431.8</b>	<b>11 618.5</b>	<b>49 354.1</b>
<b>3. Богино хугацаат өр төлбөр</b>				
- Дансны өглөг	1 025.5			1 025.5
- Бусад өглөг, урьдчилсан орлого	137.7			137.7
- Холбоотой талд өгөх өглөг	2 469.9		-1 900.0	569.9
- Банкны зээл	1 900.0			1 900.0
Богино хугацаат өрийн дүн	5 533.1		-1 900.0	3 633.1
<b>4. Урт хугацаат өр төлбөр</b>	28 237.8	-28 237.8		
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>33 770.9</b>	<b>-28 237.8</b>	<b>-1 900.0</b>	<b>3 633.1</b>
<b>5. Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>4 396.5</b>	<b>27 806.0</b>	<b>13 518.5</b>	<b>45 721.0</b>

Ийнхүү цэвэр активын үнэлгээний нэгдсэн тооцоогоор нийт хөрөнгийн үнэлгээний дүн нь 45 721.0 сая төгрөг болж 2010 оны эцэст байсан эзэмшигчийн өмчийн дүнгээс 41 324.5 сая төгрөгөөр буюу 9.4 дахин нэмэгдэж гарлаа.

Цэвэр актив буюу эзэмшигчийн үнэлгээний дүнгийн энэ өсөлтийн 67.3 хувь буюу 21806.0 сая төгрөг нь хөрөнгө оруулалтын санхүүжилтийн зээл хэлбэрээр олгосон урт хугацаат өр төлбөрийг эзэмшигчийн өмчлөлд шилжүүлэн бүртгэсэнтэй холбоотой, харин өмчийн өсөлтийн 32.7 хувь буюу 13 518.5 сая төгрөг нь нийт хөрөнгийн дахин үнэлгээний нөлөөгөөр нэмэгдсэн байна. Эдгээр тооцоолол дүгнэлтээс үндэслэн "Жаст Агро" ХХК-ийн цэвэр актив (нийт хөрөнгийн дүнгээс хүлээгдэж байгаа өр төлбөрийг хассан дүн)-ын зардлын болон зах зээлийн жишиг үнийн хандлагаар тооцсон үнэлгээний дүн 45 721.0 сая төгрөг болсоныг бүхэлтгэн 45 720.0 сая (дөчин таван тэрбум долоон зуун хорин сая) төгрөгөөр тогтов.

Хөрөнгийн зах зээлд өрийн бичиг (бонд) гаргах зориулалтаар тодорхойлсон "Жаст Агро" ХХК-ийн хөрөнгийн болоод бизнесийн нэгдсэн үнэлгээний нийлбэр дүнг дээр тогтоосон хөрөнгийн үнэлгээнд 45 хувийн, бизнесийн үнэлгээний дүнд 55 хувийн ач холбогдол өгч, тэдгээрийн жигнэсэн дунджаар тооцоолоход  $45\ 720.0 \times 0.45 + 60\ 070.0 \times 0.55 = 53\ 612.5$  сая төгрөг болж байгааг бүхэлтгэн "Жаст Агро" ХХК-ийн хөрөнгийн болон бизнес үнэлгээний нэгдсэн дүнг 53 600.0 (тавин гурван тэрбум зургаан зуун сая) төгрөгөөр тогтоож, үнэлгээний дэлгэрэнгүй тайланг холбогдох хавсралт хүснэгт тооцооллын хамт захиалагчид хүргүүлж байна.



*Handwritten signature in blue ink.*

*Handwritten signature in black ink.*

СЭЛ  
2011 оц 7 сар 06 өдөр  
БҮРТГЭВ  
1501

**Үнэлгээний талаарх захиалагчийн болон гүйцэтгэгчийн үүрэг хариуцлага**

Үнэлгээг Олон улсын үнэлгээний стандарт, Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, Засгийн газрын 2005 оны 233-р тогтоолоор батлагдсан “Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам”, “Барилгын нэгж талбайн төсөвт өртөг, төсвийн жишиг үнэлгээ батлах тухай” Засгийн газрын 2010 оны 336-р тогтоол, Дэд бүтцийн сайдын 1999 оны 343-р тушаалаар батлагдсан нэгж хүчин чадлын жишиг үнэ тогтоох аргачлал, “Барилгын дүрэм батлах тухай” Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2011 оны 29-р тушаал зэргийг удирдлага болгон тус компанийн улсын бүртгэлийн болон газар эзэмших эрхийн гэрээ гэрчилгээ, захиалагчийн санхүүгийн тайлан, хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл, бусад материалд тулгуурлан хийлээ.

Үнэлгээг Сангийн сайдын 2010 оны 280-р тушаалаар олгосон хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрлийн 071200025, тоот эрхийн гэрчилгээтэй үнэлгээчин Б. Сайнжаргал, Сангийн сайдын 2008 оны 367-р тушаалаар олгосон хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрлийн 081100106, 081100118, 091100150, 081100125 тоот эрхийн гэрчилгээтэй үнэлгээчин А.Раднаа, Н.Цацрал, С.Энхтөр, О.Чинбилэг нар хамтран гүйцэтгэсэн бөгөөд үнэлгээчид нь Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд заасан шаардлагыг үндэс болгон хариуцлагын даатгалд даатгуулсан болно.

Үнэлгээний явцад ашигласан мэдээллийн нууцлал, гэрээнд заагдсан холбогдох бусад асуудлыг гүйцэтгэгч хариуцна.

Үнэлгээг захиалагчийн ирээдүйн орлого, ашгаас хараат бусаар үнэлгээчний мэргэжлийн ёс зүйн дагуу гүйцэтгэсэн бөгөөд үнэлгээний ажлын хөлсийг үнэлгээний дүнгээс хамааралгүйгээр гэрээгээр урьдчилан тогтоосон болно.

**1.19 ҮНЭТ ЦААС ГАРГАХТАЙ ХОЛБОГДУУЛАН ГАРГАСАН ХУУЛЬЧИЙН ДҮГНЭЛТ, БУСАДТАЙ БАЙГУУЛСАН ИХ ХЭМЖЭЭНИЙ БОЛОН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ**

Компани нь олон нийтэд үнэт цаас санал болгон гаргах үйл ажиллагаатай холбогдуулан Санхүүгийн Зохицуулах Хорооны 2009 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 38 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, анхдагч зах зээлд санал болгох, худалдах тухай” журмын дагуу 2011 оны 3 дугаар сарын 10-ны өдөр Монгол Улсын хуулийн этгээд болох хууль зүйн үйлчилгээ, өмгөөлөлийн чиглэлээр дагнан үйл ажиллагаа явуулдаг “Ананд энд Батзаяа” ХХК-тай Хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээг байгуулсан. Гэрээний дагуу хуулийн компани нь холбогдох материалуудтай танилцсаны үндсэн дээр дараах чиглэлүүдээр хараат бус дүгнэлт гаргасан.

- Дүрэм, журам, бусад этгээдтэй байгуулсан гэрээ хэлцэл нь хууль тогтоомж, Компанийн Засаглалын Кодекс-т нийцэж байгаа эсэх,
- Үйл ажиллагааны гол үндэслэл болсон тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах зэргээр үйл ажиллагаанд бодитой нөлөөлж болох нөхцөл байдлын талаар,
- Олон нийтэд үнэт цаас санал болгохтой холбоотойгоор компанийн эрх бүхий этгээдийн гаргасан шийдвэр, тушаал нь хууль, эрх зүйн хувьд хүчин төгөлдөр эсэх зэрэг болно.

Дүгнэлт гаргахын тулд Компаниас гаргаж өгсөн дор дурьдсан баримт бичгүүдтэй танилцаж, шинжлэн судалсан болно. Үүнд:



1. Компанийн болон толгой компани болох “Жаст групп” ХХК-ийн дүрэм, хуулийн этгээдийн гэрчилгээ, танилцуулга,
2. Компанийн хөдөлмөрийн болон үйл ажиллагааны бусад журмууд,
3. Компаниас гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээ, хэлцлүүд,
4. Компанийн үйл ажиллагаатай холбоотой эрх олгосон төрийн захиргааны байгууллагын шийдвэр, эрхийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөл,
5. Дүгнэлт гаргахад шаардагдах холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэр.

**Хуулийн компанийн дүгнэлтээс**

- I. Компани нь “Жаст групп” ХХК-ийн 100 хувийн охин компани болохын хувьд “Монголын бахархал, төгс компани” байх хэтийн төлөвт тэмүүлж, компанийн эрх зүйн үндэс болсон Компанийн дүрэм, Компанийн үйл ажиллагааны дотоод дүрэм, Нягтлан бодох бүртгэлийн бодлого, Санхүүгийн үйл ажиллагааны заавар зэргийг Монгол Улсын хүчин төгөлдөр хууль тогтоомж хийгээд Монголын Компанийн Засаглалын Кодекс-т нийцүүлэн боловсруулж, даган мөрдөж байна. Хэдийгээр Монголын Компанийн Засаглалын Кодекс нь компанийн хувьцаа нь нийтэд чөлөөтэй арилжаалагддаг, нээлттэй буюу хувьцаат компанид тухайлан зориулагдаж боловсруулагдсан “Жаст групп” ХХК болон “Жаст Агро” ХХК нь өөрийн онцлогт тохируулан хэрэглэж байна.
- II. Компанийн Гүйцэтгэх захирал нь Компанийн дүрмийн 2 дугаар зүйлийн 2.6-д **“Хууль тогтоомж, компанийн дүрэм болон “Жаст групп” ХХК-ийн дүрэм, дотоод дүрэмд нийцүүлэн компанийн хэмжээнд дагаж мөрдөх тушаал, журам, заавар гаргах”** бүрэн эрхтэй.
- III. Компанийн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж буй дүрэм журмууд нь компанийн эрхэм зорилгыг хангах, ажилтан, албан хаагч нарын хариуцлагаа ухамсарлах нөхцлийг хангасан, аливаа шударга бус, хууль бус үйл ажиллагааг явуулахгүй байхыг тогтоосон, Монгол Улсын хүчин төгөлдөр хууль тогтоомжид нийцсэн, харилцагчаа хүндэтгэж, түүний өмнө хүлээх хариуцлагаа чухалчилсан байна.
- IV. Компани нь гуравдагч этгээдтэй байгуулсан хэлцлийг Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4-д **“Нэг өмчлөгчтэй компанид энэ бүлгийн заалтууд үл хамаарна”**, 86 дугаар зүйлийн 86.3-д **“Энэ бүлгийн заалтууд дараахь тохиолдолд үл хамаарна”** гээд мөн зүйлийн 86.3.1-д **“компанийн бүх энгийн хувьцааг нэг этгээд эзэмшиж байгаа компанид”** гэж заасны дагуу их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй хэлцэл мөн эсэхийг тодорхойлохгүй болно. Өөрөөр хэлбэл Компанийн тухай хуулийн 84, 86 дугаар зүйлүүдэд заасан их хэмжээний хэлцэл болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн эрх зүйн зохицуулалт нь компанид хамаарахгүй юм.
- V. Компанийн дүрмийн 2 дугаар зүйлийн 2.5-д **“мөнгөн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалттай холбоотой шийдвэрүүд болон банкнаас зээл авах”** асуудлыг “Жаст групп” ХХК-ийн Ерөнхий захиралтай заавал зөвшилцөн шийдвэрлэх ёстой гэж заасан байна. Хадгаламжийн банкттай байгуулсан зээлийн гэрээг байгуулахдаа “Жаст групп” ХХК-ийн Ерөнхий захиралтай амаар зөвшилцсөн болохыг “Хадгаламжийн банк” ХХК-ийн Гүйцэтгэх захирал болон компанийн Гүйцэтгэх захирал ярилцлагандаа тэмдэглэсэн болно. Цаашид

компанийн Гүйцэтгэх захирал нь дүрмийн 2 дугаар зүйлийн 2.5-д заасан эрхийг хэрэгжүүлэхдээ "Жаст групп" ХХК-ийн Ерөнхий захиралаас бичгээр шийдвэр гаргуулсан байх, эсхүл зөвшилцсөн тухайгаа баримтжуулсан байх нь ач холбогдолтой болохыг анхаарах хэрэгтэй.

- VI. Компанийн Гүйцэтгэх захирал нь Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.6-д **"Гүйцэтгэх удирдлага нь төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна"**, Компанийн дүрмийн 2.6-д **"Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хяналт тавих, Компанийн дүрэм болон "Жаст групп" ХХК-ийн дүрэм, дотоод дүрмээр хориглоогүй бусад асуудал"**, Компанийн дотоод дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1.3-д **"Компанийн нэрийн өмнөөс гэрээ, хэлэлцээр байгуулах"** гэж заасны дагуу гуравдагч этгээдтэй гэрээ байгуулах эрхтэй байна.
- VII. Компаниас байгуулж буй зарим гэрээг компанийн Ерөнхий нягтлан бодогч, Маркетинг хариуцсан захирал байгуулсан байх ба тэдгээр гэрээний заримыг компанийн Гүйцэтгэх захирал баталсан байна. Компанийн Гүйцэтгэх захирал батлаагүй, эсхүл компанийг төлөөлөн гэрээ байгуулагч этгээдэд Гүйцэтгэх захирал эрх олгоогүй тохиолдолд Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.8-д заасны дагуу тухайн гэрээ хүчин төгөлдөр бус болно. Үүний учир цаашид компанийг Төлөөлөн гэрээ байгуулагч этгээдэд эрх олгох, эсхүл тухайн гэрээг компанийн Гүйцэтгэх захирал баталгаажуулж байхыг зөвлөж байна.
- VIII. Мах, махан бүтээгдэхүүн экспортлох гэрээнүүд нь Иргэний хууль болон бусад хууль тогтоомжоос гадна мөн олон улсын худалдааны зарчим, ИНКОТЕРМС 2000 дүрмийг удирдлага болгосон байна.
- IX. Компанийн эрхэлж буй үйл ажиллагаа нь Аж ахуйн үйл ажиллагааны тухай Монгол Улсын хууль болон бусад хуульд заасан тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаанд хамаарахгүй болно. Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспорт болон дотоодын худалдааны үйл ажиллагаа эрхэлж байгаагын хувьд "Мах, махан бүтээгдэхүүн. Эрүүл ахуйн аюулгүй байдлын үндсэн шаардлага MNS5023-2001" стандартын шаардлагыг хангаж ажиллаж байгааг Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын Газрын Улсын байцаагчийн 2009 оны 4 сарын 23-ны өдрийн 11-29/189-1000 тоот дүгнэлтээр тогтоосон байна.
- X. Компанийн үйл ажиллагааг хэвийн явуулахад зайлшгүй шаардлагатай химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, ашиглах, худалдах аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг хангаж ажиллаж байгаа нь бидний судалсан баримт бичгээр тогтоогдож байна. Дүгнэлт гаргах өдрийн байдлаар энэхүү тусгай зөвшөөрлийг төрийн захиргааны эрх бүхий байгууллагаас цуцлах, шууд хүчингүй болгох нөхцөл байдлууд тогтоогдохгүй байна.
- XI. Компанийн бонд гаргах шийдвэрийг Компанийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2-д заасны дагуу компанийн хувь нийлүүлэгч "Жаст групп" ХХК гаргах бөгөөд өрийн бичгийн хэмжээ, төрөл,

ОН 7 сар 26 өдөр  
**БҮРТГЭВ**  
№ 01

хугацаа, гаргасан үнэ, хүүгийн хэмжээ, хүү төлөх хугацаа, эргүүлэн авах үнэ, бусад мэдээллийг заана. “Мах бонд” гаргах тухай “Жаст групп” ХХК-ийн 2011 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн А-01/19 дугаар тушаалд өрийн бичиг буюу бондын хэмжээ, гаргасан үнэ, хүүгийн хэмжээ, хүү төлөх нөхцөл зэргийг зааж өгсөн байна.


- XII. Компанийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч нь “Жаст групп” ХХК-ийн хувь нийлүүлэгч, Ерөнхий захирал, Монгол Улсын иргэн Шаравламдангийн Батхүү болно.
- XIII. Компани нь “Жаст групп” ХХК-ийн Ерөнхий захирлын 2011 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн А-01/18 дугаар тушаал, 2011 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн А-01/26 тоот тушаалаар өөрийн хөрөнгөө 28 237 845 241.90 /хорин найман тэрбум хоёр зуун гучин долоон сая найман зуун дөчин таван мянга хоёр зуун дөчин нэгэн төгрөг ерэн мөнгө/-н төгрөг болгон нэмэгдүүлж, УБЕГ-ын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгүүлж, баталгаажуулсан байна.
- XIV. Компанийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 26.3-т “Төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ нь компанийн өрийг хувьцаагаар солих төсөл боловсруулан хувь нийлүүлэгчдийн хуралд оруулж, уг асуудлаар саналын эрхтэй хуралд оролцогчдын дийлэнх олонхийн саналаар шийдвэрлүүлнэ.”, 63 дугаар зүйлийн 63.1.1-д “компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу түүний шинэчилсэн найруулгыг батлах;”, 60 дугаар зүйлийн 60.1-д “... Нэг хувь нийлүүлэгчтэй компанийн хувьд хувь нийлүүлэгчдийн хурлын бүрэн эрхийг хувь нийлүүлэгч өөрөө хэрэгжүүлнэ.” гэж заасны дагуу “Жаст групп” ХХК-ийн Ерөнхий захирал нь 2011 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн А-01/18 тоот тушаалаар “Жаст Агро” ХХК-ийн өөрийн хөрөнгө буюу эзэмшигчдийн өмчийг нэмэгдүүлсэн байна.

“Жаст Агро” ХХК-ийн дүрмийн 2 дугаар зүйлийн 2.2-т “Дараахь асуудлаар “Жаст групп” ХХК-ийн Ерөнхий захирал зөвхөн шийдвэр гаргана.

- компанийн дүрмийн санг нэмэгдүүлэх, хорогдуулах болон компанийн хувийг бусдад худалдах, шилжүүлэх,
- компанид үндсэн хөрөнгө эзэмшүүлэх, компанийн эзэмшиж буй үндсэн хөрөнгийг зарж борлуулах, актлах, бусдад шилжүүлэх” гэж заасан байдаг.

Иймд “Жаст групп” ХХК-ийн Ерөнхий захиралын 2011 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн А-01/18 дугаар тушаал, 2011 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн А-01/26 дугаар тушаал нь Компанийн тухай Монгол Улсын хууль, “Жаст Агро” ХХК-ийн дүрэмд нийцсэн, “Жаст групп” ХХК-ийн Ерөнхий захирал нь энэхүү шийдвэрийг гаргах бүрэн эрхтэй болно.

- XV. “Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, анхдагч зах зээлд санал болгох, худалдах тухай” журмын 2 дугаар зүйлийн 2.7-д “Нийтэд санал болгон бонд гаргаж байгаа компани нь энэ зүйлийн 2.2.1-2.2.3, 2.3-т заасан шаардлагыг хангасан байх бөгөөд бондын борлуулалтаас олохоор төлөвлөж байгаа хөрөнгийн дүн нь компанийн сүүлийн балансар байгаа цэвэр өөрийн хөрөнгийн дүнгээс илүүгүй байна” гэж заажээ. Компанийн тухай хуулийн 31





дүгээр зүйлийг 31.1-д заасны дагуу компанийн өөрийн хөрөнгө нь 2011 оны 01 дүгээр улиралын балансар **47 761 967 139.49 /дөчин долоон тэрбум долоон зуун жаран нэгэн сая есөн зуун жаран долоон мянга нэг зуун гучин есөн төгрөг дөчин есөн мөнгө/ төгрөг** болно. Иймд компанийн өөрийн хөрөнгө нь "Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, анхдагч зах зээлд санал болгох, худалдах тухай" журмын 2 дугаар зүйлийн 2.7-д заасан шаардлагыг хангаж байна.

Хуульч нь энэхүү дүгнэлтийг гаргахдаа хууль дээдлэх, хараат бус байх, шударга ёсны зарчмуудыг баримталж, Монгол Улсын Иргэний хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай Монгол Улсын хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай Монгол Улсын хууль, Монголын Компанийн Засаглалын Кодекс, Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, анхдагч зах зээлд санал болгох, худалдах тухай журам болон холбогдох бусад хууль тогтоомжуудыг үндэслэсэн болно.

### 1.20 ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

*Тус компанийн үндсэн эрхлэх үйл ажиллагаа нь мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хадгалах бөгөөд тус үйл ажиллагаатай холбоотой дараахи хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж байна. Эдгээрийн заримаас дурьдвал:*


1. Хүнсний тухай хууль
2. Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль
3. "Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай" хууль
4. "Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай" хууль г.м

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон нийслэлийн Баянгол дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 72 тоот тогтоолыг үндэслэн тус дүүргийн Засаг даргын Тамгын газрын Үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсээс Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх 97 дугаартай гэрчилгээг олгожээ. Гэрчилгээ нь 2010 оны 11 дүгээр сарын 24-нөөс 2011 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр хүртэл 1 /нэг/ жилийн хугацаанд хүчинтэй байна.

Компани нь үйлдвэрийн аюулгүй байдлыг хангаж Галын аюулгүй байдлын тухай хууль болон Онцгой Байдлын Ерөнхий Газрын даргын 2010 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 59 тоот тушаалаар батлагдсан журмын дагуу Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлтийг гаргуулжээ. Энэхүү дүгнэлт нь 2010 оны 12 дугаар сарын 03-наас 2011 оны 12 дугаар сарын 03-ны өдөр хүртэл 1 /нэг/ жилийн хугацаанд хүчинтэй байна.

Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9-д заасныг үндэслэн Улсын Мэргэжлийн Хяналтын Газраас 2011 оны 3 дугаар сарын 24-нд төв үйлдвэрт ААА зэрэглэлийн Итгэмжлэл (олон улсын зах зээлд мах нийлүүлэх эрх), компанийн бүх салбаруудад АА зэрэглэлийн Итгэмжлэл (дотоодын зах зээл, импортлогч орны эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр тухайн оронд мах нийлүүлэх үйл ажиллагаа явуулах эрх) олгосон байна. Энэхүү итгэмжлэл нь экспортлох эрх бүхий үйлдвэр, аж ахуйн нэгжид мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн үзлэг, хянан магадлагаа хийсний үр дүнд олгодог эрх зүйн баримт юм.

Монгол Улсад мах, махан бүтээгдэхүүн бэлтгэх, үйлдвэрлэх, худалдахтай холбоотой 42 стандарт мөрдөгдөж ажилладаг байна.



Компани, түүний эрх зүйн байдал, удирдлагын бүтэц, эрх үүрэг, компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны бодлого, төлөвлөгөө нь Компанийн тухай хууль, "Жаст групп" ХХК-ийн дүрэм болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагааны заавар, Компанийн дүрэм, үйл ажиллагааны дотоод дүрмээр тус тус тодорхойлогдоно.

Компанийн толгой компани нь нэг хувьцаа эзэмшигчтэй бөгөөд тухайн хувьцаа эзэмшигч нь компанийн хэлбэрийг өөрчлөх, өөрчлөн байгуулах, татан буулгах эрхтэй бөгөөд энэ нь компанийн сул тал болно.

Компани нь бонд гаргаснаар үнэт цаасны эрх зүйн харилцаанд оролцох бөгөөд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Санхүүгийн Зохицуулах Хороо, "Монголын Хөрөнгийн Бирж" ХК-иас гаргаж буй дүрэм, журам, заавраар бондтой холбоотой харилцаа нь зохицуулагдана.

Компанийн салбарын үйл ажиллагаа нь Компанийн дотоод дүрэмд заасан журмын дагуу зохицуулагддаг.

*Хөдөлмөрийн харилцааг зохицуулж буй хууль тогтоомж:*

1. Иргэний хууль,
2. Хөдөлмөрийн тухай хууль,
3. Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль,
4. Нийгмийн даатгалын тухай хууль,
5. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай,
6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай,
7. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай,
8. Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоол,
9. Засгийн газрын тогтоол Журам батлах тухай "Ажлын цагийг нэгтгэн бодох журам", "Хөдөлмөрийн маргаан таслах комиссын дүрэм",
10. Аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн ажлыг зохион байгуулах журам /Эрүүл мэнд, Нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаал/ г.м

Хөдөлмөрийн харилцааг зохицуулж буй хууль тогтоомжийн зорилго нь хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр хөдөлмөрийн харилцаанд оролцогч ажилтан, ажил олгогчийн нийтлэг эрх, үүрэг, хамтын гэрээ, хэлэлцээр, хөдөлмөрийн ганцаарчилсан ба хамтын маргаан, хөдөлмөрийн нөхцөл, удирдлага, хяналт болон хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг тодорхойлж талуудын харилцан эрх тэгш байдлыг хангахад оршино.

*Аж ахуйн нэгж, байгууллагын татвартай холбоотой харилцаа нь дараах хууль тогтоомжоор зохицуулагдаж байна. Эдгээрээс дурьдвал,*

1. Татварын ерөнхий хууль,
2. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль,
3. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль,
4. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай,
5. Татварын өршөөл үзүүлэх тухай хууль,
6. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
7. ҮТЕГ-ын даргын тушаал "Аргачлал батлах тухай" /Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх аргачлал/ г.м



*Handwritten signature in blue ink.*



Татварын ерөнхий хуулиар Монгол Улсад татвар бий болгох, тогтоох, ногдуулах, тайлагнах, төлөх, хянан шалгах, хураах эрх зүйн үндсийг тогтоож, татвар төлөгч болон татварын албаны эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлон тэдгээрийн хооронд үүсэх харилцааг зохицуулна.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулиар аж ахуйн нэгж, байгууллагын дараах төрлийн орлогод албан татвар ногдоно:

- I. Үйл ажиллагааны орлого /Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 8.1.1-8.1.11-т заасан орлого/,
- II. Хөрөнгийн орлого /Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 9.1.1-9.1.4-т заасан орлого/,
- III. Хөрөнгө борлуулсны орлого /Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 10.1.1-10.1.2/

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулиар дор дурьдсан бараа, ажил, үйлчилгээнд нэмэгдсэн өртгийн албан татварыг 0-10 хувиар тооцож ногдуулна. Үүнд:

- I. Монгол Улсын нутаг дэвсгэрт борлуулсан бүх төрлийн бараа;
- II. Худалдах, хэрэглэх буюу ашиглах зориулалтаар Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадаад улсад экспортолсон бүх төрлийн бараа;
- IV. Худалдах, хэрэглэх буюу ашиглах зориулалтаар гадаад улсаас Монгол Улсын нутаг дэвсгэрт импортолсон бүх төрлийн бараа;
- V. Монгол Улсын нутаг дэвсгэрт гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээ.

Мөн хуульд нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх, татвар ногдох боловч "тэг" хувь байх бараа, ажил, үйлчилгээний жагсаалтыг тусгасан байна. Үүний дотор:

- Үр тариа болон мах үйлдвэрлэгчдийг дэмжиж НӨАТ-аас чөлөөлсөн.
- Хүн амын хүнсний хангамжинд үйлдвэрийн аргаар бэлтгэсэн махны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх үүднээс НӨАТ-аас чөлөөлөх талаар хуулийн төсөл боловсруулан УИХ-аар хэлэлцүүлж, нааштай шийдвэр гарсан.


*Дэлхийн болон ихэнх бүс нутагт хүнсний хомсдол нүүрлэх болсон энэ цаг үед Монголчууд мах, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, будаа, төмс хүнсний ногоо зэрэг эх орны хөрсөнд бий болсон экологийн цэвэр, эрүүл хүнсээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангах, цаашлаад дэлхийн зарим улс орнуудад бүтээгдэхүүний хомсдлыг багасгахад тодорхой хувь нэмэр оруулж, экологийн цэвэр, чанартай тодорхой хэмжээний бүтээгдэхүүнийг экспортлох боломжийг харж мах бэлтгэл, боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор төр засгаас дараах хөтөлбөрүүдийг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.*

**1. "Монгол мал" хөтөлбөр**

Монголын мал аж ахуйг байгаль, цаг уурын өөрчлөлт, нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлж, зах зээлийн нөхцөлд өрсөлдөх чадвартай, эдийн засгийн үр ашигтай салбар байх нөхцлийг бүрдүүлж, хүн амыг эрүүл аюулгүй хүнсээр, боловсруулах үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангаж, экспортыг нэмэгдүүлэх зоригор 2010 оны 5 дугаар сарын 20-нд УИХ-аас уг хөтөлбөрийг баталсан байна.

**2. "Малын эрүүл мэнд" хөтөлбөр**

Засгийн газрын 1999 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 64-р тогтоолоор батлагдсан бөгөөд Мал сүрэг, аж ахуйн зориулалтаар үржүүлж буй амьтдын эрүүл мэндийг хамгаалах тогтолцоог боловсонгой болгож, ажил үйлчилгээний чанарыг дээшлүүлэх үндсэн дээр малыг халдварт өвчнөөс



хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилготой ажээ. Энэхүү хөтөлбөр амжилттай хэрэгжснээр малын халдварт өвчний гаралт буурахаас гадна аливаа өвчинтэй холбоотойгоор гадаад орнуудын махны экспортод тавьдаг элдэв хориг саад үгүй болох юм.

3. **“Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” хөтөлбөр**

Уг хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 160 дугаар тогтоолоор баталсан байна. Хөтөлбөр нь 2003-2008, 2009-2015 онуудыг хамарсан 2 үе шаттайгаар явагдах бөгөөд малыг махны, сүүний, мах-сүүний чиглэлээр эрчимсэн мал аж ахуйг хөгжүүлэх замаар малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, малын үүлдэр угсааг сайжруулах зорилготой ажээ.

Энэхүү хөтөлбөр амжилттай хэрэгжснээр цаашид экспортын махны чанарт ахиц гарч, олон улсын зах зээл дээр Монгол махны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх юм.

4. **“Малын чанар сайжруулах” хөтөлбөр**

Хөтөлбөр нь Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 4 дүгээр сарын 26-ний өдрийн 93 дугаар тогтоолоор батлагдсан бөгөөд малын чанарыг сайжруулах, малын удмын санг хамгаалах зорилготой ажээ.

5. **“Хүнсний хангамж, хоол тэжээл”, “Хүнсний баталгаат байдал” хөтөлбөр**

Засгийн газраас 2001 онд үндэсний аюулгүй байдлыг хамгаалах дээрх хоёр томоохон хөтөлбөрийг баталсан.

*Жил бүр үүсэх махны үнийн хөөрөгдлийг багасгах үүднээс нөөцийн маханд урамшуулал олгох болсон. “Мах хадгалах, борлуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх урамшуулал олгох” гэрээ*

Энэхүү гэрээ нь МУ-ын Засгийн газрын тогтоолын дагуу батлагдсан “Мах бэлтгэн хадгалж, борлуулсан аж ахуй нэгжид урамшуулал олгох” журам-ыг үндэслэн Нийслэлийн захирамжийн дагуу Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд захирагчийн ажлын албаны даргатай байгуулдаг байна.

Гэрээгээр Улаанбаатар хотын иргэдийн махны хэрэгцээг хангах, үнийг тогтвортой байлгах зорилгоор махны нөөц бүрдүүлэх, хадгалах, баталсан хуваарийн дагуу борлуулах компаниудыг шалгаруулж, үйл ажиллагаанд нь хяналт тавих, урамшуулал олгох зэрэг асуудлыг зохицуулдаг байна.

Үнэт цаас гаргагч нь хамгийн сүүлд 2010 оны 8-р сарын 25-ний өдөр энэхүү гурвалсан гэрээг Улаанбаатар хотын Захирагчийн алба, Монголын Махны холбоотой байгуулжээ. Уг гэрээгээр компани 2011 онд Улаанбаатар хотын иргэдийн махны хэрэгцээнд зориулан 2400 тонн махыг /үхэр 150 тонн, хонины мах 1770 тонн, ямааны мах 480 тонн/ бэлтгэж, борлуулах үүргийг хүлээсэн байна.



*Handwritten signature in blue ink.*



**ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА**

**2.1 ОЛОН НИЙТЭД САНАЛ БОЛГОХ БОНДЫН ТАНИЛЦУУЛГА**

Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын Компанийн тухай (1999) хуулийн 42, 43 дугаар зүйл, Үнэт цаасны зах зээлийн тухай (2002) хуулийн 4, 5 дугаар зүйлийг үндэслэн олон нийтэд нээлттэй бонд гаргаж байна.

<b>Бондын төрөл:</b>	Нэрлэсэн үнэтэй, биет бус
<b>Нэрлэсэн үнэ:</b>	10,000 төгрөг
<b>Нийт ширхэг</b>	3,000,000 ширхэг
<b>Нийт үнийн дүн:</b>	30,000,000,000 төгрөг
<b>Бондын хугацаа:</b>	12 сар
<b>Хүүгийн хэмжээ жилийн, /сарын/:</b>	16,2% , /1,35%/
<b>Хүү төлөх хугацаа:</b>	Улиралд нэг удаа
<b>Анхдагч зах зээлд байршуулах:</b>	Хэсэгчлэн
<b>Хэсэгчилэн гаргах давтамж:</b>	3 удаа
<b>Хэсэгчилэн гаргах хэмжээ:</b>	10,000,000,000 төгрөг
<b>Эргүүлэн авах нөхцөл:</b>	Хэсэгчлэн гаргасан хугацаа бүрийн эцэст нэрлэсэн үнээр
<b>Бонд гаргах зорилго:</b>	Мах бэлтгэлийн ажлыг санхүүжүүлэх
<b>Бондын баталгаа:</b>	Үл хөдлөх хөрөнгөөр (мах борлуулалтын гэрээ) баталгаажна.
<b>Бондын үндсэн болон хүүгийн төлбөрийн хугацаа хэтрэлт:</b>	Хүү төлөх өдрөөс хугацаа хэтэрсэн хоног тутамд хүүгийн төлбөрөөс 0,02 хувиар алданги нэмж тооцон хүүг алдангийн хамт Үнэт цаас эзэмшигчид шилжүүлнэ.
<b>Бондын андеррайтер:</b>	"БиДиСЕК" ХК
<b>Бонд эзэмшигчдийн бүртгэл, төлбөр тооцоо, хадгаламж:</b>	"Үнэт Цаасны Төлбөр Тооцоо Төвлөрсөн Хадгаламжийн Төв" ТӨХХК
<b>Бонд арилжаалагдах зах зээл:</b>	Монголын Хөрөнгийн Биржийн арилжаагаар дамжуулан олон нийтэд нээлттэй арилжаална.



**2.2 ҮНЭТ ЦААС ГАРГАХ ТУХАЙ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДИЙН ШИЙДВЭР**

“Компанийн тухай хууль”-ийн 42, 43 дугаар зүйл, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4, 5 дугаар зүйлийг үндэслэн Компанийн хувь нийлүүлэгч “Жаст групп” ХХК-ийн Ерөнхий захирлын 2011 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн А-01/19 дугаар тушаалаар 30 000 000 000 /гучин тэрбум/ төгрөгийн үнэ бүхий, нэг бүр нь 10 000 /арван мянга/-н төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 3 000 000 /гурван сая/ ширхэг, “Мах бонд”-ыг жилийн хүү нь 16.2 хувь байх, 90 хоног тутам хүү төлөх нөхцөлтэй гаргахаар шийдвэрлэсэн.

Тушаалын эх хувь:



**“ЖАСТ ГРУПП” ХХК-ИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН  
ТУШААЛ**

2011 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А-01/19

Улаанбаатар хот

Мах бонд гаргах тухай

“Жаст Агро” ХХК-ийн Стратегийн дунд шатны бизнес төлөвлөгөөнд дэвшүүлэгдсэн зорилтыг хэрэгжүүлэх, мал бэлтгэх үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

Нэг. “Жаст Агро” ХХК-ийн 2011 оны мал бэлтгэлийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулж нэг бүр нь 10 мянган төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 3 сая ширхэг бонд гаргахыг зөвшөөрсүгэй.

Хоёр. Компанийн гаргасан бондыг “Мах бонд” гэж нэрлэсүгэй.

Гурав. Бондын нэрлэсэн хүү жилийн 16.2 хувь, 90 хоног тутамд хүүг төлөх нөхцөлтэй байх ба үнэт цаасны зах зээлд байршуулж, худалдан борлуулах зэрэг үйл ажиллагааны зардал нь нэрлэсэн үнийн 2.5 хувиас хэтрэхгүй байхаар брокерын пүүсийн зөвлөхүүдтэй урьдчилан ярилцаж, гэрээ байгуулах ажлын бэлтгэл хангахыг Ажлын хэсгийн ахлагч Б.Хөхөөжаргалд үүрэг болгосугай.



ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

*[Signature]* Ш.БАТХҮҮ



Үнэт цаас гаргах шийдвэр нь хууль, эрх зүйн хүчин төгөлдөр эсэх талаарх хуулийн компанийн дүгнэлт:

Компанийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2-т **“Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол өрийн бичиг гаргах шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/ гаргана. Энэ шийдвэрт өрийн бичгийн хэмжээ, төрөл, хугацаа, гаргасан үнэ, хүүгийн хэмжээ, хүү төлөх хугацаа, эргүүлэн авах үнэ, бусад мэдээллийг заана.”** гэж хуульчилсан байна. “Жаст Агро” ХХК-ийн дүрэмд зааснаар тус компани нь Төлөөлөн Удирдах Зөвлөлгүй учир өрийн бичиг буюу бонд гаргах шийдвэрийг Хувь нийлүүлэгчдийн хурал буюу Компанийн тухай Монгол Улсын хуулийн 60 дугаар зүйлийн 60.1-д **“... Нэг хувь нийлүүлэгчтэй компанийн хувьд хувь нийлүүлэгчдийн хурлын бүрэн эрхийг хувь нийлүүлэгч өөрөө хэрэгжүүлнэ.”** гэж заасны дагуу “Жаст групп” ХХК-ийн Ерөнхий захирал гаргасан. “Мах бонд” гаргах тухай “Жаст групп” ХХК-ийн 2011 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн А-01/19 дугаар тушаалд өрийн бичиг буюу бондын нэр, хэмжээ, нэрлэсэн үнэ, хүү, хүү төлөх нөхцөл зэргийг зааж өгсөн байна.

Иймд “Мах бонд” гаргах тухай “Жаст Агро” ХХК-ийн хувьцаа эзэмшигч “Жаст групп” ХХК-ийн Ерөнхий захиралын 2011 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн А-01/19 дугаар тушаал нь Үнэт цаасны тухай Монгол Улсын хууль, Компанийн тухай Монгол Улсын хууль болон бусад хууль тогтоомжинд нийцсэн байна.



*Handwritten signature in blue ink.*



*Handwritten signature in blue ink.*

**2.3 БОНДЫН БАТАЛГАА**

Үнэт цаас гаргагч болон Андеррайтерын компанитай 2011 оны 3 дугаар сарын 14-ны өдөр байгуулсан Андеррайтерын гэрээний 6-р бүлэгт тусгагдсаны дагуу бондын баталгаа нь компанийн үл хөдлөх хөрөнгө болон бүтээгдэхүүний борлуулалтын гэрээгээр хийгдэж байгаа болно.

Үл хөдлөх хөрөнгө:

Бондын үндсэн болон хүүгийн төлбөрийн нийт дүнг хангахуйц үнийн дүнтэй Үнэт цаас гаргагчийн эзэмшлийн дараах үйлдвэрүүдээр баталгаа гаргасан болно.



**"ЖАСТ ГРУПП" ХХК-ИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН  
ТУШААЛ**

2011 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А-01/28

Улаанбаатар хот

Хөрөнгө тусгаарлах зөвшөөрөл олгох тухай

"Мах бонд" өрийн бичиг гаргах гэж байгаатай холбогдуулан ТУШААХ нь:

Нэг. "Жаст Агро" ХХК-ийн "Би Ди Сек" ХК-тай байгуулсан Андеррайтерын гэрээний дагуу "Мах бонд" өрийн бичиг гаргахтай холбогдуулан энэхүү тушаалын Нэгдүгээр хэсэрт дурьдагдсан "Жаст Агро" ХХК-ийн үл хөдлөх эд хөрөнгүүдийг бондын баталгааны барьцаа болгож тусгаарлан "Би Ди Сек" ХК-тай барьцааны гэрээ байгуулахыг "Жаст Агро" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Содномдаржаал-д зөвшөөрсүгэй.

Хоёр. Нэгдүгээр хэсэрт дурьдагдсан салбар үйлдвэрүүдийн хөрөнгүүдийг Андеррайтерын гэрээгээр тохиролцсоноос өөр зорилгоор ашиглахгүй байхыг "Жаст Агро" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Содномдаржаал-д үүрэг болгосугай.

Гурав. Олон нийтэд санал болгож буй бондыг бүртгэх тухай Санхүүгийн Зохицуулах Хорооны тогтоол гарсны дараа Нэгдүгээр хэсэрт дурьдагдсан хөрөнгүүдийг тусгаарлан УБЕГазрын Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газарт бүртгүүлэхийг "Жаст Агро" ХХК-ийн Санхүү хариуцсан дэд захирал М.Баасанжаргал-д үүрэг болгосугай.

Дөрөв. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын газрын захирал Б.Хөхөөжаргал-д үүрэг болгосугай.



ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ







"Жаст групп" ХХК-ийн Ерөнхий захирлын 2011 оны 05 сарын 19 өдрийн 8-41/10 дугаар тушаалын Нэгдүгээр хавсралт

Тусгаарлах хөрөнгийн жагсаалт

№	Үйлдвэрийн нэр	ҮХЭХӨЭ-ийн Улсын бүртгэлийн дугаар	Тусгаарлах хөрөнгийн дүн, (мян.төг)
1	Улаанбаатар ММ	Y-2205011375	11,939,667.9
2	Баян-Өлгий Мах маркет	Y-0213000010	4,491,252.2
		Y-0213000430	
		Y-0213000445	
		Y-0213000446	
		Y-0213000447	
		Y-0213000448	
		Y-0213000449	
		Y-0213000450	
3	Завхан Мах маркет	Y-0905000534	1,234,576.3
		Y-1213001436	
4	Сүхбаатар Мах маркет	Y-1213000413	1,157,204.0
		Y-0415000106	
5	Булган Мах маркет	Y-0415000106	1,384,128.6
6	Увс Мах маркет	Y-1520001817	815,467.6
		Y-0614002893	
7	Дорнод Мах маркет	Y-0614002894	8,374,918.5
		Y-0614002895	
		Y-1723002151	
8	Хөвсгөл Мах маркет	Y-1723002151	2,218,022.1
<b>Нийт дүн</b>			<b>31,615,237.2</b>

Борлуулалтын гэрээ:

Лалын Бүгд Найрамдах Иран Улс руу 4600 /дөрвөн мянга зургаан зуу/-н тонн хонины махыг 2012 оны 02 дугаар сарын 28-ний өдрөөс өмнө 2 удаагийн тээвэрлэлтээр нийлүүлэх гэрээг 2011 оны 3 дугаар сарын 10-ны өдөр "Юни трейд" компанитай байгуулсан.

ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улсын "Бурятмяспром" компанитай 30 720 000 /гучин сая долоон зуун хорин мянга/-н ам.долларын үнийн дүн бүхий 12000 тн адуу, үхрийн махыг 2011 оны 8 дугаар сарын 01-нээс 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд нийлүүлэхээр худалдах, худалдан авах гэрээг 2011 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр байгуулсан.



*Handwritten signature in blue ink.*



*Handwritten signature in black ink.*

**2.4 ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ**

Бонд эзэмшигч нь дараах эрхтэй байна. Үүнд:

- Бонд эзэмшигч нь дараах бичиг, баримтууд болон мэдээллийг шаардах эрхтэй. Үүнд:
  - o Төслийн гүйцэтгэл, явцын талаар мэдээ тайлан, үйлдвэрлэл худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй холбогдсон баримт бичиг
  - o Төслийн хөрөнгийн талаархи зарцуулалт, санхүүгийн бодит мэдээлэл
  - o Бондын хоёрдогч зах зээлийн арилжааны үнэ, ханш болон арилжааны мэдээ
- Бонд эзэмшигч нь өөрийн эзэмшиж буй бондыг хоёрдогч зах зээл дээр чөлөөтэй арилжиж, захиран зарцуулах,
- Улирал бүрийн эцэст бондын хүүг тооцуулан авах, Үнэт цаас гаргагчаас Бондын хүүг хугацаандаа төлөхийг шаардах, хүү төлөх хугацаа хэтэрсэн тохиолдолд хүүгийн төлбөр дээр 0.02 хувийн алданги нэмж, тооцуулан авах,
- Хугацааны эцэст бондыг нэрлэсэн үнээр Үнэт цаас гаргагчид эргүүлэн худалдах, худалдан авахыг шаардах, хугацаа хэтэрсэн тохиолдолд баталгаа гаргасан хөрөнгөөр үүргийн гүйцэтгэл хангахыг шаардах, тооцуулан авах,
- Компанийн үйлдвэрлэл, борлуулалтын явц, гүйцэтгэлтэй холбоотой тодруулга, мэдээллийг Үнэт цаас гаргагч болон Андеррайтерын компаниас гаргуулан авах болон Монгол Улсын холбогдох хууль журамд заасан бусад эрхүүдийг эдэлнэ.

**2.5 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮҮРЭГ**

- Үнэт цаас гаргагч нь өөрийн санхүү болон бусад бодит байдлын талаар үнэн зөв мэдээлнэ,
- Үнэт цаас гаргагч нь Бонд худалдан борлуулснаас орсон орлогыг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна,
- Үнэт цаас гаргагч нь бондын хүүгийн болон үндсэн төлбөрийг графикын дагуу цаг хугацаанд нь төлнө,
- Үнэт цаас гаргагч нь Бондын үүргийн гүйцэтгэлийг хангахуйц үнийн дүн бүхий, өөрийн эзэмшлийн үл хөдлөх хөрөнгө болон борлуулалтын гэрээгээр бондын баталгаа гаргана,
- Үнэт цаас гаргагч нь үйл ажиллагааны болон бусад хүчин зүйлээс хамаарч Бондын хүүгийн болон үндсэн төлбөр төлөлтөд гарах эрсдлийг өөрийн хөрөнгөөр хариуцана

**БОНД ЭЗЭМШИГЧИД МЭДЭЭЛЭЛ ХҮРГЭХ ҮҮРЭГ**

“Жаст Агро” ХХК нь бондын танилцуулгад заасан зориулалтаар хөрөнгийг зарцуулж байгаа эсэх, хүү тооцсон тооцоолол, төслийн ажлын гүйцэтгэлийн талаар бонд эзэмшигчдэд мэдээллэх үүрэгтэй. Үнэт цаас гаргагч нь тус үүргээ доор дурьдсан байдлаар хэрэгжүүлнэ.

- [www.justgroup.mn](http://www.justgroup.mn) вэб хуудсаар мэдээлэл тавих /хоёрдогч зах зээлд оролцох сонирхолтой хувь хүн, хуулийн этгээдэд төсөлтэй холбоотой цаг үеийн мэдээллийг байршуулах/
- Бонд эзэмшигчийн электрон шуудангийн хаягаар гүйцэтгэлийг тайлагнах
- Газар дээрх гүйцэтгэлтэй танилцуулах /бонд эзэмшигч болон хоёрдогч зах зээлд оролцох сонирхолтой хувь хүн, хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу

төслийн гүйцэтгэл, хэрэгжилтийг газар дээр нь биечлэн танилцуулах аялалыг зохион байгуулах/

**2.6 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНАЛ БОЛГОЖ БУЙ БОНДЫН ХҮҮГИЙН ТҮВШИН**

Эх сурвалж: Монгол банкны статистик

Үнэт цаас гаргагчийн олон нийтэд санал болгож буй “мах бонд”-ын хүүг арилжааны банкуудын хадгаламж, зээлийн хүүгийн түвшин болон МХБ дээр өмнөх хугацаанд гарч байсан бондын хүүг үндэслэн тодорхойлсон.




График 13 Банк болон ААН-ийн бондын хүүгийн судалгаа

Мах бонд нь жилийн 16.2 хувь, сарын 1.35 хувийн хүүтэй бөгөөд энэ нь арилжааны банкуудын (монгол банкны статистик мэдээ, банкны системийн жигнэсэн дундаж, 2011 оны 4 сар) олгож буй хадгаламжийн дундаж хүүтэй харьцуулахад 51.4 хувь (5.5 нэгж) аар өндөр, зээлийн хүүгийн түвшинтэй харьцуулахад 0.6 хувь (0.1 нэгж) аар бага байна.




График 14 Компанийн бондын хүүгийн мэдээлэл

2001 оноос анх Монголын хөрөнгийн зах зээл дээр аж ахуй нэгж байгууллагууд бонд гаргах замаар хөрөнгө оруулалт татаж эхэлсэн бөгөөд үүнээс хойш нийт 13 компани бонд гаргасан байна. Хөрөнгийн зах зээлд гаргасан бондын хүүгийн судалгааг дараах графикаас харж болно.

**2.7 АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ АРИЛЖАА**

Тус арилжаа нь Санхүүгийн Зохицуулах Хорооны “Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, үнэт цаасыг анхдагч зах зээл дээр санал болгох, худалдах тухай журам”, Монголын Хөрөнгийн Биржийн “Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам”-ын дагуу явагдана.

Олон нийтэд санал болгон гаргаж буй 3,000,000 ширхэг бондыг анхдагч зах зээлд байршуулах хүчин төгөлдөр хугацаа нь 12 сар байна. Бондыг анхдагч зах зээлд байршуулахдаа үндсэн гурван хэсэгт хуваан хэсэгчлэн гаргана.

- I. Эхний хэсгийн нэг сая ширхэг буюу 10 тэрбум төгрөгийн бондыг Санхүүгийн Зохицуулах Хорооны зөвшөөрөл гарч, Монголын Хөрөнгийн Биржид бүртгэгдсэнээс хойш 2011 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн дотор анхдагч зах зээлд нэрлэсэн үнээр худалдан байршуулна. Эхний нэг сая ширхэг бондыг анхдагч зах зээлд амжилттай байршуулснаас хойш ажлын 15 хоногийн дотор анхдагч зах зээлд байршуулсан тайланг холбогдох эрх бүхий байгууллагууд болон олон нийтэд хүргэнэ.
- II. Санал болгох дараагийн нэг сая ширхэг бондыг эхний хэсгийн бонд анхдагч зах зээлд амжилттай арилжаалагдсаны дараа Үнэт цаас



TTA4467 2011.07.07

2011 оны 7 сар 07 өдөр

**БҮРТГЭВ**

№ 01

гаргагчийн эргэлтийн хөрөнгийн хэрэгцээтэй уялдуулан 2011 оны 8-9 дүгээр сард анхдагч зах зээлд байршуулна. Нийтэд санал болгосон хоёрдах хэсгийн нэг сая ширхэг бондыг анхдагч зах зээлд амжилттай байршуулснаас хойш ажлын 15 хоногийн дотор анхдагч зах зээлд байршуулсан тайланг холбогдох эрх бүхий байгууллагууд болон олон нийтэд хүргэнэ.

- III. Санал болгох гуравдах хэсгийн нэг сая ширхэг бондыг хоёрдох хэсэгт санал болгосон бонд анхдагч зах зээлд амжилттай арилжаалагдсанаас хойш Үнэт цаас гаргагчийн эргэлтийн хөрөнгийн хэрэгцээтэй уялдуулан 2011 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор анхдагч зах зээлд байршуулна. Нийтэд санал болгосон гуравдах хэсгийн бондыг анхдагч зах зээлд амжилттай байршуулснаас хойш ажлын 15 хоногийн дотор анхдагч зах зээлд байршуулсан тайланг холбогдох эрх бүхий байгууллагууд болон олон нийтэд хүргэнэ.

**Бонд гаргах, төлбөр төлөх хугацааны график**

Хугацаа	2011 он					2012 он								
	8	9	10	11	12	1	2	3	4	5	6	7	8	9
Бонд 1	10 тэрбум төгрөг													
Бонд 2	10 тэрбум төгрөг													
Бонд 3	10 тэрбум төгрөг													
Хүүгийн төлбөр 1				+			+			+			+	
Хүүгийн төлбөр 2					+			+			+			+
Хүүгийн төлбөр 3						+			+			+		+
Үндсэн төлбөр 1													+	
Үндсэн төлбөр 2														+
Үндсэн төлбөр 3														+

Бонд хадгалах, өмчлөх эрх бүртгэх ажиллагаа, бондын анхдагч болон хоёрдогч зах зээл дээрх төлбөр тооцоог "ҮЦТТТХТ" ХХК хийж гүйцэтгэнэ.

Үнэт цаас гаргагч нь графикт заасан төлбөрийг ажлын өдрийн 12.00 цагаас өмнө Хадгалагчийн дансанд шилжүүлсэн бол Т+0 хугацаанд, 12.00 цагаас хойш хийсэн бол Т+1 хугацаанд багтаан холбогдох төлбөр тооцоог хийж гүйцэтгэнэ. Өөрөөр хэлбэл Хадгалагч нь 12.00 цагаас өмнө төлбөрийг хүлээн авсан тохиолдолд тухайн өдрийн 14.00-16.30 цагийн хооронд төлбөрийг бонд эзэмшигчид шилжүүлнэ. Хэрэв 12.00 цагаас хойш төлбөр хүлээн авсан тохиолдолд дараагийн ажлын өдрийн 09.00-12.00 цагт багтаан төлбөр шилжүүлнэ.

Үнэт цаас гаргагч нь графикийн дагуу нэг дэх, хоёр дах, гуравдах улирлын хүүгийн төлбөрийг, сүүлийн дөрөвдөх улиралд тухайн улирлын хүүгийн төлбөрийг бондын үндсэн төлбөрийн хамт "ҮЦТТТХТ" ХХК дах бонд эзэмшигчийн дансанд шилжүүлнэ.

Бондын хүүгийн төлбөр төлөх өдөр нь амралтын өдөр таарсан тохиолдолд дараагийн ажлын өдөр бонд эзэмшигчийн дансанд хүүгийн төлбөрийг шилжүүлнэ.



**Үнэт цаасыг хэрхэн худалдан авах вэ?**

Хөрөнгө оруулагч нь үнэт цаасыг худалдан авахын тулд “Үнэт цаасны танилцуулга” хийгдэхэд анхдагч зах зээлийн арилжаанд брокер дилерийн компаниар дамжуулан оролцоно.

Хөрөнгө оруулагч нь арилжаанд оролцохдоо бонд худалдан авах үнийн дүн болон шимтгэлд төлөх төлбөрийн нийлбэр дүнг үнэт цаасны дансандаа байршуулсан байх шаардлагатай.

**Үнэт цаасыг хэн худалдан авах вэ?**

Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд “ҮЦТТХТ”ХХК-д данс нээлгэсэн Монгол Улсын болон гадаадын аж ахуйн нэгж байгууллага, хувь хүн оролцох эрхтэй.

Данс нээх талаар та брокерийн компаниудаас дэлгэрэнгүй мэдээллийг авна уу.

**Татвар, шимтгэл**

Арилжааны шимтгэл

Үнэт цаасны арилжаанд ороход Та нийт гүйлгээний үнийн дүнгийн 0.1 хувиар шимтгэл төлнө.

Татвар

“Хувь хүний орлогын албан татварын тухай” хуулийн 30.2 дугаар зүйл “энэ хуулийн 13.1.3, 13.1.4-т заасан орлогод 2013/01/01-ний өдрөөс эхлэн албан татвар ногдуулна” гэж заасан ба 13.1.3 “ногдол ашгийн орлого” ба 13.1.4 “хүүгийн орлого” гэж тодорхойлжээ.

*Иймд иргэн, хувь хүн хүүгийн орлогод 2013 он хүртэл татвар төлөхгүй.*

“Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай” хуулийн 16.3 “Дараахь орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо албан татвар ногдуулах тухайн орлого тус бүрийн нийт дүнгээр тооцно”, 16.4.4 “хүүгийн орлого”, 9.1 “Албан татвар төлөгчийн дараахь орлогод дор дурдсан хувиар албан татвар ногдуулна”, 9.1.4 “хүүгийн орлого” гэж заагдсан.

*Иймд хүүгийн орлого олсон байгууллага нь аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлангаар хүүгийн орлогоосоо 10 хувиар татвар ногдуулж төлнө.*

Борлуулалтын орлогоос олсон ашгаас татвар төлөх:

Үнэт цаас борлуулсан тохиолдолд албан татвар төлөх орлогыг тодорхойлохдоо худалдсан үнээс худалдан авсан үнийг хасч худалдах болон худалдан авахад төлсөн шимтгэлийг хасч тодорхойлно.

*Хувь хүн аж ахуйн нэгж нь дээрх дүнгээс 10 хувиар тооцон орлогын албан татвар төлнө.*



**Төгрөгийн ханш**

Монголын Хөрөнгийн Биржийн арилжаа нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр (MNT) хийгдэнэ. Ханшийг тухайн өдрийн зах зээлийн ханшаар тооцно.

Арилжааны банкууд төгрөгтэй харьцах гадаад валютын ханшийг өдөр бүр шинэчлэн тогтоож олон нийтэд зарладаг. Монгол Улсын томоохон арилжааны банкуудын ханшийн мэдээлэл авах цахим хаягууд:

Хадгаламж банк: [www.savingsbank.mn](http://www.savingsbank.mn)  
Голомт банк: [www.golomtbank.com](http://www.golomtbank.com)  
Хаан банк: [www.khanbank.com](http://www.khanbank.com)  
Төрийн банк: [www.statebank.mn](http://www.statebank.mn)  
Худалдаа хөгжлийн банк: [www.tdbm.mn](http://www.tdbm.mn)

**Бонд худалдан авах мөнгийг хэрхэн байршуулах вэ?**

Хөрөнгө оруулагч худалдан авах бондын үнийн дүн болон арилжааны шимтгэлийн нийлбэр дүнгээс багагүй хэмжээний мөнгөн хөрөнгийг дансандаа байршуулсан байна.

Дансандаа мөнгө байршуулахдаа “ҮЦТТТХТ” ХХК-ийн арилжааны банкин дахь данс рүү шилжүүлгээр хийнэ.

Үнэт цаасны дансандаа банкны шилжүүлгээр мөнгө байршуулах нь танд аль ч улсаас мөнгө шилжүүлэн хийх боломжийг олгож байгаа.

Та төлбөрийн зориулалтан дээрээ брокерийн компанид нээлгэсэн өөрийн үнэт цаасны дансны дугаар болон овог нэрээ тусгана.

**ҮЦТТТХТ ХХК-ийн дансны дугаар**

Хүлээн авагч байгууллагын нэр: ҮЦТТТХТөв ХХК

Хүлээн авагч банк: Хадгаламж банк  
Хүлээн авагчийн дансны дугаар: 10000018669  
SWIFT code: SVBMMNUB

Хүлээн авагч банк: Голомт банк  
Хүлээн авагчийн дансны дугаар: 1102017223  
SWIFT code: GLMTMNUB


Хүлээн авагч банк: Хаан банк  
Хүлээн авагчийн дансны дугаар: 5082007254  
SWIFT code: AGMOMNUB

Хүлээн авагч банк: Төрийн банк  
Хүлээн авагчийн дансны дугаар: 3413000658  
SWIFT code: STBMMNUB

Хүлээн авагч банк: Худалдаа хөгжлийн банк  
Хүлээн авагчийн дансны дугаар: 499138239  
SWIFT code: TDBMMNUB



*Handwritten signature in blue ink.*



**Урьдчилсан санал**

“Голомт банк” ХХК, “Жаст Агро” ХХК болон “БиДиСЕК” ХК-ны хооронд 2011 оны 05 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан хамтран ажиллах санамж бичигт тусгагдсанаар Голомт банк нь Үнэт цаас гаргагчийн олон нийтэд санал болгож буй бондоос 10 тэрбум төгрөгийн үнийн дүнд худалдан авах сонирхлоо илэрхийлсэн.

**2.8 ҮНЭТ ЦААС ГАРГАХ ЗАМААР ХУРИМТЛУУЛАХ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА, ЭДИЙН ЗАСАГ ҮР АШГИЙН ТООЦОО**

**Шийдвэрлэвэл зохих асуудлууд**

“Жаст Агро” ХХК нь өнөөдөр дотоодын төдийгүй гадны түншлэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг явуулж, улирлын шинж чанартай холбоотойгоор үүсдэг удаан хугацаагаар хөлдөөж хадгалах боломжийг бүрдүүлж чадсан. Гэсэн хэдий ч дараах зайлшгүй шийдвэрлэвэл зохих асуудлууд байгаа:

Мал бэлтгэлийн үйл ажиллагаа

- Жил бүр хамгийн багадаа 300 мянган толгой мал бэлтгэх бөгөөд тэдгээрийг мал эмнэлгийн хяналт, шинжилгээнд бүрэн хамруулах, хяналтыг улам сайжруулах;
- Малыг олон тоогоор хүлээн авах үед стандартаас доогуур жинтэй /тураалтай/ мал тушаагдах;
- Мал нядалгааны үед дайвар болон дотор эрхтэн хаягдаж, үрэгдэх, дутагдуулахгүй байхад тавигдах хяналтыг бүрэн хийж чадахгүй байх;

Санхүү, төлбөр тооцоо

Мал бэлтгэл нь улирлын шинж чанартай зохион байгуулагдах тул бэлэн мөнгөний хэрэгцээ 6-10 сарын хооронд их хэмжээгээр үүсдэг нь санхүүгийн жигд, тогтвортой байдалд нөлөөлж болзошгүй;

Компани нь дээрхи үйл ажиллагааны улмаас энэхүү хэрэгцээг хангах бэлэн мөнгөний хуримтлал хангалттай бий болж чадахгүй байх;

Удирдлагын ба дотоод хяналт

Удирдлагын мэдээллийн системийг хөгжүүлж, хэрэглээ болгох; Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн тогтолцоог хөгжүүлж сайжруулах;

Шийдвэрлэх арга зам

Дээрхи үүсч, бий болж болзошгүй асуудлуудаас урьдчилан сэргийлэх, үүссэн ч түүний үзүүлэх нөлөө, үр дагаврыг бага байлгах арга зам нь стратегийн дунд шатны бизнес төлөвлөгөөг боловсруулж, үйл ажиллагааныхаа удирдлага, гүйцэтгэлийн шалгуур болгох юм. Мөн мал бэлтгэлийн хэмжээг нэмэгдүүлэх, ингэснээр нэгжийн өртөг, зардлыг хямдруулах боломжийг бий болгоно. Мал бэлтгэлийн хэмжээг нэмэгдүүлэхийн тулд:

- Мал бэлтгэлийг эрт эхлүүлэх
- Нядалгааг өрсөлдөгч үйлдвэрүүдээс түрүүлж эрт эхлэх



- Мал бэлтгэлийн үнийг зах зээлийн түвшинтэй уяж, уян хатан явуулах
- Мал бэлтгэлийн төлөөлөгч ажиллуулах

**2011-2013 оны үйл ажиллагааны төлөвлөгөө ба санхүүгийн төсөвлөлт**

**Мал бэлтгэл, мах үйлдвэрлэл**

- Жил тутамд бэлтгэх малын тоог 300 мянган толгойгоос бууруулахгүй.
- Энэ тоо нь байгалийн гамшиг, малын гоц халдварт өвчний дэгдэлт гарч болзошгүй тул эдгээрийн нөлөөллийг тооцоолсноор нийт үйлдвэрийн суурилагдсан хүчин чадал ашиглалтын хувийг 80 хувьд байлгахад хангалттай байна.
- Мал бэлтгэлийн үнийг аймаг орон нутгийн онцлогтой холбон уян хатан нөхцөлтэй байлгах бөгөөд дундажаар амьдын жингийн нэг кг тутамд 900-1000 төгрөг байлгах бөгөөд үйлдвэрт хөлөөр нь туварлан авчирч тушаасан малчдад заасан жингээс давсан кг тутамд 50-100 төгрөгийн урамшуулал өгнө.

Мал бэлтгэл, мах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь тухайн оны 6 дугаар сараас дараагийн жилийн 6 дугаар сар хүртэлхи хугацаанд он дамжиж явагддаг тул нэг бүтэн орчил буюу эргэлтээр энэхүү стратегийн дунд шатны бизнес төлөвлөгөөг тооцож хийсэн.

2011 онд нийт толгойн тоогоор 310, 2012 онд 316 мянган мал бэлтгэнэ. Энэ зорилт нь нийт суурилагдсан хүчин чадлын 80 хувиас дээш байгаа болно. Бид суурилагдсан хүчин чадлыг бүрэн ашиглах чадамжтай хэдий ч урьдчилан харж, тооцох боломжгүй байгалийн зуд, ган, малын гоц халдварт өвчний дэгдэлт зэрэг хүчин зүйлийг тооцох шаардлагатай байдаг ба энэ төрлийн үйл ажиллагаанаас хамааралтай эрсдэл нийт хүчин чадлын 20 хувиас хэтрэхгүй байна гэж үзсэн.

	2011 оны сарууд							2012 оны сарууд						
	7	8	9	10	11	12	Дүн	7	8	9	10	11	12	Дүн
<b>Бэлтгэх малын тоо, төрлөөр</b>														
Үхэр	4,500	10,200	10,700	10,200	3,400	1,000	40,000	4,500	10,200	10,700	9,700	6,900	2,500	44,500
Адуу	2,300	6,300	6,300	4,600	500	-	20,000	2,300	6,300	6,300	4,500	-	4,600	24,000
Хонь	12,000	12,000	12,000	12,000	87,000	95,000	230,000	12,000	12,000	12,000	12,000	87,000	105,000	240,000
Ямаа	-	-	-	-	-	-	20,000	-	-	-	-	-	20,000	20,000
<b>Нэг толгойн амьдын жингээрх дундаж үнэ, мянган төгрөг</b>														
Үхэр	270.0	270.0	270.0	270.0	270.0	270.0		283.5	283.5	283.5	283.5	283.5	283.5	
Адуу	252.0	252.0	252.0	252.0	252.0	252.0		257.6	257.6	257.6	257.6	257.6	257.6	
Хонь	50.0	50.0	50.0	50.0	50.0	50.0		52.5	52.5	52.5	52.5	52.5	52.5	
Ямаа	36.0	36.0	36.0	36.0	36.0	36.0		36.8	36.8	36.8	36.8	36.8	36.8	
<b>Нэг толгойд ноогдох бэлтгэл ажиллагааны зардал, мянган төгрөг</b>														
Үхэр	2.4	2.4	2.4	2.4	2.4	2.4		2.4	2.4	2.4	2.4	2.4	2.4	
Адуу	2.4	2.4	2.4	2.4	2.4	2.4		2.4	2.4	2.4	2.4	2.4	2.4	
Хонь	0.4	0.4	0.4	0.4	0.4	0.4		0.4	0.4	0.4	0.4	0.4	0.4	
Ямаа	0.4	0.4	0.4	0.4	0.4	0.4		0.4	0.4	0.4	0.4	0.4	0.4	
<b>Нэг тоо толгойн өртөг, мянган төгрөг</b>														
Үхэр	272.4	272.4	272.4	272.4	272.4	272.4	-	285.9	285.9	285.9	285.9	285.9	285.9	-
Адуу	254.4	254.4	254.4	254.4	254.4	254.4	-	260.0	260.0	260.0	260.0	260.0	260.0	-
Хонь	50.4	50.4	50.4	50.4	50.4	50.4	-	52.9	52.9	52.9	52.9	52.9	52.9	-
Ямаа	36.4	36.4	36.4	36.4	36.4	36.4	-	37.2	37.2	37.2	37.2	37.2	37.2	-
<b>Нийт өртөг, сая</b>	<b>2,415.4</b>	<b>4,986</b>	<b>5,122.3</b>	<b>4,553.5</b>	<b>5,434.6</b>	<b>5,783.5</b>	<b>28,285.0</b>	<b>2,519.1</b>	<b>5,189.0</b>	<b>5,332</b>	<b>4,578</b>	<b>6,571.5</b>	<b>8,204.1</b>	<b>32,393.8</b>
Үхэр	1,226.0	2,778.6	2,915.1	2,778.8	926.3	272.4	10,887.4	1,286.7	2,916.5	3,069.5	2,773.6	1,973.0	714.8	12,724.1
Адуу	585.2	1,603	1,602.9	1,170.4	127.2	-	5,088.7	598.1	1,638.2	1,638.2	1,170.2	-	1,196.2	6,240.8
Хонь	604.3	604.3	604.3	604.3	4,381.1	4,783.9	11,582.1	634.3	634.3	634.3	634.3	4,598.6	5,650.0	12,685.7
Ямаа	-	-	-	-	-	-	727.1	727.1	727.1	727.1	727.1	-	743.1	743.1



*Хүснэгт 18. Мах бэлтгэх төлөвлөгөө*

Мал бэлтгэх явцад тууварлалт, эм тариа, ээмэгний зардал гардаг бөгөөд тэдгээрийг өмнөх оны гүйцэтгэлээр нэг малд ногдуулж тооцсон. Малыг бөөнөөр нь худалдан авахаар худалдан авалтыг зохион байгуулна. Иймээс нэг толгой малыг худалдан авах үнэ өмнөх жилийнхээс өсөхгүй гэж үзэж өнгөрсөн оны хаалтын ханшаар тооцсон.

Нэг толгой малаас авах махны гарцыг 2010 онд хүрсэн түвшингээс бууруулахгүй байна.

*Нийт үйлдвэрлэх тураг мах /тн/*

Үзүүлэлтүүд		2011 он	2012 он
Нийт гулууз махны жин, тн	Үхэр	5,076.0	5,647.1
	Адуу	2,800.0	3,360.0
	Хонь	4,025.0	4,200.0
	Ямаа	320.0	320.0
Бүгд дүн		12,224.0	13,530

*Хүснэгт 19. Тураг мах үйлдвэрлэл*

Нэг толгой малаас авах махны гарцаар тооцсон нийт махны нэгжийн өртөг дундажаар 2314 төгрөг байна.

*Нийт махны нэгжийн өртөг, төгрөг*

Үзүүлэлтүүд	2011 он	2012 он
Мал бэлтгэлийн өртөг, сая.төгрөг	28,295.4	32,393.8
Нийт махны жин, тн	12,221.0	13,527.1
Нэг кг махны бэлтгэлийн өртөг, төгрөг	2,314	2,394

*Хүснэгт 20. Махны нэгжийн өртөг*

Мал бэлтгэлийн өртөг нь шууд материалын өртөгийг тодорхойлохгүй, учир нь өмнөх онд бэлтгэгдсэн махны өртөг нөлөөлдөг. Энэ өртгийг санхүүгийн төсөвлөлтийн хэсэгт шилжих өртөг гэж тооцсон. Иймээс мал бэлтгэлийн өртгийг малчдаас худалдан авах үнийн өсөлт байгаа эсхийг харуулах зорилгоор тооцож байгаа болно.

Борлуулалтын таамаглал

Борлуулалтын таамаглал нь экспортын, дотоодын буюу нөөцийн махны, дотор болон дайвар бүтээгдэхүүний гэсэн чиглэлээр хийгдэнэ.

Экспортын борлуулалтын хувьд урьдчилан хийгдсэн гэрээний үнээр буюу дундажаар 3395 төгрөг, дотоодын борлуулалт нь өнгөрсөн жилийн жижиглэнгийн борлуулалтын дундаж үнээр буюу 2900 төгрөгөөр тооцогдсон.

Борлуулалтын орлогын таамаглал, сая төгрөг

	2011-2012 он	2012-2013 он
Экспорт	29,387.5	32,825.0
Дотоодын борлуулалт	6,702.6	7,521.4
Бусад орлого	4,143.3	4,460.0
Нийт дүн	40,233.4	44,806.5

Махны бизнесийн мөнгөний урсгалын цикл нь хугацааны хувьд 12-15 сарын хугацааг хамарч үргэлжилдэг. Өөрөөр хэлбэл, 2010 оны 6 дугаар сард мал



*Handwritten signature in blue ink.*

УЛААНБААТАР  
БАНК-ОЮУ  
Анхны  
Эрөн захирлын газар  
ТТА-4487

2011 он 7 сар 25 өдөр  
**БҮРТГЭВ**  
№ 01

бэлтгэлд гаргасан мөнгө нь мөн оныхоо 9-12 сард мах болж, дараа оны шинэ мах өргөнөөр худалдаалагдаж эхлэх хүртэл хугацаанд арилжаалагдана. Шинэ мах өргөнөөр худалдаалагдаж эхлэх хугацаа нь ерөнхийдээ 9 дүгээр сар байдаг.

Иймээс 2010 онд мал бэлтгэл, маханд гарсан мөнгө дараагийн ээлжит мал бэлтгэл, махны үйлдвэрлэлийг санхүүжүүлэх хангалттай эх үүсвэр болж чаддаггүй.

Борлуулсан бүтээгдэхүүний өртгийг:

$$ББӨ = ББ_{эхний үлдэгдэл} + ДҮ_{тайлант жилийн нийт} - ББ_{эцсийн үлдэгдэл}$$

гэсэн аргачлалаар тооцсон. Учир нь, мал бэлтгэл, боловсруулалт, хадгалалтын нэг циклийн үргэлжлэх хугацаа, санхүүгийн тайлангийн жилийн үргэлжлэх хугацаа тохирдоггүйгээс борлуулсан бүтээгдэхүүний өртөг, тайлангийн жилийн мал бэлтгэлийн өртөг, боловсруулалтын зардлын дүнгээс зөрдөг.

Ашгийн таамаглал

Ашгийн таамаглалыг хийхдээ санхүүгийн тайлангийн хугацаагаар бус мал бэлтгэл, махны үйлдвэрлэлийн нэг удаагийн орчлын үргэлжлэх хугацаагаар 2011 оны 6 дугаар сарын 30-наас дараа оны 7 дугаар сарын 01-ний өдрөөр заагласан. Учир нь, санхүүгийн жилээр авахад мал бэлтгэлийн өртгийн хувьд зөрүү гардаг. Үүний шалтгааныг тайлбарлавал:

Тухайн санхүүгийн жилийн эхний хагас жилд борлогдож буй мах нь өмнөх онд бэлтгэгдсэн өөр өртөгтэй, сүүлийн хагас жилд борлогдож буй мах тухайн ондоо бэлтгэгдсэн мөн өөр өртөгтэй байдаг. Иймээс тухайн мал бэлтгэлийн үйл ажиллагаанаас хэрхэн амжилттай ажилласан бэ гэдгийг мэдэж байх үүднээс, мөн дараа дараагийн жилийн мал бэлтгэлийн үнийн талаар баримтлах бодлогыг тодорхойлох үүднээс мал бэлтгэлийн үйл ажиллагааны орчлоор тооцож төлөвлөх шаардлага хэрэгцээтэй байдаг.

Ашгийн таамаглал, сая төгрөг

	2011-2012 он	2012-2013 он
Борлуулалтын орлого	40,233.4	44,806.5
Нөөцийн махны урамшуулал	1,200.0	1,200.0
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	30,327.5	34,290.2
<b>Нийт ашиг</b>	<b>11,105.9</b>	<b>11,716.3</b>
Удирдлага, маркетингийн зардал	1,987.8	1,977.6
Элэгдлийн зардал	1,754.3	2,279.7
Санхүүгийн зардал	4,787.0	842.0
Үйл ажиллагааны ашиг	2,576.6	7,020.5
Үйл ажиллагааны бус орлого, зардал	403.6	403.6
Татварын зардал	298.1	702.0
<b>Цэвэр ашиг</b>	<b>2,682.1</b>	<b>6,318.5</b>

Ашгийн таамаглалаар удирдлагын болон элэгдлийн зардал нь харьцангуй тогтмол шинжтэй байна.



Мөнгөн урсгалын таамаглал


"Жаст Агро" ХХК нь өмнөх онуудад бэлтгэсэн мах 6 дугаар сарын сүүлч гэхэд бүрэн борлогдож, хөлдөөгч агуулахуудад ямар ч мах, махан бүтээгдэхүүний үлдэгдэлгүй болж, технологийн дагуу цэвэрлэгээ, ариутгал хийн 7 дугаар сараас эхлэн мах хүлээн авахад бэлэн болсон байх ёстой. Мөнгөний урсгалын таамаглалын хугацааг мөн л мал бэлтгэлийн орчлоор зааглан авсан.

Үзүүлэлтүүд	2011 он	2012 он
Борлуулалтын орлого	3,678,772.73	11,201,457.93
Экспортын борлуулалтын орлого	7,150,000.00	55,062,500.00
Хадгалалтын орлого	76,291.27	76,291.27
Нядалгааны орлого	327,272.73	327,272.73
Нөөцийн махны урамшуулал	-	1,200,000.00
Үйл ажиллагааны зээл	935,750.21	1,976,221.46
НӨАТ-ын авлага	-	-
Бондын санхүүжилт	30,000,000.00	-
<b>Мөнгөний орох урсгалын дүн</b>	<b>42,168,086.94</b>	<b>69,843,743.39</b>
Үйл ажиллагааны зээл төлөлт	752,987.13	1,975,988.30
Эргэлтийн хөрөнгийн зээл төлөлт	-	-
Бонд эргэн төлөлт	-	30,000,000.00
Хөрөнгө оруулалт	-	-
Худалдан авалт	25,723,063.64	29,448,900.30
Худалдан авалтын НӨАТ	2,572,306.36	2,944,890.03
Үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал	3,801,858.85	4,998,901.19
Удирдлагын үйл ажиллагааны зардал	1,574,607.50	3,570,781.59
Борлуулалт, маркетингийн зардал	317,105.90	472,950.76
Үйл ажиллагааны зээлийн хүү	16,843.50	32,003.44
Эргэлтийн хөрөнгийн зээлийн хүү	-	-
Бондын зээлийн хүү	810,000.00	4,050,000.00
Бондын гаргалтын зардал	705,000.00	-
Урт хугацаат зээлийн хүү	-	-
Тооцсон татвар	(337,161.97)	1,310,289.78
<b>Мөнгөний гарах урсгалын дүн</b>	<b>35,936,610.92</b>	<b>78,804,705.40</b>
Элэгдлийн зардал	839,641.11	2,054,510.89
Мөнгөний цэвэр урсгал	7,071,117.13	(6,906,451.12)
<b>Мөнгөний эцсийн үлдэгдэл</b>	<b>7,071,117.13</b>	<b>164,666.01</b>

Мөнгөний урсгалын таамаглалаар 2011-2012 онд мал бэлтгэлийн үйл ажиллагаанд санхүүгийн эх үүсвэр хангалтгүй байгаа бөгөөд Үнэт цаас гаргагч нь тус хэрэгцээг олон нийтэд бонд гарган санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. Тооцооллоор уг санхүүжилтийг бүрэн барагдуулж, дараагийн үйл ажиллагаанд хангалттай өөрийн санхүүгийн эх үүсвэрийг хуримтлуулах боломж бүрэн байна.



*Handwritten signature in blue ink.*



**2.9 ТУХАЙН ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВСНААР ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД УЧИРЧ БОЛОХ ЭРСДЭЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛС**


Монгол улсын мал аж ахуй, байгаль цаг уурын онцлог, компанийн үйл ажиллагаа, удирдлага, улс орны эдийн засаг, төр засгийн бодлого шийдвэрүүдийн улмаас тус компанид учирч болох эрсдлүүдийн хүчин зүйлс.

**Байгаль , цаг уураас хамааралтай эрсдэл:**

Монгол улсын мал аж ахуйн салбар нь нүүдлийн мал аж ахуй бөгөөд байгал, цаг, уурын өөрчлөлтөөс шууд хамааралтай. Энэ утгаараа байгалийн аливаа аюулт үзэгдэл, ган, зуд, халдварт өвчин зэрэг нь махны салбарт шууд нөлөөлдөг.

Махны салбарт байгал орчны өөрчлөлтийн нөлөөллөөс хамааран дараах эрсдэлүүд үүсэх магадлалтай. Үүнд:

- Ган, зудын нөлөөллөөр малын зүй бус хорогдол гарах. Энэ нь махны нийлүүлэлтийг бууруулж, махны үнийг өсгөх. Тухайлбал 2009-2010 оны өвөл зуд болж, нийт 7.5 сая мал хорогдсон нь махны нийлүүлэлтийг эрс бууруулсан.



- Махны үнэнд нөлөөлж буй хамгийн том шокын нөлөө нь ган, зудны асуудал байдаг.

Судалгаанаас харахад манай улсад зуд 115 жилийн давтамжтайгаар тохиолдолддог бөгөөд тухайн жилд махны нийлүүлэлт буурч, хомсдол ихсэж махны үнэ маш ихээр нэмэгддэг.

- Зун хэт халснаас мал өвс тэжээлийн дутагдалд орж, тарга хүчээ бүрэн авч чадахгүй байх. Энэ нь махын гарц болон чанарт нөлөөлөх,
- Монгол улс малын шүлхий, боом зэрэг халдварт өвчний идэвхтэй бүсэд байдаг ба эдгээр өвчин гарсан тохиолдолд махны чанар болон нийлүүлэлтийг бууруулах

**Компанийн үйл ажиллагааны эрсдэл**

**Мах бэлтгэлийн үйл ажиллагааны эрсдэл:**

Тус компанийн салбар үйлдвэрүүд нь үйл ажиллагааны цар хүрээгээ ойр орчмын 200 километрийн радиус бүхий тойрог дахь хөдөө, орон нутагт ажиллаж амьдарч буй малчдыг хамруулан мал бэлтгэх үйл ажиллагаагаа явуулдаг ба үүнд дараах эрсдэл учрах магадлалтай. Үүнд:

- Махны салбар нь мах бэлтгэх, боловсруулах, худалдах нэгдсэн системд ороогүйгээс дурын худалдаачин /ченж/ малчдаас малыг өндөр үнээр худалдан авч зах зээлд нийлүүлж байгаа нь компанийн мах бэлтгэлийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх. Тухайлбал, мал бэлтгэлийн зах зээлийг багасгах болон малын үнийг нэмэгдүүлэх,
- Малын тууварлалтын явцад малын жингийн алдагдал үүсэх болон мал алдагдах, өөрчлөгдөх, хорогдох зэрэг шалтгаанаас малчид малаа үйлдвэр дээр туурварлаж авч ирэхээс газар дээр нь ченжүүдэд худалдахыг илүүд үзэх.

**Бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хадгалалтын үйл ажиллагааны эрсдэл**

Компани нь үйлдвэрлэлийн технологи, бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйг дээшлүүлэхэд ихээхэн анхаарч хөрөнгө оруулалт болон ажлын хүчин чармайлт гаргаж байгаа боловч гэнэтийн болон гадаад, дотоодын хүчин зүйлээс хамаарч үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд дараах эрсдэл гарах магадлалтай. Үүнд:



*Handwritten signature in blue ink.*

Stamp: ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ  
ТТ4467/2023  
2024 он 7 сар 26 өдөр  
БҮРТГЭВ  
№ 01

- Түүхий эдийн хомсдолоос шалтгаалан хүчин чадлаа бүрэн ашиглаж чадахгүй байх,
- Мал бэлтгэл хийгдэж буй бүм нутагт малын гоц халдварт өвчин гарснаас хөл, хорио цээр тавигдах,

*Борлуулалтын үйл ажиллагааны эрсдэл:*

Мах нь хүн амын хүнсний хэрэглээний нэг үндсэн хэсэг тул маханд эрүүл ахуйн өндөр шалгуурыг тавьдаг. Компанийн мах бэлтгэл, боловсруулалт болон худалдан авагчдын үйл ажиллагаатай холбоотойгоор дараах эрсдэл учрах магадлалтай. Тухайлбал,

- Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа болон бүс нутагт гарсан аливаа байгалийн гамшиг, халдварт өвчний улмаас махны тээвэрлэлтэнд хориг тавих, энэ нь борлуулалт цагтаа хийгдэхгүй байх,
- Дотоодод гарсан малын халдварт өвчний улмаас импортлогч орны мэргэжлийн байгууллагаас худалдан авалтандаа хориг тавих, шаардлага өндөрсгөх,
- Импортын татвараа нэмэгдүүлэх. Ингэснээр борлуулалтын зардал нэмэгдэх,
- Дотоодын зах зээл дээр ченжүүд болон малчдаас шууд нийлүүлж буй махны борлуулалтаас шалтгаалж, компанийн борлуулалт буурах,

*Хүний нөөц, удирдлагын үйл ажиллагааны эрсдэл*

Улс орны эдийн засаг өсч, салбаруудын өсөлт эрчимтэй явагдаж байна. Ялангуяа уул уурхай салбарын эдийн засагт эзлэх байр суурь хурдацтай нэмэгдэж байгаа нь иргэдийн энэ салбарт ажиллах сонирхолыг нэмэгдүүлж байна. Энэ дараах эрсдэлийг учруулах магадлалтай. Тухайлбал,

- Чадварлаг удирдлага, ажилтнуудаа алдаж, боловсон хүчний дутагдалд орох,
- Мах бэлтгэлийн үед хөдөө орон нутагт байгаа салбаруудад үндсэн ажиллах хүчний дутагдал үүсэх,

*Санхүүгийн үйл ажиллагааны эрсдэл*

Компанийн үйл ажиллагаа, худалдан авагч болон үйлдвэрлэлийн гол түүхий эдийн үнийн өөрчлөлтөөс шалтгаалж компанид дараах эрсдэл учрах магадлалтай. Тухайлбал,


- Түүхий эд болон бусад шаардлагатай материалуудын үнийн өсөлтөөс шалтгаалж төсөвлөсөн зардал хэтрэх,
- Зардлын өсөлтийн улмаас үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай эргэлтийн хөрөнгийн дутгадалд орох,
- Худалдан авагч нь цаг хугацаандаа төлбөрөө төлөхгүй байх,
- Улс орны эдийн засийн байдлаас шалтгаалж нөөцийн махны урамшууллын мөнгө цаг хугацаандаа төлөгдөхгүй байх,
- Махны бизнесийн мөнгөний урсгалын цикл нь хугацааны хувьд 12-15 сарын хугацааг хамарч үргэлжилдэг. Өөрөөр хэлбэл, тухайн оны 6 дугаар сард мал бэлтгэлд гаргасан мөнгө нь мөн оныхоо 9-12 сард мах болж, дараа оны шинэ мах өргөнөөр худалдаалагдаж эхлэх хүртэл арилжаалагддаг. Энэ хугацаа нь ерөнхийдээ 9 сар байдаг. Иймээс тухайн онд мал бэлтгэл, маханд гарсан мөнгө дараагийн ээлжит мал бэлтгэл, махны үйлдвэрлэлийг санхүүжүүлэх хангалттай эх үүсвэр болж чадахгүй байх,

**Эдийн засгийн хүчин зүйлсийн эрсдэл**

Улс орны эдийн засаг, нийгэмд бий болж болзошгүй сөрөг үзүүлэлтүүд нь компанийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүний борлуулалт, бүтээгдэхүүний өртөгт нөлөөлөх магадлалтай. Тухайлбал,



*Handwritten signature in blue ink.*



- Инфляцийн түвшний өсөлтөөс шалтгаалан дотоодын худалдан авагчдын чадвар буурах,
- Цахилгаан эрчим хүчний үнийн өсөлт нь бүтээгдэхүүний өртгийг нэмэгдүүлэх,
- Валютын ханшийн тогтворгүй байдлаас шалтгаалж, ханшийн зөрүүнээс алдагдал хүлээх,
- Хятадын бизнес эрхлэгчид ченжүүдтэй хамтран махны зах зээлд орж, малыг ихээр худалдан авч байгаа нь малын үнийг өсгөх,
- ОУ-ын зах зээл дээрх газрын тосны үнийн болон ОХУ-н экспортын татварын өсөлтөөс шалтгаалсан түлш, шатахууны үнийн өсөлт нь компанийн мах тээвэрлэлтийн зардлыг нэмэгдүүлэх,
- Гадаад худалдааны өсөлтөөс шалтгаалан төмөр замын тээвэр нэмэгдэж байгаа нь бүтээгдэхүүний тээвэрлэлт саатах, цаг хугацаандаа худалдан авагчид очихгүй байх,
- Малыг хөлөөр нь хөрш зэргэлдээ улс орнуудад экспортлох,

**Улс төрийн бодлого, шийдвэрийн эрсдэл**

Төр засгийн эдийн засаг, нийгмийн салбарт хэрэгжүүлж буй бодлого, шийдвэрүүд компанийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтад нөлөөлөх магадлалтай. Тухайлбал,

- Төр засгийн тогтворгүй байдлаас шалтгаалж, салбарын хууль, эрх зүйн орчинд өөрчлөлт оруулах,
- Махны үнийг тогтвортой байлгах нэрийдлээр махны үнийг зах зээлийн бодит үнээс доогуур байлгах,
- Иргэдийн нийгмийн халамжийн чиглэлээр авч хэрэгжүүлж буй бодлого нь улсын төсвийг тэлж, үүнтэй холбоотойгоор татварын хэмжээнд өөрчлөлт орох,
- Нөөцийн махыг бэлтгэх, борлуулалтанд олгож буй урамшууллын хэмжээ бууруулах,

**Төлбөрийн чадварын эрсдэл**

Бонд гаргагч нь бондын хүүгийн ба үндсэн төлбөрийг цаг хугацаанд нь төлж чадахгүй байдалд түр болон бүрмөсөн орж болзошгүй байх эрсдэл бага ч энэхүү эрсдэлийг бий болгох тодорхой хүчин зүйлс байх магадлалтай юм.

- Дээр дурдсан эдийн засаг, улс төрийн нөхцөл байдал, байгалийн давагдашгүй хүчин зүйл болон малын гоц халдварт өвчин зэргээс шалтгаалах эрсдэл гэх мэт хүчин зүйлс төлбөрийн чадварт өөрчлөлт оруулах шалтгаан болохыг үгүйсгэх аргагүй.

**Бусад эрсдэл**

Мөнгөний үнэгүйдлээс шалтгаалж хөрөнгө оруулагчийн эзэмшиж буй бондын бодит үнэ цэнэ, хүүгийн бодит орлого буурах эрсдэл байдаг. Энэхүү эрсдлээс амжилттай зайлсхийх шийдэл гэж байдаггүй.

Дээр дурдсан эрсдлүүд нь гадаад болон дотоод хүчин зүйлсийн нөлөөнөөс хамааран учирч болох эрсдлүүд юм.



*Handwritten signature in blue ink.*



**ҮНЭТ ЦААСЫГ ЗУУЧЛАГЧ АНДЕРРАЙТЕРЫН КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ**

“БиДиСЕК” ХК нь 1995 онд байгуулагдсан бөгөөд хөрөнгийн зах зээл дээр тасралтгүй 15 жил үйл ажиллагаа явуулж буй андеррайтер, брокер, дилер хөрөнгө оруулалтын зөвлөхийн компани юм. Компани 2006 оны 6-р сард зохион байгуулалтын хэлбэрээ өөрчлөн олон нийтэд өөрийн хувьцааг санал болгон арилжаалан хөрөнгийн зах зээл дээрээс 1 тэрбум төгрөг, 2008 онд нэмэлт хувьцаа гаргаснаар хөрөнгийн зах зээлээс нийт 3.7 тэрбум төгрөгийг хөрөнгийг татан төвлөрүүлж үйл ажиллагааныхаа цар хүрээг өргөтгөн ажиллаж байна.

“БиДиСек” ХК компани нь Андеррайтерийн үйлчилгээ үзүүлдэг ууган компаниудын нэг бөгөөд 2005 оны 6-р сарын 07-ны өдрийн 34 тоот тогтоолоор Андеррайтерийн үйлчилгээ эрхэлэх тусгай зөвшөөрөл авсан юм. Монголын Хөрөнгийн зах зээл дээр 2005-2008 онд нийт 13 компани шинээр үнэт цаас гаргах замаар хөрөнгө оруулалт татан төвлөрүүлсэн бөгөөд “БиДиСЕК” ХК нь 8 хувьцаат компанийн Андеррайтераар ажилласан.

Мөн 2004, 2005 онд “Пума групп”-ийн Пума бонд, 2005 онд “Монинжбар” ХК-ийн “Бүтээн байгуулалт бонд”, 2007 онд “Нийслэл өргөө” ХК-ийн “Нийслэл өргөө бонд”-ын ерөнхий зуучлан борлуулагч, 2004 онд “МСиЭС электроникс” ХХК-ийн “МСиЭС электроникс бонд”-ын туслан гүйцэтгэгчээр тус тус ажилласан дадлага туршлагатай.

***Үнэт цаасны талаарх дэлгэрэнгүй мэдээлэлтэй танилцаж болох газар, хариуцах мэргэжилтний нэр, холбоо барих утасны дугаар***



**“БИДИСЕК” ХК  
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГИШҮҮН**

*Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Залуучуудын өргөн чөлөө 27/1, “БиДиСЕК” ХК-ний байр*

**Үнэт цаасны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл авч болох хариуцлагатан:**

**Андеррайтер**

Б.Лхагвадорж	9908-2846	lkh@bdsec.mn
Б.Лхамдолгор	9901-0589	lhamdolgor@bdsec.mn
Б.Ганболд	9901-2845	ganbold@bdsec.mn
Б.Бямбацогт	9905-7062	byambatsogt@bdsec.mn
Г.Мөнхтулга	9901-3089	mganbold@bdsec.mn
Т.Отгонцэрэн	9904-3165	otgontseren@bdsec.mn

**Үнэт цаас гаргагч компани**

Т.Содномдаржаа	9911-8370	sodnomdarjaa@justgroup.mn
Ч.Баасанжаргал	9906-8880	baasanjargal@justgroup.mn



*Handwritten signature in blue ink.*



## ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГЫН ХАВСРАЛТ

- I. “Монголын Хөрөнгийн Бирж” ХК-ийн 2011/08/19-ны өдрийн I/501 тоот албан бичгийн дагуу хөрөнгө оруулагчдад хүргэх мэдээлэл
- II. Үнэт цаас бүртгэх тухай “Санхүүгийн Зохицуулах Хороо”-ны 2011/07/26-ны өдрийн 223 тоот тогтоолын хуулбар
- III. Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- IV. Үнэт цаас гаргагчийн дүрмийн хуулбар
- V. Үнэт цаас гаргах үйл ажиллагаатай холбогдуулан “Ананд Энд Батзаяа” ХХК-ийн хараат бус хуулийн дүгнэлт
- VI. Нийслэлийн мэргэжлийн хяналтын газраас гаргасан ажлын байрны тодорхойлолтын хуулбар
- VII. Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, ашиглах, худалдах аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн хуулбар
- VIII. Үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээ
- IX. “Голомт банк” ХХК-тай байгуулсан хамтран ажиллах санамж бичгийн хуулбар
- X. “Бурятмяспром” ХХК-тай байгуулсан бүтээгдэхүүн худалдах гэрээ, орчуулга
- XI. “Юни-Трейд” ХХК-тай байгуулсан бүтээгдэхүүн худалдах гэрээ, орчуулга
- XII. Андеррайтерын компанийн дүгнэлт
- XIII. Аудитлагдсан тайлан – 2011 оны 2-р улирал
- XIV. Аудитлагдсан тайлан – 2010 оны жилийн эцэс
- XV. Аудитлагдсан тайлан – 2009 оны жилийн эцэс
- XVI. Хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний тайлан



## 2011-2013 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ БА САНХҮҮГИЙН ТӨСӨВЛӨЛТ

### Мал бэлтгэл, мах үйлдвэрлэл

Бонд гаргах хугацаанд өөрчлөлт орсонтой холбоотойгоор мөнгөн урсгалд зарим өөрчлөлт оруулсан. Бондын санхүүжилтийн хугацаа хойшлож 8-р сард эхний 10 тэр бум төгрөгийн санхүүжилт, 9-р сард 2 дахь 10 тэрбум төгрөгийн санхүүжилт, 10-р сард сүүлийн 10 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэнэ гэж үзээд төлөвлөсөн бөгөөд мал бэлтгэлийн үйл ажиллагаа 9-р сараас эхлэн 12-р сарыг дуустал хийгдэнэ.

Бизнесийн мөчлөг нь мал бэлтгэл, мах боловсруулах, борлуулах үйл ажиллагаанаас бүрдэх бөгөөд тухайн оны 6-р сараас дараа оны 6-р сар хүртэл үргэлжлэн он дамжин явагддаг тул энэхүү стратегийн дунд шатны бизнес төлөвлөгөөг нэг бүтэн эргэлтээр тооцож хийсэн.

Дийлэнх малыг 9, 10-р саруудад худалдан авч бэлтгэх бөгөөд 12-р сарыг дуустал үйлдвэрүүд дээр мал төхөөрч, мах боловсруулах үйл ажиллагаа явагдана. Үйлдвэрүүдийн хоногийн хүчин чадал бодод шилжүүлсэнээр /5 бог= 1бод/ 1860 толгой бөгөөд мал төхөөрөх нийт хугацаанд 160 мянган толгой бод төхөөрөх хүчин чадалтай, үүнээс эхний жилд 67 хувийг ашиглах буюу бодод шилжүүлсэнээр /5 бог= 1бод/ 110 мянган толгой мал бэлтгэхээр тооцоолсон. Үүнд дараахь байдлаар малын төрөл түүнд зарцуулах мөнгөн хөрөнгийн хэмжээг тооцоолсон.

Мал бэлтгэлийн төлөвлөгөө /сараар/								
№	Үзүүлэлтүүд	2011 он						
		7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар	Нийт
A	Б	7	8	9	10	11	12	13
	<b>Бэлтгэх малын тоо, төрлөөр</b>							
1	Үхэр	0	-	13,000.00	13,000.00	10,500.00	3,500.00	<b>40,000.00</b>
2	Адуу	0	-	6,800.00	6,600.00	4,600.00	2,000.00	<b>20,000.00</b>
3	Хонь	0	-	24,000.00	24,000.00	87,000.00	95,000.00	<b>230,000.00</b>
4	Ямаа	0	-	-	-	-	20,000.00	<b>20,000.00</b>
	<b>НИЙТ БЭЛТГЭХ МАЛЫН ӨРТӨГ, /сая.төгрөг/</b>	-	-	6,480.38	6,429.50	8,412.03	6,973.44	<b>28,295.30</b>
1	Үхэр	-	-	3,541.65	3,541.65	2,860.57	953.52	<b>10,897.41</b>
2	Адуу	-	-	1,730.16	1,679.27	1,170.40	508.87	<b>5,088.70</b>
3	Хонь	-	-	1,208.56	1,208.56	4,381.05	4,783.91	<b>11,582.11</b>
4	Ямаа	-	-	-	-	-	727.14	<b>727.14</b>

2012 оны мал бэлтгэлийг эрт эхлэн 7-12-р сарын турш худалдан авалт хийгдэж, 12-р сарыг дуустал үйлдвэрүүд дээр мал төхөөрч, мах боловсруулах үйл ажиллагаа явагдана. Үйлдвэрүүдийн хүчин чадлыг 70 хувийг ашиглах буюу бодод шилжүүлсэнээр /5 бог= 1бод/ 113.6 мянган толгой мал бэлтгэхээр тооцоолсон. Үүнд дараахь байдлаар малын төрөл түүнд зарцуулах мөнгөн хөрөнгийн хэмжээг тооцоолсон.

Мал бэлтгэлийн төлөвлөгөө /сараар/								
№	Үзүүлэлтүүд	2012 он						
		7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар	Нийт
А	Б	7	8	9	10	11	12	13
<b>Бэлтгэх малын тоо, төрлөөр</b>								<b>328,500.00</b>
1	Үхэр	4,500	10,200.00	10,700.00	9,700.00	6,900.00	2,500.00	<b>44,500.00</b>
2	Адуу	2,300	6,300.00	6,300.00	4,500.00	-	4,600.00	<b>24,000.00</b>
3	Хонь	12,000	12,000.00	12,000.00	12,000.00	87,000.00	105,000.00	<b>240,000.00</b>
4	Ямаа	0	-	-	-	-	20,000.00	<b>20,000.00</b>
<b>НИЙТ БЭЛТГЭХ МАЛЫН ӨРТӨГ, /сая.төгрөг/</b>		<b>2,519.07</b>	<b>5,189.04</b>	<b>5,332.01</b>	<b>4,578.01</b>	<b>6,571.51</b>	<b>8,204.12</b>	<b>32,393.79</b>
1	Үхэр	1,286.70	2,916.54	3,059.50	2,773.57	1,972.95	714.83	<b>12,724.12</b>
2	Адуу	598.08	1,638.22	1,638.22	1,170.15	-	1,196.16	<b>6,240.84</b>
3	Хонь	634.28	634.28	634.28	634.28	4,598.55	5,549.98	<b>12,685.68</b>
4	Ямаа	-	-	-	-	-	743.14	<b>743.14</b>

Нэг толгой малаас гарах махны гарцыг 2010 онд хүрсэн түвшингээс бууруулахгүй байна.

Мал бэлтгэлийн өртөг нь шууд материалын өртгөөр тодорхойлогдохгүй, учир нь шууд хөдөлмөр болон үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал /цахилгаан, дулаан, ус, гм /-аар нэмэгдэж тодорхойлогдоно. Оны эцэст бараа материалын үлдэгдэлтэй гарах бөгөөд энэ шилжих өртөг нь дараа онд гарсан шууд хөдөлмөр, үйлдвэрлэлийн нэмэгдэл зардалтай нийлж борлуулсан бүтээгдэхүүний өртгийг тодорхойлно. Бизнесийн мөчлөг дуусах үед бүх махаа борлуулж дууссан байна.

#### Нийт үйлдвэрлэх тураг мах

Үзүүлэлтүүд		2011 он	2012 он
Нийт гулууз махны жин, тн	Үхэр	5,076.0	5,647.1
	Адуу	2,800.0	3,360.0
	Хонь	4,025.0	4,200.0
	Ямаа	320.0	320.0
Бүгд дүн		12,221.0	13,527.1

#### Борлуулалтын таамаглал

Борлуулалтыг экспортын, дотоодын, бусад жижиглэнгийн гэсэн 3 ерөнхий ангилалд хуваасан байгаа. Экспортын борлуулалтанд ОХУ болон арабын орнуудад үхэр, адуу, хонины махны экспорт, дотоодын борлуулалтанд нийслэлийн хөдөлмөрчдийн хэрэгцээнд нийлүүлэгдэх нөөцийн махны борлуулалт, бусад жижиглэнгийн борлуулалтанд дотор дайвар эрхтэн, арьс, шир болон жижиглэнгийн борлуулалтыг хамааруулан ангилсан.

2011 оны хувьд 9-р сараас мал төхөөрч эхлэх бөгөөд төхөөрсөн малын арьс шир болон зарим дотор эрхтэн борлуулах дотоод борлуулалт хийгдэнэ. 10-р сараас экспортын борлуулалт хийж эхлээд дараа оны 7-р сар гэхэд махаа дотоод, гадаад зах зээлд бүрэн борлуулж дууссан байхаар тооцоолсон.

#### **Борлуулалтын орлогын таамаглал, сая төгрөг**

	2011-2012 он	2012-2013 он
Экспорт	29,387.5	32,825.0
Дотоодын борлуулалт	6,702.6	7,521.4
Бусад орлого	4,143.3	4,460.0
<b>Нийт дүн</b>	<b>40,233.4</b>	<b>44,806.5</b>

Нийслэлийн хэрэглэгчдийн хэрэгцээнд нийлүүлэх махны хэмжээг 2010 оны хэмжээнд тогтмол байлгах буюу 2011 болон 2012 онуудад тус бүр 2400 тн мах нийлүүлэхээр төлөвлөсөн нөөцийн махны урамшуулалыг 1 кг-д 500 төгрөг байхаар тооцоолсон. Энэ нь 2010 онд хэрэгжсэн урамшуулалын гэрээний дүнгээр байгаа.

#### Ашгийн таамаглал

Ашгийн таамаглалыг хийхдээ санхүүгийн тайлангийн хугацаагаар бус мал бэлтгэл, махын үйлдвэрлэлийн нэг удаагийн мөчлөгийн үргэлжлэх хугацаагаар тухайн оны 6-р сарын 30-наас дараа оны 7-р сарын 01-ний өдрөөр заагласан.

Санхүүгийн жилээр авахад 12-р сарын эцэст ихээхэн хэмжээний бараа материалын үлдэгдэлтэй байдаг, мал бэлтгэл, мах боловсруулалтын оргил ачаалалын үед буюу 9-12-р саруудад үйлдвэрлэлийн зардал өндөр гардаг, бэлтгэсэн махны дийлэнх хэсгийг дараа онд борлуулдаг зэргээс шалгаалан оны эцсээр үр дүн тодорхой харагддаггүй, учраас бизнесийн мөчлөгөөр санхүүгийн тайланг бэлтгэсэн. Энэ нь мал бэлтгэлийн үйл ажиллагаа тухайн онд бэлтгэсэн малын өртөг, дараа онд бэлтгэсэн малын өртгөөс тусад нь бүртгэж, борлуулалтыг тодорхой харах боломжтой юм.

#### **Ашгийн таамаглал, сая төгрөг**

	2011-2012 он	2012-2013 он
Борлуулалтын орлого	40,233.4	44,806.5
Нөөцийн махны урамшуулал	1,200.0	1,200.0
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	30,327.5	34,290.2
<b>Нийт ашиг</b>	<b>11,105.9</b>	<b>11,716.3</b>
Удирдлагын зардал	1,987.8	1,977.6
Элэгдлийн зардал	1,754.3	2,279.7
Санхүүгийн зардал	4,787.0	842.0
<b>Үйл ажиллагааны ашиг</b>	<b>2,576.6</b>	<b>7,020.5</b>
Үйл ажиллагааны бус орлого, зардал	403.6	403.6
Татварын зардал	298.1	702.0
<b>Цэвэр ашиг</b>	<b>2,682.1</b>	<b>6,318.5</b>

Ашгийн таамаглалаар удирдлагын зардал нь харьцангуй тогтмол шинжтэй байна. Энэ нь нэгэнт бүрдсэн үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой удирдлагын бүрэлдэхүүний зардал

*“Монголын Хөрөнгийн Бирж” ХК-ийн 2011/08/19-ны өдрийн I/501 тоот албан бичгийн дагуу энэхүү мэдээллийг Үнэт цаасны танилцуулгад хавсаргав.*

бөгөөд хүчин чадлын ашиглалтаа дээшлүүлэх тусам энэ зардлын 1 кг маханд ногдох хэмжээ буурах болно.

Элэгдэлийн зардлын хувьд одоо баригдаж байгаа дуусаагүй барилга болон хөрөнгө оруулалтын ажлууд 2012 онд ашиглалтанд орж үндсэн хөрөнгө нэмэгдэж мөн дахин үнэлгээгээр үндсэн хөрөнгө нэмэгдэнэ гэж тооцоолж элэгдэлийн зардлыг өсгөсөн. Гэвч энэ нь мөнгөөр гарахгүй зардал учраас бондын эргэн төлөлтөнд нөлөөлөхгүй.

Санхүүгийн зардалд бондын хүү болон бонд гаргалтын зардал багтсан байгаа.

### Мөнгөн урсгалын таамаглал

Мөнгөн урсгалын таамаглалын хугацааг мөн л мал бэлтгэлийн мөчлөгөөр зааглан гаргасан.

<b>Мөнгөн урсгалын төсөв, /сая төгрөг/</b>			
№	Үзүүлэлтүүд	2011- 2012	2012- 2013
1	Борлуулалтын орлого	40,233.37	44,806.53
2	Хадгалалт, нядалгааны орлого	403.56	403.56
3	Нөөцийн махны урамшуулал	1,200.00	1,200.00
4	Үйл ажиллагааны зээл	2,057.88	1,977.62
5	Бондын санхүүжилт	30,000.00	-
	<b>Мөнгөний орох урсгалын дүн</b>	<b>73,894.81</b>	<b>48,387.72</b>
1	Үйл ажиллагааны зээл төлөлт	2,057.88	1,977.62
2	Бонд эргэн төлөлт	-	30,000.00
3	Хөрөнгө оруулалт	-	6,000.00
4	Худалдан авалт	25,723.06	29,448.90
5	Худалдан авалтын НӨАТ	2,572.31	2,944.89
6	Үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал	4,604.41	4,841.30
7	Удирдлагын үйл ажиллагааны зардал	3,752.18	4,257.33
8	Үйл ажиллагааны зээлийн хүү	20.50	32.02
10	I. Бондын зээлийн хүү	3,240.00	1,620.00
11	Бондын гаргалтын зардал	705.00	-
12	Тооцсон татвар	298.18	702.05
	<b>Мөнгөний гарах урсгалын дүн</b>	<b>42,973.53</b>	<b>81,824.11</b>
	Элэгдлийн зардал	1,754.30	2,279.71
	<b>Мөнгөний цэвэр урсгал</b>	<b>32,675.59</b>	<b>(31,156.69)</b>
	Мөнгөний эхний үлдэгдэл	-	32,675.59
	<b>Мөнгөний эцсийн үлдэгдэл</b>	<b>32,675.59</b>	<b>1,518.90</b>

Мөнгөн урсгалын таамаглалд 2011 оны 8-р сараас бондын санхүүжилт орно гэж тооцоолж мал бэлтгэлийн үйл ажиллагаа 9,10,11-р сард идэвхитэй бэлтгэгдэн, 9-р сараас мал төхөөрч, мах боловсруулах үйл ажиллагаа явагдахтай зэрэгцэн арьс, ширний борлуулалт хийгдэнэ. 10-р сараас эхлэн дараа оны 6-р сар хүртэл экспортын борлуулалт хийгдэж дуусна, мөн дотоодын борлуулалт 6-р сард эцэслэн дуусна гэж тооцоолсон.

2011 оын 4-р улирлын эцсээр мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 4,798.5 сая төгрөг байх бөгөөд бэлтгэсэн махны үлдэгдэл 20,384.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь дараа онд борлуулагдах махны өртөг бөгөөд 1-6-р саруудад борлуулж бонд, бондын хүү, үйл ажиллагааны зардлуудад зарцуулагдана.

Төсөвлөгдөж буй баланс /сая.төгрөгөөр/					
№	Үзүүлэлтүүд	2011 он		2012 он	
		3-р улирал	4-р улирал	1-р улирал	2-р улирал
<b>1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>18,933.41</b>	<b>28,041.16</b>	<b>31,793.66</b>	<b>35,533.71</b>
1.1	Мөнгө	6,131.04	4,798.54	16,863.58	32,675.59
1.2	Авлага	345.82	345.82	345.82	345.82
1.2.1	НӨАТ-ын авлага	1,113.63	2,512.31	2,512.31	2,512.31
1.3	Бараа материалын нөөц	11,342.93	20,384.49	12,071.95	0.00
1.4	Урьдчилж гарсан зардал, төлбөр	-	-	-	-
<b>2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>45,171.23</b>	<b>44,751.41</b>	<b>44,294.08</b>	<b>43,836.75</b>
2.1	Үндсэн хөрөнгө	45,168.16	44,748.44	44,291.21	43,833.98
2.2	Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө	-	-	-	-
2.3	Бусад биет бус хөрөнгүүд	3.06	2.97	2.87	2.77
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>64,104.63</b>	<b>72,792.56</b>	<b>76,087.74</b>	<b>79,370.46</b>
<b>4</b>	<b>Өр төлбөр</b>	<b>20,570.74</b>	<b>30,828.03</b>	<b>31,148.82</b>	<b>31,052.51</b>
4.1	Богино хугацаат өглөгийн дүн	165.74	18.03	338.82	242.51
4.2	Бонд, бондын хүүний өглөг	20,405.00	30,810.00	30,810.00	30,810.00
<b>5</b>	<b>Эзэмшигчийн өмч</b>	<b>43,533.89</b>	<b>41,964.53</b>	<b>44,938.91</b>	<b>48,317.95</b>
5.1	Хувьцаат хөрөнгө	28,247.85	28,247.85	28,247.85	28,247.85
5.2	Дахин үнэлгээний нөөц	24,129.78	24,129.78	24,129.78	24,129.78
5.3	Хуримтлагдсан ашиг /алдагдал	(8,843.73)	(10,413.09)	(7,438.71)	(4,059.67)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН</b>	<b>64,104.63</b>	<b>72,792.56</b>	<b>76,087.74</b>	<b>79,370.46</b>

2012 оны 12-р сар гэхэд бондын өр болон хүүгийн төлбөрийг төлж дуусах бөгөөд тэр үед мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 166.5 сая төгрөг, бараа материалын /мах/ өртөг 6,153.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төсөвлөгдөж буй баланс /сая.төгрөгөөр/					
№	Үзүүлэлтүүд	2012 он		2013 он	
		3-р улирал	4-р улирал	1-р улирал	2-р улирал
<b>1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>18,528.12</b>	<b>12,122.60</b>	<b>9,976.16</b>	<b>7,321.91</b>
1.1	Мөнгө	8,247.53	166.15	1,133.82	1,518.90
1.2	Авлага	345.82	345.82	345.82	345.82
1.2.1	НӨАТ-ын авлага	4,113.96	5,457.20	5,457.20	5,457.20
1.3	Бараа материалын нөөц	5,820.81	6,153.44	3,039.33	0.00
1.4	Урьдчилж гарсан зардал, төлбөр	-	-	-	-
<b>2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>43,266.82</b>	<b>42,696.90</b>	<b>45,126.97</b>	<b>47,557.04</b>
2.1	Үндсэн хөрөнгө	43,264.15	42,694.33	42,124.50	41,554.67
2.2	Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө	-	-	3,000.00	6,000.00
2.3	Бусад биет бус хөрөнгүүд	2.67	2.57	2.47	2.37
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>61,794.94</b>	<b>54,819.49</b>	<b>55,103.13</b>	<b>54,878.95</b>
<b>4</b>	<b>Өр төлбөр</b>	<b>10,780.41</b>	<b>425.51</b>	<b>415.81</b>	<b>242.51</b>

*"Монголын Хөрөнгийн Бирж" ХК-ийн 2011/08/19-ны өдрийн I/501 тоот албан бичгийн дагуу энэхүү мэдээллийг Үнэт цаасны танилцуулгад хавсаргав.*




4.1	Богино хугацаат өглөгийн дүн	375.41	425.51	415.81	242.51
4.2	Урт хугацааат өр төлбөрийн дүн	10,405.00	-	-	-
<b>5</b>	<b>Эзэмшигчийн өмч</b>	<b>51,014.54</b>	<b>54,393.99</b>	<b>54,687.32</b>	<b>54,636.44</b>
5.1	Хувьцаат хөрөнгө	28,247.85	28,247.85	28,247.85	28,247.85
5.2	Дахин үнэлгээний нөөц	24,129.78	24,129.78	24,129.78	24,129.78
5.3	Хуримтлагдсан ашиг /алдагдал	(1,363.08)	2,016.37	2,309.70	2,258.82
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН</b>	<b>61,794.94</b>	<b>54,819.49</b>	<b>55,103.13</b>	<b>54,878.95</b>



*“Монголын Хөрөнгийн Бирж” ХК-ийн 2011/08/19-ны өдрийн I/501 тоот албан бичгийн дагуу энэхүү мэдээллийг Үнэт цаасны танилцуулгад хавсаргав.*

## БОНДЫН БАТАЛГАА

Үнэт цаас гаргагч болон Андеррайтерын компанитай 2011 оны 3 дугаар сарын 14-ны өдөр байгуулсан Андеррайтерын гэрээний 6-р бүлэгт тусгагдсаны дагуу бондын баталгаа нь компанийн үл хөдлөх хөрөнгө болон бүтээгдэхүүний борлуулалтын гэрээгээр хийгдэж байгаа болно.

		
<b>“ЖАСТ АГРО” ХХК</b>		ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД
16102-Улаанбаатар хот, Баянгол дүүрэг 20 дугаар хороо, Сонголон Max Market төв үйлдвэрийн байр Утас: 7732-9074, Факс: (976-11) 636277 E-mail: agro@justgroup.mn, http://www.justgroup.mn		
2011-08-22 № 03-01/366		
танай _____	ны _____	-Т _____
Тайлбар бичиг		

“Жаст Агро” ХХК нь олон нийтэд 30 тэрбум төгрөгийн бонд гарган санхүүжилт татан төвлөрүүлж буйтай холбогдуулан бид дараах үүргийг хүлээж буйг хөрөнгө оруулагч таньд үүгээр мэдэгдэж байна.

Нэг. “Жаст Агро” ХХК-ын бондын эргэн төлөлт дуусах хүртэлх хугацаанд түүний толгой компани болох “Жаст Групп” ХХК нь ямарваа нэгэн ногдол ашиг төлөхгүй;



Хоёр. Олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгөөс болон бондын эргэн төлөлт дуусах хүртэл борлуулалтын орлогоос нэгдмэл сонирхолтой этгээдүүдэд зээл олгохгүй, хөрөнгө оруулалт хийхгүй;


Гурав. Бонд гаргагч нь Үнэт цаасны тухай хуулийн 9.5-д заасны дагуу бондын борлуулалтаар татан төвлөрүүлсэн хөрөнгийг зөвхөн үнэт цаасны танилцуулгад тусгагдсан үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулна;

Дөрөв. “Жаст Агро” ХХК-ийн бондын санхүүжилтээр бэлтгэсэн махыг үнэт цаас гаргагч болон түүний нэгдмэл сонирхолтой этгээд нь аливаа барьцаанд тавихгүй, түүгээр бусдын өмнө үүргийн гүйцэтгэл хангахгүй болно;

Тав. Бид Андеррайтер “БиДиСЕК” ХК-тай хамтарсан данс нээн татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт, борлуулалтын орлогоос бондын хүүгийн болон үндсэн төлбөрийн төлөлт дээр хөндлөнгийн хяналттай ажиллана.

ХҮНДЭТГЭСЭН:

	
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ	Т.СОДНОМДАРЖАА



“Монголын Хөрөнгийн Бирж” ХК-ийн 2011/08/19-ны өдрийн I/501 тоот албан бичгийн дагуу энэхүү мэдээллийг Үнэт цаасны танилцуулгад хавсаргав.



**“ЖАСТ ГРУПП” ХХК**

210648 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Бага тойруу 44, Монголын залуучуудын холбооны байр,  
Утас: 31-82-61, 32-79-21, Факс: (976-11) 31-56-12  
E-mail: info@justgroup.mn, http://www.justgroup.mn

2011.08.26 № 3/675

танай \_\_\_\_\_-ны \_\_\_\_\_-т

Албан тоот хүргүүлэх тухай

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД

“Жаст Агро” ХХК нь мал, мах бэлтгэлийн ажлын санхүүжилтэнд зориулж 30 тэрбум төгрөгийн бондыг олон нийтэд санал болгон гаргахтай холбогдуулан өөрийн эзэмшлийн мах боловсруулах 8 үйлдвэрийг бондын баталгааны барьцаанд тавьж, УБЕГ-ын Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газар, түүний орон нутгийн Улсын бүртгэлийн хэлтсүүдэд бүртгүүлсэн. Энэ хөрөнгийн нийт өртөг 31.6 тэрбум төгрөг бөгөөд бондын баталгааны хувьд хангалттай барьцаа болно. Иймд, “Жаст Агро” ХХК-ийн 2011 оны 08 дугаар сарын 22-ны өдөр хийсэн 03-01/366 тоот тайлбар бичгийг хүлээн зөвшөөрч байгаа тул,

Нэгдүгээрт, “Жаст Групп” ХХКомпани нь нэмэлт баталгаа гаргах үүрэггүйг,

Хоёрдугаарт, дээрх үйлдвэрүүдийг өөр зорилгоор гуравдагч этгээдэд барьцаалах эрхгүйг,

Гуравдугаарт, “Монгол Мах бонд”-ын эргэн төлөлт дуусах хүртэлх хугацаанд “Жаст Агро” ХХК-ийн орлого, үр дүнгээс ямарваа нэг хэлбэрээр ногдол ашиг хуваарилуулахгүйг мэдэгдэж байна.

Хүндэтгэсэн,

БИЗНЕСИЙН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ



Б.ЭНХБАТ





Үл хөдлөх хөрөнгө:

Бондын үндсэн болон хүүгийн төлбөрийн нийт дүнг хангахуйц үнийн дүнтэй Үнэт цаас гаргагчийн эзэмшлийн дараах үйлдвэрүүдээр баталгаа гаргасан болно.



**“ЖАСТ ГРУПП” ХХК-ИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН  
ТУШААЛ**

2011 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А-01/28

Улаанбаатар хот

Хөрөнгө тусгаарлах зөвшөөрөл олгох  
тухай

“Мах бонд” өрийн бичиг гаргах гэж байгаатай холбогдуулан ТУШААХ нь:

Нэг. “Жаст Агро” ХХК-ийн “Би Ди Сек” ХК-тай байгуулсан Андеррайтерын гэрээний дагуу “Мах бонд” өрийн бичиг гаргахтай холбогдуулан энэхүү тушаалын Нэгдүгээр хавсралтад дурьдагдсан “Жаст Агро” ХХК-ийн үл хөдлөх эд хөрөнгүүдийг бондын баталгааны барьцаа болгож тусгаарлан “Би Ди Сек” ХК-тай барьцааны гэрээ байгуулахыг “Жаст Агро” ХХК-ийн Гүйцэтгэх захирал /Т.Содномдаржаа/-д зөвшөөрсүгэй.

Хоёр. Нэгдүгээр хавсралтад дурьдагдсан салбар үйлдвэрүүдийн хөрөнгүүдийг Андеррайтерын гэрээгээр тохиролцсоноос өөр зорилгоор ашиглахгүй байхыг “Жаст Агро” ХХК-ийн Гүйцэтгэх захирал /Т.Содномдаржаа/-д үүрэг болгосугай.

Гурав. Олон нийтэд санал болгож буй бондыг бүртгэх тухай Санхүүгийн Зохицуулах Хорооны тогтоол гарсны дараа Нэгдүгээр хавсралтад дурьдагдсан хөрөнгүүдийг тусгаарлан УБЕГазрын Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газарт бүртгүүлэхийг “Жаст Агро” ХХК-ийн Санхүү хариуцсан дэд захирал /Ч.Баасанжаргал/-д үүрэг болгосугай.

Дөрөв. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын газрын захирал /Б.Хөхөөжаргал/-д үүрэг болгосугай.



ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

 Ш.БАТХҮҮ



"Жаст групп" ХХК-ийн Ерөнхий  
захирлын 2011 оны 02 сарын 19  
өдрийн А-01/2011 дугаар тушаалын  
Нэгдүгээр хавсралт

Тусгаарлах хөрөнгийн жагсаалт

№	Үйлдвэрийн нэр	ҮХЭХӨЭ-ийн Улсын бүртгэлийн дугаар	Тусгаарлах хөрөнгийн дүн, (мян.төг)
1	Улаанбаатар ММ	Ү-2205011375	11,939,667.9
2	Баян-Өлгий Мах маркет	Ү-0213000010	4,491,252.2
		Ү-0213000430	
		Ү-0213000445	
		Ү-0213000446	
		Ү-0213000447	
		Ү-0213000448	
		Ү-0213000449	
		Ү-0213000450	
		Ү-0213000451	
3	Завхан Мах маркет	Ү-0905000534	1,234,576.3
4	Сүхбаатар Мах маркет	Ү-1213001436	1,157,204.0
		Ү-1213000413	
5	Булган Мах маркет	Ү-0415000106	1,384,128.6
6	Увс Мах маркет	Ү-1520001817	815,467.6
7	Дорнод Мах маркет	Ү-0614002893	8,374,918.5
		Ү-0614002894	
		Ү-0614002895	
8	Хөвсгөл Мах маркет	Ү-1723002151	2,218,022.1
<b>Нийт дүн</b>			<b>31,615,237.2</b>



### Борлуулалтын гэрээ:

Лалын Бүгд Найрамдах Иран Улс руу 4600 /дөрвөн мянга зургаан зуу/-н тонн хонины махыг 2012 оны 02 дугаар сарын 28-ний өдрөөс өмнө 2 удаагийн тээвэрлэлтээр нийлүүлэх гэрээг 2011 оны 3 дугаар сарын 10-ны өдөр “Юни трейд” компанитай байгуулсан.

ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улсын “Бурятмяспром” компанитай 30 720 000 /гучин сая долоон зуун хорин мянга/-н ам.долларын үнийн дүн бүхий 12000 тн адуу, үхрийн махыг 2011 оны 8 дугаар сарын 01-нээс 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд нийлүүлэхээр худалдах, худалдан авах гэрээг 2011 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр байгуулсан.

### **Бонд эзэмшигчдийн мөнгийг эргэн төлөх тухай**

Бонд эзэмшигчдийн хүүгийн болон үндсэн төлбөрийг цаг хугацаанд нь төлж барагдуулаагүй бол дараах арга хэмжээнүүд авагдах болно.

### Компанийн тухай хуулиас

Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол өрийн бичиг гаргах шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/ гаргана. Энэ шийдвэрт өрийн бичгийн хэмжээ, төрөл, хугацаа, гаргасан үнэ, хүүгийн хэмжээ, хүү төлөх хугацаа, эргүүлэн авах үнэ, бусад мэдээллийг заана.

### Андеррайтерийн гэрээний заалтаас

Үнэт цаас гаргагч нь андеррайтерийн компанитай 2011 оны 3 сарын 14-ны өдөр андеррайтерийн гэрээг байгуулан ажиллаж байгаа бөгөөд уг гэрээний 5.8-д “Бонд гаргагч н болон батлан даагч нь зуучлагчийн гаргасан графикайн дагуу бондын хүү, үндсэн төлбөрийг төлөлгүй ажлын 5 хоног хэтэрсэн тохиолдолд барьцаа хөрөнгөөр дараах нөхцлөөр бондын хүүгийн болон үндсэн төлбөрийг төлөх үүрэгтэй”

5.8.1. Зуучлагч нь эхний ээлжинд бонд эзэмшигчдэд Батлан даагчийн баталганы барьцаа хөрөнгийг санал болгон андеррайтерийн гэрээний 6-р бүлэгт заасан хөрөнгийг өмчлөх эрхийг бонд эзэмшигчдэд шилжүүлэх,

5.8.2. Бонд эзэмшигчид нь хүү болон үндсэн төлбөрийг бэлэн мөнгөөр барагдуулах санал гаргасан тохиолдолд баталгаа гаргасан хөрөнгийг зах зээлд санал болгох, уг хөрөнгийг худалдан авахгүй тохиолдолд өдөрт 5%-аар ханшийг буулган худалдах санал тавьж худалдан борлуулж бонд эзэмшигчдийн төлбөрийг төлж барагдуулах,

5.8.3. Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Бонд эзэмшигчдийг төлөөлөн Бонд гаргагчид аудитын шалгалт оруулах, хуулийн байгууллагад гомдол гаргах, иргэний болон эрүүгийн хэрэг үүсгэх

6.7. Бонд гаргагчийн баталгаа болгож буй хөрөнгө нь бондын хүү болон үндсэн төлбөрийг төлж барагдуулахад дутах тохиолдолд Бонд гаргагч нь дутах төлбөрийг бүрэн хариуцаж төлнө.



Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээний заалтаас

Уг барьцааны гэрээгээр нийт 31,615,236,600 төгрөгийн үнэлгээ бүхий 8 үйлдвэрийн барилга, байгууламж байгаа бөгөөд уг гэрээний 3.1-д дараах байдлаар үүргийн гүйцэтгэл хангахаар заасан байна.

3.1. Барьцаалуулагч нь Андеррайтерын гэрээний дагуу хүлээсэн үүргээ зохих ёсоор, бүрэн гүйцэт биелүүлээгүй тохиолдолд Барьцаалагч нь энэ талаар бичгээр сануулах бөгөөд ийнхүү сануулснаас хойш 15 хоногийн дотор хариу ирүүлээгүй бол Барьцааны зүйлийг шүүхийн журмаар худалдан борлуулж үүргийн гүйцэтгэл хангана.





МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2011 оны 07 сарын 26 өдөр

Дугаар 223

Улаанбаатар хот

Г “Мах” бондыг бүртгэх тухай 7

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Компанийн тухай хуулийн 42.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Жаст агро” ХХК-ийн гаргах 12 сарын хугацаатай, жилийн 16.2 хувийн хүүтэй, нэг бүр нь 10,000 /арван мянга/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 3,000,000 /гурван сая/ ширхэг “Мах” бондыг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /С.Тулгаа/, Хөрөнгийн биржийн жагсаалтад бүртгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, төвлөрсөн хадгаламжинд бүртгэхийг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Д.Гандулам/-д тус тус зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан “Жаст агро” ХХК-ийн 3,000,000 /гурван сая/ ширхэг бондоос эхний ээлжинд 1,000,000 /нэг сая/ ширхэг бонд худалдахыг зөвшөөрч, үлдсэн 2,000,000 /хоёр сая/ ширхэг бондыг худалдахдаа Хороонд тухай бүр мэдэгдэж зохих зөвшөөрөл авсны үндсэн дээр худалдахыг “Жаст агро” ХХК /Г.Содномдаржаа/-д үүрэг болгосугай.

3. Бонд гаргах тухай үнэт цаасны танилцуулгыг Үнэт цаасны газраар баталгаажуулан, уг үнэт цаасны танилцуулгад үндэслэн олон нийтэд үнэ төлбөргүйгээр холбогдох мэдээлэл хүргэж ажиллахыг “Жаст агро” ХХК /Г.Содномдаржаа/, “Би Ди Сек” ХК /Д.Даяанбилгүүн/-д тус тус үүрэг болгосугай.

4. Бондын арилжааны тайланг хууль, журамд тогтоосон хугацаанд Хороонд ирүүлж, хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлж ажиллахыг “Жаст агро” ХХК /Г.Содномдаржаа/-д үүрэг болгосугай.

5. Бондын борлуулалт, үндсэн болон хүүгийн төлөлтөд холбогдох журмын дагуу хяналт тавьж ажиллахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, “ҮЦГТГХТ” ХХК /Д.Гандулам/-д тус тус даалгасугай.

6. Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /С.Тулгаа/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-г тус тус даалгасугай.



ДАРГА

Д.БАЯРСАЙХАН



МОНГОЛ УЛС  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

2007.05.11  
Аврсан өдөр

УТГ 10900074  
Аврсан өдөр

5138124  
Аврсан өдөр

Жас-Агро

Хилээр дамнан харууцрагтай компани

Хуулийн зөвсөлийн гэр, харууцрагтай хэлбэр

Дүрэм

Гүүсэл (байгуулах баримт бичиг)

Шийдвэр  
Хуулийн зөвсөлийн гэр

01  
Хууль

2007.01.17  
он, сар, өдөр

151100  
Ард

Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хэрэглэх  
Гүндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл

012200

Бусад амьтад үржүүлэн, ациг шиймийг авах

012100

Мал аж ахуй

602300

Авто ачаа тээвэрлэх үйлчилгээ

Ард

Хуульч  
Хуульч

Гүүсэл эрхлэх үйл ажиллагааны чиглэл

1

Гэгшүүдийн тос

2007.05.11  
УТГ 10900074  
5138124  
10,000.0  
Төлбөрийн үнэ, зарийг тасчлав.  
Гүүсэлийн хонгируу  
Төлбөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр

Баянгол, 20-р хороо, Дунд гол БГД, Өөрийн байр - 00, утас: 636277, утас2: , факс:

Хуулийн зөвсөлийн гэр, харууцрагтай хэлбэр

Улсын Бүртгэлийн Албаны Гүйцэтгэх Зөвлөлийн гишүүн  
Хуульч  
Хуульч  
Улсын Бүртгэлийн Албаны Гүйцэтгэх Зөвлөл  
Нотариат

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ  
УЛСЫН  
БҮРТГЭЛИЙН  
АЛБАНЫ БҮРТГЭЛИЙН АЛБА  
Бүртгэсэн байгууллагын нэр  
УХЛ0175

Харилцагч байгууллага

Дансны төрөл

Дансны дугаар

Бүртгэсэн ажлын төрөл

Звонок банкны 117-р сэлбэр  
Звонок банкны 117-р сэлбэр

Төгрөгний  
Валютын

210000000  
210000000

10-р бүс  
10-р бүс

**Хуулийн этгээдийн үүсэл бийрүүлэх баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтгүй, бүртгэн**

Д/д	Нэмэлт, өөрчлөлтгүйн дугаар	Бүртгэсэн	
		Огноо	Ажлын, гэмдэл
1	Капитрон банк 3053002741 тоот төгрөгийн дансыг бүртгэсэн	2009.04.13	Б.Авирмэд
1	ХААН банк 5030006741 тоот төгрөгийн дансыг бүртгэсэн	2009.04.13	Б.Авирмэд
1	ХААН банк 5027337529 тоот төгрөгийн дансыг бүртгэсэн	2009.04.13	Б.Авирмэд
1	Голомт тус банк 1103003710 тоот төгрөгийн дансыг бүртгэсэн	2009.04.13	Б.Авирмэд
2	Сэлбэр-1 Завхан аймags Төрсөнцэвэл сум Хайрхан баг 9 9 байрлах сэлбэр нэгжийг бүртгэсэн.	2009.04.13	Б.Авирмэд
2	Сэлбэр-2 Булган аймags Хутаг-Өндөр сум 1-р баг байрлах сэлбэр нэгжийг бүртгэсэн.	2009.04.13	Б.Авирмэд
2	Сэлбэр-3 Сүхбаатар аймags Бруун-Урт сум байрлах сэлбэр нэгжийг бүртгэсэн.	2009.04.13	Б.Авирмэд
2	Сэлбэр-4 Баян-Өлгий аймags Өлгий сум байрлах сэлбэр нэгжийг бүртгэсэн.	2009.04.13	Б.Авирмэд
2	Сэлбэр-5 Увс аймags Улаангом сум байрлах сэлбэр нэгжийг бүртгэсэн.	2009.04.13	Б.Авирмэд
2	Сэлбэр-6 Дорнод аймags Хэрлэн сум 1-р баг байрлах сэлбэр нэгжийг бүртгэсэн.	2009.04.13	Б.Авирмэд
2	Сэлбэр-7 Хөвсгөл аймags Морьн сум 8-р баг байрлах сэлбэр нэгжийг бүртгэсэн.	2009.04.13	Б.Авирмэд
3	Дүрмийн шинэчилсэн найруулгыг бүртгэсэн.	2009.04.13	Б.Авирмэд
4	Сэлбэр-8 Өвөрхангай аймags, Арвайхээр сум байрлах сэлбэр нэгжийг бүртгэсэн.	2009.09.17	Б.Авирмэд
4	Сэлбэр-9 Сэлэнгэ аймags Сүхбаатар сум 4-р баг байрлах сэлбэр нэгжийг бүртгэсэн.	2009.09.17	Б.Авирмэд
4	Сэлбэр-10 Багайнуур дүүрэг 3-р хороо Үйлдвэр 24 хэсэг байрлах сэлбэр нэгжийг бүртгэсэн.	2009.09.17	Б.Авирмэд
5	Хадгаламжийн банк 1700065750 тоот төгрөгийн дансыг бүртгэсэн.	2009.09.18	Б.Авирмэд
5	Хадгаламжийн банк 170007509 тоот валютын дансыг бүртгэсэн.	2009.09.18	Б.Авирмэд
5	Хадгаламжийн банк 1700007111 тоот валютын дансыг бүртгэсэн.	2009.09.18	Б.Авирмэд
6	Төртөгтох овоотой Содномдаржаа -г Гүйцэтгэх захирал -г томилсныг бүртгэсэн.	2010.12.29	Б.Авирмэд
7	Звонок банкны 117-р сэлбэр 2417040822 тоот төгрөгийн дансыг бүртгэлээс хасав.	2011.01.04	Б.Авирмэд
7	Звонок банкны 117-р сэлбэр 2417040833 тоот валютын дансыг бүртгэлээс хасав.	2011.01.04	Б.Авирмэд
8	Капитрон банк 3053002741 тоот төгрөгийн дансыг бүртгэлээс хасав.	2011.01.04	Б.Авирмэд
8	Хадгаламжийн банк 10220012715 тоот төгрөгийн дансыг бүртгэсэн.	2011.01.12	Б.Авирмэд
8	Хадгаламжийн банк 10510001528 тоот төгрөгийн дансыг бүртгэсэн.	2011.01.12	Б.Авирмэд
9	Дүрмийн сан 28237845.5-р нэмэгдэж 28247845.5.0 мянган төгрөг болж, үүсгэн байгуулагчийн тоо 1 болж өөрчлөгдсөнийг бүртгэсэн.	2011.04.22	Б.Авирмэд



Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу харбуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.



**ЖАСТ АГРО**  
**ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ДҮРЭМ**  
(2011 оны 03-р сарын 31-ний өдрийн шинэчилсэн найруулга)

**Нэг. Нийтэл үндэслэл**

1.1 "Жаст Агро" ХХК нь (дараахд Компани гэх) Монгол улсын Компанийн тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, үйл ажиллагаагаа явуулж буй, өөрийн төрийн өмчөөс эрх эдлэн, үүрэг хүлээж хуулийн этгээд болох бөгөөд бие даасан тайлан тэнцэтгэл, банкнд харилцах данстай, өөрийн үйл ажиллагааг явуулах зохих зовноороолтэй, хувь нийлүүлэгчдийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хувишдаж, түүнийг захиран зарцуулах эрх нь энэхүү дүрмээр хязгарлагдах, хязгарлагдмал хариуцлагатай компани байна.

1.2 Компанийн оноосон нэр: монголоор - "Жаст Агро" ХХК  
англиар - "Just Agro" LLC

1.3 Компанийн оршин байгаа газар, хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р Хороо, Сонголон, өөрийн байранд Утас: 632392, Факс: 636277, имэйл: [meatmarket@justgroup.mn](mailto:meatmarket@justgroup.mn)

1.4 Компанийн үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгч нь "Жаст Групп" ХХК болно. Үүнд:

Хуулийн этгээдийн регистр: 5085659

Улсын бүртгэлийн дугаар: 9011060127

Оршин байгаа хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу-42, Монголын Залуучуудын Холбооны байр, 4 давхарт, Утас: 318261, Факс: 315612

1.5 Компани нь 28 247 845 541.90 ( хорин найман тэрбум хоёр зуун дөчин долоон сая найман зуун дөчин таван мянга таван зуун дөчин нагэн төгрөг ерэн мөнгө ) төгрөгийн өөрийн хөрөнгө буюу дүрмийн сангай болно. Компанийн дүрмийн санг хувь нийлүүлэгч "Жаст групп" ХХК 100 хувь эзэмшдэг болно.

1.6 Компани нь "Жаст групп" ХХК-ийн өхнө компани бөгөөд "Жаст групп" ХХК-ийн дүрэм, дотоод дүрэмд нийцүүлэн баталсан энэхүү дүрэмд заасан эрх зүйн хэм хэмжээнд үйл ажиллагаагаа явуулна.

1.7 Компани нь "Жаст групп" ХХК-ийн үүргийг харуулахгүй бөгөөд "Жаст групп" ХХК нь компанийн үүргийг түүнд оруулсан хоронгийн хэмжээгээр харуулна.

1.8 Компани нь дараахь чиглэлгээр үйл ажиллагаа явуулна. Үүнд:

- Мал бэлтгэл; махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл
- Мах, махан бүтээгдэхүүний бооный болон жижиглэнгийн борлуулалт
- Галзад, дотоод худалдаа;
- Хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагаа.

1.9 Компани нь оорчлон байгуулах, татан буугдах хүргэл үйл ажиллагаатай хугацаагүйгээр эрхлэх бөгөөд энэхүү хугацаа нь түүнд олгогдсон тусгай зовноорлоор зохицуулагдаж байна.

1.10 Компани нь эрхлэх үйл ажиллагааны чиглэл болон хугацаанд орсон оорчлолгийг тухай бүр дүрэмдээ тусгаж, улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.

1.11 Компани нь бүртгэх байгууллагад зохих журмын дагуу бүртгэгдсэн бэлгэдэл болон барааны тэмдэгтэй байж болох бөгөөд албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн нэр бүхий тамга тэмдэг хэрэглэнэ.

1.12 Компанийн санхүүгийн жил нь тухайн жилийн нэгдүгээр сарын нэгэнд эхэлж арван хоёрдугаар сарын гучин нэгэнд дуусна.

1.13 Компанийн үйл ажиллагаатай холбоотой, энд тусгагдаагүй бусад харилцааг компанийн дотоод дүрэм болон "Жаст групп" ХХК-ийн дүрэм, дотоод дүрмээр зохицуулна.

### Хоёр. Компанийн удирдах байгууллага

2.1 Компанийн эрх барих дээд удирдлага нь "Жаст групп" ХХК байна.

2.2 Дараахь асуудлаар "Жаст групп" ХХК-ийн Ерөнхий захирал зөвхөн шийдвэр гаргана.

Үүнд:

- компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу түүний шинэчилсэн найруулгыг батлах



- компанийн дүрмийн санаг төмөрлүүлэх, хоросруулах болон компанийн хүний бусдад судалдах, шилжүүлэх
- компанийн бүтэц, зохион байгуулалтыг багтаах
- компанийн Гүйцэтгэх захирлыг томшиох, чөлөөлөх, түүний эрх хэмжээг тогтоох
- компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн жилийн төлөвлөгөөг хэлэлцэж багтаах
- компанийн хөрөнгө оруулалтын болон үйл ажиллагааны шрдлын төлөвлөгөөг багтаах
- компанид үндсэн хөрөнгө эзэмшүүлэхээр шилжүүлэх, компанийн эгэмшиж буй үндсэн хөрөнгийг зарж борлуулах, автлах, бусдад шилжүүлэх
- компанийн дотоод аудиторыг сонгож, гэрээ байгуулах компанийн нэгдэл ашигийн хэмжээг тогтоож, төлөх журмыг багтаах
- компанийн хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад асуудлууд
- гүйцэтгэх захирлын болон "Жаст групп" ХХК-ийн төв удирдлагын саналаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудлууд

2.3 Компани нь Захирлуудын зөвлөлтэй байна.

2.4 Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг "Жаст групп" ХХК-ийн Ерөнхий захирлаас томилсон Гүйцэтгэх захирал удирдана.

2.5 Компанийн Гүйцэтгэх захирал нь дараахь асуудлыг "Жаст групп" ХХК-ийн Ерөнхий захиралтай заавал зөвшилцсний үндсэн дээр шийдвэр гаргана. Үүнд:

- компанийн Ерөнхий нягтлан бодогчийг ажилд авах, ажлаас чөлөөлөх
- компанийн ажилтнуудын цалингийн сүлжээг тогтоох, өөрчлөх
- компанийн борлуулах бараа, ажил үйлчилгээний зах зээлийн үнийг тогтоох, өөрчлөлт оруулах
- компанийн ажилтнуудад үр дүнгийн шагнал олгох, гавьяа шагналд тодорхойлох, орон сууц олгох, хандив тусламж олгох
- хуулийн этгээд, хувь хүнд компаниас хандив, тусламж өгөх
- харилцагч байгууллага, хувь хүнээс авах авлагыг найдваргүй авлагын ангилалд шилжүүлэх, найдваргүй авлагыг данс бүртгэлээс хасах
- үндсэн эд хөрөнгийг худалдан авах болон бусдад хүлээсэн үүргийн биелэлтэнд барьцаалах

хөрөнгийн хөрөнгө нэхэхэн хэмжээгээр төлөгдөх (нэхэхэн хэмжээ гэдгийг тухай бүр тодорхойлно)

нэхэхэн хэмжээний бараа бүтээгдэхүүнийг бусдад гэрээгээр борлуулах (нэхэхэн хэмжээ гэдгийг тухай бүр тодорхойлно )

- компанийн 5 ба түүнээс дээш эрэгт хамаарах албан тушаалтнуудыг сонгон шалгаруулах, ажилд авах, ажлаас чөлөөлөх, асуудлыг консилицож байж шийдвэрлэх
- хөрөнгө оруулалт, төлөнлогоо
- мөнгөн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалттай холбоотой шийдвэрүүд болон банкнаас гээл авах

#### 2.6 Компанийн Гүйцэтгэх захирал нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Компанийн одор тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хянагт тавих
- Компанийн өмч хөрөнгийг компанийн үйл ажиллагаанд үзэмших
- Компанийн санхүүгийн тайлан тэнцдгийг хэлэлцэж, батлах
- Өөрийн эрх мэдлийн хүрээнд холбогдох баримт бичигт гарын үсэг зурах, хэлцэл хийх, гэрээ байгуулах, хийгдэж буй бүх гэрээнд хяналт тавих, шүүхэд нэхэмжлэл гаргах, тайлбар хүргүүлэх, компанийг төлөөлөх
- Хууль тогтоомж, компанийн дүрэм болон "Жаст групп" ХХК-ийн дүрэм, дотоод дүрэмд нийцүүлэн компанийн хэмжээнд дагаж мөрдөх тушаал, журам, заавар гаргах
- Компанийн ажилтан, албан хаагчдыг ажилд авах, ажлаас халах
- Компанийн ажилтан, албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг батлах, тэдэнтэй хөдөлмөрийн болон хөлсөөр ажиллуулах гэрээг байгуулах
- Компанийн ажилтан, албан хаагчдад сахилгын болон бусад хариуцлага тооцох
- Компанийн өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтын байдалд өдөр тутам тавих хяналтыг зохион байгуулах
- Компанийн салбар, нэгжийн гүйцэтгэх удирдлагыг томилох
- Компанийн дүрэм болон "Жаст групп" ХХК-ийн дүрэм, дотоод дүрмээр хориглоогүй бусад асуудлаар

### Гурав. Компанийн гүйцэтгэх удирдлагын хүлээх хариуцлага

- 3.1 Компанийн гүйцэтгэх удирдлагад компанийн гүйцэтгэх захирал, тэргүүн дэд захирал, дэд захирал, албаных дараа, ерөнхий тусгаан бодсон, ерөнхий үдийн засагч, ерөнхий мэргэжилтэн нар багтана. Эдгээрийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.
- 3.2 Компанийн гүйцэтгэх удирдлага компанийн дотоод журамд авсан үүргийг биелүүлж, компанийн ашиг сонирхлын төлөө үргэлч шударгаар ажиллана. "Жаст Групп" ХХК-ийн Ерөнхий захирлын зөвшөөрөлөөс бусад тохиолдолд компанийн нууцыг мэдсэн гуравдагч этгээлд дамжуулах, хувийн ашиг сонирхлын төлөө ашигланхыг хориглоно.
- 3.3 Компанийн гүйцэтгэх удирдлага өөрийн хууль бус үйл ажиллагаанаас компанид учруулсан хохирлыг хариуцна. Компанийн гүйцэтгэх удирдлагад хариуцлага хүлээлгэх, түүний хэм хэмжээг тогтоох асуудлыг тэдгэртэй байгуулсан хөдөлмөрийн гэрээнд тусгах бөгөөд асуудлыг энэ хүрээнд шийдвэрлэх боломжгүй бол шүүхээр шийдвэрлүүмэг.
- 3.4 Компанийн гүйцэтгэх удирдлага санаатайгаар дараахь хууль бус үйл ажиллагаа явуулсан бол компанид учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр хариуцна. Үүнд:
- хувийн ашиг сонирхлын үүднээс компанийн нэрийг ашиглан аж ахуйн үйл ажиллагаа явуулсан
  - компанийн хувь нийлүүлэгчид хуурамч мэдээлэл өгсөн
  - компанийн харилцагчтай нэгдмэл сонирхолтой этгээд болохоо мэдэгдээгүй
  - компанийн бичиг баримтыг зохих ёсоор хадгалаагүй
  - энэ дүрмийн 3.2-д заасан зарчмыг баримтлаагүй
  - энэ дүрмээр тогтоосон гэрээ хэлцэл байгуулах, эд хөрөнгө захиран зарцуулах эрх хэмжээг хэтрүүлсэн

### Дөрөв. Компанийн санхүүгийн тайлан

- 4.1 Компанийн санхүүгийн тайлан нь үлдэгдэл тэнцэл, орлого үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, эзэмшигчийн өмчийн хөдлөлийн тайлан болон тайлбар, тодруулгаас бүрдэнэ.
- 4.2 Компани санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиар тогтоосон нягтлан бодох бүртгэлийн зарчимд нийцүүлэн улирал, жилээр гаргаж, Аудитын

хуулийн дагуу баталгаажуулан санхүүгийн байгууллагад туншаж байна.

- 4.3 Компани санхүүгийн тайлан дээрээ үндэслэн татварын хуулийн дагуу төлбөрсөн цн хугацаанд татварын тайлан гаргаж татварыг төлж байна.
- 4.4 Компани нь оорийн охин компаниудын санхүүгийн тайлан тэнцлийг ооргоо нэгтгэж н санхүүгийн нэгдсэн тайлан тэнцлийг гарган, аудитор баталгаажуулан холбогдох банк, санхүүгийн байгууллагад мэдгээж байна.
- 4.5 Компанийн санхүүгийн тайлангийн үгэн юмийг компанийн Гүйцэтгэх захирал хариуцна. Компанийн Ерөнхий нягтлан бодогч эгэхүү хариуцлагаас чөлөөлөгдөхгүй.

### **Тав. Компанийн бичиг баримтыг хадгалах**

5.1 Компани нь хяналт шалгалт, лавлагаа, түүх, архивын зорилгоор дараахь баримт бичгүүдийг хуульд заасан хугацаагаар хадгална. Үүнд:

- Компанийн дүрэм, түүнд орсон нэмэлт оорчлолтууд
- Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ
- Компанийн дотоод бичиг баримт, материалууд
- Компаниас байгуулсан бүх гэрээнүүд
- Компанийн салбар, төлөөлөгчийн газрын журам, гэрээнүүд
- Нягтлан бодох бүртгэлд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох баримт бичгүүд
- Гүйцэтгэх захирлын тушаал, шийдвэр, болон захирлын зөвлөлийн хурлын тэмдэглэл, тогтоол
- Санхүү, аж ахуйн ажиллагааны анхан шатны болон дэлгэрэнгүй бүртгэл, нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг, материалууд
- Хянан шалгагчийн болон аудиторын дүгнэлт, тайлангууд
- Хүний нөөцийн холбогдолтой баримт бичгүүд
- Хууль болон компанийн дүрмээр тодорхойлсон бусад баримт бичиг, материалууд

5.2 Энэхүү дүрмийн 5.1 -д заасан бичиг баримтын хадгалалт хамгаалалтын компанийн Гүйцэтгэх захирлаас томилогдсон эрх бүхий албан тушаалтан хариуцна.



**Зургаа. Компанийг оорчлон байгуулах, татан буулгах**

- 6.1 Компанийг оорчлон байгуулах тухай ойлголтонд компанийг хуваах, бусад компанийтай нийлэх, нэгдэх, тусгаарлах, оорчлох асуудлууд хамрагдана.
- 6.2 Компанийг "Жаст груш" ХХК-ийн Ерөнхий захирлын шийдвэрээр оорчлон байгуулж, татан буулгана.
- 6.3 Компанийг оорчлон байгуулах, татан буулгах тохиолдолд татан буулгах комиссыг "Жаст груш" ХХК-ийн Ерөнхий захирлын шийдвэрээр томилж, татан буулгах комисс томилсноор компанийн бүрэн эрх дуусгавар болж, татан буулгах комисст шилжинэ.
- 6.4 Татан буулгах комисс нь Компанийн тухай хуулийн 26-29-р зүйлд тасна дагуу ажиллана.
- 6.5 Татан буулгах комисс үүргээ гүйцэтгэж байх үедээ өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас компанид ямарваа нэг хохирол учруулсан бол уул хохирлыг хуульд заасан журмын дагуу хариуцна.
- 6.6 Компанийг улсын бүртгэлээ хассанаар татан буулгсанд тооцно.



**Долоо. Дүрэм хүчин төгөлдөр болох**

- 7.1 Энэхүү дүрмийг Монгол хэлээр 2 хувь үйлдэж, нэг хувийг Улсын бүртгэлийн албанд, нэг хувийг Компани өөртөө хадгалав.
- 7.2 Энэхүү дүрэм нь компанийн улсын бүртгэлийн Гэрчилгээнд тэмдэглэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 7.3 Энэхүү дүрмийг 2011 оны 03 дугаар сарын 31 -ний өдөр Улаанбаатар хотноо үйлдэв.



*[Handwritten Signature]* ШЕБАТХҮҮ

Монгол улс, Улаанбаатар 210646,  
Сүхбаатар дүүрэг, Метро Бизнес Төв, 10 давхар  
Утас: 329442, Факс: 70119442  
Цахим шуудан: info@anand-advocates.mn

2011 оны 05 сарын 02 № 11/16

“Жаст Агро” ХХК-ийн тухай

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2009 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 38 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, анхдагч зах зээлд санал болгох, худалдах тухай” журмын 2 дугаар зүйлийн 2.2.4-д заасны дагуу “Жаст Агро” ХХК-ийн тухай гаргасан хууль зүйн дүгнэлтийг хүргүүлж байна.

Хүндэтгэсэн,



ЗАХИРАЛ:

*Б. Батзаяа* Б.БАТЗАЯА

*Б. Батзаяа*





**ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ**

**Нэг. "Жаст Агро" ХХК-ийн тухай**

- 1.1. Монгол Улсын хуулийн этгээд болох хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 9011098074 дүгээрт бүртгэгдсэн, 5138124 тоот регистрийн дугаартай "Жаст Агро" ХХК /цаашид Компани гэнэ/ нь 2007 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр үүсгэн байгуулагдсан, "Жаст групп" ХХК-ийн 100 хувийн охин компани болно.
- 1.2. Компани нь "Жаст групп" ХХК-ийн Ерөнхий захиралын 2011 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А-01/18 дугаар тушаал, 2011 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А-01/26 тоот тушаалаар өөрийн хөрөнгөө 28 247 845 241.90 /хорин найман тэрбум хоёр зуун дөчин долоон сая найман зуун дөчин таван мянга хоёр зуун дөчин нэгэн төгрөг ерэн мөнгө/-н төгрөг болгон нэмэгдүүлж, улмаар УБЕГ-ын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт 2011 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр бүртгүүлж, баталгаажуулсан байна.
- 1.3. Компани нь Улаанбаатар хотод "Мах маркет" төв үйлдвэртэй бөгөөд орон нутагт 10 /арав/-н салбар үйлдвэртэй. Салбар үйлдвэрүүдээ 2009 онд УБЕГ-ын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгүүлсэн байна. Төв үйлдвэр болон салбаруудын байршил нь:

Д/Д	Салбарын нэр	Байршил	Үйл ажиллагааны чиглэл
1	Завхан мах маркет	Завхан аймаг, Тосонцэнгэл сум, Хайрхан баг 9-9.	Мах, махан бүтээгдэхүүн бэлтгэн боловсруулж, ангилан хөлдөөх, хадгалах
2	Булган мах маркет	Булган аймаг, Хутаг-Өндөр сум, 1-р баг	Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх,
3	Сүхбаатар мах маркет	Сүхбаатар аймаг, Баруун-Урт сум	Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх,
4	Баян-Өлгий мах маркет	Баян-Өлгий аймаг, Өлгий сум	Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх,
5	Увс мах маркет	Увс аймаг, Улаангом сум	Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх,
6	Дорнод мах маркет	Дорнод аймаг, Хэрлэн сум, 1-р баг	Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх,
7	Хөвсгөл мах маркет	Хөвсгөл аймаг, Морон сум, 8-р баг	Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх,
8	Өвөрхангай мах маркет	Өвөрхангай аймаг, Арвайхээр сум	Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх,
9	Сэлэнгэ мах маркет	Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум, 4-р баг	Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх,
10	Багануур мах маркет	Улаанбаатар хот, Багануур дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн хэсэг	Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх,
11	Мах маркет төв үйлдвэр	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, өөрийн байранд	Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, боловсруулах

- 1.4. Компанийн эрхлэх үйл ажиллагааны үндсэн чиглэл нь Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хадгалах бөгөөд туслах үйл ажиллагаа нь гадаад худалдаа, бусад амьтад үржүүлэн ашиг шимийг нь авах, авто ачаа тээвэрлэх үйлчилгээ, мал бэлтгэл, мах, махан бүтээгдэхүүний бөөний болон жижиглэнгийн борлуулалт болно.

*(Handwritten signature)*



- 1.5. Компанийн Гүйцэтгэх захиралаар Төртөгтохын Содномдаржаа ажиллаж байна. Т.Содномдаржааг толгой компани болох "Жаст групп" ХХК-ийн Ерөнхий захиралын 2007 оны 10 дугаар сарын 12-ний өдрийн А-161/07 тоот тушаалаар "Жаст Агро" ХХК-ийн Гүйцэтгэх захиралаар томилсон. Гүйцэтгэх захирал нь "Жаст групп" ХХК-ийн Ерөнхий захирал Ш.Батхүүтэй Гүйцэтгэх захирлын үр дүнгийн гэрээг байгуулсан байна.
- 1.6. **Толгой компанийн тухай:** Компанийн толгой компани нь Монгол Улсын хуулийн этгээд болох "Жаст групп" ХХК болно. "Жаст групп" ХХК нь нэг хувьцаа эзэмшигчтэй бөгөөд хувьцаа эзэмшигч нь Монгол Улсын иргэн Шаравламдангийн Батхүү юм. "Жаст групп" ХХК-ийн өөрийн хөрөнгө нь 2 014 000 000 /хоёр тэрбум арван дөрвөн сая/ төгрөг. "Жаст групп" ХХК нь нефтийн бүтээгдэхүүний импорт, борлуулалт, мах бэлтгэл, махны экспортын болон дотоодын борлуулалт, ашигт малтмалын ашиглалт, барилга угсралтын ажил эрхэлдэг. "Жаст групп" ХХК нь "Жаст Агро" ХХК-иас гадна "Жаст Ойл" ХХК, "Меркентайл хаус" ХХК, "Эрд тана" ХХК, "Олон Овоот гоулд" ХХК, "Хадгаламжийн банк" ХХК-иудын хувьцааг 100 хувь эзэмшдэг.

**Хоёр. Хууль зүйн дүгнэлт гаргах үндэслэл, арга зүй**

- 2.1. Санхүүгийн Зохицуулах Хорооны 2009 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 38 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, анхдагч зах зээлд санал болгох, худалдах тухай" журмын 2 дугаар зүйлийн 2.1-д "Нийтэд санал болгон анх удаа хувьцаа гаргаж байгаа компани болон түүний андеррайтер нь дараах ажиллагааг хийж гүйцэтгэсэн, компани нь мөн энэ хэсэгт заасан шаардлагыг хангасан байна", мөн зүйлийн 2.2.3-г "Хорооноос хүлээн зөвшөөрсөн хуульчтай гэрээ байгуулан дараахь дүгнэлт гаргуулсан байна" гэж заасан нь энэхүү хууль зүйн дүгнэлтийг гаргаж үндэслэл болно.
- 2.2. Компани нь 2011 оны 03 дугаар сарын 10-ны өдөр Монгол Улсын хуулийн этгээд болох хууль зүйн үйлчилгээ, өмгөөлөлийн чиглэлээр дагнан үйл ажиллагаа явуулдаг "Ананд энд Батзаяа" ХХК-тай Хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээг байгуулсан.
- 2.3. Энэхүү дүгнэлтийн зорилго нь Компани бонд гаргахтай холбогдуулан "Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, анхдагч зах зээлд санал болгох, худалдах тухай" журмын 2 дугаар зүйлийн 2.2.3-т заасан дүгнэлтийг гаргахад оршино.
- 2.4. Дүгнэлт гаргахын тулд Компаниас гаргаж өгсөн дор дурьдсан баримт бичгүүдтэй танилцаж, шинжлэн судалсан болно. Үүнд:
1. Компанийн болон толгой компани болох "Жаст групп" ХХК-ийн дүрэм, хуулийн этгээдийн гэрчилгээ, танилцуулга,
  2. Компанийн хөдөлмөрийн болон үйл ажиллагааны бусад журмууд,
  3. Компаниас гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээ, хэлцлүүд,
  4. Компанийн үйл ажиллагаатай холбоотой эрх олгосон төрийн захиргааны байгууллагын шийдвэр, эрхийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөл,



- 2.5. Хуульч нь энэхүү дүгнэлтийг гаргахдаа хууль дээдлэх, хараат бус байх, шударга ёсны зарчмуудыг баримталж, Монгол Улсын Иргэний хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай Монгол Улсын хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай Монгол Улсын хууль, Монголын Компанийн Засаглалын Кодекс, Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, анхдагч зах зээлд санал болгох, худалдах тухай журам болон холбогдох бусад хууль тогтоомжуудыг үндэслэсэн болно.

**Гурав. Компанийн эрх зүйн орчин**

- 3.1. Компани нь Монгол Улсын Иргэний хууль болон Компанийн тухай Монгол улсын хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасны дагуу хязгаарлагдмал хариуцлагатай компани бөгөөд “Жаст групп” ХХК-ийн 100 хувийн охин компани болно.
- 3.2. Компани, түүний эрх зүйн байдал, удирдлагын бүтэц, эрх үүрэг, компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны бодлого, төлөвлөгөө нь Компанийн тухай Монгол Улсын хууль, “Жаст групп” ХХК-ийн дүрэм болон “Жаст групп” ХХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлого, Санхүүгийн үйл ажиллагааны заавар, Компанийн дүрэм, үйл ажиллагааны дотоод дүрмээр тус тус тодорхойлогдоно.
- 3.3. Компани нь охин компани болохын хувьд санхүүгийн тайлангаа тусдаа гаргахын зэрэгцээ мөн толгой компанитайгаа нэгдсэн тайлан гаргадаг.
- 3.4. Компанийн толгой компани нь нэг хувицаа эзэмшигчтэй бөгөөд тухайн хувицаа эзэмшигч нь компанийн хэлбэрийг өөрчлөх, өөрчлөн байгуулах, татан буулгах эрхтэй болно.
- 3.5. Компани нь бонд гаргаснаар үнэт цаасны эрх зүйн харилцаанд оролцох бөгөөд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын Хөрөнгийн Бирж” ХХК-иас гаргаж буй дүрэм, журам, заавраар бондтой холбоотой харилцаа нь зохицуулагдана.

**Дөрөв. Компанийн дүрэм, хөдөлмөрийн болон бусад журмуудын тухай**

- 4.1. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг 2011 оны 03 дугаар сарын 31-ний өдөр баталж, мөн өдрөө УБЕГ-ын Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн байна. Компанийн дүрэмд хувь нийлүүлэгчдийн хурлын бүрэн эрхийг толгой компани болох “Жаст групп” ХХК хэрэгжүүлэх, эрх барих дээд байгууллага нь “Жаст групп” ХХК-ийн Ерөнхий захирал байх, түүний эрх, үүргийг тухайлан тогтоож өгсөн байна. Мөн Компанийн Гүйцэтгэх захиралыг “Жаст групп” ХХК-ийн Ерөнхий захиралаас томилох бөгөөд Гүйцэтгэх захиралын бүрэн эрхийг дүрмийн 2 дугаар зүйлийн 2.5, 2.6-д, Гүйцэтгэх захиралын хүлээх хариуцлагыг 3 дугаар зүйлд тус тус тодорхойлжээ. Компани нь Захирлуудын Зөвлөлтэй байхаар дүрмэндээ тусгажээ.
- 4.2. Компани нь Компанийн үйл ажиллагааны дотоод дүрэм, Компанийн хөдөлмөрийн дотоод журам, Компанийн хариуцлагатай жижүүрийн мөрдөх журам, Компанийн “Мах маркет” төв үйлдвэрийн ажиллагсад үр дүнгийн шагнал олгох тухай журам, Нууцын журам, Эрсдэлийн сан байгуулах, зарцуулах, тайлагнах журам мөн “Жаст групп” ХХК-ийн Ерөнхий захиралаас баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлого



болон Санхүүгийн үйл ажиллагааны зааврыг баталж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэвшүүлж байна.

- 4.3. Компанийн үйл ажиллагааны дотоод дүрмээр Компанийн хэтийн төлөв, эрхэм зорилго, уриа, хариуцлагын шатлал, гишүүн бүрийн баримтлах зарчим, компанийн бүтэц, зохион байгуулалт, дотоод, гадаад үйл ажиллагаанд баримтлах зарчим, удирдлагын тогтолцоо, эрх мэдэл, чиг үүрэг, хэм хэмжээ, хариуцлагыг тодорхойлжээ.
- 4.4. Компанийн хөдөлмөрийн дотоод журмаар ажил олгогч, ажилтны хоорондын хөдөлмөрийн харилцааг зохицуулна.
- 4.5. Компани нь “Жаст групп” ХХК-ийн 100 хувийн охин компани болохын хувьд “Жаст групп” ХХК-иас баталсан Санхүүгийн үйл ажиллагааны зааврыг өөрийн санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж байна.
- 4.6. Компани нь хариуцлагатай, үр ашигтай, “Жаст групп” ХХК болон Компанийн тодорхойлсон хэтийн төлөв, эрхэм зорилгод нийцсэн үйл ажиллагаа явуулахын тулд шаардлагатай журам, зааврууд болох Компанийн хариуцлагатай жижүүрийн мөрдөх журам, Компанийн “Мах маркет” тов үйлдвэрийн ажиллагсдад үр дүнгийн шагнал олгох тухай журам, Эрсдэлийн сан байгуулах, зарцуулах, тайлагнах журам Нууцын журмыг Гүйцэтгэх захиралын шийдвэрээр баталж, мөрдөж байна.

#### Тав. Компанийн байгуулсан гэрээнүүдийн тухай

- 5.1. Компани нь эрхлэх үйл ажиллагааны үндсэн чиглэл болох мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хадгалах, гадаад худалдаа үйл ажиллагааны хүрээнд мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэж экспортлох, мал худалдан авах, үйлдвэрийн техник тоног төхөөрөмжийг сайжруулах, боловсронгуй болгохтой холбоотой гэрээ хэлцлийг ихэвчлэн байгуулж байна. Мөн түүнчлэн үйлдвэрийн гол хэсэг болох хөргүүртэй агуулахыг иргэн, хуулийн этгээдэд түрээслэх гэрээг байгуулсан байна. Үүнд:
  - 5.1.1. ОХУ-ын Буриадын Бүгд Найрамдах Улсын “Бурятмяспром” компанитай адуу, үхрийн мах худалдах, худалдан авах гэрээг 2011 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр байгуулсан байна. Энэхүү гэрээгээр ястай мах 10 800 тонн, ясгүй мах 1200 тонныг 2011 оны 08 дугаар сарын 01-нээс 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд нийлүүлэхээр харилцан тохирчээ. Нийт гэрээний үнийн дүн 30 720 000 /гучин сая долоон зуун хорин мянга/-н ам.доллар бөгөөд гэрээг Гүйцэтгэх захирал байгуулсан байдаг.
  - 5.1.2. Ираны Бүгд Найрамдах Улс руу хонины мах нийлүүлэх гэрээг 2011 оны 03 дугаар сарын 10-ны өдөр “Юни трейд” компанитай байгуулжээ. Энэхүү гэрээгээр 4600 /дөрвөн мянга зургаан зуу/-н тонн хонины махыг 2012 оны 02 дугаар сарын 28-ний өдрөөс өмнө 2 удаагийн тээвэрлэлтээр нийлүүлэхээр харилцан тохирчээ. Гэрээ нь Англи улсын хууль болон олон улсын худалдааны INCOTERMS 2000 дүрмийг удирдлага болгоно.
  - 5.1.3. 2011 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр НГ/46 дугаартай “Нөөцийн мах, махан бүтээгдэхүүнийг худалдан борлуулахаар хамтран ажиллах” гэрээг “Билгүүн Эрхэт” ХХК-тай байгуулсан байна. Гэрээний хугацаа нь 2011 оны 02 сарын 01-нээс 2011



оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэл 5 сарын хугацаатай. Гэрээг Компанийг төлөөлж ахлах менежер байгуулж, улмаар Гүйцэтгэх захирал баталсан байна.

5.1.4. 2011 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр ЖА/86-6 тоот “Хөргүүртэй агуулахын түрээсийн гэрээ”-г иргэн Т.Баянжаргалтай байгуулсан байна. Гэрээгээр Улаанбаатар төв мах маркет үйлдвэрийн 105-р аммиакан хөргүүртэй 500 тоннын багтаамжтай агуулахыг мах, махан бүтээгдэхүүн хадгалах зориулалтаар 2011 оны 01 сарын 05-ны өдрөөс мөн оны 05 дугаар сарын 5-ны өдөр хүртэл нийт 4 сарын хугацаанд иргэн Т.Баянжаргалд түрээслүүлэх, Т.Баянжаргал нь нэг сарын түрээсийн төлбөрт 10 000 000 төгрөг төлөхөөр харилцан тохиролцож, гэрээг Компанийн Ерөнхий нягтлан бодогч С.Бүүвэйбаатар байгуулсан байна.

5.1.5. 2010 оны 10 дугаар сарын 06-ны өдөр МБ-04 тоот “Мал бэлтгэлийн гэрээ”-г иргэн Г.Намбарназадтай Компанийн Ерөнхий нягтлан бодогч С.Бүүвэйбаатар байгуулжээ. Гэрээгээр 3 000 толгой үхрийг гарцын жингээс 1 кг-ыг нь 2 600 төгрөгөөр тооцож Компанид нийлүүлэх, Компани нь төлбөрийг төлөхөөр харилцан тохиролцжээ. Гэрээг “Жаст групп” ХХК-ийн Ерөнхий захирал Ш.Батхүү баталсан байна.

5.1.6. 2010 оны 05 дугаар сарын 07-ны өдөр ЖА/34 дугаартай Худалдах, худалдан гэрээг Компанийн маркетинг хариуцсан дэд захирал Л.Болор “Геомандал” ХХК-тай 1 жилийн хугацаатай байгуулжээ. Гэрээг Компанийн Гүйцэтгэх захирал баталсан байна.

5.2. Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, орчин үеийн, бүтээмж өндөр, байгаль орчинд халгүй үйлдвэрлэлийг хөгжүүлэх, эрүүд ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэх үүднээс банкнаас зээл авах, мөн түүнчилэн банкны зээлдэгчээс зээл шилжүүлэн авч ашиглах гэрээ хэлцлийг байгуулсан байна. Үүнд:

5.2.1. 2010 оны 10 дугаар сарын 29-ны өдөр 1060/136 тоот Зээлийн гэрээг Компанийн гүйцэтгэх захирал нь Хадгаламжийн банкттай байгуулжээ. Гэрээгээр эргэлтийн хөрөнгө нэмэгдүүлэх зориулалтаар 1 900 000 000 /нэг тэрбум есөн зуун сая/ төгрөгийг сарын 1.8 хувь, жилийн 21.6 хувийн хүүтэйгээр 12 сарын хугацаатайгаар зээлэхээр харилцан тохиролцжээ.

5.2.2. 2010 оны 01 дүгээр сарын 01-нээс мөн оны 10 дугаар сарын 19-ны өдөр хүртэлх хугацаанд нийтдээ 19-н удаа Зээл шилжүүлэн ашиглах гэрээг “Батсав” ХХК, Зөөлөн хараат” ХХК, “Торгууд нутаг” ХХК, “Төгс дээвэр” ХХК, “Анхтамир” ХХК, “Эс Жи групп” ХХК, “Хөх тэнгэрийн зам” ХХК, “Жаст групп” ХХК, “Цэнхэр хязгаар” ХХК, “Шидявшил” ХХК, иргэн Г.Дүүрэнжаргал, Л.Хаш-Эрдэнэ нартай тус тус байгуулжээ. Гэрээнүүд нь 650 000 ам.доллараас 3 000 000 ам.доллар хүртэлх үнийн дүнтэй. Гэрээг Компанийн Гүйцэтгэх захирал байгуулсан байдаг.

5.2.3. Зээлийн болон Зээл шилжүүлэн ашиглах гэрээнүүдээс 12 гэрээний зээл бүрэн төлөгдөж, дуусгавар болсон үлдэх гэрээнүүдийн үүргийн гүйцэтгэл зохих ёсоор явагдаж, зээлийн эргэн төлөлт хэвийн үргэлжилж байгаа болохыг Компани болон банкны зээлийн дансны дэлгэрэнгүй хуулбараар баталж байна.

5.3. Монгол Улсын Засгийн Газраас жил бүр хэрэгжүүлж байдаг нийслэл, томоохон хотуудын хүн амын хэрэгцээнд мах бэлтгэн, нөөц бүрдүүлэх, борлуулах үйл



ажиллагаанд идэвхтэй оролцож, жил бүр Улаанбаатар хотын иргэдэд мах нийлүүлэх тухай Мах хадгалах, борлуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, урамшуулал олгох гэрээг Нийслэлийн Засаг даргын Тамгын Газартай байгуулж иржээ.

- 5.4. Компани болон түүний салбарууд нь үйлдвэрийн тоног төхөөрөмж, барилга байгууламжаа ашиглах тухай Өмч шилжүүлэн ашиглах гэрээг “Жаст групп” ХХК-тай 2010 оны 03 дугаар сарын 31-ний өдөр Гүйцэтгэх захирал байгуулсан байдаг. Улмаар “Жаст групп” ХХК-ийн 2011 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А-01/26 тоот тушаалаар Өмч шилжүүлэн ашиглах гэрээгээр ашиглаж байсан үйлдвэрлэлийн барилга байгууламжийг шилжүүлэн, үндсэн хөрөнгөндөө бүртгэсэн байна.

**Зургаа. Компанийн үйл ажиллагаа явуулах эрх зүйн байдал**

- 6.1. Компанийн эрхлэх үйл ажиллагаа болох мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хадгалах бөгөөд туслах үйл ажиллагаанууд нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай Монгол Улсын хуулинд заасан тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх аж ахуйн үйл ажиллагаанд хамаарахгүй болно. Харин үндсэн үйл ажиллагаагаа явуулахад зайлшгүй шаардлагатай зарим төрлийн химийн хортой болон аюултай бодисыг ашиглахтай холбогдуулан химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, ашиглах, худалдах аж ахуйн үйл ажиллагааны 2010/D-096 дугаар бүхий тусгай зөвшөөрлийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 2010 оны 12 дугаар сарын 03-ны өдөр 1 /нэг/ жилийн хугацаатайгаар авсан байна.
- 6.2. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон нийслэлийн Баянгол дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 72 тоот тогтоолыг үндэслэн тус дүүргийн Засаг даргын Тамгын газрын Үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсээс Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх 97 дугаартай гэрчилгээг олгожээ. Гэрчилгээ нь 2010 оны 11 дүгээр сарын 24-ний өдрөөс 2011 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр хүртэл 1 /нэг/ жилийн хугацаанд хүчинтэй байна.
- 6.3. Компани нь үйлдвэрийн аюулгүй байдлыг хангаж Галын аюулгүй байдлын тухай Монгол Улсын хууль болон Онцгой байдлын Ерөнхий Газрын даргын 2010 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 59 тоот тушаалаар батлагдсан журмын дагуу Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлтийг гаргуулжээ. Энэхүү дүгнэлт нь 2010 оны 12 дугаар сарын 03-ны өдрөөс 2011 оны 12 дугаар сарын 03-ны өдөр хүртэл 1 /нэг/ жилийн хугацаанд хүчинтэй байна.
- 6.4. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9-д заасныг үндэслэн Улсын Мэргэжлийн Хяналтын Газраас 2011 оны 03 дугаар сарын 24-нд төв үйлдвэрт тус тус ААА зэрэглэлийн Итгэмжлэл, компанийн бүх салбаруудад АА зэрэглэлийн Итгэмжлэл олгосон байна. Энэхүү итгэмжлэл нь экспортлох эрх бүхий үйлдвэр, аж ахуйн нэгжид мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн үзлэг, хянан магадлагаа хийсний үр дүнд олгодог эрх зүйн баримт юм.
- 6.5. Компанийн салбарын үйл ажиллагаа нь Компанийн дотоод дүрэмд заасан журмын дагуу зохицуулагддаг.



**Долоо. Бондыг бүртгүүлэх өргөдөл болон танилцуулгын тухай**

- 7.1. Компанийн хувь нийлүүлэгчээс 30 000 000 000 /гучин тэрбум/ төгрөгийн үнэ бүхий, нэг бүр нь 10 000 /арван мянга/-н төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 3 000 000 /гурван сая/ ширхэг, “Мах бонд”-ыг жилийн хүү нь 16.2 хувь байх, 90 хоног тутам хүү төлөх нөхцөлтэй гаргахаар “Жаст групп” ХХК-ийн Ерөнхий захирлын 2011 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А-01/19 дугаар тушаалаар шийдвэрлэсэн байна.
- 7.2. Компани нь гаргаж буй бондоо Санхүүгийн Зохицуулах Хороонд бүртгүүлэхээр “Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, анхдагч зах зээлд санал болгох, худалдах тухай” журмын 2 дугаар зүйлийн 2.8-д дурьдсан баримт бичгийн бүрдүүлбэрийг хангасан хүсэлтийг боловсруулсан байна.
- 7.3. Бонд бүртгүүлэх тухай хүсэлт болон түүнд хавсаргасан баримт бичгүүд нь “Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, анхдагч зах зээлд санал болгох, худалдах тухай” журмын 2 дугаар зүйлийн 2.10 болон бусад зүйлд заасан шаардлагыг хангажээ.

**Долоо. Дүгнэлт**

- 8.1. Компани нь “Жаст групп” ХХК-ийн 100 хувийн охин компани болохын хувьд “Монголын бахархал, төгс компани” байх хэгийн төлөвт тэмүүлж, компанийн эрх зүйн үндэс болсон Компанийн дүрэм, Компанийн үйл ажиллагааны дотоод дүрэм, Нягтлан бодох бүртгэлийн бодлого, Санхүүгийн үйл ажиллагааны заавар зэргийг Монгол Улсын хүчин төгөлдөр хууль тогтоомж хийгээд Монголын Компанийн Засаглалын Кодекс-т нийцүүлэн боловсруулж, даган мөрдөж байна. Хэдийгээр Монголын Компанийн Засаглалын Кодекс хувьцаа нь нийтэд чөлөөтэй арилжаалагддаг, нээлттэй буюу хувьцааг компанид тухайлан зориулагдаж боловсруулагдсан хэдий боловч “Жаст групп” ХХК болон “Жаст Агро” ХХК нь өөрийн онцлогт тохируулан хэрэглэж байна.
- 8.2. Компанийн Гүйцэтгэх захирал нь Компанийн дүрмийн 2 дугаар зүйлийн 2.6-д “Хууль тогтоомж, компанийн дүрэм болон “Жаст групп” ХХК-ийн дүрэм, дотоод дүрэмд нийцүүлэн компанийн хэмжээнд дагаж мөрдөх тушаал, журам, заавар гаргах” бүрэн эрхтэй.
- 8.3. Компанийн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж буй дүрэм журмууд нь Компанийн эрхэм зорилгыг хангах, ажилтан, албан хаагч нарын хариуцлагаа ухамсарлах нөхцлийг хангасан, аливаа шударга бус, хууль бус үйл ажиллагааг явуулахгүй байхыг тогтоосон, Монгол Улсын хүчин төгөлдөр хууль тогтоомжид нийцсэн, харилцагчаа хүндэтгэж, түүний өмнө хүлээх хариуцлагаа чухалчилсан байна.
- 8.4. Компани нь гуравдагч этгээдтэй байгуулсан хэлцлийг Компанийн тухай Монгол Улсын хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4-д “Нэг өмчлөгчтэй компанид энэ бүлгийн заалтууд үл хамаарна”, 86 дугаар зүйлийн 86.3-д “Энэ бүлгийн заалтууд дараахь тохиолдолд үл хамаарна” гээд мөн зүйлийн 86.3.1-д “компанийн бүх элчийн хувьцааг нэг этгээд эзэмшиж байгаа компанид” гэж заасны дагуу ихэ хэмжээний болон сонирхолтой зөрчилтэй хэлцэл мөн эсэхийг тодорхойлохгүй болно. Өөрөөр хэлбэл Компанийн тухай хуулийн 84, 86 дугаар зүйлүүдэд заасан их хэмжээний



хэлцэл болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн эрх зүйн зохицуулалт нь Компанид хамаарахгүй юм.

Тус компанийн мах, махан бүтээгдэхүүний байнгын хэрэглэгчид нь өндөр зэрэглэлийн зочид буудал, ресторан зоогийн газар, гадаад дотоодын томоохон компаниуд, улсын нэгдсэн эмнэлэг, сувиллын газрууд бөгөөд ангилж савласан дайвар болон үндсэн мах, махан бүтээгдэхүүнээ сүлжээ дэлгүүрүүд, мөн өөрийн нэрийн барааны дэлгүүрээр худалдан борлуулахын хамт гадаад зах зээлд өөрийн бүтээгдэхүүний үнэлэмжийг бий болгосноор ОХУ, БНХАУ, Иран зэрэг оронд мах экспортолж, гадаад зах зээл нь нэмэгдэж байгаагийн дотор Ойрхи дорнод, Азийн орнуудад хонины мах авах сонирхол өсөх хандлагатай байна. Түүнчлэн “Жаст Агро” ХХК нь ОХУ-ын “Бурят Мясо” компанийн хувьцааны 50 хувийг эзэмшиж байгаа зэрэг нь гадаад зах зээлд таатай нөлөө болж байна.

Үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний ариун цэвэр, чанарын баталгааг олон улсын стандартад нийцүүлэхийн тулд компани нь 2010 онд “Эгзэгтэй цэгийн аюултай байдлыг шинжлэн хянах” (НАССР) системийг нэвтрүүлэн ажиллаж байна.



### **1.3 Үнэлгээний зорилго, хэрэглэсэн арга зүй, объектын давуу болон сул талууд**

1.3.1. Үнэлгээний гэрээт ажлын зорилго нь “Жаст Агро” ХХК-ий мах боловсруулах үйлдвэрүүдийн хөрөнгийн болон бизнесийн үнэлгээг хөрөнгийн зах зээлд өрийн бичиг (бонд) гаргах зориулалтаар тодорхойлоход оршино.

1.3.2 Хөрөнгийг 2009 оны 1-р сарын 1-ний байдлаар бид урьд нь үнэлсэн тул нэмэгдсэн болон хасагдсан хөрөнгө, шинээр хийсэн хөрөнгө оруулалт, худалдан авалттай холбогдох бичиг баримтуудыг судлан шинээр худалдан авч үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрүүдийн хөрөнгийн ашиглалтын байдалтай биечлэн танилцаж, хэмжилт, тооллого хийж, хөрөнгийн жагсаалтыг шинэчлэн гаргасан болно.

1.3.3 Хөрөнгийн болон бизнесийн үнэлгээг аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ, газар эзэмшүүлэх гэрчилгээ, гэрээ, санхүүгийн тайлан, хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл, бизнес төлөвлөгөө, худалдан авалт болон хөрөнгө оруулалтын гэрээ, төсөвт зардлын тооцоо, “Жаст групп” ХХК-ий болон мах боловсруулах үйлдвэрүүдийн танилцуулга зэрэг материалыг үндэслэн 2011 оны 3-р сарын 1-ний байдлаар тодорхойллоо.

1.3.4 Үнэлгээний ажлын гэрээг захиалагчийг төлөөлж “Жаст групп” ХХК-ийн Санхүүгийн газрын захирал Ш.Батсайхан, гүйцэтгэгчийг төлөөлж “Бүртгэл-Эрдэм” нийгэмлэгийн тэргүүн Л.Мөнх-Очир нар баталж, харилцан хүлээх үүрэг хариуцлага, ажлын хамрах хүрээ, хугацаа, төлбөр тооцоог гэрээгээр урьдчилан тохиролцож ажилласан болно.

1.3.5 Үнэлгээний гэрээт ажлын зорилгоос хамааралтайгаар үнэлгээнд зардлын хандлага (санхүүгийн тайлагийн зориулалтаарх элэгдэл тооцсон орлуулалтын өртөг)-ын болон зах зээлийн жишиг үнийн хандлагыг ашиглан шинэчилсэн үнэлгээг тодорхойлов.

1.3.6 Компани нь төв ба орон нутагт байршилтай мах боловсруулах үйлдвэрийн нэгдсэн сүлжээг бүрдүүлж зах зээлд тэргүүлэх байр суурийг эзлэх болсон, сүүлийн үед гадаад зах зээл нь өсөж түүнтэй уялдуулан бүтээгдэхүүний ариун цэвэр, чанарын баталгааг олон улсын стандартад нийцүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлж байгаа, үйлдвэрүүдийг өндөр хөгжилтэй орнуудын сүүлийн үеийн тоног төхөөрөмжөөр иж бүрэн тоноглож техникийн хүчин чадлыг нэмэгдүүлсэн зэргийг үйл ажиллагааны давуу тал гэж үзэж байна.

1.3.6 Үйл ажиллагаа нь улирлын шинж чанартай, үйлдвэрийн болон мах хадгалах хүчин чадлыг бүрэн ашиглаж чадахгүй байгаа, санхүүгийн хувьд авч үзвэл бизнесийн үр дүн нь төдийлөн тогтвортой бус зэргийг үйл ажиллагааны сул тал гэж үзэх үндэстэй.

### **Хоёр. Хөрөнгийн үнэлгээ, дүгнэлт**

#### **2.1 Хөрөнгийн үнэлгээнд баримталсан нийтлэг арга зүй.**

**Барилга байгууламжийн үнэлгээ.** Барилга байгууламжийн үнэлгээнд зардлын хандлага, зах зээлийн жишиг үнийн хандлагуудыг ашигласан.

3



**Зардлын хандлагаар.** Зардлын хандлага нь тухайн барилга объектийн нөхөн сэргээх өртгөөс ашиглагдсан хугацааны биет болон хоцрогдол, гадаад орчноос хамаарсан элэгдлүүдийг хасаж тодорхойлсон үлдэгдэл өртгийг барилгын ашиглалт, чанар байдал, түүнд хийсэн засвар, сайжруулалтыг харгалзан зохих коэффициентээр зохицуулалт хийж өнөөгийн үнэлгээг тооцоолдог.

Нөхөн сэргээх өртгийн тооцоонд Дэд бүтцийн сайдын 1999 оны 343-р тушаал, Засгийн газрын 2010 оны 336-р тогтоол, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2011 оны 29-р тушаалаар батлагдсан барилгын нэгж талбайн төсөвт өртөг, төсвийн жишиг үнэлгээг ашигласан бөгөөд барилгын хэмжилтээр тодорхойлсон хүчин чадал (талбай)-ыг нэгж хүчин чадлын жишиг үнэлгээгээр үржүүлж нөхөн сэргээх өртгийг тодорхойллоо. Барилгын зарим хэсгийн үнэлгээг журамд заасны дагуу өндрөөс хамаарсан итгэлцүүрээр өсгөж тооцсон (журмаар барилгын өндөр 4 метрээс дээш бол өндрийн 1 метр тутамд үнэлгээг 0.5 хувиар өсгөхөөр заасан). Барилгын биет элэгдлийн тооцоололд Засгийн газрын 2005 оны 233-р тогтоолын заалтыг (жилд 1.66 хувь) үндэс болгосон.

Барилгуудын хүчин чадал буюу талбайг нэгж хүчин чадлын үнэлгээгээр үржүүлж нөхөн сэргээх өртгийг тодорхойлон түүнээс хуримтлагдсан элэгдлийг хасаж тодорхойлсон үлдэгдэл өртгийг барилгын ашиглалт, чанар байдлаас хамааруулан тодорхой хувиар засварлан зардлын хандлагаарх үнэлгээг тодорхойллоо.

Байгууламжийн үнэлгээнд томсгосон төсвийн болон төсвийн үнэлгээний арга ашигласан. Томсгосон төсвийн үнэлгээний арга нь хэмжилтээр тодорхойлсон байгууламжуудын тоо хэмжээ (хүчин чадал)-г нэгжийн тогтоосон үнэлгээгээр үржүүлэн, түүнээс ашиглагдсан хугацааны хуримтлагдсан элэгдлийг хасах замаар үлдэгдэл өртгийг тодорхойлж, байгууламжуудын чанар, ашиглалтын байдлыг харгалзан коэффициентээр зохицуулалт хийж өнөөгийн үнэлгээг тодорхойлдог.

Дулааны болон цэвэр бохир ус, хэрэглээний халуун усны шугамын үнэлгээг томсгосон төсвийн үнэлгээний аргаар Засгийн газрын 2010 оны 36-р тогтоолоор батлагдсан “Дэд бүтцийн байгууламж, инженерийн шугам сүлжээний нэгж хүчин чадлын төсвийн жишиг үнэлгээ”-г ашиглан тодорхойллоо. Уг тогтоолоор баталсан жишиг үнэлгээнд цахилгаан дамжуулах шугамын үнэлгээ ороогүй (холбогдох байгууллагаас 2011 оны эхний улиралд багтаан гаргахаар заасан) тул газраар татсан кабелийн үнэлгээг өнөөгийн үнийн мэдээлэлд тулгуурлан тодорхойллоо.

Томсгосон төсвийн үнэлгээ ашиглах боломжгүй байгууламжуудын хувьд гүйцэтгэсэн ажил, зарцуулсан материалын тооцоог хэмжилтээр гаргаж, төсвийн үнэлгээний арга ашиглан өнөөгийн үнэлгээг тодорхойллоо. Төсвийн үнэлгээ нь материалын зардлаас тээврийн зардлыг 12.0, цалингийн зардлыг 30.0 хувиар, цалингийн зардлаас нэмэгдэл зардлыг 58.0, төлөвлөгөөт ашгийг 95.0, бусад зардлыг 56.2 хувиар тус бүр тооцож, нийт зардлын дүнг тодорхойлон түүнээс байгууламжуудын ашиглагдсан хугацааны хуримтлагдсан элэгдлийг хасаж үлдэгдэл өртгийг тооцоолдог. Байгууламжуудын хийц тус бүрээр материалын орцыг нэр төрлөөр нь хэмжин тодорхойлж, түүнийг өнөөгийн зах зээлийн үнээр үржүүлж материалын зардлыг тооцсон.

Барилга, байгууламжуудын зардлын хандлагаарх үнэлгээнд сүүлийн 2 жил хийгдсэн томоохон хэмжээний хөрөнгө оруулалтын зардлуудыг нэмж тооцлоо.

4



**Зах зээлийн жишиг үнийн хандлагаар.** Зах зээлийн жишиг үнийн хандлага нь тухайн үнэлж байгаа объектод ижил буюу ойролцоо барилга байгууламжийн зах зээлд худалдаалагдсан нэгж (1м<sup>2</sup> г.м)-ийн үнийг сонгон авч, жишиж байгаа объектын ялгаатай талуудад үндэслэн үнэд тохируулга хийх замаар үнэлдэг.

Барилга объектийн хийц, бүтээц, чанар байдал, ашиглалтын зориулалт, худалдаалагдах боломж, байршил зэргийг харгалзан эдгээр барилгатай ижил буюу ойролцоо барилгын өнөөгийн зах зээл дахь нэг квадрат метр талбайн жишиг үнэлгээгээр үнэлж байгаа барилгын хүчин чадал (талбай)-г үржүүлэх замаар барилгуудын зах зээлийн жишиг үнийг тодорхойлсон.

Барилгын үнэлгээнд ашигласан хандиагуудын ач холбогдлыг харгалзан зардлын хандлагаарх үнэлгээнд 60.0 хувийн, зах зээлийн жишиг үнийн хандлагаарх үнэлгээнд 40.0 хувийн холбогдол өгөх замаар шинэчилсэн үнэлгээг тогтоосон.

**Үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжийн үнэлгээ.** Тоног төхөөрөмжийн ашиглалтын байдал, шинэчлэл, шинээр худалдан авах үнийн өсөлтийг харгалзан дансны үнийг тоног төхөөрөмжийн төрөл тус бүр дээр дунджаар 6-15 хувиар нэмэгдүүлэн үнэлсэн. Энэ 2010 оны жилийн эцсийн үнэ тул эзэгдэл тооцоогүй. Үнийн өсөлтийг одоо ашиглагдаж байгаа үндсэн тоног төхөөрөмжийг тухайн улс орноос нь худалдан авах үнийн мэдээлэлд үндэслэсэн болно.

**Тээврийн хэрэгслийн үнэлгээ.** Автомашин, тээврийн хэрэгсэл тус бүрийн үйлдвэрлэгдсэн болон манай улсад оруулж ирсэн он, худалдан авсан үнэ, өнөөгийн чанар байдлыг харгалзан зах зээлийн одоогийн жишиг үнээр баримжаалан үнэлсэн.

**Компьютер, тавилга, эд хогшлын үнэлгээ.** Тус компанийн эзэмшилд байгаа компьютер, тавилга эд хогшил нь нэлээд хуучирсан, зарим нь ашиглалтын хугацаа дууссан, нөгөө талаар компьютер, компьютерийн техник хэрэгсэл, тавилга, эд хогшлын зах зээлийн үнэ тогтвортой, зарим талаар буурах хандлагатай байгааг харгалзан үнэлгээг 2010 оны жилийн эцсийн бүртгэлийн үнээр авсан болно.

**Газар эзэмших эрхийн үнэлгээ.** Барилга, хот байгуулалтын сайдын 2007 оны 136-р тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааны анхны үнэ тодорхойлох аргачлал"-ын дагуу үйлдвэрлэлийн зориулалтаар эзэмшүүлсэн газрын эзэмших эрхийн дуудлага худалдааны доод үнийг тодорхойллоо. Газар эзэмших эрхийн үнэлгээнд эрх бүхий байгууллагаас олгосон гэрчилгээ, түүнд бичигдсэн газрын хэмжээ, байршил, зориулалтыг үндэс болгосон ба үйлдвэрлэлийн зориулалтаар эзэмших нэг квадрат метр газрын эрхийн дуудлага худалдааны суурь үнэ Улаанбаатар хотод 8800, Багануурт 4400, аймгийн төвд 800-1000, сум суурин газарт 600 төгрөгөөр бодож дуудлага худалдааны доод үнийг тодорхойлсон.

Газар эзэмших эрхийн үнэлгээнд дээрх аргаас гадна зах зээлийн жишиг үнийг баримжаа болгон эзэмших эрхийн 1 кв.метрийн үнэлгээг Улаанбаатар хотод 25.0, Багануурт 20.0, орон нутагт 8.0-12.0 мянган төгрөгөөр бодож газар эзэмших эрхийн дуудлага худалдааны анхны үнэ тодорхойлох аргачлаар тодорхойлсон үнэлгээнд 40.0 хувийн, зах зээлийн жишиг үнээр тодорхойлсон үнэлгээнд 60.0 хувийн холбогдол өгөх замаар үнэлгээг тогтоосон.





## 2.2 Үйлдвэрүүдийн хөрөнгийн тодорхойлолт болон үнэлгээ

### 2.2.1 “Улаанбаатар төв Мах Маркет” МБҮ

#### 2.2.1a Үйл ажиллагаа болон хөрөнгийн тодорхойлолт

Тус үйлдвэр нь Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны нутаг, Сонсголонд 3,2 га эдлэлбэр газар эзэмшдэг, төвийн цэвэр бохир ус, халаалтын шугамд холбогдсон цэвэрлэх байгууламж бүхий хөргүүртэй агуулахын болон конторын цогцолбор 2 давхар барилгатай. Агуулахын болон гараж, модны үйлдвэрийн барилга нь хийцийн хувьд угсармал төмөр бетон аяган болон шугаман хосолмол суурьтай, угсармал төмөр бетон каркас, төмөр бетон хавтан ханатай, бетон шалтай, анхнаасаа хөргүүртэй агуулахын зориулалтаар баригдсан. Конторын барилга нь угсармал төмөр бетон шугаман суурьтай, төмөр бетон каркас, тоосгон ханатай, 59x12-ын давхар дундын болон дээврийн хучилттай, барилгын баруун жигүүрт үйлдвэрийн контор, лаборатори, ажилчдын цайны газар, зүүн жигүүрт мал нядалгаа, эхлэн боловсруулах үйлдвэр, сэврээх камер байрлана.

2009-2010 онд лаборатори, нядалгааны болон эхлэн боловсруулах цехийн шугамын дагуу барилгын дотоод байдлыг олон улсын стандартад нийцүүлэн өөрчлөн, засаж тохижуулж, ариун цэвэр халдваргүйжүүлэлтийн тоног төхөөрөмжөөр тоногложсон. Хөргүүртэй агуулахын 3-р давхрын шалыг шинээр бетондож, хана, таазыг тусгай хөөсөөр дулаалж, дулаан тусгаарлалтыг нэмэгдүүлж, хөргөлтийн тоног төхөөрөмжөөр тоноглон агуулахын зориулалтаар ашиглаж эхлээд байна. Мөн гаражийн барилгад их засвар хийж, сайжруулан ашиглаж байна. Үүнд: барилга байгууламжид 449,6 сая төгрөг, тоног төхөөрөмж шинээр худалдан авч суурилуулахад 818,4 сая төгрөг, бусад зардалд 208,2 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

Үйлдвэрийн хүчин чадал нь нэг ээлж (хоногт)-индээ 200 бод, 1000 бог мал нядлах нядалгааны шугам, 100-120 тн мах сэврээх болон хөлдөөх, бас дайвар бүтээгдэхүүний сэврээх болон хөлдөөх камер зэрэг нийтдээ 6000 тн мах хадгалах агуулахтай.

#### 2.2.1б Хөрөнгийн үнэлгээ

“Улаанбаатар төв Мах Маркет” МБҮ-ийн хөрөнгийн үнэлгээг хөрөнгийн ангилал тус бүр дээр дэлгэрэнгүй нэр төрлөөр тайлангийн 2.1-д заасан аргачлалын дагуу үнэлж барилгын үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.1.1-ээр, байгууламжийн томсгосон төсвийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.1.2а-аар, төсвийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.1.2б-ээр, тоног төхөөрөмжийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.1.3-аар, тээврийн хэрэгслийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.3.1-ээр, тавилга эд хогшлын үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.1.4-өөр, компьютерийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.1.5-аар, газар эзэмших эрхийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.3.2-оор тус тус хийж хавсаргалаа.

Тус үйлдвэрийн хөрөнгийн үнэлгээ **13,416,122.4 мянган тогрог** болсныг хөрөнгийн ангиллын дагуу дараах хүснэгтээр товчоолой харуулав.



6



## Хөрөнгийн шинэчилсэн үнэлгээний товчоо

(мян.төг)

№	Хөрөнгийн ангилал	2010.12.31-ний үлдэгдэл өртөг	Шинэчилсэн үнэлгээ	Тооцооллыг харуулсан хүснэгтийн дугаар
1	Барилга	7,332,829.5	8,430,150.0	2.2.1.1
2	Байгууламж	261,502.0	957,712.0	2.2.1.2а, 2.2.1.2б
3	Тоног төхөөрөмж	2,277,843.3	2,551,805.9	2.2.1.3
4	Тээврийн хэрэгсэл	642,081.7	724,700.0	2.3.1
5	Эд хогшил	43,767.9	43,767.9	2.2.1.4
6	Компютор	17,193.3	17,193.3	2.2.1.5
7	Газар	615,000.0	690,793.3	2.3.2
<b>Дүн</b>		<b>11,190,217.7</b>	<b>13,416,122.4</b>	-

### 2.2.2 “Баян-Өлгий Мах Маркет” ХХК

#### 2.2.2 а Үйл ажиллагаа болон хөрөнгийн тодорхойлолт

Тус үйлдвэр нь 1992 онд баригдаж ашиглалтад орсон, 2006 онд “Жаст групп” ХХК худалдан авч үйл ажиллагаа явуулж байна. Үйлдвэр анхнаасаа зориулалтын дагуу, ЗХУ-ын (хуучин нэрээр) техник технологийн тусламжаар баригдсан. Үйлдвэр, хөргүүртэй агуулахын барилга нь цутгамал төмөр бетон аяган болон шугаман хосолмол суурьтай, угсармал төмөр бетон каркас, бетон хавтан ханатай, төмөр фермэн дам нуруу, ПКЖ хавтан хучилттай, контор нь угсармал төмөр бетон шугаман суурь, 64-ийн тоосгон гадна, 25, 38-ын дотор ханатай, 59х12-ын хавтан давхар дундын болон дээврийн хучилттай, 2 давхар барилга.

Нийт 2,1 га талбайг эзэлсэн, гадуураа төмөр бетон хавтан хашаатай, контор, үйлдвэр, хөргүүртэй агуулахын иж бүрэн барилга байгууламж нь төвийн цэвэр бохир усны шугамд холбогдсон, дулааны зардал өндрийн улмаас ашиглалтгүй, нам даралтын зуухаар халааж байна.

“Баян-Өлгий Мах Маркет” Мах боловсруулах үйлдвэр хоногт 120 бод, 800 бог нядлах, 20 тн-ын гүн хөлдөөх камер, 1000 тн-ын агуулахын хүчин чадалтай. Мөн яс боловсруулах, хяам үйлдвэрлэх цехтэй боловч өнөөдрийн байдлаар ашиглагдаагүй.

#### 2.2.2 б Хөрөнгийн үнэлгээ

“Баян-Өлгий Мах Маркет” МБҮ-ийн хөрөнгийн үнэлгээг хөрөнгийн ангилал тус бүр дээр дэлгэрэнгүй нэр төрлөөр тайлангийн 2.1-д заасан аргачлалын дагуу үнэлж барилгын үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.2.1-ээр, байгууламжийн томсгосон төсвийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.2.2а-аар, төсвийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.2.2б-ээр, тоног төхөөрөмжийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.2.3-аар, тээврийн хэрэгслийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.3.1-ээр, тавилга эд хогшлын үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.2.4-өөр, компьютерийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.2.5-аар, газар эзэмших эрхийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.3.2-оор тус тус хийж хавсаргасан.

  
7



Тус үйлдвэрийн хөрөнгийн үнэлгээ 4,833,174.8 мянган төгрөг болсныг хөрөнгийн ангиллын дагуу дараах хүснэгтээр товчоолон харуулав.

**Хөрөнгийн шинэчилсэн үнэлгээний товчоо**

				(мян.төг)
№	Хөрөнгийн ангилал	2010.12.31-ний үлдэгдэл өртөг	Шинэчилсэн үнэлгээ	Тооцооллыг харуулсан хүснэгтийн дугаар
1	Барилга	2,177,457.00	3,357,800.00	2.2.2.1
2	Байгууламж	184,189.00	299,287.60	2.2.2.2а, 2.2.2.2б
3	Тоног төхөөрөмж	744,085.3	834,164.6	2.2.2.3
4	Тээврийн хэрэгсэл	12,640.0	12,760.0	2.3.1
5	Эд хогшил	290.5	290.5	2.2.2.4
6	Компютор	168.0	168.0	2.2.2.5
7	Газар	64,200.0	328,704.0	2.3.2
<b>Дүн</b>		<b>3,183,029.80</b>	<b>4,833,174.8</b>	-

**2.2.3 “Завхан Мах Маркет” ХХК**

**2.2.3а Үйл ажиллагаа болон хөрөнгийн тодорхойлолт**

Тус үйлдвэр 1994 онд баригдсан 300 тн-ын аммиакан хөргүүртэй агуулахыг түшиглэн 2002 онд “Тэсийн гол” ХХК барилга байгууламж нэмж барин нядалгааны цех болгон ашиглаж байсныг “Жаст групп” ХХК 2007 онд худалдан авч өнөөг хүртэл үйл ажиллагаа явуулж байна. Суурилагдсан тоног төхөөрөмжүүд бүгд ОХУ-д үйлдвэрлэгдсэн бөгөөд худалдан авсаны дараа бүх компрессор, цахилгаан автоматикийн хэсэг, нядалгааны шугам, барилгад урсгал болон их засвар хийж, худгийн болон халаалтын насосуудыг сольж, 120 кВт-ын дизель станц суурилуулан ашиглаж байна.


Тус үйлдвэр нь 1.4 га эдэлбэр газарт байршсан, контор, үйлдвэр, агуулахын болон дэлгүүр гаражийн барилгуудтай. Хөргүүртэй агуулахын болон нядалгаа, эхлэн боловсруулах цехийн барилга нь цутгамал бетон суурьтай, угсармал бетон каркас, тоосгон хана, ПСЖ хавтан хучилттай. Конторын барилга нь цутгамал бетон суурь, шаварлагатай хар модон балкан хана, модон шувуу нуруу, шипр дээвэртэй.

2009-2010 онд тус үйлдвэрт нийтдээ 110,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, барилга, байгууламж, тоног төхөөрөмжийг шинэчлэн засварласан.

**2.2.3б Хөрөнгийн үнэлгээ**

“Завхан Мах Маркет” МБҮ-ийн хөрөнгийн үнэлгээг хөрөнгийн ангилал тус бүр дээр дэлгэрэнгүй нэр төрлөөр тайлангийн 2.1-д заасан аргачлалын дагуу үнэлж барилгын үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.3.1-ээр, байгууламжийн томгосон төсвийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.3.2а-аар, төсвийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.3.2б-ээр, тоног төхөөрөмжийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.3.3-аар, тээврийн хэрэгслийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.3.1-ээр, тавилга эд хогшлын үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.3.4-өөр, компьютерийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.3.5-аар, газар эзэмших эрхийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.3.2-оор тус тус хийж хавсаргасан.

8




Тус үйлдвэрийн хөрөнгийн үнэлгээ 1,322,070.2 мянган төгрөг болсныг хөрөнгийн ангиллын дагуу дараах хүснэгтээр товчоолон харуулав.

### Хөрөнгийн шинэчилсэн үнэлгээний товчоо

				(мян.төг)
№	Хөрөнгийн ангилал	2010.12.31-ний үлдэгдэл өртөг	Шинэчилсэн үнэлгээ	Тооцооллыг харуулсан хүснэгтийн дугаар
1	Барилга	425,967.0	590,250.0	2.2.3.1
2	Байгууламж	32,117.6	96,907.1	2.2.3.2а, 2.2.3.2б
3	Тоног төхөөрөмж	485,710.8	547,419.2	2.2.3.3
4	Тээврийн хэрэгсэл	15,563.4	17,100.0	2.3.1
5	Эд хогшил	-	-	-
6	Компютер	130.0	130.0	2.2.3.5
7	Газар	16,265.0	70,263.9	2.3.2
<b>Дүн</b>		<b>975,753.8</b>	<b>1,322,070.2</b>	-

#### 2.2.4 “Сүхбаатар Мах Маркет” ХХК

##### 2.2.4а Үйл ажиллагаа болон хөрөнгийн тодорхойлолт

1976-1978 онд баригдсан аймгийн худалдаа бэлтгэлийн трест (хуучин нэрээр)-ийн 300 тонны аммиакан хөргүүртэй агуулахыг 2006 онд, 500 тонны аммиакан хөргүүртэй агуулахын дуусаагүй барилгыг 2007 тус тус худалдан авч, 2006-2007 онд нядалгааны цехийн барилгыг барьж, тоног төхөөрөмж суурилуулан үйлдвэрийг байгуулсан.

Үйлдвэр нь 0.3 га эдэлбэр талбайд байршсан нядалгааны цех, машин заал, хөргөх болон сэврээх хэсэг, шинэ хуучин хөргүүртэй агуулахууд, уурын зуух зэрэг барилгуудтай, үйлдвэрлэлийн хүчин чадал нь хоногт 120 бод, 800 бог нядлах шугамтай, 20 тонн мах сэврээх камер, 700 тонн мах хадгалах агуулахтай, хуучин агуулахын тоног төхөөрөмж нь ОХУ-д, шинэ агуулахын болон нядалгааны тоног төхөөрөмжүүд нь БНХАУ-д үйлдвэрлэгдсэн байна.

2009-2010 онд тус үйлдвэрт нийтдээ 374,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийжээ.

##### 2.2.4б Хөрөнгийн үнэлгээ

“Сүхбаатар Мах Маркет” МБҮ-ийн хөрөнгийн үнэлгээг хөрөнгийн ангилал тус бүр дээр дэлгэрэнгүй нэр төрлөөр тайлангийн 2.1-д заасан аргачлалын дагуу үнэлж барилгын үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.4.1-ээр, байгууламжийн төмсгосон төсвийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.4.2а-аар, төсвийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.4.2б-ээр, тоног төхөөрөмжийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.4.3-аар, тээврийн хэрэгслийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.3.1-ээр, тавилга эд хогшлын үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.4.4-өөр, компьютерийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.4.5-аар, газар эзэмших эрхийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.3.2-оор тус тус хийж хавсаргасан.



Тус үйлдвэрийн хөрөнгийн үнэлгээ **1,201,164.8** мянган төгрөг болсныг хөрөнгийн ангиллын дагуу дараах хүснэгтээр товчоолон харуулав.

### Хөрөнгийн шинэчилсэн үнэлгээний товчоо

№	Хөрөнгийн ангилал	2010.12.31-ний үлдэгдэл өртөг	Шинэчилсэн үнэлгээ	(мян.төг)
				Тооцооллыг харуулсан хүснэгтийн дугаар
1	Барилга	483,301.0	516,300.0	2.2.3.1
2	Байгууламж	29,787.2	42,116.1	2.2.4.2а, 2.2.4.2б
3	Тоног төхөөрөмж	532,169.6	598,787.9	2.2.4.3
4	Тээврийн хэрэгсэл	15,877.6	18,340.0	2.3.1
5	Эд хогшил	345.7	345.7	2.2.4.4
6	Компьютер	184.3	88.7	2.2.4.5
7	Газар	3,990.0	25,186.5	2.3.2
<b>Дүн</b>		<b>1,065,559.8</b>	<b>1,201,164.8</b>	-

## 2.2.5 “Булган Мах Маркет” ХХК

### 2.2.5а Үйл ажиллагаа болон хөрөнгийн тодорхойлолт

1992 онд баригдаж ашиглагдаж байсан Мах боловсруулах үйлдвэрийг “Жаст групп” ХХК 2006 онд худалдан авсан. Тус үйлдвэрийг худалдан авах үед барилга байгууламж, тоног төхөөрөмж нь нилээн тоногдсон, үйлдвэрийн болон конторын барилгын халаалт, цэвэр бохир усны шугам эвдэрсэн байсан бөгөөд 2006-2007 онд нилээд их хөрөнгө оруулалт хийн өнөөдрийг хүртэл хэвийн үйл ажиллагаа явуулж байна.


Үйлдвэр нь 1,3 га эдэлбэр газарт байршсан контор, үйлдвэрийн болон хөргүүртэй агуулах, уурын зуух, худаг, модон хашаа зэрэг барилга байгууламжтай. Үйлдвэрийн болон хөргүүртэй агуулахын барилга нь угсармал төмөр бетон аяган болон шугаман хосолмол суурьтай, төмөр бетон каркас, тоосгон ханатай, бетон дам нуруу, ПКЖ хавтан хучилттай, бетон шалтай. Конторын барилга нь угсармал төмөр бетон шугаман суурьтай, 64-ийн тоосгон хана, 59x12-ын хавтан хучилттай, модон шалтай.

Үйлдвэр нэг ээлжиндээ 120 бод, 700 бог нядалж, 20 тонн мах гүн хөлдөөх камер, 500 тонн мах хадгалах хөргүүртэй агуулахтай. 2009-2010 онд тус үйлдвэрт 371,4 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг шинэчилсэн бөгөөд нийтдээ 377,1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийжээ.

### 2.2.5б Хөрөнгийн үнэлгээ

“Булган Мах Маркет” МБҮ-ийн хөрөнгийн үнэлгээг хөрөнгийн ангилал тус бүр дээр дэлгэрэнгүй нэр төрлөөр тайлангийн 2.1-д заасан аргачлалын дагуу үнэлж барилгын үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.5.1-ээр, байгууламжийн томсгосон төсвийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.5.2а-аар, төсвийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.5.2б-ээр, тоног төхөөрөмжийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.5.3-аар, тээврийн хэрэгсэлийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.3.1-ээр, тавилга эд хогшлын үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.5.4-өөр, компьютерийн үнэлгээг хавсралт хүснэгт

10



УЛААНБААТАР ХОТ  
 МАХ-БОО ШИГЭЭН  
 АНДРАХАГЕР  
 БИРЭГ ДЭГЭРИЙН  
 “БИ.ИИ.СБ” ХХК  
 ТТА4452 3852482



2.2.5.5-аар, газар эзэмших эрхийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.3.2-оор тус тус хийж хавсаргасан.

Тус үйлдвэрийн хөрөнгийн үнэлгээ 1,483,064.4 мянган төгрөг болсныг хөрөнгийн ангиллын дагуу дараах хүснэгтээр товчоолон харуулав.

### Хөрөнгийн шинэчилсэн үнэлгээний товчоо

(МЯН.ТӨГ)				
№	Хөрөнгийн ангилал	2010.12.31-ний үлдэгдэл өртөг	Шинэчилсэн үнэлгээ	Тооцооллыг харуулсан хүснэгтийн дугаар
1	Барилга	702,917.4	838,700.0	2.2.5.1
2	Байгууламж	52,778.2	55,507.5	2.2.5.2а, 2.2.5.2б
3	Тоног төхөөрөмж	433,163.2	489,921.2	2.2.5.3
4	Тээврийн хэрэгсэл	29,091.9	32,300.0	2.3.1
5	Эд хогшил	1,257.9	1,257.9	2.2.5.4
6	Компьютер	251.4	251.4	2.2.5.5
7	Газар	11,520.0	65,126.4	2.3.2
	<b>Дүн</b>	<b>1,230,980.0</b>	<b>1,483,064.4</b>	-

## 2.2.6 “Увс Мах Маркет” ХХК

### 2.2.6а Үйл ажиллагаа болон хөрөнгийн тодорхойлолт

2006 онд баригдсан, нэг ээлжиндээ 80 бод, 400 бог нялдах хүчин чадалтай нядалгааны 2 шугам, 50 тонн мах гүн хөлдөөх камер, 250 тонн мах хадгалах багтаамжтай хөргүүртэй агуулах бүхий “Увс мах экспо” ХХК-ий Мах боловсруулах үйлдвэрийг “Жаст групп” ХХК 2007 онд худалдан авсан байна.

“Увс Мах Маркет” Мах боловсруулах үйлдвэр нь 1.4 га эдэлбэр газарт байрлалтай контор, үйлдвэрийн болон агуулахын барилга, автомашины гараж, дэлгүүр, блокон хашаа зэрэг барилга байгууламжтай. Үйлдвэрийн барилга нь угсармал төмөр бетон аяган суурь, төмөр бетон каркас, тоосгон хана, бетон дам нуруу, ПКЖ хавтан хучилттай. Конторын хэсэг нь үйлдвэрийн барилга дотроо, барилгын зүүн урд хэсэгт оршино.

2008 онд үйлдвэрийн тоног төхөөрөмжид засвар хийж, мал эмнэлгийн ариун цэврийн лаборатори шинээр байгуулсан. Мөн барилгуудад урсгал засвар хийсэн байна. 2009-2010 онд барилга байгууламжид 44,9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийн шинээр бетон блокон хашаа барьж, 40,3 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг шинээр суурилуулан, 24,0 сая төгрөгийн эд хогшил, тээврийн хэрэгсэл худалдан авч, нийт 109,3 сая төгрөг зарцуулжээ.

### 2.2.6б Хөрөнгийн үнэлгээ

“Увс Мах Маркет” МБҮ-ийн хөрөнгийн үнэлгээг хөрөнгийн ангилал тус бүр дээр дэлгэрэнгүй нэр төрлөөр тайлагшийн 2.1-д заасан аргачлалын дагуу үнэлж барилгын үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.6.1-ээр, байгууламжийн төмсгөсөн төсвийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.6.2а-аар, төсвийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.6.2б-ээр, тоног төхөөрөмжийн үнэлгээг хавсралт

*Handwritten signature*



хүснэгт 2.2.6.3-аар, тээврийн хэрэгслийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.3.1-ээр, тавилга эд хогшлын үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.6.4-өөр, компьютерийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.6.5-аар, газар эзэмших эрхийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.3.2-оор тус тус хийж хавсаргасан.

Тус үйлдвэрийн хөрөнгийн үнэлгээ **885,821.6** мянган төгрөг болсныг хөрөнгийн ангиллын дагуу дараах хүснэгтээр товчоолон харуулав.

#### Хөрөнгийн шинэчилсэн үнэлгээний товчоо

				(мян.төг)
№	Хөрөнгийн ангилал	2010.12.31-ний үлдэгдэл өртөг	Шинэчилсэн үнэлгээ	Тооцооллыг харуулсан хүснэгтийн дугаар
1	Барилга	436,721.3	451,450.0	2.2.6.1
2	Байгууламж	58,524.5	93,418.6	2.2.6.2а, 2.2.6.2б
3	Тоног төхөөрөмж	241,975.2	270,599.2	2.2.6.3
4	Тээврийн хэрэгсэл	27,631.0	30,400.0	2.3.1
5	Эд хогшил	447.2	447.2	2.2.6.4
6	Компьютор	69.8	69.8	2.3.2
7	Газар	6,240.0	39,436.8	2.2.6.5
	<b>Дүн</b>	<b>771,609.0</b>	<b>885,821.6</b>	-

#### 2.2.7 “Дорнод Мах Маркет” ХХК

##### 2.2.7а Үйл ажиллагаа болон хөрөнгийн тодорхойлолт

Тус үйлдвэр 1970 онд Болгар улсын тусламжаар баригдсан. Ашиглалтад орсноос хойш 1990-ээд он хүртэл хэвийн ажиллаж байсан бөгөөд өдөрт 200 бод, 1600 бөг нядлах хүчин чадалтай, 60 тонн мах гүн хөлдөөх камер, 3000 тонн мах хадгалах хөргүүртэй агуулах бүхий “Жаст групп” ХХК-ий томоохон үйлдвэрийн нэг юм. Энэхүү үйлдвэрийг “Жаст групп” ХХК 2008 онд худалдан авч үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 1990 оноос хойш ашиглалтгүй, нилээд тоногдсон байсныг сэргээн, 2008 онд нийт 230,0 сая төгрөгийн, 2009-2010 онд 57,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийн, барилгын газрын давхарт сараалжин цонх хийж, үйлдвэрийн цахилгаан хангамжийг сэргээж, нам даралтын уурын зуух шинээр байгуулан, барилгуудад урсгал засвар, бусад шинэчлэл хийснээр үйлдвэр өнөөдөр хэвийн ажиллаж байна.

Үйлдвэр нийт 8,4 га эдэлбэр газарт, мал хүлээн авах байр, хөргөлтийн болон хүйтэн агуулах, контор, засвар механикийн цех, ахуйн байр, дэлгүүр, агуулахын барилгатай. Мөн угсармал төмөр бетон хашаа, салбар төмөр зам зэрэг байгууламжтай, төвийн дулаан, цэвэр ус, бохир усны шугамд холбогдсон.

Үйлдвэрийн барилга нь цуггамал төмөр бетон суурь, каркас, тоосгон хана, бетон шалтай, бетон дам нуруу, ПКЖ хавтан давхар дундын болон дээврийн хучилттай, 6 давхар барилга юм. Барилгын 1 ба 2-р давхрыг зориулалтын дагуу ашиглаж байгаа бөгөөд бусад давхруудыг ашиглахад нилээд их хөрөнгө оруулалт шаардлагатай. Конторын болон бусад барилгууд нь төмөр бетон шугаман суурь, каркас, 64-ийн тоосгон гадна хана, 59\*12-ийн хавтан давхар дундын болон дээврийн хучилттай.

12



## 2.2.7б Хөрөнгийн үнэлгээ

“Дорнод Мах Маркет” МБҮ-ийн хөрөнгийн үнэлгээг хөрөнгийн ангилал тус бүр дээр дэлгэрэнгүй нэр төрлөөр тайлангийн 2.1-д заасан аргачлалын дагуу үнэлж барилгын үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.7.1-ээр, байгууламжийн томсгосон төсвийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.7.2а-аар, төсвийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.7.2б-ээр, тоног төхөөрөмжийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.7.3-аар, тээврийн хэрэгслийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.3.1-ээр, тавилга эд хогшлын үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.7.4-өөр, компьютерийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.7.5-аар, газар эзэмших эрхийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.3.2-оор тус тус хийж хавсаргасан.

Тус үйлдвэрийн хөрөнгийн үнэлгээ **9,024,136.9** мянган төгрөг болсныг хөрөнгийн ангиллын дагуу дараах хүснэгтээр товчоолон харуулав.

### Хөрөнгийн шинэчилсэн үнэлгээний товчоо

(мян.төг)				
№	Хөрөнгийн бүлэглэсэн нэр	2010.12.31-ний үлдэгдэл өртөг	Шинэчилсэн үнэлгээ	Тооцооллыг харуулсан хүснэгтийн дугаар
1	Барилга	1,946,968.4	5,737,360.0	2.2.7.1
2	Байгууламж	795,587.8	1,502,703.1	2.2.7.2а, 2.2.7.2б
3	Тоног төхөөрөмж	998,736.8	1,134,855.4	2.2.7.3
4	Тээврийн хэрэгсэл	6,745.2	9,250.0	2.3.1
5	Эд хогшил	452.8	452.8	2.2.7.4
6	Компьютер	184.4	184.4	2.2.7.5
7	Газар	101,160.0	639,331.2	2.3.2
	<b>Дүн</b>	<b>3,849,835.4</b>	<b>9,024,136.9</b>	-

## 2.2.8 “Хөвсгөл Мах Маркет” ХХК

### 2.2.8а Үйл ажиллагаа болон хөрөнгийн тодорхойлолт

1982 онд Мөрөн хотын төвд баригдсан Модны үйлдвэрийн зориулалттай барилгыг “Жаст групп” ХХК 2008 онд худалдан авч, конторын болон үйлдвэрийн хэсгийг шинэчлэн засварлаж, хөргөлтийн агуулах, машин заалын сендвичэн барилга, уурын зуухыг шинээр барьж ашиглаж байна. “Улаанбаатар төв Мах Маркет” үйлдвэрийн хуучин ашиглаж байсан нядалгааны шугам, тоног төхөөрөмжийг суурилуулсан бөгөөд үйлдвэрийн эдэлбэр газар 0,64 га. Нэг ээлжиндээ 200 бод, 500 бог нядлах хөс шугам, 40 тонн мах гүн хөлдөөх камер, 100 тонн мах хадгалах хөргүүртэй агуулах бүхий тус үйлдвэрийн хөргөлтийн тоног төхөөрөмжүүд нь БНХАУ-д үйлдвэрлэсэн юм байна.

2009-2010 онд тус үйлдвэрийн барилга байгууламжид 78,2 сая төгрөг, 93,5 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн шинэчлэл хийн, нийтдээ 195,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийжээ.





## 2.2.8б Хөрөнгийн үнэлгээ

“Хөвсгөл Мах Маркет” МБҮ-ийн хөрөнгийн үнэлгээг хөрөнгийн ангилал тус бүр дээр дэлгэрэнгүй нэр төрлөөр тайлангийн 2.1-д заасан аргачлалын дагуу үнэлж барилгын үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.8.1-ээр, байгууламжийн томсгосон төсвийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.8.2а-аар, төсвийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.8.2б-ээр, тоног төхөөрөмжийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.8.3-аар, тээврийн хэрэгслийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.3.1-ээр, тавилга эд хогшлын үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.8.4-өөр, компьютерийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.8.5-аар, газар эзэмших эрхийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.3.2-оор тус тус хийж хавсаргасан.

Тус үйлдвэрийн хөрөнгийн үнэлгээ **2,308,544.4** мянган төгрөг болсныг хөрөнгийн ангиллын дагуу дараах хүснэгтээр товчоолон харуулав.

### Хөрөнгийн шинэчилсэн үнэлгээний товчоо

(мян.төг)				
№	Хөрөнгийн бүлэглэсэн нэр	2010.12.31-ний үлдэгдэл өртөг	Шинэчилсэн үнэлгээ	Тооцооллыг харуулсан хүснэгтийн дугаар
1	Барилга	1,030,323.5	1,110,800.0	2.2.8.1
2	Байгууламж	178,296.9	344,476.5	2.2.8.2а, 2.2.8.2б
3	Тоног төхөөрөмж	689,952.5	762,745.5	2.2.8.3
4	Тээврийн хэрэгсэл	31,076.8	41,500.0	2.3.1
5	Эд хогшил	352.6	352.6	2.2.8.4
6	Компьютер	132.2	132.2	2.2.8.5
7	Газар	7,680.0	48,537.6	2.3.2
	<b>Дүн</b>	<b>1,937,814.5</b>	<b>2,308,544.4</b>	-

## 2.2.9 “Сэлэнгэ Мах Маркет” ХХК

### 2.2.9а Үйл ажиллагаа болон хөрөнгийн тодорхойлолт

Анх хөргүүртэй агуулахын зориулалттай баригдсан барилгыг 2002 онд “Дорнын говь” ХХК авч, Мах боловсруулах үйлдвэр болгон шинэчлэн, өргөтгөл хийж ашиглаж байсныг “Жаст групп” ХХК 2009 онд худалдан авч, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлж байна. Нэг ээлжиндээ 350 бод, 1600 бог нядлах хүчин чадалтай хагас автомат хос шугам, 40 тонн мах -40 хэмд гүн хөлдөөх камер, 3000 тонн мах -20 хэмд хадгалах агуулах бүхий иж бүрэн үйлдвэр юм байна.

Үйлдвэрийн буюу нядалгааны цех, эхлэн боловсруулах цехийн барилга нь төмөр бетон суурь, бетон каркас, тоосгон ханатай, 59х12-ын хавтан хучилт, бетон шалтай, газрын давхартай. Сэврээх, гүн хөлдөөх болон хөргөлттэй агуулахын барилга нь хийцийн хувьд дээрх барилгатай адил. 3000 тонны багтаамжтай төмөр бетон суурь, төмөр каркас бүхий сендвичэн агуулахын барилга 2008 онд баригдсан. Контор, гурилын үйлдвэр, ажилчдын сууц автомашины гараж зэрэг барилга нь бетон суурьтай, 15\*15 см-ийн шавардлагатай балкан хана, модон шувуу нуруу хучилт, налуу хавтгай шипр дээвэртэй, модон шалтай.



Угсармал төмөр бетон болон тоосгон хашаа, гүний худаг, салбар төмөр зам, мал хүлээн авах, сойлтын хашаа, аммиакны агуулах, цахилгааны дэд өртөө, бохир усны төвлөрсөн шугам, хөргүүрийн болон үйлдвэрийн технологийн хэрэгцээний усан сан зэрэг байгууламжтай, томоохон үйлдвэр. Мөн манай орны хангайн бүсд, ОХУ-ын хилд ойр байршилтай, салбар төмөр замтай тул мах, махан бүтээгдэхүүнийг экспортлоход хамгийн боломжтой үйлдвэр юм. Фото зураг 1-36.

## 2.2.96 Хөрөнгийн үнэлгээ

“Сэлэнгэ Мах Маркет” МБҮ-ийн хөрөнгийн үнэлгээг хөрөнгийн ангилал тус бүр дээр дэлгэрэнгүй нэр төрлөөр тайлангийн 2.1-д заасан аргачлалын дагуу үнэлж барилгын үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.9.1-ээр, байгууламжийн томсгосон төсвийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.9.2а-аар, төсвийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.9.2б-ээр, тоног төхөөрөмжийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.9.3-аар, тээврийн хэрэгслийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.3.1-ээр, тавилга эд хогшлын үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.9.4-өөр, компьютерийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.9.5-аар, газар эзэмших эрхийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.3.2-оор тус тус хийж хавсаргасан.

Тус үйлдвэрийн хөрөнгийн үнэлгээ 6,029,254.4 мянган төгрөг болсныг хөрөнгийн ангиллын дагуу дараах хүснэгтээр товчоолон харуулав.

### Хөрөнгийн шинэчилсэн үнэлгээний товчоо


				(мян.төг)
№	Хөрөнгийн бүлэглэсэн нэр	2010.12.31-ний үлдэгдэл өртөг	Шинэчилсэн үнэлгээ	Тооцооллыг харуулсан хүснэгтийн дугаар
1	Барилга	1,536,112.5	3,659,076.9	2.2.9.1
2	Байгууламж	484,287.3	1,012,882.9	2.2.9.2а, 2.2.9.2б
3	Тоног төхөөрөмж	830,418.4	924,525.1	2.2.9.3
4	Тээврийн хэрэгсэл	36,831.0	49,500.0	2.3.1
5	Эд хогшил	12,237.3	12,237.3	2.2.9.4
6	Компьютер	804.1	804.1	2.2.9.5
7	Газар		370,228.1	2.3.2
	<b>Дүн</b>	<b>2,900,690.6</b>	<b>6,029,254.4</b>	-


## 2.2.10 “Багануур Мах Маркет” ХХК

### 2.2.10а Үйл ажиллагаа болон хөрөнгийн тодорхойлолт

1980-аад оны дундуур зүүн бүсийн худалдаа бэлтгэлийн агуулахын зориулалтаар баригдсан байгууламж байсныг “Дорнын говь” ХХК худалдан авч мах боловсруулах үйлдвэрийн зориулалтаар өргөтгөл хийж ашиглалтад оруулсан. 2009 оны 6-р сард “Жаст групп” ХХК худалдан авч, “Багануур Мах Маркет” МБҮ болгон өөрчилж, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлж байна.

Үйлдвэрийн барилга нь угсармал төмөр бетон суурь, каркастай, 64-ийн тоосгон ханатай, бетон дам нуруу, ПКЖ хавтан хучилттай, бетон шалтай, тусдаа уурын зуухтай. Үйлдвэрийн барилгын хойд хэсэгт мал сойх хэсэгтэй. Фото зураг 37-40.





Конторын барилга нь угсармал бетон суурьтай, 64-ийн тоосгон хана, 59х12-ын хавтан давхар дундын болон дээврийн хучилттай, үйлдвэрийн барилгаас тусдаа уурын зуухаар халаадаг. Мөн засвар механикийн цехийн барилгатай, хийцийн хувьд конторын барилгатай адил, одоогоор ашиглалтгүй. Угсармал төмөр бетон болон төмөр хашаа, автомашины пүү, гүний худаг, усан сан, мал хүлээн авах төмөр хашаа, салбар төмөр зам, ачааны тавцан, саравч, цэвэр ус, бохир усны шугам зэрэг байгууламжтай. Фотозураг41-62 .

Хоногт 300 бод, 1000 бог нядлах хагас автомат хос шугам, 50 тонн мах -40 хэмд гүн хөлдөөх камер, -20 хэмд 1200 тонн мах хадгалах хөргөлттэй агуулах бүхий тус үйлдвэр нь бүтээгдэхүүнээ төв компаниараа дамжуулан экспортлохын зэрэгцээ өөрийн нэрийн барааны дэлгүүрээр дамжуулан эрүүл, чанартай мах, махан бүтээгдэхүүнээр иргэдийн хэрэгцээг хангаж байна.

### 2.2.106 Хөрөнгийн үнэлгээ

“Багануур Мах Маркет” МБҮ-ийн хөрөнгийн үнэлгээг хөрөнгийн ангилал тус бүр дээр дэлгэрэнгүй нэр төрлөөр тайлангийн 2.1-д заасан аргачлалын дагуу үнэлж барилгын үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.10.1-ээр, байгууламжийн томсгосон төсвийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.10.2а-аар, төсвийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.10.2б-ээр, тоног төхөөрөмжийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.10.3-аар, тээврийн хэрэгслийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.3.1-ээр, тавилга эд хогшлын үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.10.4-оор, компьютерийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.2.10.5-аар, газар эзэмших эрхийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.3.2-оор тус тус хийж хавсаргасан.

Тус үйлдвэрийн хөрөнгийн үнэлгээ 4,283,754.8 мянган төгрөг болсныг хөрөнгийн ангиллын дагуу дараах хүснэгтээр товчоолон харуулав.

#### Хөрөнгийн шинэчилсэн үнэлгээний товчоо

(мян.тог)				
№	Хөрөнгийн бүлэглэсэн нэр	2010.12.31ний үлдэгдэл өртөг	Шинэчилсэн үнэлгээ	Тооцооллыг харуулсан хүснэгтийн дугаар
1	Барилга	1,317,214.9	2,217,475.7	2.2.10.1
2	Байгууламж	462,895.7	597,236.3	2.2.10.2а, 2.2.10.2б
3	Тоног төхөөрөмж	884,176.4	986,923.5	2.2.10.3
4	Тээврийн хэрэгсэл	23,922.6	19,000.0	2.3.1
5	Эд хогшил	8,402.7	8,402.7	2.2.10.4
6	Компьютер	380.8	380.8	2.2.10.5
7	Газар		454,335.8	2.3.2
	<b>Дүн</b>	<b>2,696,993.1</b>	<b>4,283,754.8</b>	-

### 2.2.11 “Өвөрхангай Мах Маркет” ХХК

#### 2.2.11а Үйл ажиллагаа болон хөрөнгийн тодорхойлолт

Өвөрхангай аймгийн төв Арвайхээр суманд тус компани, хоногт 200 бод, 500 бог нядлах хагас автомат хос шугам, 1000 тонн мах хадгалах хөргөлттэй агуулах бүхий мах боловсруулах



үйлдвэр барихаар үйлдвэрийн барилгын ажлыг эхлүүлэн, энэ онд ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна.

## 2.2.116 Хөрөнгийн үнэлгээ

“Өвөрхангай Мах Маркет” МБҮ-ийг шинээр барихаар блокон хашаа, цахилгаан дамжуулах агаарын шугамын ажил хийгдсэнийг гарсан зардлын дүнгээр үнэллээ. Тайлангийн 2.1-д заасан аргачлалын дагуу тээврийн хэрэгсэл, газар эзэмших эрхийг үнэлж тээврийн хэрэгслийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.3.1-ээр, газар эзэмших эрхийн үнэлгээг хавсралт хүснэгт 2.3.2-оор тус тус хийж хавсаргасан.

Хөрөнгийн үнэлгээ **284,223.5** мянган төгрөг болсныг дараах хүснэгтээр товчоолон харуулав.

### Хөрөнгийн үнэлгээний товчоо

				(мян.төг)
№	Хөрөнгийн бүлэглэсэн нэр	2010.12.31-ний үлдэгдэл өртөг	Шинэчилсэн үнэлгээ	Тооцооллыг харуулсан хүснэгтийн дугаар
1	Байгууламж	67,882.4	71,623.5	Гарсан зардлын дүнгээр
2	Тээврийн хэрэгсэл	16,590.8	23,000.0	2.3.1
3	Газар		189,600.0	2.3.2
	<b>Дүн</b>	<b>84,473.2</b>	<b>284,223.5</b>	-

## 2.2.12 “Баянхонгор Мах Маркет” ХХК

### 2.2.12а Үйл ажиллагаа болон хөрөнгийн тодорхойлолт

Баянхонгор суманд мөн Мах боловсруулах үйлдвэр барихаар төлөвлөн одоогоор нийт 37,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийн цахилгаан хангамжийн асуудлыг шийдвэрлээд байна.

## 2.2.12б Хөрөнгийн үнэлгээ

“Баянхонгор Мах Маркет” МБҮ-ийг шинээр барихаар газрын зөвшөөрлийг авч цахилгаан дамжуулах агаарын шугамын ажил хийгдсэнийг гарсан зардлын дүнгээр үнэллээ. Газар эзэмших эрхийн үнэлгээг тайлангийн 2.1-д заасан аргачлалын дагуу үнэлж тооцооллыг хүснэгт 2.3.2-оор хийж хавсаргасан.

Хөрөнгийн үнэлгээ **135,592.0** мянган төгрөг болсныг дараах хүснэгтээр товчоолон харуулав.

### Хөрөнгийн үнэлгээний товчоо

				(мян.төг)
	Хөрөнгийн бүлэглэсэн нэр	2010.12.31-ний үлдэгдэл өртөг	Шинэчилсэн үнэлгээ	Тооцоолол хийсэн хүснэгтийн дугаар
1	Барилга	37,000.0		
2	Байгууламж		37,000.0	Гарсан зардлын дүнгээр
3	Газар		98,592.0	2.3.2
	<b>Дүн</b>	<b>37,000.0</b>	<b>135,592.0</b>	



### 2.3 Хөрөнгийн нэгдсэн үнэлгээ, дүгнэлт

Хөрөнгийн үнэлгээг үндсэн хөрөнгийн ангилал, нэр төрлөөр үйлдвэр тус бүрээр тооцоолсоныг “Жаст Агро” ХХК-ийн хэмжээгээр нэгтгэвэл бүгд 45,206,924.1 мянган төгрөг (дөчин таван тэрбум хоёр зуун зургаан сая есөн зуун хорин дөрвөн мянга нэг зуун) төгрөг болж байгааг товчоолон үзүүлбэл:

#### “Жаст Агро” ХХК-ийн Мах боловсруулах үйлдвэрүүдийн үндсэн хөрөнгийн шинэчилсэн үнэлгээний товчоо

(мян.төг)

дугаар	Үйлдвэрийн нэр	Бүгд	Үүнээс				
			Барилга байгууламж	Үйлдвэрийн тоног төхөөрөмж	Тээврийн хэрэгсэл	Эд хогшил, компштор	Газар
1	Улаанбаатар Мах Маркет	13,416,122.4	9,387,862.0	2,551,805.9	724,700.0	60,961.2	690,793.3
2	Баян-Өлгий Мах маркет	4,833,174.8	3,657,087.6	834,164.6	12,760.0	458.6	328,704.0
3	Завхан Мах Маркет	1,322,070.2	687,157.1	547,419.2	17,100.0	130.0	70,263.9
4	Сүхбаатар Мах Маркет	1,201,164.9	558,416.1	598,787.9	18,340.0	434.4	25,186.5
5	Булган Мах Маркет	1,483,064.4	894,207.5	489,921.1	32,300.0	1,509.4	65,126.4
6	Увс Мах Маркет	885,821.4	544,868.5	270,599.1	30,400.0	517.0	39,436.8
7	Дорнод Мах Маркет	9,024,136.9	7,240,063.1	1,134,855.4	9,250.0	637.2	639,331.2
8	Ховсгол Мах Маркет	2,308,544.5	1,455,276.6	762,745.5	41,500.0	484.8	48,537.6
9	Сэлэнгэ МахМаркет	6,029,254.4	4,671,959.8	924,525.1	49,500.0	13,041.4	370,228.1
10	Багануур МахМаркет	4,283,754.8	2,814,712.0	986,923.5	19,000.0	8,783.5	454,335.8
11	Өвөрхангай МахМаркет	284,223.5	71,623.5		23,000.0	-	189,600.0
12	Баянхонгор МахМаркет	135,592.0	37,000.0			-	98,592.0
	<b>Бүгд дүн</b>	<b>45,206,924.2</b>	<b>32,020,233.8</b>	<b>9,101,747.3</b>	<b>977,850.0</b>	<b>86,957.5</b>	<b>3,020,135.6</b>

### Гурав. Бизнесийн үнэлгээ, дүгнэлт

#### 3.1 . Санхүүгийн тайлангийн шинжилгээ, дүгнэлт

Аливаа байгууллага, нэгжийн бизнесийн болоод хөрөнгийн үнэлгээг бодитой тодорхойлох нэгэн чухал үндэс, мэдээллийн эх сурвалж нь тэр байгууллагын санхүүгийн тайланд хийсэн судалгаа, дүгнэлт болдог. Энэ үүднээс тус компанийн сүүлийн 3 жилийн (2008-2010 оны ) санхүүгийн тайлангийн зэрэгцүүлсэн шинжилгээ (Хавсралт хүснэгт 3.1, 3.2, 3.3) хийж, үнэлгээний зориулалтаар товч дүгнэлт өглөө.

**1. Хөрөнгө, эх үүсвэрийн байдал.** Жаст-Агро (Мах маркет) салбар нь 2010 оны санхүүгийн тайлангаар 38167.4 сая төгрөгийн нийт хөрөнгөтэй, энэ хөрөнгийн 11.5 хувийг эзэмшигчийн өөрийн өмчөөр санхүүжүүлэн ажиллаж байна.

#### “Жаст-Агро” салбарын нийт хөрөнгө, түүний санхүүжилт

(сая.төг)

Балансын бүлгүүд	2010 он		2009 он		2008 он	
	Дүн	%	Дүн	%	Дүн	%
1. Эргэлтийн хөрөнгө	5,576.3	14.6	10,312.7	26.0	5,419.9	18.5
2. Эргэлтийн бус хөрөнгө	32,591.1	85.4	29,302.4	74.0	23,949.1	81.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>38,167.4</b>	<b>100.0</b>	<b>39,615.4</b>	<b>100.0</b>	<b>29,369.0</b>	<b>100.0</b>
3. Нийт өр төлбөр	33,770.9	88.5	34,918.1	88.1	22,590.1	76.9
4. Эзэмшигчийн өмч	4,396.5	11.5	4,697.0	11.9	6,778.9	23.1
<b>Өр төлбөр ба эзний өмч</b>	<b>38,167.4</b>	<b>100.0</b>	<b>39,615.4</b>	<b>100.0</b>	<b>29,369.0</b>	<b>100.0</b>



Нийт хөрөнгийн дүн өнгөрсөн оноос 1447.7 сая төгрөгөөр буюу 3.7 хувиар буурсан боловч сүүлийн 3 жилийн дундаж нь 35717.2 сая төгрөг болж жил тутам 14 орчим хувиар нэмэгдэж ирсэн байна. Өнгөрсөн 3 жилд (2008-2010 онд) нийт хөрөнгийн дүн бараг 30 хувиар нэмэгдсэн төдийгүй, хөрөнгийн бүтэц бүрэлдэхүүн өөрчлөгдөн, эргэлтийн хөрөнгийн хувийн жин 18.4-14.6 хувь болон багасаж, удаан гүйлгээтэй эргэлтийн бус хөрөнгүүд, тэр дундаа үндсэн хөрөнгө болон дуусаагүй хөрөнгө оруулалтын ажлын өртөг 8642,8 сая төгрөгөөр буюу 36.1 хувиар нэмэгдсэн байна. Үндсэн хөрөнгийн энэ өсөлт нь 2009 онд “Дорнын говь” ХХК-ийн махны бизнесийг худалдан авсан, 2010 онд Өвөрхангай, Баянхонгор аймагт махны үйлдвэр байгуулж эхэлсэн, Улаанбаатар, Булган, Завхан, Сүхбаатар аймаг дахь Мах маркет үйлдвэрүүдийнхээ хөргөлтийн системийг шинэчилж, танилцуулгад тэмдэглэснээр сүүлийн 3 жилд нийтдээ 25 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэнтэй холбоотой юм байна.

Эргэлтийн хөрөнгийн тухайд бэлтгэсэн мал мах, бараа материалын нөөцийн үлдэгдэл жилээс жилд буурах хандлагатай (2010 оны үлдэгдэл нь 2008 оныхоос 34,6 хувиар, 2009 оныхоос 59,6 хувиар тус бүр буурсан), борлуулалтын авлагын тооцооны үлдэгдэл 2009 оны огцом өсөлтийг эс тооцвол борлуулалтын дүнд эзлэх хувийн жингээрээ 2008 онд 2,9 хувь байсан нь 2010 онд 1,9 хувь болж багасчээ. Эдгээр үндсэн болон эргэлтийн хөрөнгүүд нь тус компанийн пэрийн бонд гаргахад хөрөнгийн баталгаа болох төдийгүй Монгол орны бараг бүх аймаг (Өмнөговь, Дундговь, Говь-Алтайгаас бусад), бүс нутгийг хамарсан мал бэлтгэлийн болон махны үйлдвэрлэл борлуулалтын нэгдсэн сүлжээг бүрдүүлснээрээ тус компанийн бизнесийн үнэлгээнд нөлөөлөх болно. Харин хөрөнгө, тэдгээртэй холбогдсон өр, авлагын тооцоог данс бүртгэлд хэрхэн тусгаж, зохих үнэ хашпаар тайлагнасан талаар цэвэр активын үнэлгээний тооцоонд нэг бүрчлэн авч үзэх шаардлагатай.

Хөрөнгийг санхүүжүүлсэн эх үүсвэрийн тухайд гаднаас татан дайчилсан өр төлбөрийн оролцоо 2008 онд 76,9 хувь байсан нь нэмэгдсээр 2010 онд 88,5 хувь болж, нийт өр төлбөрийн дүн 2010 оны тайлангаар өмнөх оноос 1147,2 сая төгрөгөөр буюу 3,3 хувиар багассан боловч 2008 оны тайлангийн үлдэгдлээс 11 180,8 сая төгрөгөөр буюу 49,5 хувиар нэмэгдсэн байна. Энэ нь өмнө тэмдэглэсэн нийт хөрөнгийн болоод нэмэлт хөрөнгө оруулалтыг дан ганц гаднын урт хугацаатай зээлийн төлбөр болон толгой ба охин компанийн хоорондын тооцооны өглөгөөр санхүүжүүлж тэр нь бүхэлдээ дараа төлөгдөх өр төлбөр байдлаар тайлагнагдаж ирсэнийг харуулж байна.

Бизнесийн өргөтгөл, шинэчлэлийн зориулалттай хөрөнгө оруулалтын зонхилох хэсгийг урт хугацаат зээл, өр төлбөрөөр санхүүжүүлдэг нь нийтлэг жишиг юм. Тэгэхдээ тэдгээр өр төлбөрүүд нь тодорхой хугацаатай, олон эх үүсвэрээс өрийн багцыг бүрдүүлсэн, хэтийн боломжийн хувьд төлөгдөхөөр байх учиртай.

Тус компанийн “Мах маркет”-ийн бизнес өргөжин хөгжихийн хэрээр махны үйлдвэрлэлт, борлуулалт, экспортын хэмжээ жил тутам нэмэгдэж байгаа (Борлуулалтын орлого 2008-2009 онд 34,9 хувиар, 2009-2010 онд 72,7 хувиар тус бүр нэмэгдсэн) боловч бизнесийн үр дүн нь тогтвортой биш, тухайлбал 2008 ба 2010 онд дөнгөж 0,12-0,8 хувийн ашигтай, харин 2009 онд 20,2 хувийн алдагдалтай ажилласан нь эзэмшигчийн өмчийн дүн (хуримтлагдсан алдагдлын дүнгээр) буурахын шалтгаан болжээ. Энэ нөлөөгөөр эзэмшигчийн дүн 2008-2009 онд 2081,9 сая төгрөгөөр (буюу 30,7 хувиар), 2009-2010 онд 300,5 сая төгрөгөөр (6,4 хувиар) тус бүр буурч, нийт санхүүжилтын дүнд эзлэх хувийн жин нь 2008 онд 23,1 хувь байсан нь 2010 онд 11,5 хувь болж 2 дахин багассан байна. Ийнхүү эзэмшигчийн өмчийн дүн төдийгүй оролцооны хувь хэмжээ жилээс жилд багассаар байгаа нь хөрөнгө оруулалтын хурдацтай



өсөлтийн нөлөөллөөс гадна бий болгосон хүчин чадлын ашиглалт нэн доогуур, бас гаднаас татан төвлөрүүлсэн санхүүжилтын өртөг зардал (зээлийн хүү) өндөр байгаагаас алдагдалтай ажилласантай холбоотойг үгүйсгэх аргагүй. (дэлгэрэнгүй тооцоог хавсралт хүснэгт 3.1-ээр харуулав) Тэгэхдээ эргэлтийн хөрөнгийн санхүүжилтын зориулалтаар өрийн бичиг гаргаж, хөрөнгийн зах зээлээс санхүүжилт олох шийдвэрийг гаргахдаа энэ хүндрэлтэй байдлаа тооцсон гэж найдаж байгаа.

**2. Салбарын орлого, үр дүнгийн байдал.** Борлуулалтын орлого жил дараалан хурдацтай нэмэгдэж байгааг өмнөх хэсэгт тэмдэглэсэн. Борлуулалтын орлогын өсөлтийг дагаад борлуулалтын өртөг зардал өсөх нь зүйн хэрэг, гэхдээ борлуулалтын өртгийн хувийн жин 2008 онд 65,3 хувь байсан нь 2009 онд 58,2 хувь, 2010 онд 49,9 хувь болж буурснаар нийт ашгийн хувь 34,7-50,1 хувь болж өсчээ. Энэ нь мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өртөг зардлын бууралт гэхээсээ илүүтэй борлуулалтын өртгийг зөвхөн мал мах худалдан авалтын шууд зардлаар тооцсон болон махны худалдах үнийн өсөлттэй холбоотой байх магадлалтай. Ийнхүү нийт ашиг нэмэгдсэн боловч борлуулалтын болон удирдлагын ерөнхий зардал 2008-2009 онд 2,2 дахин, 2009-2010 онд 27,9 хувиар тус бүр нэмэгдсэн нь үндсэн ажиллагааны үр дүн алдагдалтай гарахын шалтгаан болжээ.

Бизнесийн өсөлт хөгжил, үнэлгээг тодорхойлогч үндсэн шалгуур үзүүдэлт нь үндсэн ажиллагааны ашгийн тогтвортой өсөлт байдаг. Тус салбарын хувьд үндсэн ажиллагаанаас сүүлийн 3 жилийн дундажаар тооцоход жил тутам 1238,1 сая төгрөгийн буюу борлуулалтын орлогын 10,4 хувьтай дүйцэхүйц алдагдалтай ажилласан нь дээр тэмдэглэсэн мах, махан бүтээгдэхүүний үнийн өсөлт, борлуулсан бүтээгдэхүүний өртгийн бууралт зэрэгтэй жипихэд нэн харамсалтай, бизнесийн үнэлгээнд сөргөөр нөлөөлөх хүчин зүйл гэж болно. Гагцхүү энэ алдагдал нь хэр бодитой, чухам юунаас шалтгаалсан, үйл ажиллагааны зардалд ялангуяа 2009 онд юу юуг оруулж тооцов гэдгээс эцсийн үнэлгээ дүгнэлт хамаарна.

Үйл ажиллагааны бус үр дүнгээр жил тутам багагүй ашиг (2008-2009 онд тус бүр 643,2-766,7 сая төгрөгийн, харин 2010 онд 375,5 сая төгрөгийн ашиг) олдог, тэр нь үндсэн ажиллагааны алдагдлын нилээдийг нөхдөг юм байна. Тайлангаар 2008 ба 2010 онд бага хэмжээний ашигтай ажилласан нь гагцхүү үйл ажиллагааны бус орлого, үр дүнгээс бий болжээ. Салбарын дүнгээр нийт орлого 2010 онд 18172,9 сая төгрөг болж жил дараалан нэмэгдсэн боловч 2009 онд нийт зардлын өсөлт нь давамгайлж орлогын төгрөг тутмаас 1,2 мөнгөний алдагдалтай, харин 2010 онд 1 мөнгөний ашигтай ажилласан тайлан гаргажээ (дэлгэрэнгүй тооцоог хавсралт хүснэгт 3.2-оор харуулав).

Цаашдаа мах, махан бүтээгдэхүүний зах зээлийн үнэ тогтвортой нэмэгдэж, махны хомедолтой байгаа өнөөгийн хандлага, борлуулсан барааны өртөг 50 хувьд бараг хүрэхгүй байгаа нөхцөл байдлыг тооцвол үндсэн ажиллагаанаас алдагдал гарахааргүй бөгөөд тэр ч байр сууринаас энэ бизнесийг улам өргөжүүлээд, хөрөнгө оруулалтыг нь нэмээд байгаа болов уу. Гагцхүү хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хүчин чадлыг оновчтой тогтоох, нэгэнт бий болгосон хүчин чадлыг бүрэн эзэмшиж ашиглах, үйлдвэрлэлийн улирлын нөлөөллийг багасган жигд ажиллуулах, бэлтгэсэн махны эцсийн боловсруулалтыг нэмэгдүүлэх, экспортонд гаргах хэмжээг өсгөх зэрэг удирдлага, зохион байгуулалтын олон хүчин зүйлүүдийг харгалзаж бизнесийн үнэлгээг тогтоох шаардлагатай юм байна.



**3. Санхүүгийн харьцаануудын төлөв байдал.** Нийтдээ 4 бүлэг, 20 шахам үзүүлэлтүүдийг хавсралт хүснэгт 3.3-аар тооцоолж тайланд хавсаргав. Үзүүлэлтүүдийн төлөв байдлаас харахад:

**Санхүүгийн тогтворжилтын** хувьд өөрийн хөрөнгийн оролцоо багассаар 2010 онд дөнгөж 11,5 хувь болсон, тэр хэмжээгээр өрийн харьцаа нэмэгдэж 2008 онд өр төлбөрийн дүн өөрийн хөрөнгөөс 3,3 дахин их байсан нь 2010 онд 7,7 дахин их болж 2 дахин өссөн, эргэлтийн хөрөнгийн харьцаа хангалттай биш (дөнгөж 1,01-1,04) байгаа хүндрэлүүд байна. Тэгээд ч үндсэн ажиллагаанаас алдагдалтай ажилласаар байгаа болохоор хөрөнгө оруулалтын санхүүжилтийг ойрын хугацаанд нөхөн төлөх боломж нэн хязгаарлагдмал (ихээхэн эрсдэлтэй) болжээ. Магадгүй урт хугацаат өрийн дансанд бичигдээд байгаа хөрөнгө оруулалтын санхүүжилтийн зарим хэсэг нь толгой компаниас оруулсан юм бол, тэр оруулсан хөрөнгөө тус салбарын хувьд эзэмшигчийн хувь нийлүүлсэн хөрөнгөөр шилжүүлэн бүртгэж, өр зээл, зээлийн хүүний дарамтаас охин компанийг зохих хэмжээгээр чөлөөлөх бодлогыг хэрэгжүүлэх нь зөв болов уу.

**Төлбөрийн чадварын** өнөөгийн болон ойрын боломж маш доогуур, эргэлтийн хөрөнгийн тогтвортой санхүүжилт дутагдалтай, богино хугацаат төлбөрүүд нь авлагын дүнгээс дундажаар 15 дахин их байгаа нь эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн тусгайлсан бодлого, зохицуулалт шаардлагатайг илтгэж байна. Ийм байдалд хүргэсэн өөр нэг шалтгаан нь тус салбарын борлуулалтын орлогыг тусгай дансаар толгой компанид төвлөрүүлдэгтэй ч холбоотой байж болох юм. Хэрэв эргэлтийн хөрөнгийн санхүүжилтэд зориулсан бонд гаргаад мал бэлтгэл, махны үйлдвэрлэл борлуулалтыг нэмэгдүүлж чадвал тэр хэмжээгээр нийт эргэлт, үйлдвэрлэлийн хүчин чадлын ашиглалт нэмэгдэн, бизнесийн үр ашигт эерэгээр нөлөөлөхийг үгүйсгэхгүй.

**Хөрөнгийн ашиглалтын** хувьд нийт болон өөрийн хөрөнгийн ачаалал жилээс жилд хурдацтай (бараг 2 дахин) нэмэгдсэн нь борлуулалтын орлогын өсөлттэй холбоотой бөгөөд авлагын цугларуулалт 40-өөс 25 хоног болж түргэссэн, бараа материалын нөөцийн эргэц 2009 оноос 165 хоногоор (буюу 5-6 сараар), мөнгөн циклийн хугацаа бараг 2 дахин түргэсэж, 2010 оны гүйцэтгэлээр 209 хоног болсон нь нэн сайшаалтай.

Монгол орны мал, мах бэлтгэлийн улирлын онцлогтой холбон тооцвол мал бэлтгэлд зориулсан санхүүжилтын эргэц хамгийн багадаа 3 сарын дараагаас, нилээд хэсэг нь хагас жилийн хугацаанд төлөгдөж эхлэх бөгөөд, өвөл хаврын хэрэгцээнд зориулан нөөцөлсөн мах нь нядалгаанаас хойш 9-12 сарын дараа борлогдохоор байгаагаас үзэхэд эргэлтийн хөрөнгийн зориулалтаар гаргасан бондын нөхөн төлбөр дунджаар жилийн дараа төлөгдөх боломжтойг бондын хугацаа, хүүг тогтоохдоо харгалзвал зохино.

**Оруулсан хоронгийн өгөөж** буюу ашгийн хувь хэмжээний тухайд өнгөрсөн 3 жилийн хугацаанд тус салбар жил дараалан алдагдалтай ажилласан учраас ихэнх үзүүлэлтүүд сөрөг утгатай гарчээ. “Жаст Агро” салбарын хөрөнгө, түүний санхүүжилт, түүнээс улбаалан бий болсон санхүүгийн өнөөгийн төлөв байдал, борлуулалтын болоод бусад орлогын өсөлт, үйлдвэрлэлийн хүчин чадлын ашиглалтын одоогийн төлөв байдал, ойрын чиг хандлагыг хөрөнгийн болоод бизнесийн үнэлгээг тогтооход сайтар харгалзан үзэх бас хараат бус аудитын байгууллагын дүгнэлт, компанийн бизнес төлөвлөгөөгөөр сайтар тодруулах шаардлагатай юм байна.

*Бичиг*  
21





### 3.2. Мах, махан бүтээгдэхүүний зах зээл, өрсөлдөгчид

Монголчууд нь байгаль цаг уурын онцлог, хэрэглээний уламжлал зэргээсээ шалтгаалаад хэзээнээсээ махны хэрэглээ ихтэй “махсаг” хүмүүс гэж боно. Нэг хүнд ногдох малын тоо толгойн өсөлт нь энэ хэрэглээг бүрэн хангах боломжтой. Хөдөөгийн малчин өрхүүд төдийгүй хот суурин газрын иргэдийн нилээд нь идшээ хөдөөнөөс бэлтгэдэг онцлогоос хамаараад дотоодын зах зээл дэх мах махан бүтээгдэхүүний хэрэглээг нарийвчлан тодорхойлоход төвөгтэй ч ерөнхийд нь жил бүрийн хүн амын статистикийн тоо баримт, Монгол хүний жилийн махны хэрэглээний дундаж нормыг үндэслэн жилд дунджаар 6-8 сая малыг хүнсэнд хэрэглэж, 200 гаруй мянган тонн махны хэрэгцээтэй гэсэн тооцоо байдаг. Манай улсад нийтдээ том, жижиг нийлсэн 30 орчим үйлдвэр ажиллан, жилд 90 орчим мянган тонн мах, махан бүтээгдэхүүнийг үйлдвэрийн аргаар боловсруулах хүчин чадалтай хэдий ч тэдгээрийн хүчин чадлын 20-30 хувийг ашиглаж, хотуудын махны хэрэглээний 30 орчим хувийг хангаж байна.

Энэ байдал нь мах, махан бүтээгдэхүүний ханган нийлүүлэлт үндсэндээ чөлжүүдээр дамжин хийгдэж байна гэсэн үг юм. Мах махан бүтээгдэхүүний дотоодын зах зээл бага байдгийн дээр албан бус худалдаа зонхилдог учраас “Жаст Агро” ХХК нь өөрийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний дийлэнхийг экспортонд гаргах болон бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байж л энэ зах зээл дээр өрсөлдөх, нэгэнт бий болгосон хүчин чадлаа ашиглан үйл ажиллагаагаа тогтвортой явуулах бодлогыг баримталдаг юм байна.

Гадаад зах зээлийн хувьд “Жаст Агро” ХХК нь ОХУ-ын “Бурят Мясо” компанийн хувьцааны 50 хувийг эзэмшиж байгаа нь экспортонд ихээхэн зэрэг нөлөөллийг үзүүлж, байнгын худалдан авагч байх боломжтой.

Хятад улсад албан ёсоор адууны мах нийлүүлж байгаа ч албан бус сурвалжаас үзвэл хонь, ямааны мах ч гаргаж байгаа. Ойрхи Дорнод, Азийн орнууд манай улсаас хонины мах авах сонирхол их байдаг. Иран улс сүүлийн 3 жилд манайхаас хонины мах авч байгаа бөгөөд энэ жил худалдан авалтаа нэмэгдүүлэн 2000 тонн болгосон. Малайз улс 3000 тн мах худалдан авахаар саяхан гэрээ хийсэн. Арабын орнуудад их хэмжээний мах нийлүүлэх боломж бий гэнэ. Хамгийн бэрхшээлтэй зүйл нь гадаадын худалдан авагчид технологийн тодорхой шаардлага тавьдаг, бас тээвэрлэлтийн асуудал хүндрэлтэй байдаг юм байна.

Дээрх шаардлагуудыг хангаж, хүнсний бүтээгдэхүүний ариун цэвэр, чанарын стандартын баталгааг олон улсад хүлээн зөвшөөрөгдөхүйц хэмжээнд хүргэхийн тулд тус компани нь 2010 онд “Эгзэгтэй цэгийн аюултай байдлыг шинжлэн хянах” (НАССР) системийг нэвтрүүлж, хөргөлтийн хүчин чадлаа нэмэгдүүлжээ.

Дэлхийн болон ихэнх бүс нутагт хүнсний хомсдол нүүрлэх болсон энэ цаг үед монголчууд бид мах, сүү, гурил, хүнсний ногоо зэрэг экологийн цэвэр бүтээгдэхүүнээр өөрсдийнхээ хэрэгцээг хангах төдийгүй, дэлхийн зарим улс орны хүнсний бүтээгдэхүүний хомсдлыг багасгахад тодорхой хувь нэмэр оруулж, экологийн цэвэр бүтээгдэхүүн болох махыг экспортолох боломж улам бүр нэмэгдэж байна.

АНУ-д энэ оны 2-р сард махны үнэ түүхэнд байгаагүй дээд түвшиндээ хүртэл өсөж, нэг фунт бузуу 454 грамм нь 4,29 ам доллар (1 кг мах 9,44 доллар) болсон төдийгүй 2011 оны сүүлч





гэхэд махны үнэ өмнөх жилээс даруй 15 хувиар нэмэгдэнэ гэж гаднын шинжээчид үзэж байгаа юм.

Одоогоор манай махны үйлдвэрүүдийн олонхи нь тураг мах экспортонд гаргахаас гадна нийт бэлтгэсэн махны 10 хүрэхгүй хувийг эзэлдэг ангилсан мах, хиам, консерв, хагас боловсруулсан бэлэн бүтээгдэхүүний зах зээл дээр өрсөлдөж байна. Гэхдээ эдгээр үйлдвэрлэгчдийг “Жаст Агро” нь өрсөлдөгчид гэж шууд үзэхгүй байгаа бөгөөд тус компанийн үйлдвэрлэлийн гол зорилго нь тураг мах үйлдвэрлэх, түүний дийлэнхийг экспортонд гаргах явдал гээд өнөөгийн нөхцөл байдлаа дараах байдлаар үнэлжээ. (Бизнес төлөвлөгөө 2011-2013 он)

<p><b>Давуу тал:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>-Орон нутагт мал хүлээн авч үйлдвэрийн аргаар нийдалж боловсруулах, хадгалах үйлдвэрүүдийн сүлжээг бий болгосон.</li> <li>-Мах боонөөр нь бэлтгэн үйлдвэрлэх чадвар сайн</li> <li>-Малыг хамгийн алсдаа 200 км-ийн зайд тууварлах болж махны гарцыг нэмэгдүүлэх</li> <li>-Эгзэгтэй цэгийн аюултай байдлыг шинжлэн хянах НАССР системийг бий болгосон.</li> </ul>	<p><b>Боломж:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>-Дотоодын бэлэн мөнгөний зах зээл дээрээс үнэт цаас гаргах замаар хөрөнгө бий болгох</li> <li>-НӨАТ-аас чөлөөлсөн</li> <li>-ОХУ-ын “Бурят мясо” компанийн хувьцааны 50 хувийг эзэмисэн нь махны экспортод ихээхэн нөлөвтэй</li> <li>-НАССР, ISO 22000 стандартыг салбар сүлжээ үйлдвэрүүдэд шат дараалан нэвтрүүлэх</li> <li>-Засгийн газар нөөцийн махны хэмжээг нэмэгдүүлэхэд ихээхэн анхаарч байна.</li> <li>-Арабын ертөнц рүү мах гаргах анхны гэрээгүүд хийгдсэн.</li> </ul>
<p><b>Сул тал:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>-Үйлдвэрүүд эргэлтийн хөрөнгийн дутагдлаас хамааран бүрэн суурилагдсан хүчин чадлаараа ажиллахгүй байх</li> <li>-Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны цикл улирлын шинж чанартай, мал бэлтгэл 7-12 сарын хооронд, хадгалалт нь 12-6 сарын хооронд байдаг.</li> <li>-Энэ цикл нь мөнгөн хөрөнгийг хамгийн багадаа 6 сар, түүнээс дээш саршир бараа хэлбэрээр хадгалахад хүргэдэг учир байнгын эргэлтийн хөрөнгийн дутагдалд ордог</li> </ul>	<p><b>Учирч болох эрсдэл:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>-Мал бэлтгэлд шаардлагатай мөнгөн хөрөнгө хангалттай бус</li> <li>-Малыг хөлөөр хөрш зэргэлдээ орнуудад шууд экспортлох</li> <li>-Малын гоц халдварт өвчин гарч үйлдвэрүүдийн хүчин чадлыг бүрэн ашиглаж чадахгүй байх</li> <li>-ОХУ өөрийн хилээр орох махны экспортод хориг тавих</li> <li>-Арабын орнуудад үүсээд байгаа нөхцөл байдлаас болж гэрээ сунгагдахгүй байх</li> <li>-Засгийн газар, Монгол банкнаас боломжийн хуу амалсан их хэмжээний үнэт цаас гаргах</li> </ul>

23



SWOT шинжилгээнээс дүгнэвэл үйлдвэрийн аргаар бэлтгэсэн мах, махан бүтээгдэхүүний хэрэглээний дотоод болон гадаад зах зээл хүрэлцэхүйц байгаа бөгөөд учирч болох гол эрсдэл нь малын гоц халдварт өвчин, эргэлтийн хөрөнгө (мал бэлтгэлийн зардал)-ийн санхүүжилтийн дутагдалтай байдал гэж болохоор байна.

**Зах зээлийн үнэ.** “Жаст Агро” ХХК нь мал бэлтгэлийн ба худалдах үнэ гэсэн 2 төрлийн үндсэн үнэ хэрэглэдэг. Мал бэлтгэлийн үнэ нь малчид, бэлтгэн нийлүүлдэгчдээс орон нутагт мал худалдан авах үнэ бөгөөд тус компани тодорхой радиусын дотор сүлжээ үйлдвэрүүд байгуулснаар малчдын тууврын зардлыг хэмнэж нэг дор их хэмжээгээр мал худалдан авах хүчин чадлыг суурилуулсан тул бэлтгэлийн үнийн хувьд ченжүүдийн нөлөөлөл ороогүй, дундын зуучлалгүй малчдад шууд төлөх үнэ төдийгүй, компаниас малын тарга хүч, таварлаг байдал, тушаасан малын тооноос хамааруулан урамшууллыг олгодог юм байна. Үүнээс гадна уламжлалт мал аж ахуйгаа хөгжүүлэх малчдыг дэмжих төрийн бодлогын хүрээнд “гариаланчдын ургуулсан улаан буудайд нь урамшуулал өгч байгаатай адилаар үйлдвэрт нийлүүлсэн эрүүл чанартай түүхий эд, бүтээгдэхүүн (мал, маханд) тодорхой урамшуулал олгодог тогтолцоонд ойрын үед шилжих болно” гэдгээ Монгол Улсын Засгийн Газар мэдэгдээд байгаа нь мал, мах бэлтгэлийг нэмэгдүүлэхэд том хүчин зүйл болох нь дамжиггүй. Худалдан борлуулах үнийн хувьд гэрээний ба зах зээлийн үнэ байна. Гэрээний үнэ нь бөөний болон экспортонд, зах зээлийн үнэ нь жижиглэнгийн борлуулалтад голчлон хэрэглэгдэнэ.

Бизнесийн төлөвлөгөөнд Тураг махны борлуулалтын нэгжийн үнэ (гадаадад) 2-3\$, шулсан махны борлуулах нэгжийн үнэ (гадаадад) 2,8-3,6\$ гэж тооцоолсон ба зах зээлийн мэдээллээр Орос улсад үхрийн махыг 2,4\$, адууны махыг 1,8\$ орчимд гэрээгээр нийлүүж байна. Дэлхий дахинд үүсээд байгаа хүнсний хомсдол, мах махан бүтээгдэхүүний үнийн өсөлт, манай улсын махны зах зээлийн үнэ бүрдэлтийн дээрх хүчин зүйлүүд нь энэ бизнесийн өсөлт хөгжилд зэрэгээр нөлөөлөх болно. Махны үйлдвэрлэл нь улирлын шинж чанартай тул жил жилийн хавар махны хомсдол бий болж, үнэ өсөн улмаар инфляци байнга бий болдог.

Монгол Улсын Засгийн газар махны үнээс улбаатай инфляцийг зогсоох гол арга зам нь жил бүр нэгдсэн бодлогоор улсын нөөцөд мах бэлтгэн нөөцлөх, ХААҮ-ийг хөгжүүлэх, дэмжихэд чиглэсэн урамшуулал, татаас өгөх, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх, махны үйлдвэрлэлийг НОАТ-аас чөлөөлж, улсын нөөцөд бэлдэх махны тоо хэмжээг нэмэгдүүлэх, малчдад өгөх татаас, урамшууллыг мах үйлдвэрлэгчдээр дамжуулах олгох зэрэг санал санаачлагыг дэмжин хэрэгжүүлж байна.

“Жаст Агро” ХХК нь 2000 оноос эхлэн техник технологийн шинэчлэлтийг тууштай хийж, мал бэлтгэлийн бүсчилсэн хөдөө, орон нутгийн иргэд, малчдаас дундын зуучлалгүйгээр шууд мал худалдан авах шинэлэг хэлбэрийг нэвтрүүлэн, мах махан бүтээгдэхүүнийг үйлдвэрийн аргаар боловсруулан дотоод гадаадын зах зээлд нийлүүлж “мал бэлтгэл, мах үйлдвэрлэлийн нэгдсэн үр ашигтай системийг төлөвшүүлэх” зорилтыг хэрэгжүүлж байна. Энэ бодлого, хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд өнөөдөр нэг удаад 10,7 мянган толгой мал бэлтгэн нядалж, 19,2 мянган тонн мах хөргөн хөлдөөх аммиакан хөргөлт бүхий хөдөө орон нутагт 11 салбар үйлдвэр, борлуулалтын цэгүүд бүхий үйлдвэрлэлийн хүчин чадлыг бий болгож мал бэлтгэл, мах үйлдвэрлэл, борлуулалтын нэгдсэн цогц тогтолцоо бүхий мах үйлдвэрлэгч томоохон компани болжээ. Ингэснээр “Жаст Агро” ХХК нь Монгол улсын хэмжээнд мал бэлтгэлийн 30 гаруй хувь, мал нядах хүчин чадлын 26 хувь, мах махан бүтээгдэхүүн хадгалах хүчин чадлын 30 орчим хувь, махны экспортын 20 гаруй хувийг дангаараа хангаж байна. Мөн

24



үйлдвэрийн аргаар бэлтгэж буй нийт махны 40 орчим хувийг үйлдвэрлэн, нийслэлийн хүн амын мах махан бүтээгдэхүүний 1/3-ыг дангаараа нийлүүлж байна.

Манай улс жилдээ 20-30 мянган тонн мах экспортолдог гэсэн мэдээлэл бий. “Жаст Агро” ХХК нь жилдээ 9 мянга орчим тонн мах экспортолдог нь нийт зах зээлийн 30-45 орчим хувийг эзэлж байна. Монгол Улсын Эдийн Засгийн өсөлтөнд мал аж ахуйн салбарын эзэлж байгаа байр суурийг үндэсний статистикийн мэдээгээр харуулахад манай улсын экспортын бүтцэнд мал амьгад тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүний эзлэх хувь хэмжээ жилээс жилд нэмэгдэж, эдгээр бүтээгдэхүүний гадаад худалдааны биет хэмжээний индекс 2005 оны түвшингээс 54,5 хувиар нэмэгдсэн хэдий ч экспортын дүнд эзлэх хувийн жин нь нэн чамлалттай байгаа юм.

### Экспортын бүтэц

(хувиар)

Бүтээгдэхүүн	2006	2007	2008	2009
Мал амьгад тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүн	1.7	1.4	1.3	2.4
Эрдэс бүтээгдэхүүн	58.0	66.8	60.3	66.4
Үнэт, хагас үнэт чулуу	17.5	12.1	23.7	16.5
Бусад	22.8	19.7	14.7	14.7
<b>Нийт дүн</b>	<b>100%</b>	<b>100%</b>	<b>100%</b>	<b>100%</b>

Эх сурвалж: Статистикийн эмхэтгэл 2009 он

Монгол орны байгалийн болон газрын хэвлийн баялгаас бий болж байгаа санхүүгийн нөөцийн зарим хэсгийг хүлсний үйлдвэрлэл, мал аж ахуйг хөгжүүлэхэд зориулан эдийн засгийн бүтцийн тэнцвэртэй байдлыг хангахад махны үйлдвэрлэлийн хөгжил чухал үүрэгтэй. Тус компанийн хамт олон Улс орны эдийн засгийн хөгжилд оруулах бизнесийн үүргээ нэмэгдүүлэх, сүлжээ үйлдвэрүүдийнхээ суурилагдсан хүчин чадлыг бүрэн дүүрэн ашиглахын тулд мал бэлтгэлийн зардлыг санхүүжүүлэх зорилгоор өөрийн хөрөнгө болон бизнесийн үйл ажиллагаагаар баталгаажсан “өрийн бичиг” (30 тэрбум төгрөгийн бонд) гарган хөрөнгийн зах зээлээс зохих санхүүжилт авч мал бэлтгэлийг өмнөх 4 жилийн дунджаас 5-6 дахин нэмэгдүүлж, хөргөлтийн хүчин чадлын ашиглалтыг 60-70 хувьд хүргэх, үйл ажиллагааныхаа мөнгөн урсгалаар бондын өрөө 2 жилийн дотор эргүүлж төлөхөөр ойрын 3 жилийн бизнес төлөвлөгөө боловсруулжээ.

Компаний мал бэлтгэлийн зохион байгуулалт, нэгэнт бий болгосон хүчин чадал, үйлдвэрүүдийн сүлжээг үүсгэсэн байдал, махны зах зээлийн эрэлт хэрэгцээ, экспортын боломж, бизнесийн болон бусад үүсэж болох эрсдэлийг тооцоолж, түүнийг даван туулах арга замыг тодорхойлсон байдал, ойрын жилүүдийн мөнгөн урсгалын төлөвлөлт зэргээс дүгнэвэл төлөвлөсөн зорилтыг хэрэгжүүлэх зохих үндэслэлтэй гэж болохоор байна. Энэ байр сууринаас тус компанийн бизнесийн үнэлгээг тодорхойлов.

### 3.3. Ирээдүйн цэвэр мөнгөн урсгалын төсөв

Тус компаний бэлтгэсэн бизнесийн төлөвлөгөөгээр 2011 онд мал бэлтгэлийн хэмжээг өмнөх 4 жилийн дундажаас 5,5 дахин нэмэгдүүлж нийтдээ 310 мянгаас доошгүй тоо толгой, үүнээс бод мал 60 мянга, бог 250 мянган толгойг бэлтгэн 2011-2012 онд 11300 тн тураг болон шулсан мах үйлдвэрлэн, 80 хувийг нь экспортонд гаргах зорилт дэвшүүлжээ.

*[Handwritten signature]*



Үйлдвэрлэлийн аргаар мал мах бэлтгэх болон мах үйлдвэрлэлтийн өртгийн 85 орчим хувь нь зөвхөн мал бэлтгэл буюу худалдан авалтын өртөг байдаг бөгөөд мал бэлтгэл нь жилийн турш бус, зун намрын 7-11 дүгээр сард оргил ачааллаар явагддаг онцлогоос шалтгаалан эдгээр саруудад 28,3 тэрбум төгрөгийн худалдан авалтын хэрэгцээ үүсэж, жилийн нийт мөнгөн зарлагын бараг 70 хувь нь эдгээр саруудад гардаг юм байна. Гэтэл бэлтгэсэн махны борлуулалт дараа оны 6-р сарыг дуустал үргэлжилдэг онцлогтой. Үйлдвэрлэл-борлуулалтын мөчлөгийн энэ онцлог байдлыг үндэслэн мөнгөн урсгалын (мөнгөн орлого ба зарлагын) төсвийг энэ оны 7-р сараас дараа оны 6-р сарыг дуустал он дамнуулан хийсэн бөгөөд эргэлтийн хөрөнгийн өөрийн санхүүжилтийн дутагдлыг нөхөхийн тулд 30 тэрбум төгрөгийн өөрийн бичиг гарган 2 жилийн хугацаанд эргүүлэн төлөхөөр мөнгөн урсгалын төсөв боловсруулжээ.

Ийнхүү 2011-2012 оны мал бэлтгэлийн дүнд 11300 тонн тураг болон шулсан мах, 2300 орчим тонн дайвар бүтээгдэхүүн (дотор мах) бүгд 13600 тонн мах үйлдвэрлэснээр үйлдвэрүүдийн хөргөлтийн хүчин чадлын ашиглалт 70,8 хувьд хүрч, нядалгааны оргил ачаалалтай сарууд (7-12 дугаар)-д хопогт дунджаар 1700 толгой мал нядалснаар хүчин чадлын ашиглалт 15-20 хувьд болох учраас дээрх төлөвлөгөө нь суурилагдсан хүчин чадлын хувьд хэрэгжих боломжтой юм байна. Тус компанийн бэлтгэх мах нь манай улсын хүн амын жилийн дундаж хэрэглээ (дотоод)-ний 10 хүрэхгүй хувь болох учраас борлуулалтын эрсдэл багатай гэж болно. Гагцхүү мал бэлтгэлийг малын тарга хүч гүйцсэн зун намрын тааламжтай улиралд багтаан шуурхай зохион байгуулах, бэлтгэсэн мал махны үнийг цаг тухайд нь бэлэн мөнгөөр олгохын тулд санхүүжилтийн асуудлыг л урьдчилан шийдэх шаардлага тулгарч байна.

Дараагийн онуудад мал бэлтгэл болон мах үйлдвэрлэлт жил дараалан нэмэгдсээр 2015-2016 онд бэлтгэх малын тоо толгой 404,5 мянгал хүрч өнөөдрийн (2011-2012 оны) түвшингээс 30,5 хувиар буюу жилд дундажаар 6,9 хувиар, бэлтгэх махны хэмжээ 8,5 хувиар тус бүр нэмэгдэхээр тооцно. Энэ зорилтыг хангахын тулд мал бэлтгэлийн бүс нутгийг өргөжүүлэх, сүлжээ үйлдвэрүүдийн хоорондын зайг багасгаж нягтруулахын тулд Баянхонгор, Говь-Алтай, Ховд аймгуудад дундаж хүчин чадлтай 3 үйлдвэр нэмж байгуулахтай холбогдсон мөнгөн урсгалыг төсвийн тооцоонд тусгасан болно.

Бид тус компанийн 2011-2013 оны бизнес төлөвлөгөө болон цаашдын чиг хандлагыг үндэслэн тооцоог ойрын 5 жил (он тус бүрээр), дараагийн 10 жил (жил тутмын баримжаалсан дундажаар) гэсэн хоёр үе шатаар бэлтгэсэн бөгөөд мөнгөн урсгалыг үндсэн ажиллагааны болон санхүүжилт, хөрөнгө оруулалтын мөнгөн урсгалаар нь ангилан тооцно.

Тус компанийн бүртгэл тайлагналын практикаас үзвэл борлуулсан бүтээгдэхүүний өртгийг зөвхөн мал бэлтгэлийн шууд зардлаар тодорхойлж, махны дахин боловсруулалт, хадгалалтын зардлыг үйл ажиллагааны зардлаар тайлагнадаг учраас нийт ашгийн хувь нь 2008-2010 онд 34,7-50,1 хувь болж нэмэгдэж ирсэн. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2010 онд шинээр боловсруулан, 2011 оноос мөрдүүлсэний дүнд дээр нэрлэсэн зардлууд борлуулсан бүтээгдэхүүний өртөгт орж тооцогдох болж, нийт ашгийн хувь хэмжээ ирэх онуудад 25-27,6 хувь болон буурах юм. Мал бэлтгэл, махны үйлдвэрлэл жил дараалан өсөхийн хэрээр мал худалдан авах, махны тээвэр хадгалалтын зэрэг шууд зардлууд үнийн дүнгээр өсөх боловч, тэдгээрийн борлуулалтын орлогод эзлэх хувийн жин болон шууд бус зардлын нэгжид ногдох хэмжээ буурах хандлагыг иш үндэс болгон компанийн үндсэн ажиллагааны цар хэмжээ, хүчин чадлын ашиглалт, орлогын өсөлт, зардлын болон ашгийн хувь хэмжээг дараах хэмжээгээр авч ирээдүйн мөнгөн урсгалын төсвийг бэлтгэв.

*[Handwritten signature]* 26



### Он тус бүрийн төсөвлөсөн үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	2011-2012	2012-2013	2013-2014	2014-2015	2015-2016	Дараагийн 10 жил
1. Мал бэлтгэл (мянган толгой)	310.0	328.5	362.0	392.0	404.5	420.0
2. Үйлдвэрлэл борлуулах мах (тн)	13,600	15,033	16,900	18,550	18,820	19,800
Үүнээс: экспортын хувийн жин	66.2	66.5	68.0	68.5	69.1	70.0
3. Хүчин чадлын ашиглалт (%)	50.0	53.0	56.0	58.0	59.0	62.0
4. Борлуулалтын орлогын өсөлт	-	111.0	113.0	111.3	101.9	109.1
5. Борлуулалтын орлогод эзлэх хувиар:						
борлуулалтын өртөг	72.4	73.2	74.0	74.5	74.8	75.0
үйл ажиллагааны зардал	8.9	9.2	9.1	8.6	8.5	8.1
санхүүгийн зардал	8.7	4.0	0.1	0.1	0.1	0.1
үндсэн ажиллагааны ашиг	10.0	13.6	16.8	16.8	16.7	16.6

### Орлого, үр дүн цэвэр мөнгөн урсгалын төсөвлөсөн тооцоо (сая.төгрөгөөр)

Үзүүлэлтүүд	2011-2012	2012-2013	2013-2014	2014-2015	2015-2016	Дараагийн 10 жил
<b>1. Үйл ажиллагааны мөнгөн урсгал</b>						
1.1 Борлуулалтын орлого	41,840.0	46,450.0	52,490.0	58,430.0	59,550.0	65,000.0
1.2 Борлуулалтын өртөг	30,290.0	34,000.0	38,840.0	43,530.0	44,540.0	48,750.0
1.3 Нийт ашиг	11,550.0	12,450.0	13,650.0	14,900.0	15,010.0	16,250.0
1.4 Үйл ажиллагааны зардал	3,723.0	4,273.0	4,776.0	5,025.0	5,060.0	5,460.0
1.5 Санхүүжилтийн зардал (хүү)	3,627.0	1,867.0	34.0	35.0	35.0	35.0
<b>1.6 Үндсэн ажиллагааны цэвэр ашиг</b>	<b>4,200.0</b>	<b>6,310.0</b>	<b>8,840.0</b>	<b>9,840.0</b>	<b>9,915.0</b>	<b>10,755.0</b>
1.7 Бусад орлого (үр дүн)	300.0	350.0	400.0	460.0	485.0	495.0
1.8 Татварын өмнөх цэвэр ашиг	4,500.0	6,660.0	9,240.0	10,300.0	10,400.0	11,250.0
1.9 Орлогын татвар	675.0	1,215.0	1,860.0	2,125.0	2,150.0	2,360.0
1.10 Элэгдлийн зардал	1,750.0	2,280.0	2,700.0	2,920.0	2,920.0	2,910.0
<b>1.11 Татварын дараах цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>5,575.0</b>	<b>7,725.0</b>	<b>10,080.0</b>	<b>11,095.0</b>	<b>11,170.0</b>	<b>11,800.0</b>
<b>2. Санхүүжилт ба хөрөнгө оруулалт</b>						
2.1 Үйл ажиллагааны зээл	1,975.0	1,980.0	2,060.0	2,150.0	2,160.0	2,300.0
2.2 Өрийн бичиг (бонд)	30,000.0					
2.3 Буцаан төлөлт: Зээл	1,975.0	1,980.0	2,060.0	2,150.0	2,160.0	2,300.0
Өрийн бичиг	10,000.0	20,000.0				
2.4 Хөрөнгө оруулалт		6,000.0	5,000.0	1,000.0		
<b>Санхүүжилтийн цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>20,000.0</b>	<b>(26,000)</b>	<b>(5,000)</b>	<b>(1,000)</b>		
<b>3. Цэвэр мөнгөн гүйлгээ бүгд</b>	<b>25,575.0</b>	<b>18,275.0</b>	<b>5,080.0</b>	<b>10,095.0</b>	<b>11,170.0</b>	<b>11,800.0</b>
Дискаунтын хувь	18	16	14	14	12	10
Өнөөгийн үнэ цэнийн коэф	0.847458	0.730567	0.640848	0.562148	0.501918	3.08407
<b>4. Мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ</b>	<b>21,673.7</b>	<b>(13,351.1)</b>	<b>3,255.5</b>	<b>5,674.9</b>	<b>5,606.4</b>	<b>36,392.0</b>

**Бүгд дүн 59 251,4 сая төгрөг**

*Handwritten signature*



Бидний гаргасан он тус бүрийн цэвэр мөнгөн урсгалын төсөвлөсөн тооцоогоор борлуулалтын орлого 2011-2012 онд 41 840,0 сая төгрөг болж 2010 оны санхүүгийн тайлангийн гүйцэтгэлээс 2-3 дахин нэмэгдэхээр байгаа нь юуны өмнө 2011 онд өрийн бичгийн 30 тэрбум төгрөгийн санхүүжилт авсаны дүнд бий болох мал бэлтгэлийн болон үйлдвэрлэх махны биет хэмжээний өсөлт, нөгөө талаар төсвийг календарийн жилээр биш бизнесийн мөчлөгөөр гаргасантай холбоотой бөгөөд харин мах ба махал бүтээгдэхүүний худалдах үнийг өнөөгийн дундаж үнэ ханшаар авч тооцсон болно.


Ийнхүү мал, мах бэлтгэлийн өсөлтийн нөлөөгээр борлуулалтын орлого жил дараалан нэмэгдсээр 2015-2016 онд 59 550,0 сая төгрөгт хүрч, жилийн дундаж өсөлт нь 9,2 хувь байгааг хэрэгжих боломжтой гэж үзэж байна. Энэ үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдон 2011-2012 онд гэхэд л татвар шимтгэлийг оролцуулаад үндсэн ажиллагааны 36 565,0 сая төгрөгийн, санхүүжилтийн төлбөрийн 11972,0 сая төгрөгийн, бүгд 48 540,0 сая төгрөгийн мөнгөн зардал гарах бөгөөд зээл болон 30,0 тэрбум төгрөгийн бондын санхүүжилтийг оруулаад 74 115,0 сая төгрөгийн мөнгөн орлого орж, цэвэр дүн нь 25 575,0 сая төгрөг болж дараа оны санхүүжилтэд шилжин ашиглагдах боломжтой юм байна. Өөрөөр хэлбэл 2011-2012 онд үндсэн ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ нь 5 575,0 сая төгрөг, харин санхүүжилтийн цэвэр мөнгөн гүйлгээ нь 20 000,0 сая төгрөгийн эерэг үлдэгдэлтэй, үндсэн ажиллагаанаас борлуулалтын орлогын 10 хувь, мөнгөн орлогын 13,2 хувийн ашигтай (эерэг дүнтэй) ажиллах тооцоо гарч байна. Энэ байдлаас дүгнэвэл төсөвлөсөн хугацааны эхний 2 жилийн үр дүнгээр гаргасан бондын санхүүжилтээ бүрэн төлөөд 7 300,0 сая төгрөгөөр (цэвэр мөнгөн гүйлгээ нь) нэмэгдэх юм байна. Үүнтэй холбогдуулан төсөвлөсөн бондын санхүүжилтийн талаар хөрөнгийн зах зээл, төр Засгийн хэмжээнд үнэн зөв, бодитой мэдээллийг бүх сувгаар хүргэж, хүрэх үр дүн, зөв ойлголтыг нийгэмд төлөвшүүлэн, сонирхогч талуудын дэмжлэгийг авах нь чухал байна. Ийнхүү өөрийн үндсэн ажиллагааны цэвэр мөнгөн урсгалын дүн 2011-2012 онд 5 575,0 сая, 2012-2013 онд 7 725,0 сая төгрөг гэхэдэн жил тутам нэмэгдсээр 2015-2016 онд 11 170,0 сая төгрөг болж 5 жилийн хугацаанд 2 дахин, жил тутам дунджаар 19 хувиар нэмэгдэх тооцоо гарч байгаа нь үйлдвэрлэлийн хүчин чадлын өсөлт, гадаад дотоод зах зээлийн боломж, үнэ ханшны өсөлт зэрэгтэй холбон үзэхэд хэрэгжих боломжтой гэж үзлээ.

2012-2013 оноос эхлэн бизнесийн цар хүрээгээ тэлэх, мал бэлтгэлийн боломжийг нэмэгдүүлэх зорилгоор 3-4 үйлдвэр шинээр нэмж байгуулахад зориулсан 12 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг өөрийн цэвэр мөнгөн урсгалын чөлөөт үлдэгдлээр санхүүжүүлэхээр тооцов.

### **Хорогдуулах хувийн тооцоолол**

Ирээдүйн төсөвлөсөн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг тооцоолохын тулд хорогдуулах (дискаунтын) хувийг дараах үндэслэл, аргачлал журмаар тооцоолов. Хорогдуулах хувь нь ирээдүйн төсөвлөсөн цэвэр орлого эсвэл он тус бүрийн ЦМГ-ний өнөөгийн үнэ цэнийг тооцоолоход ашиглагдах хүүний хувь хэмжээ бөгөөд тэр нь ирээдүйн орлогыг олж авах магадлал (эрсдэл), мөнгөний цаг хугацааны хүчин зүйл, гаднаас татан төвлөрүүлсэн санхүүжилтийн дундаж зардал, хугацаанаас хамааралтай тогтоогддог. Хорогдуулах хувийн хөрөнгийн үнэ бүрдэлтийн загвар (CAPM)-аар тооцоолоход:

Хамгийн эрсдэлгүй хүү гэгдэх Засгийн газрын бондын хүү жилийн 11 хувь орчим байгаа бөгөөд 2010 онд инфляцийн түвшин 13,5 хувьтай гарсан нь одоохоондоо төдий л буурах төлөвгүй, харин ч нэмэгдэх хандлагатай байгаагаас үзвэл хөрөнгө оруулалтын өгөөжийн эрсдэлгүй хувийг  $R_f = 11 * 1,135 = 12,48$  хувиар авахад хүргэлээ.

 28



Тус компанийн эрхэлж байгаа мал мах бэлтгэл, борлуулалтын үйл ажиллагаа нь хүн амын хүнсний хэрэглээ, дэлхий нийтийн хүнсний хомсдол, төр засгаас явуулж буй мал аж ахуй, малчдыг дэмжих бодлогын нөлөө зэрэг эерэг хамаарал ихтэй ч, байгаль цаг уур, ган гачгийн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллийн давтамж ихтэй, бизнесийн цэвэр ашгийн хувьд хэвийн (дундаж хэмжээний) гэж болохоор байдлыг үндэслэн эрсдэлийн  $\beta$  коэффициентийг 20 хувийн өсөлттэйгээр  $\beta=1,2$  гэж авлаа. Хөрөнгө оруулалтын ашгийн норм махны үйлдвэрийн салбарт одоохондоо бага байгаа хэдий ч хэрэглэгчийн эрэлт хэрэгцээ, төсөвлөсөн мөнгөн урсгалын ирээдүйн цэвэр ашгийн төлвийг үндэслэн салбарын ашгийн түвшинг дээд тал нь 17 хувь гэж авахад ирээдүйн цэвэр мөнгөн урсгалыг хорогдуулах хувь нь бидний тооцоогоор  $R=12,48+1,2(17-12,48)=17,904$  гарч байгааг бүхэлтгэн 18 хувиар авч болох юм гэж үзлээ.

Цаашдаа улс орны эдийн засгийн өсөлт, бизнесийн үйл ажиллагааны тогтворжилт, зээлийн хүүний бууралтын нөлөөгөөр хорогдуулах хувь нь дараа, дараагийн онуудад 16-12 хувь, бүр дараачийн 10 жилд 10 хувь болж буурах болов уу гэсэн төсөөлөл байна.

### 3.4 Бизнесийн орлогын хандлагаарх үнэлгээ, дүгнэлт

Компанийн бизнесийн үнэлгээг тодорхойлох нэг үндсэн арга хандлага нь Ирээдүйн цэвэр мөнгөн урсгал (он тус бүрээр), түүнийг хорогдуулан тооцоолсон өнөөгийн үнэлгээ байдаг. Энэ зорилгоор дискаунтын хувийг эхний 5 жилд он тус бүрээр ялгаатай 18-12 хувиар, харин дараагийн 10 жилд тогтвортой 10 хувь байх юм гэсэн төсөөллөөр хоёр үе шатаар бодоход ойрын 15 жилийн он тус бүрийн цэвэр мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийн нийлбэр нь 59 251,4 сая төгрөг болж цэвэр мөнгөн урсгал нь 5 жил тутамд 2 дахин нэмэгдэх тооцоо гарлаа. Бид дараагийн 10 жил гэдгийг нэг талаар бизнесийн тасралтгүй үргэлжлэл, нөгөө утгаар ойрын 5 жилийн дараах үлдэх өртгийн өнөөгийн үнэ цэнэ гэсэн утгаар авсан болно.

Бизнесийн үнэлгээг тодорхойлохдоо ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ дээр мөнгөн хөрөнгийн одоо байгаа үлдэгдлийг нэмж тооцдог. 2010 оны жилийн эцсийн тайлангаар мөнгөн хөрөнгийн үлдэгдэл дөнгөж 16,9 сая төгрөг гэж гарсан хэдий ч оны эхэнд бэлэн байгаа бүтээгдэхүүний үлдэгдлийг 2011 оны 7 дугаар сарыг хүртэлх хугацаанд борлуулсаны дүнд олох цэвэр ашиг болон нөөцийн мах бэлтгэсний урамшуулал зэргээс багадаа 800,0 орчим сая төгрөгийн цэвэр мөнгөн орлого орох боломжтой гэж тооцоход тус компанийн ирээдүйн төсөвлөсөн мөнгөн урсгалаар тооцсон бизнесийн үнэлгээ нь бүгд  $16,9+800,0+59\ 251,4=60,068.3$  сая төгрөг гарч байгааг бүхэлтгэн 60,070.0 (жаран тэр бум далан сая) төгрөгөөр тогтоож болох юм гэж үзлээ.

### 3.5 Компанийн бизнесийн болон хөрөнгийн нэгдсэн үнэлгээ, дүгнэлт

Тус компанийн үндсэн хөрөнгийн үнэлгээг үйлдвэр тус бүрээр, хөрөнгийн нэр төрлөөр тайлангийн 2-р дугаар бүлэгт тооцоолсноор бүгд 45,206.9 сая төгрөг гэж гарсан (товчоолсон хүснэгт, 18-р хуудас)

Нийт активын үнэлгээний цэвэр дүн нь үндсэн ба эргэлтийн хөрөнгийн үнэлэгдсэн дүнгээс хүлээгдэж байгаа өр төлбөрийг хассан дүнгээр тооцоологддог. Энэ зорилгоор 2010 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар тодорхойлсон нийт хөрөнгө, тэдгээрт хийгдсэн хараат бус аудитын байгууллагын ("Далайван Аудит" ХХК) дүгнэлт тодруулга зэргээс үзвэл:

1. Эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл 5576,3 сая төгрөг гэж тайлагнагдсан боловч бусад авлагаас 12,3 сая төгрөгийг урьдчилж төлөгдсөн төлбөр тооцоонд шилжүүлдгээ.

29





Эргэлтийн хөрөнгийн өнөөгийн үнэлгээг тодорхойлохын тулд бид бэлэн бүтээгдэхүүний үлдэгдэл 15 хувиар борлуулалтын цэвэр ашгийг тооцоолж үнэлгээг 467,7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, харин “Жаст” группийн компани хоорондын тооцоогоор үүссэн 1900,0 сая төгрөгийг авлага болон богино хугацаат өрийн дүнгээс хасаж, эргэлтийн хөрөнгийн цэвэр дүнг 4 144,0 сая төгрөгөөр, богино хугацаат өрийн үлдэгдлийг 3 633,1 сая төгрөгөөр тус тус тооцлоо.


2. Урт хугацаат өрийн дансанд бүртгэгдсэн 28 237,8 сая төгрөгийн өр төлбөр нь бүхэлдээ “Жаст Агро” ХХК-ийн төв ба орон нутгийн сүлжээ үйлдвэрүүдийг байгуулахад Жаст групп (толгой компани)-ээс сүүлийн 5 жилд оруулсан хөрөнгө оруулалтын санхүүжилт тул “Далайван-Аудит” компанийн дүгнэлт, менежментийн зөвлөмжийн дагуу үлдэгдлийн дүнгээр урт хугацаат өрийн дүнг бууруулж, “Жаст Агро” ХХК-ийн эзэмшигчдийн өмчлөлд бүртгэх тухай “Жаст групп” ХХК-ийн ерөнхий захирлын 2011 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн А-01/18 тоот тушаалыг үндэслэн урт хугацаат өр төлбөрөөс хасаж цэвэр активын үнэлгээг хүснэгт 3-ээр тодорхойллоо.

### Цэвэр активын үнэлгээний нэгдсэн товчоо (сая төгрөгөөр)

Хөрөнгийн нэр	2010 оны санхүүгийн тайлангийн		Үнэлгээний тохируулга	Шинэчилэн тогтоосон үнэлгээ
	Үлдэгдэл	Аудитын тохируулга		
<b>1. Эргэлтийн хөрөнгө</b>				
-Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	16,9			16,9
-Дансны болон бусад авлага	345,8	(12,3)		333,5
-Холбоотой талуудын тооцоо	1 900,0		(1 900,0)	
-Бараа материал	3 313,6		467,7	3 781,3
-Урьдчилж төлсөн төлбөр, тооцоо	-	12,3		12,3
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>5576,3</b>		<b>(1 432,3)</b>	<b>4 144,0</b>
<b>2. Эргэлтийн бус хөрөнгө</b>				
-Үндсэн хөрөнгө (цэвэр) ба дуу саагүй барилга	32 587,9	(431,8)	13 050,8	45 206,9
-Биет бус хөрөнгө	3,2			3,2
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>32 591,1</b>	<b>(431,8)</b>	<b>13 050,8</b>	<b>45 210,1</b>
<b>Нийт хөрөнгө</b>	<b>38 167,4</b>	<b>(431,8)</b>	<b>11 618,5</b>	<b>49 354,1</b>
<b>3. Богино хугацаат өр төлбөр</b>				
-Дансны өглөг	1 025,5			1 025,5
-Бусад өглөг, урьдчилсан орлого	137,7			137,7
-Холбоотой талд өгөх өглөг	2 469,9		(1 900,0)	569,9
-Банкны зээл	1 900,0			1 900,0
<b>Богино хугацаат өрийн дүн</b>	<b>5 533,1</b>		<b>(1 900,0)</b>	<b>3 633,1</b>
<b>4. Урт хугацаат өр төлбөр</b>	<b>28 237,8</b>	<b>(28 237,8)</b>		
<b>Нийт өр төлбөр</b>	<b>33 770,9</b>	<b>(28 237,8)</b>	<b>(1 900,0)</b>	<b>3 633,1</b>
<b>5. Эзэмшигчийн өмчийн дүн (цэвэр актив)</b>	<b>4 396,5</b>	<b>27 806,0</b>	<b>13 518,5</b>	<b>45 721,0</b>

Ийнхүү цэвэр активын үнэлгээний нэгдсэн тооцоогоор нийт хөрөнгийн үнэлгээний дүн нь 45,721,0 сая төгрөг болж 2010 оны эцэст байсан эзэмшигчийн өмчийн дүнгээс 41 324,5 сая төгрөгөөр буюу 9,4 дахин нэмэгдэж гарлаа.

Цэвэр актив буюу эзэмшигчийн үнэлгээний дүнгийн энэ өсөлтийн 67,3 хувь буюу 27 806,0 сая төгрөг нь хөрөнгө оруулалтын санхүүжилтийн зээл хэлбэрээр олгосон урт хугацаат өр

  
30



төлбөрийг эзэмшигчийн өмчлөлд шилжүүлэн бүртгэсэнтэй холбоотой, харин өмчийн өсөлтийн 32,7 хувь буюу 13 518,5 сая төгрөг нь нийт хөрөнгийн дахин үнэлгээний нөлөөгөөр нэмэгдсэн байна. Эдгээр тооцоолол дүгнэлтээс үндэслэн “Жаст Агро” ХХК-ийн цэвэр актив (нийт хөрөнгийн дүнгээс хүлээгдэж байгаа өр төлбөрийг хассан дүн) –ын зардлын болон зах зээлийн жишиг үнийн хандлагаар тооцсон үнэлгээний дүн 45 721,0 сая төгрөг болсоныг бүхэлтгэн 45 720,0 сая (дочин таван тэр бум долоон зуун хорин сая) төгрөгөөр тогтоов.

Хөрөнгийн зах зээлд өрийн бичиг (бонд ) гаргах зориулалтаар тодорхойлсон “Жаст Агро” ХХК-ийн хөрөнгийн болоод бизнесийн нэгдсэн үнэлгээний нийлбэр дүнг дээр тогтоосон хөрөнгийн үнэлгээнд 45 хувийн, бизнесийн үнэлгээний дүнд 55 хувийн холбогдол өгч, тэдгээрийн жинлэсэн дунажаар тооцоолоход  $45,720.0 * 0,45 + 60,070.0 * 0,55 = 53,612.5$  сая төгрөг болж байгааг бүхэлтгэн “Жаст Агро” ХХК-ийн хөрөнгийн болон бизнес үнэлгээний нэгдсэн дүнг 53,600.0 (тавин гурван тэрбум зургаан зуун сая) төгрөгөөр тогтоож, үнэлгээний дэлгэрэнгүй тайланг холбогдох хавсралт хүснэгт тооцооллын хамт захиалагчид хүргүүлж байна.

### Дөрөв. Үнэлгээний талаарх захиалагчийн болон гүйцэтгэгчийн үүрэг хариуцлага

4.1 Үнэлгээг Олон улсын үнэлгээний стандарт, Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, Засгийн газрын 2005 оны 233-р тогтоолоор батлагдсан “Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам”, “Барилгын нэгж талбайн төсөвт өртөг, төсвийн жишиг үнэлгээ батлах тухай” Засгийн газрын 2010 оны 336-р тогтоол, Дэд бүтцийн сайдын 1999 оны 343-р тушаалаар батлагдсан нэгж хүчин чадлын жишиг үнэ тогтоох аргачлал, “Барилгын дүрэм батлах тухай” Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2011 оны 29-р тушаал зэргийг удирдлага болгон тус компанийн улсын бүртгэлийн болон газар эзэмших эрхийн гэрээ гэрчилгээ, захиалагчийн санхүүгийн тайлан, хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл, бусад материалд тулгуурлан хийлээ.

4.2 Үнэлгээг Сангийн сайдын 2010 оны 280-р тушаалаар олгосон хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрлийн 071200025, тоот эрхийн гэрчилгээтэй үнэлгээчин Б.Сайнжаргал, Сангийн сайдын 2008 оны 367-р тушаалаар олгосон хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрлийн 081100106, 081100118, 091100150, 081100125 тоот эрхийн гэрчилгээтэй үнэлгээчин А.Раднаа, Н.Цацрал, С.Энхтөр, О.Чинбилэг нар хамтран гүйцэтгэсэн бөгөөд үнэлгээчид нь Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд заасан шаардлагыг үндэс болгон хариуцлагын даатгалд даатгуулсан болно.

4.3 Үнэлгээний явцад ашигласан мэдээллийн нууцлал, гэрээнд заагдсан холбогдох бусад асуудлыг гүйцэтгэгч хариуцна.

4.4 Үнэлгээг захиалагчийн ирээдүйн орлого, ашгаас хараат бусаар үнэлгээчний мэргэжлийн ёс зүйн дагуу гүйцэтгэсэн бөгөөд үнэлгээний ажлын хөлсийг үнэлгээний дүнгээс хамааралгүйгээр гэрээгээр урьдчилан тогтоосон болно.

31



## Тав. Үнэлгээний тайлангийн хавсралтууд

Үнэлгээний тооцоолол болон дүгнэлтийн үндэслэл, өмчлөлийн бэлэн байдлын нотолгоо болгох зорилгоор дараах баримтуудыг тайланд хавсаргав. Үүнд:

- Компанийн Улсын бүртгэлийн гэрчилгээ
- Салбарын гэрчилгээний хуулбар
- Газар эзэмших эрхийн гэрээ, гэрчилгээний хуулбар
- Тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар
- 2010 оны жилийн санхүүгийн тайланг
- “Жаст агро” ХХК-ий Ерөнхий захирлын тушаал
- “Жаст агро” ХХК-ий 2011-2016 оны бизнес төлөвлөгөө

Тайланд хавсаргасан үнэлгээний хүснэгт тооцооллууд болон ашиглах эрхийн гэрчлэх баримтууд нь тайлангийн салшгүй хэсэг болох бөгөөд үнэлгээний тооцооллын хүснэгтүүд, шилгээр худалдан авч үйл ажиллагаа эрхэлж байгаа объектуудын барилга байгууламж, тоног төхөөрөмжийн фотозургийн энэхүү тайлангийн хавсралт байдлаар гаргасан болно.

## Үнэлгээг тодорхойлж тайлан бичсэн

Үнэлгээчид:

/Б.Сайнжаргал/

/Н.Цацраг /

/А.Раднаа /

/С.Энхтөр /

/О.Чинбилэг/

## Үнэлгээний тайланг:



2011-04-11

Зөвшөөрч хүлээн авсан:

“Жаст групп” ХХК-ийн  
Санхүүгийн газрын захирал

/ Ш.Батсайхан /

2011-04-

32



**"ЖАСТ-АГРО" ХХК-ийн ХӨРӨНГӨ, ЭХ ҮҮСВЭРИЙН БАЙДАЛ (2008-2010)**  
(сая.төгрөгөөр/)

№	Утга	Бэлэн үлдэгдэл (сая.төг)			Хувийн жин			3 жилийн дундаж		Хавсралт хүснэгт 3.1	
		2010	2009	2008	2010	2009	2008	сая төгрөг	хувиар	2010-2009	хувиар
<b>1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>											
1.1.	Мөнгө	16.90	18.00	128.70	0.04	0.05	0.44	54.53	0.15	(1.10)	(6.11)
1.2.	Авлага ба бусад тооцоо	345.80	2,095.10	222.80	0.91	5.29	0.76	887.90	2.49	(1,749.30)	(83.49)
1.3.	Бараа материалын нөөц	3,313.6	8,196.4	5,068.4	8.7	20.7	17.3	5,526.1	15.5	(4,882.8)	(59.6)
1.4.	Салбаруудын тооцоо	1,900.0			5.0			633.3	1.8	1,900.0	
1.5.	Урьдчилж гарсан зардал, төлбөр		3.2		0.0	0.0	0.0	1.1	0.0	(3.2)	(100.0)
	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>5,576.3</b>	<b>10,312.7</b>	<b>5,419.9</b>	<b>14.6</b>	<b>26.0</b>	<b>18.5</b>	<b>7,103.0</b>	<b>19.9</b>	<b>(4,736.4)</b>	<b>(45.9)</b>
<b>2. ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</b>											
2.1.	Үндсэн хөрөнгө	30,063.6	29,197.1	23,945.2	78.8	73.7	81.5	27,735.3	77.7	866.5	3.0
2.3.	Дуусаагүй барилга	2,524.4	101.7		6.6			875.4	2.5	2,422.7	2,382.2
2.4.	Бусад биет бус хөрөнгүүд	3.1	3.6	3.9	0.0	0.0	0.0	3.5	0.0	(0.5)	(13.9)
	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>32,591.1</b>	<b>29,302.4</b>	<b>23,949.1</b>	<b>85.4</b>	<b>74.0</b>	<b>81.5</b>	<b>28,614.2</b>	<b>80.1</b>	<b>3,288.7</b>	<b>11.2</b>
	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>38,167.4</b>	<b>39,615.1</b>	<b>29,369.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>35,717.2</b>	<b>100.0</b>	<b>(1,447.7)</b>	<b>(3.7)</b>
<b>3. ӨР ТӨЛБӨР</b>											
3.1.	Давсаарх өглөг	1,025.5	2,819.5	602.0	2.7	7.1	2.0	1,482.3	4.2	(1,794.0)	(63.6)
3.2.	Банкны зээл	1,900.0	0.0		5.0	0.0	0.0	633.3	1.8	1,900.0	
3.3.	Бусад өглөгүүд	21.5	6.3	14.8	0.1	0.0	0.1	14.2	0.0	15.2	241.3
3.4.	Салбар хоорондын тооцоо	2,469.9	7,109.9	4,989.0	6.5	17.9	17.0	4,856.3	13.6	(4,640.0)	(65.3)
3.5.	Урьдчилж орсон орлого	116.2			0.3	0.0	0.0	38.7	0.1	116.2	
	<b>Богшино хугацаатай өр төлбөрийн дүн</b>	<b>5,533.1</b>	<b>9,935.7</b>	<b>5,605.8</b>	<b>14.5</b>	<b>25.1</b>	<b>19.1</b>	<b>7,024.9</b>	<b>19.7</b>	<b>(4,402.6)</b>	<b>(44.3)</b>
3.6.	Урт хугацаатай өр төлбөр	28,237.8	24,982.4	16,984.3	74.0	63.1	57.8	23,401.5	65.5	3,255.4	13.0
	<b>Ор төлбөрийн дүн</b>	<b>33,770.9</b>	<b>34,918.1</b>	<b>22,590.1</b>	<b>88.5</b>	<b>88.1</b>	<b>76.9</b>	<b>30,426.4</b>	<b>85.2</b>	<b>(1,147.2)</b>	<b>(3.3)</b>
<b>4. ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ</b>											
4.1.	Хувьцааг хоронго	10.0	10.0	10.0	0.0	0.0	0.0	10.0	0.0	0.0	0.0
4.2.	Дахин үнэлээний нөөц	11,129.8	11,554.8	11,554.8	29.2	29.2	39.3	11,413.1	32.0	(425.0)	(3.7)
4.3.	Хуримтлагдсан ашиг (адагдал)	(6,743.3)	(6,867.8)	(4,785.9)	(17.7)	(17.3)	(16.3)	(6,132.3)	(17.2)	124.5	(1.8)
	<b>өмчөө онуудын тайлант оны</b>	<b>(6,866.6)</b>	<b>(4,785.9)</b>	<b>(4,791.4)</b>	<b>(18.0)</b>	<b>(12.1)</b>	<b>(16.3)</b>	<b>(5,481.3)</b>	<b>(15.3)</b>	<b>(2,080.7)</b>	<b>43.5</b>
	<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>123.3</b>	<b>(2,081.9)</b>	<b>5.5</b>	<b>0.3</b>	<b>(5.3)</b>	<b>0.0</b>	<b>(651.0)</b>	<b>(1.8)</b>	<b>2,205.2</b>	<b>(105.9)</b>
	<b>Өр төлбөр ба өмчийн дүн</b>	<b>4,396.5</b>	<b>4,697.0</b>	<b>6,778.9</b>	<b>11.5</b>	<b>11.9</b>	<b>23.1</b>	<b>5,290.8</b>	<b>14.8</b>	<b>(300.5)</b>	<b>(6.4)</b>
	<b>Нийт өр төлбөр ба өмчийн дүн</b>	<b>38,167.4</b>	<b>39,615.1</b>	<b>29,369.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>35,717.2</b>	<b>100.0</b>	<b>(1,447.7)</b>	<b>(3.7)</b>

*(Handwritten signature)*



**"ЖАСТ АГРО" ХХК-ийн орлого, үр дүнгийн зэргэцүүлэлт (2008-2010 он)**  
/сая.төгрөгөөр/

Хавсралт хүснэгт 3.2

№	Утга	Тайланг оны гүйцэтгэл (сая. төг)			Хувийн жин			3 жилийн дундаж		Өөрчлөлт (2010-2009)	
		2010	2009	2008	2010	2009	2008	сая.төгрөг	хувиар	сая.төгрөг	хувиар
		1. Борлуулалтын орлого	17,799.6	10,309.5	7,669.3	100.0	100.0	100.0	11,926.1	100.0	7,490.1
Нийт борлуулалт	1.9	2.1	27.2				10.4		(0.2)	(9.5)	
Борлуулалтын хөнгөлөлт	17,797.7	10,307.4	7,642.1	100.0	100.0	100.0	11,915.7	100.0	7,490.3	72.7	
Цэвэр борлуулалт	8,875.0	6,000.0	4,992.7	49.9	58.2	65.3	6,622.6	55.6	2,875.0	47.9	
2. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	8,922.7	4,307.4	2,649.4	50.1	41.8	34.7	5,293.2	44.4	4,615.3	107.1	
3. Нийт ашиг	9,154.1	7,156.0	3,283.7	51.4	69.4	43.0	6,531.3	54.8	1,998.1	27.9	
4. Үйл ажиллагааны зардал	(231.4)	(2,848.6)	(634.3)	(1.3)	(27.6)	(8.3)	(1,238.1)	(10.4)	2,617.2	(91.9)	
5. Үйл ажиллагааны бус орлого	375.2	826.2	668.7	2.1	8.0	8.8	623.4	5.2	(451.0)	(54.6)	
6. Үйл ажиллагааны бус зардал		59.5	25.5	0.0	0.6	0.3	28.3	0.2	(59.5)	(100.0)	
7. Татварын өмнөх ашиг	143.8	(2,081.9)	8.9	0.8	(20.2)	0.1	(643.1)	(5.4)	2,225.7	(106.9)	
8. Орлогын татвар	20.5		3.4	0.1	0.0	0.0	8.0	0.1	20.5		
9. Татварын дараах ашиг (алдагдал)	123.3	(2,081.9)	5.5	0.7	(20.2)	0.1	(651.0)	(5.5)	2,205.2	(105.9)	
10. Компанийн нийт орлого	18,172.9	11,133.6	8,310.8	102.1	108.0	108.8	12,539.1	105.2	7,039.3	63.2	
Компанийн нийг зардал	18,049.6	13,215.5	8,305.3	101.4	128.2	108.7	13,190.1	110.7	4,834.1	36.6	
Орлогын I төгрөгт ноогдох зардал, мөнгөөр	1.0	1.2	1.0				1.1		(0.2)	(16.3)	

*(Handwritten signature)*



**"ЖАСТ АГРО" ХХК-ИЙН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ЗЭРЭГЦҮҮЛЭЛТ  
(2008-2010)**

Хавсралт хүснэгт 3.3

№	Тооцсон үзүүлэлт	Тооцсон үзүүлэлт	2010	2009	2008	3 жилийн дундаж
<b>1. Санхүүгийн төгтворжилт</b>						
1.1.	Өөрийн капиталын өршдоо, хувь	ӨК:НХ	11.5	11.9	23.1	15.49
1.2.	Нийт өрийн харьцаа	ГК:ӨК	7.7	7.4	3.3	6.15
1.3.	Ажлын капитал (сая төгрөгөөр)	ЭХ-БХӨ	43.2	377	-185.9	78.10
1.4.	Санхүүгийн уян хатан байдал	АК:ӨК	0.01	0.08	-0.03	0.02
1.5.	Эргэлтийн хөрөнгийн харьцаа	ЭХ:БХӨ	1.01	1.04	0.97	1.00
<b>2. Төлбөрийн чадвар</b>						
2.1.	Төлбөрийн өлсөөгийн боломж	Мх:БХӨ	0.003	0.002	0.023	0.01
2.2.	Төлбөрийн ойрын боломж	(Мх+Ав):БХӨ	0.066	0.213	0.063	0.11
2.3.	Эргэлтийн хөрөнгийн санхүүжилт	АК:ЭХ	0.008	0.037	-0.034	0.00
2.4.	Өр төлбөр ба аялагын харьцаа	БХӨ:Аялага	16.0	4.7	25.2	15.30
<b>3. Хөрөнгийн ашиглалт</b>						
3.1.	Нийт хөрөнгийн ачаалал	НО:НХ	0.47	0.26	0.26	0.33
3.2.	Өөрийн хөрөнгийн ачаалал	БО:ӨК	4.05	2.19	1.13	2.46
3.3.	Аялага цуглуулалтын хугацаа	Ав:БО*360	25	40		
3.4.	БМН-ийн эргэцийн хугацаа	Н:ББО*360	253	398		
3.5.	Үйл ажиллагааны шилт	(3.3+3.4)	258	438		
3.6.	БХӨ-ийн барагдуулалт (хугацаа)	Өгл:МЗ*360	49	44		
3.7.	Мөнгөн циклийн хугацаа (3.5-3.6)		209	394		
<b>4. Хөрөнгийн өгөөж, хувнар</b>						
4.1.	Борлуулалтын ашигт ажиллагаа	ҮАЦА:БО	-0.01	-0.28	-0.08	-0.12
4.2.	Нийт хөрөнгийн өгөөж	ХТӨЦА:НХ	0.0038	0.0526	0.0003	-0.02
4.3.	Өөрийн хөрөнгийн өгөөж	ТӨЦА:ӨК	0.028	-0.443	0.001	-0.14
4.4.	Зардлын түвшин	НЗ:НО	0.99	1.19	1.00	1.06



# Бичиг баримтын хуулбарууд

*[Handwritten signature]*



УБ-2

Монгол Улсын Засгийн газрын  
2004 оны 20 дугаар тогтоолоор батлас



# МОНГОЛ УЛС УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

2007.05.11  
*Бүртгэсэн өг, сар, өдөр*

9011098074  
*Улсын бүртгэлийн дугаар*

5138124  
*Регистрийн дугаар*

Жаст-Агро Хязгаарлагдмал хариуцлагатай компани  
*Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр*

Дүрэм  
*Мүүсэл байгуулах баримт бичиг*

Шийдвэр  
*Шийдвэрийн нэр*

01  
*Дугаар*

2007.01.17  
*өг, сар, өдөр*

151100  
*код*

Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хадгалах  
*Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл*

012200  
012100  
602300

Бусад амьтад үржүүлэн, ашиг шимийг авах  
Мал аж ахуй  
Авто, ичөө тээвэрлэх үйлчилгээ

Хугацаагүй  
*хугацаа*

1  
*шилүүдийн тоо*

10,000.0  
*Мөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр*

Баянгол, 20-р хороо, Дунд гол БГД, Өөрийн байр - 00, утас: 536277, утас2: факс:

*Хуулийн этгээдийн албан заны тал*

8007098074 21 өдөр  
Бүртгэлийн № 5138124  
УБ-2  
Татварын Ерөнхий  
Улсын бүртгэлийн  
Албаны дарга  
Төгсгөл хуучин  
2007.05.11

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ  
УЛСЫН  
БҮРТГЭЛИЙН  
АЛБАНЫ ДАРГА  
УХА0175

УЛААНБААТАР  
МАХ-ийн тээвэр  
Анхны  
Брокер, тээвэр  
"БИЛЭГ"





# САЛБАРЫН ГЭРЧИЛГЭЭ

РЕГИСТРИЙН ДУГААР: 5138124

УБД: 9011098074

Жаст-Агро ХХК  
"Сэлэнгэ аймаг дахь салбар"

(Хуулийн этгээдийн нэр)

Салбар нь хуулийн этгээдийн эрхийг эдлэхгүй. Эрх бүхий байгууллагаас баталсан журмын дагуу үйл ажиллагаагаа илүүлдэг.

Шийдвэр гаргасан	Эрх бүхий байгууллага		Үүсгэн байгуулагчийн шийдвэр	
	он, сар, өдөр		2009.08.19	
Эрхлэх үйл ажиллагаа	Код	1511	Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хадгалах.....	
гацаа	Хугацаагүй			
Харилцагч банкны	нэр		дансны дугаар	
	нэр		дансны дугаар	
	нэр		дансны дугаар	
Хаяг	Аймаг, (хот' сум (дүүрэг)	Байгууллага	Сэлэнгэ аймаг	Оюунцэцэг
	Баг, хороо		Сүхбаатар сум	Баатарцогт
	Орших газар		4-р баг	Хан-Уул дүүрэг
	Утасны дугаар		99118370	5-р хороо
			Яармаг 1-1 Б	99066700
			Удирдлын, олог, цэцэг (эх)-ийн нэр, нэр	

БҮРТГЭСЭН: Үндэсний татварын ерөнхий газрын даргаар  
Улсын бүртгэлийн албаны дарга

Татварын улсын  
(ахлах) байцаагч  
2009 09

17

Ц.Ганболд

Ч.Гэрэлцэцэг





УБ-1А



# САЛВАРЫН ГЭРЧИЛГЭЭ

Салбар нь хуулийн этгээдийн эрхийг эдлэхгүй. Эрх бүхий байгууллагаас баталсан журмын дагуу үйл ажиллагаагаа явуулна

РЕГИСТРИЙН ДУГААР: 5138124

УБД: 9011098074

Жаст-Агро ХХК  
"Багануур" аймаг дахь салбар

(Хуулийн этгээдийн нэр)

Шийдвэр гаргасан	Эрх бүхий байгууллага		Үүсгэн байгуулагчийн шийдвэр		
	он, сар, өдөр		2009.08.19		
Эрхлэх үйл ажиллагаа	Код	1511	Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хадгалах.....		
			-----		
Хугацаа		Хугацаагүй			
Харилцагч банкны	нэр		дансны дугаар		
	нэр		дансны дугаар		
	нэр		дансны дугаар		
Хаяг	Аймаг, (хот) сум (дүүрэг)	Байгууллага	Улаанбаатар хот	Магсарбямба Гантөмөр	
	Баг, хороо		Багануур дүүрэг	Сэлэнгэ	
	Орших газар		3-р хороо	Сүхбаатар	4-р баг 6-р хэсэг
	Утасны дугаар		Үйлдвэрийн хэсэг		
			99118370	Удирдлагын, овог, эцэг (эх)-ийн нэр, нэр	
				99066700	

БҮРТГЭСЭН: Үндэсний татварын ерөнхий газрын дэргэдэх Улсын бүртгэлийн албаны дарга,

Татварын улсын (ахлах) байцаагч  
2009 09

оны ..... дугаар сарын .....-ны өдөр

Ц.Ганболд

